ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ



Улаанбаатар 2004 он

Сая живаа сайн буян хотол чуулж мэндэлсэн лагшинт
Сааршгүй олон амьтны эгээрлийг хангагч зарлигт
Сац хамаг мэдэгдэхүүнийг ёсчлон болгоосон таалалт
Сартваахь Шагжа язгуурын Эрхэм танаа тэргүүн юүгээр мөргөмү

Монголын Бурханы Шашны Төв-Гандан Тэгчэнлин Хийд
Өндөр Гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурхан Шашны Их Сургууль
Азийн Буддистуудын Энхтайвны Бага Хурал

ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ



I дэвтэр
(Бага ба дунд төрөлхтний мөр)

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D) Т.Булган
Ариутган шүүсэн: гавж Ө.Гүндсамбуу
гавж Д.Цэрмаа
Эрдэм шинжилгээний зөвлөх:
академич Д.Дагвадорж
доктор, профессор Г.Лувсанцэрэн

Улаанбаатар 2004 он

"Цастын орны мэргэдийн оройн чимэг хэмээн алдаршсан Зонхава Лувсандагва (1357-1419) богдын туурвисан "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэ их бүтээл нь "Гурван төрөлхтний мөр" буюу хүний оюун ухааны гурван их үе шатаар дамжуулан сэтгэл оюуны гэгээрэхүйн их хутагт хүрэх арга замыг Бурхан Буддхагийн заасан гэгээн үзэл онол, явдал мөрийн суртгаалд үндэслэн Хутагтын орны мэргэд дээдсийн оюуны бүтээлийн охь шимээр баяжуулан, хүний оюуны хөгжлийн дээд шатанд хүрэх арга замыг арга билгийн үүднээс тодорхойлон тайлбарласан гүн ухаан, оюун сэтгэлгээ, анхааран авах бясалгалын аньс шимийг хураасан оюуны их бүтээл бөлгөө"

© *All rights reserved Т.Булган 2004*

"Их бодь мөрийн зэрэг"

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D) Т.Булган
Ариутган шүүсэн: гавж Ө.Гүндсамбуу
гавж Д.Цэрмаа
Эрдэм шинжилгээний зөвлөх:
академич Д.Дагвадорж
доктор, профессор Г.Лувсанцэрэн
Компьютерт оруулж, хянасан: З.Эрдэнэжаргал
Компьютерт эхийг бэлтгэсэн:
дизайнер С.Адъяа
дизайнер Т.Энхцог

ISBN

Хэвлэлийн эхийг "Нью Майнд" ХХК-д бэлтгэв. 2004 он

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРГИЙН АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ I

УДИРТГАЛ 1

I. НОМЫН ҮНДЭС АРИУНЫГ ҮЗҮҮЛЭХИЙН ТУХАЙД ЗОХИОГЧИЙН ЭРДМИЙГ ҮЗҮҮЛЭХ 2-10
А. Хотол чуулсан язгуурт мэндэлсэн ёсон 3
Б. Тэрхүү бие шүтээн дээр эрдмийг эрхшээсэн ёсон 3
1. Олныг болгоох эшийн эрдэмд сурсан ёсон 3
2. Ёсчлон бүтээх онолын эрдэмд сурсан ёсон 5
а. Ёс суртахууны суртгаалд гурван зүйл 5
1) Тус тус гэтэлгэгчийн санваар төгөлдөр асан 5
2) Бодисадвын санваар төгөлдөр асан 6
3) Очирт хөлгөний санваар төгөлдөр асан 6
б.Бясалгалын суртгаал төгөлдөр асан ёсноо хоёр зүйл 7
1) Нийтийн ёсноо бясалгалын суртгаал төгөлдөр асан нь 7
2) Нийт бусын ёсноо бясалгалын суртгаал төгөлдөр асан нь 7
в. Билгийн суртгаал төгөлдөр асан 7
1) Нийтийн ёсон 7
2) Нийт бусын ёсон 7
В. Эрдмийг эрхшээн шашнаа тусыг зохиосон нь 8
1. Энэтхэгт (Хутагтын орон) зохиосон ёсон 8
2. Төвдөд (Цастын орон) зохиосон ёсон 9

II. УВДИСТ БИШРЭЛ ТӨРҮҮЛЭХИЙН ТУХАЙД НОМЫН ЭРДМИЙГ ҮЗҮҮЛЭХ 11-18
А. Хамаг шашин (дээдийн ном) бүгдийг харшуулахгүй онох эрдэм 12
Б. Хамаг эрхэм зарлигийг увдис болгож ургуулсан эрдэм 15
В. Ялгуусадын тааллыг амар хялбар олох эрдэм 18
Г. Их гэмт явдлаас өөрийгөө буцаах эрдэм 18

III. ХОЁР ЭРДЭМ ТӨГӨЛДӨР НОМЫГ ХЭРХЭН СОНСОХ БОЛОН НОМНОХ ЁСОН 19-31
А. Сонсохуй ёсон 19
1. Номыг сонсохын тус эрдмийг санах 20
2. Ном хийгээд номыг өгүүлэгчнээ хүндлэл үйлдэх 21
3. Сонсохын бодит ёсон 22
а. Савны гурван гэмийг тэвчих 22
б. Зургаан хур мэдлийг шүтэх 23
Б. Номнохуй ёсон 28
1. Ном номнохуйн тус эрдмийг санах 28
2. Багш хийгээд номоо өргөн хүндлэх 28

3. Ямар санаа бодол болон үйл ажлаар номнох 29
4. Номнох, эс номнох орны ялгаа 30
В. Төгсгөлд нийтээр үйлдэх ёсон 31

ҮНДСЭН БҮЛЭГ
IV. БОДИТ УВДИСААР ШАВИЙГ ХЭРХЭН ХӨТЛӨХ ЗЭРЭГ 32
***Буяны садныг шүтэх ёсон* 32-54**
А. Мөрийн язгуур-Буяны садныг шүтэх ёсон 32
1. Ойлголт төрүүлэхийн тул өчүүхэн дэлгэрэнгүй номнох 32
а. Шүтээн буяны садны бэлэг чанар 33
б. Шүтэгч шавийн бэлэг чанар 38
в. Тэр бээр хэрхэн шүтэх ёсон 39
1) Сэтгэлээр шүтэх ёсон 40
а) Ерөнхий шүтэх сэтгэлийг үзүүлэх нь 40
б) Ялангуяа язгуур-Сүсэглэх сэтгэлийг үзүүлэх 40
в) Зарлигийн ачийг санах-Бишрэх сэтгэлийг үзүүлэх 45
2) Үйл ажлаар шүтэх ёсон 46
а) Эд өлөг өргөх 47
б) Бие, хэлээр өргөн хүндлэх 48
в) Зарлигчлан бүтээх 48
г) Шүтэхийн тус эрдэм 49
д) Эс шүтэхийн гэм 51
е) Утгын хураангуй 53

***2. Бясалгах ёсыг хураангуйлан үзүүлэх* 55-75**
а. Бодитой бясалгах ёсон 55
1) Жинхэнэ бясалгалын үест үйлдэх зүйл 55
а) Бэлтгэл ажил 55
б) Бодит суурийн үест бясалгах ёс 61
1. Ерөнхий бясалгах ёсон 61
2. Энэ үесийн бясалгах ёсон 61
в) Төгсгөлд хэрхэн үйлдэх 62
2) Бясалгалын завсрын үест үйлдэх зүйл 62
а) Эрхтэний үүдийг хориглох 63
б) Ухамсартай эдлэх 64
в) Идээний хэмжээг барих 65
г) Үл хэвтэн бясалгалд шамдах ба хэвтэхийн цагт юу үйлдэх 67
б. Бясалгалын талаарх буруу бодлыг няцаах 69

***Чөлөө учралыг санах* 76-86**
Б. Шүтэж сэтгэлээ хэрхэн судлах зэрэг 76
1. Чөлөөт шүтээний шимийг авахаар шаардах 76
а. Чөлөө учралыг танин барих 76
1) Чөлөө 76

2) Учрал 77
а) Өөрийн таван учрал 77
б) Бусдын таван учрал 78
б. Түүний хэрэг ихтэйг санах 78
в. Олоход бэрхтэйг санах 82

Гурван төрөлхтний мөр **86-96**
2. Хэрхэн шимийг авах ёсон 86
а. Мөрийн ерөнхий агуулгыг магадлан мэдэх 86
1) Эрхэм зарлиг бүхэн гурван төрөлхтний мөрд хураагдах ёсон 86
2) Гурван төрөлхтний үүднээс зэрэгчлэн хөтлөх учир шалтгааныг үзүүлэх 88
а) Гурван төрөлхтний мөрийн үүднээс хөтлөх утга 88
б) Тэрхүү зэргээр хөтлөх учир шалтгаан 89
1. Бодит учир шалтгаан 89
2. Хэрэг зорилго 94
б. Шимийг авах бодит ёсон 97
(I) Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах
(II) Дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах
(III) Их төрөлхтний мөрийн зэрэгт оюунаа судлах

Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөр
I. Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах 97
А. Бага төрөлхтний сэтгэлийг бодитой судлах 97
Мөнх бусын ёсыг санах **97-113**
1. Хойд төрлийг чухалчлах ухааныг төрүүлэх 97
а. Энэ ертөнцөд удаан оршихгүй үхэх ёсыг дурдан санах 97
1) Үхэхийг дурдан санаагүйн гэм 97
2) Үхэхийг бясалгахын тус эрдэм 99
3) Үхэхийг санах ухааныг хэрхэн үүсгэх 100
4) Үхэхийг дурдан санаж бясалгах ёс 101
а) Магадтай үхэхийг санах 102
1. Үхлийн эзэн магадтай ирэхэд ямар ч шалтгаанаар буцаах аргагүйг санах 102
2. Насанд нэмэгдэл байхгүй, байнга хорогдож байхыг санах 103
3. Амьд байх цагт ном буян үйлдэх чөлөөгүй байсаар үхэхийг санах 105
б) Хэзээ үхэх магадгүйг санах 107
1. Замбуу тивийн нас батгүйг санах 107
2. Үхэх шалтгаан маш олон, амьд явах шалтгаан өчүүхнийг санах 108
3. Бие машид бялд өчүүхэн тул хэзээ үхэх магадгүйг санах 110
в) Үхэх цагт номоос бусад юу ч үл туслахыг сана 111
1. Элгэн садан ч үл хөтлөх 111

2. Эд баялаг ч үл хөтлөх 111
3. Энэ бие цогцос ч үл хөтлөх 111

Муу заяаны зовлонг санах **114-128**
б. Хойд төрөлд хэрхэн одох хоёр заяаны жаргал зовлонг санах 114
1) Там 115
а) Их (халуун) тамын амьтан 115
б) Ойр орчмын там 118
в) Хүйтэн там 119
г) Энд тэндхийн там 120
2) Адгуусны зовлонг санах 122
3) Бирдийн зовлонг санах 123
а) Идээ ундаа нь гаднаас түйтгэрлэгдэх 123
б) Идээ ундаа нь дотроос түйтгэрлэгдэх 123
в) Идээ ундааны түйтгэр 123

Аврал одуулах **129-158**
2. Хойд төрөлд амгалантай байх арганаа суралцахад хоёр 129
а. Шашнаа орохуйн дээд үүд–Авралыг одуулахуйг судлах 129
1) Алинаа шүтэн аврал одуулахын шалтгаан 129
2) Шүтэж аврал одуулах орон 130
а) Орноо танин мэдэх 130
б) Тэд авралд зохистойн учир шалтгаан 131
3) Хэрхэн аврал одуулах ёс 132
а) Эрдмийг мэдэж аврал одуулах 132
1. Бурханы эрдэм 132
(а) Лагшингийн эрдэм 133
(б) Зарлигийн эрдэм 134
(в) Тааллын эрдэм 135
(г) Үйлсийн эрдэм 137
2. Номын эрдэм 140
3.Хуврагийн эрдэм 140
б) Ялгамжааг мэдэн аврал одуулах 140
1. Бэлэг чанараас гарсан ялгамжаа 140
2. Үйлсийн ялгамжаа 141
3. Сүсгийн ялгамжаа 141
4. Бүтээлийн ялгамжаа 141
5. Даган санахын ялгамжаа 141
6. Буян арвижихын ялгамжаа 141
в) Ам авахын аврал одуулах 141
г) Бусдад үл өгүүлэн аврал одуулах 141
4) Аврал одуулах суртгаалын зэрэг 143
а) “Хураангуй”- гаас гарсан суртгаал 143
1. Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг 143

(а) Дээд төрөлхтнийг шүтэх 143
(б) Дээдийн номыг сонсох 143
(в) Сонссоноо сэтгэлдээ бодох 143
(г) Ном даган зохилдож ном бүтээх 143
2. Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг 143
(а) Эрхтэнээ үл дошигруулах 143
(б) Суртгаалын суурийг үнэхээр авах 144
(в) Амьтаныг энэрэн хайрлах 144
(г) Цаг цагт чухал дээдийг тахихаар хичээх 144
б) "Увдис"-аас гарсан суртгаал 144
1.Тус тусын зургаан суртгаал 144
(а) Гурван хорихуйн суртгаал 144
(б) Гурван бүтээхүйн суртгаал 145
2. Нийтийн зургаан суртгаал 147
(а) Чухаг дээд гурван ялгамжаа болон эрдмийг даган дурдан дахин дахин аврал одуулах 147
(б) Зарлигийн их ачийг дурдан санаж цаг үргэлжид тахихуйяа хичээж идээ ундны дээжээр тахих 147
(в) Их нигүүлсэхүйг дурдан санаж бусад амьтныг энэ ёсноо байгуулах 152
(г) Аливаа үйлийг үйлдэх ба хэрэг юу нэгэн гарлаа ч чухаг дээд гурвыг тахиж залбирал талбин ертөнцийн бусад аргыг тэвчих 152
(д) Тус эрдмийг мэдээд өдөр шөнөд гурвантаа аврал одуулах 152
(1) "Хураангуй"-гаас номносон тус эрдэм 152
а/ Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг 153
б/ Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг 153
(2) "Увдис"-аас номносон тус эрдэм 154
а/ Дотоод бурханы номтонд багтах 154
б/ Хамаг санваар төрөх шүтээн болох 154
в/ Урьд хураасан үйлийн түйтгэр нимгэрэн барагдах 154
г/ Агуу их буян хураах 155
д/ Муу заяанд үл унах 155
е/ Хүн болоод хүн бусын ад зүтгэрт үл дийлдэх 155
ё/ Юу санасан бүгд бүтэх 155
ж/ Түргэн бурхан болох 155
(е) Инээдэм наадмын төдийд ч авралыг үл орхих 155

Үйлийн үрийг санах ***159-204***
б. Хамаг сайн амгалангийн язгуур–Сэтгэл итгэмжлэх сүсэг төрүүлэх 159
1) Үйл үрийг ерөнхий санах 159
а) Ерөнхий бодитой санах ёс 159
1. Үйл магадтай ёсон 159

2. Үйл арвижих ёсон 160
3. Үйлдээгүй үйлтэй үл учрах 163
4. Үйлдсэн үйл үл шамшаагдах 163
б) Тус тус ялган санах 164
1. Арван үйлийн мөрийг голчлон үзүүлэх 164
2. Үйл болон үр дагаварыг нотлон буулгах 166
(а) Нүглийн үйл болон үр дагавар 166
(1) Бодит арван нүглийн үйлийн мөрүүд 166
(2) Хүнд хөнгөний ялгаа 175
а/ Үйлийн арван мөрийн хүнд хөнгөний ялгаа 175
б/ Дашрамд хүнд үйлийн суурийг
хураангуйлан үзүүлэх 178
(3) Тэдгээрийн нүглийн үр дагаварыг үзүүлэх 183
а/ Тийн боловсролын үр 183
б/ Шалтгаан зохилдох үр 183
в/ Эзэт үр буюу эрхэт үр 183
(б) Буяны үйл болон үр дагавар 184
(1) Буяны үйлүүд 184
(2) Тэдгээрийн үр дагавар 185
(в) Үйлийн бусад ялгалыг үзүүлэх 185
(1) Хүрэх (хаях) үйл ба гүйцээх (хаягдсан) үйл 186
(2) Амсах ёстой ба ёсгүй үйл 187
2) Өвөрмөц ялган санах 188
а) Тийн боловсролын үрийн эрдэм найм 189
б) Тийн боловсролын үрийн үр найм 189
в) Тийн боловсролын үрийн үндэс найм 190
3) Санаад орох буцахын ёсон 191
а) Ерөнхий үзүүлэх 192
б) Тусгайлан дөрвөн хүчээр арилгах ёсон 196
Б. Тэрхүү (бага төрөлхтний) санаа бодол төрөх хэмжээ 203
В. Тэдгээрийн талаарх буруу сэжгийг буцаах 203

Дунд төрөлхтөн лугээ нийтийн мөр **205**
II. Дунд төрөлхтний нийтийн мөрийн зэрэгт
оюунаа судлахад дөрвөн зүйл 206
А. Сэтгэлийг бодитой судлах 206
1. Нирваныг чухалчлах ухааныг танин барих 207
2. Түүнийг үүсгэх арга 207
Зовлонгийн үнэнийг санах **207-232**
а. Зовлон хийгээд Бухэн гарахуйн үүднээс санах 208
1) Зовлонгийн үнэн буюу хорвоогийн гэм эргүүг санах 208
а) Зовлонгийн үнэнийг дөрвөн үнэний эхэнд айлдсан
хэргийг үзүүлэх 208
б) Зовлонг бодитой бясалгах 210

1. Хорвоогийн ерөнхий зовлонг санах 210
(а) Найман зовлонг санах 210
(б) Зургаан зовлонг санах 219
(в) Гурван зовлонг санах 226
2. Тус тусын зовлонг санахад зургаа 228
(а) Гурван муу заяаны зовлон
(б) Гурван сайн заяаны зовлон 228
Зовлонгийн шалтгааныг санах **233-260**
2) Бүхэн гарахуй буюу хорвоод орохын зэргийг санах 233
а) Хэрхэн нисваанис төрөх ёс 233
1. Нисваанисыг танин барих 234
2. Хэрхэн төрөх зэрэг 235
3. Нисваанисын үндэс шалтгаан 236
4. Нисваанисын гэм эргүү 236
б) Хэрхэн түүгээр үйл хураах ёс 238
1. Хураагдахуун үйлээ танин барих 238
(а) Сэтгэлийн үйл 238
(б) Санааны үйл 238
2. Түүнийг хэрхэн хураах ёс 239
(а) Амгалантай амсуургын тухайд хураах 241
(б) Тэгш агуулах амсуургын тухайд хураах 241
в) Хэрхэн үхэх ба төрөл авах ёс 242
1. Үхэх шалтгаанууд 242
2. Үхэх үеийн сэтгэл 242
3. Хаанаас эхэлж элч хураагдах ёс 244
4. Үхлийн дараа зуурдын төрөл авах ёс 244
5. Түүний дараа орчлонд төрөл авах ёс 246
б. Арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санах 248
(1) Гишүүдийн ялгал 248
(2) Гишүүдийн хураангуй 251
(3) Хэдэн төрөлд төгсөх 254
(4) Тэдгээрийн утгын хураангуй 255
Б. Тэрхүү бодол бясалгал төрөх хэмжээ 256
В. Алжаас буруу бодлыг буцаах 257

Мөрийн үнэнийг бясалгах **261-281**
Г. Нирваанд хүрэх мөрийн мөн чанарыг үзүүлэх 261
1. Ямар шүтээн дээр хорвоог (зовлонг) буцаах 262
2. Ямар мөрийг бясалгаж түүнийг буцаах 267
а. Гурван суртгаалын тоо хэмжээ 267
1) Сэтгэлийн номхотголд харгалзах тоо хэмжээ 268
2) Үр дагаварт харгалзах тоо хэмжээ 268
3) Тэвчигдэхүүнд харгалзах тоо хэмжээ 268
б. Тэдгээрийн эрэмбэ дараа 268

в. Гурван суртгаалын мөн чанар 268

Хавсралт **283**

Түвд эх

Ном зүй

Зарим үгийн тайлбар

Ерөөлийн үг

ИХ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХҮЙ

ӨМНӨХ ҮГ

Аливаа мэдэгдэхүүн бүхэнд төрвөл үгүй Зөөлөн эгшигт
Асар хязгаарлашгүй амьтны эх болсон Нүдээр үзэгч
Атгагт шимнусын өмөг хоцрол үгүйг даран зохиогч Нууцын эзэн
Аврал гурван язгуурын мөн чанар Богдын гэгээнээ мөргөмү ①

(Цахар гэвш Лувсанцүлтим)

Оршихуйн "Цагийн хүрдэн" орчилдон эргэсээр нэгэн мянганыг үдэж нэгэн шинэ мянганыг угтав хэмээн хүмүүн төрөлхтөн хотлоор догдлон баяснам.

Зөвхөн өнгөрсөн зуунд гэхэд хүн төрөлхтөн хүн нийгмийн хөгжил дэвшилд их буян, их амгалан жаргаланг бүтээсэн гэдэгтэй хэн ч маргахгүй билээ л. Гэвч хүн төрөлхтөн тэргүүтэн эх болсон зургаан зүйл хамаг амьтан хичнээн зууныг элээж, хичнээн ч мянганыг угтавч, орь ганц хүсэл эгээрэлд хүлэгдэж ирснийг "Хамаг амьтан ялгалгүй бүгдээр, зөвхөн жаргахыг хүснэ. Хэн ч зовохыг үл хүснэ" хэмээн дээдэс зарлиглажээ.

Тийм ээ, өнөөдөр шинэ зуун, шинэ мянганы босгыг алхсан хэдий ч тэрхүү мөнхийн гэмээр, хүн төрөлхтний хүсэл эгээрэл урьдын адил хэвээрээ л байна. Гэвч тэрхүү мөнхийн гэмээр хүсэл эгээрэл болсон жинхэнэ аз жаргал, энх амгалан амьдрал сайн сайхан бүхэндээ хүрч чадав уу?

Хүн төрөлхтөн анх үүсэн бий болсон тэр цагаас хойш мөн түүний дараа туулсан хөгжил түүхийн олон янзын үе шат, орон зай, цаг хугацаа хангирсах тусам материаллаг эд баялгийн буюу техник технологийн өндөр хөгжлийн ач тусаар зүйрэлшгүй хөгжил дэвшлийн их амжилтанд хүрсэнтэй хэн ч маргахгүй.

Үүний дээр энэхүү шинэ зууны гараан дээр хүн төрөлхтний оюун санаа, сэтгэлгээ, шинжлэх ухаан танин мэдэхүйн өндөр хөгжлийн ачаар, цахим техник, мэдээллийн их сүлжээ, даяарчлалын их үйл явц зэрэг урьд өмнө байгаагүй хүний нийгмийн хөгжлийн өндөр төвшинд хүрчээ.

① *Цахар гэвш Лувсанцүлтим "Богд Зонховын намтар" (Д.Цэрэнсоднoм, Д.Нарантуяа нарын крилл бичигт хөрвүүлсэн. УБ 2004 он 128-р тал)*

Гэвч нөгөө талаас харвал хүний төрөлхтний зовлон хэвээрээ л байх шиг. Өвчин зовлон, үгүйрэл хоосрол, дайн дажин, цөмийн дайны аюул занал, байгалын гай гамшиг, хүрээлэн байгаа сав шим ертөнцийн тэнцвэргүй байдал, баян ядуугийн ялгарал, тогтворгүй хөгжил гээд олон зүйлийн шийдвэрлэх ёстой асуудалтай бид яг энэ мөчид тулгарсаар байна.

Бас нэг дурдахгүй өнгөрч болохгүй хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа нэг аймшигт зовлон бол олохуй яа бэрх эрдэнээс илүү үнэтэй хүний амь насыг тэр тусмаа гэм зэмгүй энгийн иргэдийн амь насыг хөнөөх "аллага хядлага" хэмээх аймшигт нүгэлт явдал энэ шинэ зууны эхэн дээр бүр гааран хамаг амьтны энх амгалан амьдрал, дэлхий ертөнцийн хөгжил дэвшлийн замд бодит аюул занал учруулах болов. Бурхан багш бээр алтнаас илүү үнэтэй амьтны амийг хөнөөх гэдэг ямар аймшигтай нүгэл болохыг басхүү тийм хүнд нүглийг үйлдэхгүй тэвчиж явахыг эрхэмлэн захиж, энэрэн нигүлсэхүйн сэтгэлээр эгнэгт амьтныг хайрлаж байх учиртайг:

Аяа, Хаан та амьтны амийг бүү бүрэлгэхтүн ②
Амь нас гэдэг амьтан бүхнээ хамгийн эрхэм буюу
Ашид мөнх амьдрахыг хэн хүн хүсэх аваас л
Алин байдгаараа амь таслахыг ер бүү санагтүн хэмээн айлдсан буй.

Мөн мэргэд дээдэс Бурхан багшийн ном сургаалын мөн чанар, утга агуулгыг олон талаас нягтлан тодорхойлсон байдгаас нэгийг дурдваас,

Элдэв муу хилэнц нүглийг үл үйлдэх ба ③
Эрхэм сайн буяны чуулганыг хотол хурааж
Өөрийн сэтгэлээ гэгээрүүлэх явдал болвоос
Өнөөх бурханы ном болно хэмээсэн буй.

Энэ бүх аюулаас ангижрах оюун ухаан, сэтгэл санаа, чадал боломж хүн төрөлхтөнд бий. Түүнийгээ олж нээж амьдралд зөв хэрэгжүүлснээр, зөв хөгжүүлснээр л бид өнө мөнхийн хүсэл эгээрэл болсон эрхэм дээд аз жаргалдаа хүрнэ гэдэгт эргэлзэх юун.

Чинхүү энэ л хүсэл эгээрлийг хангахын төлөө, эдүгээгээс хоёр мянга хагас илүүтэй жилийн өмнө Буддха (МТӨ-VI зуун) буюу Бурхан багш хэмээх олноо алдаршсан нэгэн бээр хутагтын орон Энэтхэгт хамаг амьтныг үл хүсэх зовлонгоос гэтэлгэх болон үргэлжийн мөрөөдөл болсон тэрхүү их амгалан жаргалд хүрэх мөр болсон "гэгээрэхүйн хутагт зорчих бодь мөр"-ийн эрхэм зарлигаа эх болсон хамаг амьтны тусын тулд айлдсан гэдэг.

② *Түвд Ганжуур "Олон судрын аймаг" 199-р тал*

③ *Дхармапада "Винайн аймаг" 1963 он Коломба*

Гэвч дээд мэргэдийн айлдсан ном суртгаал нэгэн хэрэг гэх ч бий. Харин түүнийг анхааран авч амьдрал ахуйдаа тухайлбал, өөрийн сэтгэлдээ тогтоон суулгах гэдэг түүнээс эрхэм нэгэн билээ.

Чухам үүнийг Монголын их эрдэмтэн лам Агваан Ишсамбуу бээр:

Энэ нас ахар, мэдэх зүйл их буй
Үхлийн эзэн хэзээ ирэхийн болзоогүй тул
Эрхэм зарлиг бүхний үг, утгыг хуйлруулсан гол ном
Энэхүү бодь мөрийн зэргийг анхааран суралцахыг хичээсүгэй (4)
хэмээн айлдсан буй.

Золгон буй шинэ мянганд ч хүн төрөлхтний хүсэл эгээрэл урьдын адил хэвээр үргэлжлэх нь дамжиггүй. Харин түүнийг биелүүлэхийн тулд тэрхүү гэгээн зорилгодоо хүрэхийн тулд хүний нийгмийн хөгжил, дэвшлийг хангах олон талын эрдэм ухааныг шинжлэн судалж, суралцах хэрэгтэй болж байна. Үүний нэг нь "Оюуны хөгжил, оюуны тогтвортой хөгжил"-ийн асуудал чухлаар шаардагдаж байгааг дэлхийн ухаантан мэргэд олонтаа зарлиглах болов.

Тэрхүү оюуны хөгжлийн хэрэгцээг адбиш хангахад Бурхан багшаас үндэслэн дамжиж түүний шавь эрдэмтэн мэргэдийн ухаанаар "Оюуны хөгжлийн дээд шат гэгээрэхүйн хутагт хүрэх арга замын увдис" болон дэлгэрсэн "Бодь мөрийн зэрэг" хэмээх эл ухаан тус болно хэмээн санаж Зонхава Лувсандагва буюу Сумадигирди Богдын (1357-1416) туурвисан "Их Бодь мөрийн зэрэг" хэмээх агуу увдис бүтээлийг орчуулан эрхэм уншигч танаа толилуулж байна.

"Эрдэнэт сайхан галбирваас модны дэргэд илч шимгүй зэгс суулгасан мэт" хэмээсэн адилаар өтөл өчүүхэн миний бие ухаж онохын чадал мөхөс, оносон гэвч буруу талаас ухаарах, эсвээс тээнэгэлзэх сэжиглэх зэргийн өөрийн гэм буруугаас шалтгаалж дээдийн номын гүн утгыг эндүү ташаа буулгасан вий гэж ихэд эмээж хүлцэл өчнөм. Эрхэм та бүхэн эхийн энэрэнгүй сэтгэлийн, эцгийн уужим ухаанаа ач буянтай санал зөвлөгөө юүгээн хайрлаарай.

А. Богд Зонхавын намтрын хураангуй

Хамаг Ялгуусан бүгдийн айлдал, энэрэл, чадал гурван эрдмийн мөн чанар болсон, Гурван язгуурын бурханы хувилгаан, Цаст Түвдийн мэргэдийн оройн чимэг, Хоёрдугаар ялгуусан Богд Зонхава Лувсандагва

(4) *"Зурхэнд хадгалваас зохист үг хэмээгдэх захиас суртгаал оршвой" (гар бичмэл 7 тал)*

(1357- 1419) хэмээн алдаршсан энэ их хүний намтар цадиг, зохиол бүтээл, шашин амьтны төлөөх үйлс хэрэг нь санаанд багташгүй гайхамшигт их бөлгөө.

Монголын их эрдэмтэн Цахар гэвш Лувсанцүлтим тэргүүтэн олон дээдэс мэргэдийн туурвисан Богд Зонхава ламын гайхамшигт намтар цадиг зэргийг түшиж, Их богдын намтраас товч хураангуйлан өгүүлсүгэй.

Бидний бурхан багш Шагжамуни цагаан мичин жилд хувилж төрөөд хорин есөн насны шар хулгана жилд тойн болж зургаан жил болтол бясалгал бүтээлийг үйлдэв.

Гучин таван насны хөх морин жилийн дөрвөн сарын арван тавнаа илт туулж Бурхан болоод мөн тэр жилийн зургаанаа анх эхэлж олон амьтанд ном номлов. Шагжамуни шашин гарах эх нь тэр буй.

Тэр морин жилээс хоёр мянга хоёр зуун наян жил төгсөөд, Төвдийн Амду нутгийн Зонха хэмээх газарт эцэг Лүмбүмгэ, эх Шинса Ачой нарын хөвгүүн болж 6 дугаар жарны улаагчин тахиа жилд (1357) Зонхава гэгээнтэн хувилж мэндэлжээ. Гурван настай байхдаа Монголын Тогоонтөмөр хаан Гармава Ролбидорж хэмээх ламыг залах үеэр гэгээн багштай учирч гэнэн сахил хүртжээ. Долоон насандаа цорж Дондүврэнчин ламаас гэцэл сахил хүртэн багшийн дэргэд бараа болж олон ном хүртэв. Сахилын алдар Лувсандагва (санск: Сумади Гирди) хэмээн алдаршжээ.

Арван долоон настайдаа Төвдийн Үй зан зүгт морилж Дэважин хийд зэрэгт саатаж Сажийн их багш Рэндава, Ёндонжамц лам, Нябо лам тэргүүтэн олон багшаас судрын аймгийн олон эш номыг сонсож судлав. Мөн Чонба лам, Чойжибал лам тэргүүтнээс тарнийн аймгийг сонсож судлав. Бас бус олон лам нараас судар дандарын ном цаглашгүй олон зүйлийг сонссоноор мэргэд бүхний оройн чандмань мэт болжээ. Хорин дөрвөн наснаа Цүлтимринчэн ламаас аяга тахимлагийн санваарыг хүртжээ.

Гучин зургаан сүүдэртэйдээ гэгээн эрдэм төгс найман шавийн хамт есүүл аглагт гараад, Жормүлүнгээс Олхад морилж судар тарни хослон барилдсан гүн мөрийг бясалган бүтээснээр үлэмж онолын эрдэмд төгс боловсорчээ.

Гучин есөн сүүдэртэйдээ Түвдийн Нялын Лүнра хэмээх газар номын хүрдийг эргүүлжээ.

Дөчин зургаан сүүдэртэйдээ (1402) “Ялгуусан бурхадын эрхэм зарлиг бүгдийн аньсийн хураангуй”, “Хамгийг болгоогчийн газар зорчих дээд төрөлхтний номын ёс”, “Гурван төрөлхтний бясалгалын зэргийг үлдээлгүй

хураагч" зэргээр ихэд алдаршсан, Буддын гүн ухаан, оюун сэтгэлгээ, бясалгалын бүтээлийн агуу их цогц тайлбар, гайхамшигт бүтээлүүдийн нэг болсон **"Их бодь мөрийн зэрэг"** хэмээх бүтээлээ туурвижээ.

Дөчин найман сүүдэртэйдээ (1405) "Түгээмлийн их эзэн бурхан Очирдарагийн мөрийн зэрэг, нууц бүхний утгыг сайтар ялгасан хэмээхүй" бурхан багшийн эрхэм зарлигийн манлайн дээд оргил болсон нууц тарнийн ёсны гайхамшигт их тайлбар, нэвтэрхий толь болох бүтээлээ туурвижээ.

Чингэж Их богд бээр зөвхөн дээрх хоёр "мөрийн зэрэг" бүтээлээрээ бурханы айлдсан хамаг судар тарнийн номын утгыг хойчийн шавь нар бээр үнэн зөвөөр анхааран авч судлах "Зүрхэн тайлбар"-ыг бүтээж үлдээсэн цаглашгүй их номын ачтан бөлгөө.

Тавин хоёр сүүдэртэйдээ Лхасын их чонпрүл ерөөлийг эхэлж хуруулжээ. Энэчлэн Гандан хийд тэргүүтэн хийд орон байгуулах, бурхан шүтээн бүтээх, хурал сургууль тогоох, ном бүтээл тууурвих зэргээр шашин амьтны тусыг агуу ихээр зохиожээ. Чингээд их Богд бээр 7 дугаар жарны шороон гахай жил (1419) шашин, амьтны тусын тулд дүрс лагшинаа хураах ёсыг үзүүлж жанч хальжээ. Тэрээр буддын мэдлэг ухааны олон салбараар олон зуун зохиол, бүтээл туурвисныг 19 боть болгон эмхэтгэсэн байна.

Түүний бүтээсэн хиргүй гэгээн номын энэ мөрийг эрдэмт сайн шавь нар болох Жалцав хайдүв тэргүүтэн болон үндэслэн баригч багш дээдэс, мэргэд, сүсэгтэн олон шавь нар, хүндлэн биширэгч номч бүтээлчин зэрэг олон ардууд эдүгээ хүртэл тэтгэн дэлгэрүүлснээр зүг бүхнээ түгээмэл оршиж буй нь энэ болой.

Б. "Их бодь мөрийн зэрэг"-ийн товч агуулга

Богд Зонхава (1357-1419) бээр "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэхүү бүтээлдээ нэгэн бодьгалийг гурван төрөлхтний мөрөөр дагуулан хөтөлж бурханы хутагт хүргэх арга замыг дэлгэрүүлэн айлдсан онцлоготой. Чингэхдээ бурхан багшийн үндэслэсэн гэгээрхүйн хутагт хүрэх билиг барамидын эрхэм зарлигууд болон түүнийг залгамжлан увидас дамжлагын ээзд Майдарын гэгээн, "Замбу тивийн чимэг", "Их тэрэгчин" хэмээн алдаршсан Нагаржуна Асанга, Адиша тэргүүтэн их мэргэдийн туурвисан тааллын тайлбар, их шастар номлолоор чимэглэн энэхүү увдисаа айлджээ. Тийм учраас эл увдис гурван төрөлхтний мөр хэмээн алдаршжээ.

Богд бээр энэхүү бүтээлээ туурвих өлзий учрал бүрдэх тэр үед ямар

гайхамшигт сонин бэлэг дэмбэрэл сүндэлсэн талаар Цахар гэвшийн намтарт: "Ялангуяа Радэнгийн дээд сүм Гүнбигүн хэмээхэд тэргүүн хэвийсэн их дүр хэмээн алдаршсан, Адишагийн гэгээн лүгээ дүрс бодат Жову Адиша лугаа их адистэдэт шүтээний өмнө олон хоног залбирснаар, Бурхан багшаас Намхайжалцан ламд хүртэл үндэслэсэн зарлиг увьдастний мөрийн зэргийн үндсэн лам нарыг илт үзэв.

Ялангуяа Жову Адиша, Бром багш, Бодова, Шарава нугууд сар болтол илтүзэгдэж увдис ба даган үзүүлэх нүгүүдийг олонтаа хайрлаад, сүүлд Бром багш тэргүүтэн гурвуул Жову Адишад шингэв. Адиша бээр Богд Зонхавын тэргүүн дээр талбиж бүрүүн, Шашанд үйлийг агуу их үйлдээд бодийг бүтээх ба амьтны тусыг үйлдэх нөхрийг би үйлдсүгэй хэмээн айлдаад, үл үзэгдэх болсон тэргүүтэн гайхамшиг тэмдэг олон болов.

Тэр цагт бодь мөрийн зэргийн үндсэн лам нарын залбирал "Дээд мөрийн хаалгыг нээгч"-ийг зохиов. Энэ үеийн урьдаас Гог хэлмэрч Лэгвийшарав ламын байгуулсан Санбо хийдийн лам Гончогцүлтим ба Жадолжаны хийд Цолбугийн ширээний лам Гончогбалсан лам тэргүүтэн Түвдийн лам нар мэргэд олон нугууд бээр хэдэнтээ дуртган айлтгасан бөгөөд энэ үед их хэлмэрч Жавцогбалсан-бэр их шамдлаар айлтгасан ба Жову Адишагийн гэгээн адислах тэргүүтэн дээрхи сайн тэмдгүүд нийлсний тул бодь мөрийн зэргийг зохиосугай хэмээн айлдаад, ялгуусны сайн зарлиг бүгдийн оньсны хураангуй их тэргэний зам мэтийн журам гаргасан Нагаржуна багш ба Төрвөлгүй хутагт хоёр багшийн мөрийн журам, гурван төрөлхтний мөрийн үүднээс сайн хувьтныг бурханы хутагт удирдахын ёсыг дэлгэрэнгүйеэ номлосон их мөрийн зэргэ Ламрим чэнмо зохиов. Энэ ламрим нь ариун ном үйлдэхийг хүсэгч төгс хувьтанд гагц нүд мэт бөгөөд гурван ертөнцийн гагц наран мэт гайхамшигтайяа алдаршин дэлгэрсээр байх нь буй" хэмээсэн нь гайхамшигтай.

Чингээд гэгээрэхүйн дээд хутагт хүрэх гурван төрөлхтний мөрийг үзүүлсэн бодь мөрийн увдисын утгаас хураангуйлан өгүүлсү.

Ер Бурхан багш анхлан бодь сэтгэлийг эгүүсгэн улмаар буяныг хурааж эцэст илт туулсан бурхан хутаг олсон зэрэг эл бүгд зөвхөн хамаг амьтны тусын тулд үйлдсэн бөлгөө. Тиймээс түүний айлдсан зарлиг ном бүгдээр мөн л амьтны тус ямагтад зорьсон буюу. Тийнхүү бүтээх амьтны тус нь хоёр зүйл бөгөөд ахуй үест өндөр язгуур сайн төрлийг бүтээх ба эцэс хойдод тонилохуйн хутгийг бүтээх тустай билээ. Түүний дотроос ахуй үесийн өндөр язгуурыг бүтээхийн төлөө айлдсан ном зарлиг бүгд бага төрөлхтөн буюу бага төрөлхтөн лүгээ нийтийн номын аймагт багтана. Бага

төрөлхтнийг ухааны үүднээс гурав ялгах бөгөөд ялгамжаатай бага төрөлхтөн гэдэг энэ насны ажлыг ихэд чухалчлан хойд насны өндөр язгуур зэргийг чухалчлан түүнийг бүрдүүлэхээр хичээгч нэгэн болой.

Мөн Энэтхэгийн их бандида Жову Адиша (982-1054) "Бодь мөрийн зул" бүтээлдээ гурван төрөлхтний мөрийн мөн чанарыг тодорхойлон айлдсан буй.

Тонилохуй хутагт зовлонгоос тонилох төдийн хутаг болон хамгийг айлдагч бурханы хутаг хоёр буй ажээ. Сонсоод сонсогч (шарвака) болон Өөрөө ялгуугсадын (брадигабуддха) хөлгөнөөс эхлэн номносон зарлигласан бүгд бодит дунд төрөлхтөн буюу дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн аймагт багтана. Дунд төрөлхтөн нь хамаг орчлонгоос уйдаж түүнээс тонилох хутгийг өөрийн тусад олж үйлдсүгэй хэмээн түүнд хүрэх арга зам болсон гурван суртгаалд суралцах болой.

Хамгийг айлдагч бурханы хутгийг бүтээх арганаа судрын болон нууц тарнийн хэмээх хоёр хөлгөнөө суралцах явдал багтана. Тэрхүү хоёр хөлгөнөө их төрөлхтний мөрд суралцан судлах ном суртгаал, анхааран авах зам мөр, хослон орох арга ухаан бүхэн хураагдах аж. Их төрөлхтөн болвоос их нигүүлсэхүй сэтгэлээр эзлэгдэн хамаг амьтны зовлон зүдгүүрийн мөн чанарт болохыг болгоон үл тэсэж улмаар тэрхүү зовлонгоос гэтэлгэхээр хамаг амьтны тусад бурханы хутаг олохоор судар тарнийн их зам мөрд суралцагч бас басхүү тэр зам мөрийг илт туулан төгссөн дээдэс мэргэд бөлгөө.

Нэг. Бага төрөлхтөн болон түүн лүгээ нийтийн мөрд суралцах :

Энэ үед үзүүлэх бага төрөлхтөн энэ насны ажлыг төдийлэн чухалчлах бус харин хойд насны өндөр язгуур буюу хойд насандаа сайн заяанд төрөх арга ухаанаа эрхэмлэн суралцагч нэгэн билээ. Тэрээр хойд төрөлдөө сайн заяанд очихын тулд эдүгээгээс эхлэн дараах бага төрөлхтөн болон бага төрөлхтөн лүгээ нийтийн мөр эрдэмд суралцаж тэдгээрээр оюунаа боловсруулах хэрэгтэй аж. Тэрхүү мөрд анхааран авах орныг дараах байдлаар Богд лам болгоожээ. Үүнд:

1. *Бодь мөрийн үндэс -Буяны садныг шүтэх*
2. *Чөлөө учралыг санах*
3. *Мөнх бусыг санах*

4. *Муу заяаны зовлонг санах*
5. *Аврал одуулах*
6. *Үйлийн үрийг санах эдгээр болой.*

Гэхдээ эдгээрээс эхний хоёр бодол нь дараа зэрэгчлэн бясалгах мөр бүхний өмнө зайлшгүй мөрдөгдөх бясалгал учраас удиртгал мөрд багтаан айлдсан байна.

Хоёр. Дунд төрөлхтний мөр ба түүн лүгээ нийтийн мөрд суралцах:

Дээрх бага төрөлхтний мөрийг анхааран авч суралцаж ухаарсны дараа дунд мөрийн эрдэм ухаанд суралцах нөхцөл бүрдэнэ. Энэ үед зөвхөн хойд төрлийн сайн заяаг олох гэж бодож байсан бодол зорилго өөрчлөгдөх буюу ер орчлонгийг ямар ч өндөр язгуур сайн төрөлд төрлөө аанай л эдлэх зовлон ав адилхан болохыг мэдэрч хорвоогийн амгалан сайн сайханд шунах сэтгэл буцаж ерөөс зовлонгүй амар жаргалтай байх тийм тонилохуй хутагийг (нирваан) эрэх хайх бодол засваргүй үнэнээр төрөх болно. Товчлон хэлбэл дунд төрөлхтөн бол өөрийн тусад нирваан хутгийг эгээрэгч болой.

Энэ үед хорвоог зовлонгийн мөн чанарт сайтар ухаарч түүнээс гарах арга замыг чухалчлах болно. Тийнхүү дунд төрөлхтний тонилохуй хутгийг бүтээх арга болгож "хутагтын дөрвөн үнэн"–ийг авч орхихуйн орон болгож бясалгадаг аж. Дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийг дараах үндсэн хоёр агуулгад багтаажээ. Үүнд:

1. *Бүхэн гарах зүг (орхих зүг) болон*
2. *Тийн амарлих зүг (авах зүг)-ийг нотлон буулгах.*

1. *Бүхэн гарахуйн зүг буюу орхих зүгт:*
   а. *"Зовлонгийн үнэн"–хорвоогийн гэмийг санах*
   б. *"Бүхэн гарахуйн үнэн"-хорвоод төрөхийн зэргийг санах (Мөн арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санах)*
2. *Тийн амарлих буюу авахын зүгт:*
   а. *"Хорихуйн үнэн"- тонилохуйн хутгийг олох ёсыг санах*
   б. *"Мөрийн үнэн"- гурван суртгаалд суралцах ёсон эдгээр болой.*

Гурав. Их төрөлхтний мөрд суралцах:

Чингэж бага болон дунд төрөлхтний мөрд суралцсаар ухааны хүч чадал улам дээш боловсорч ирнэ. Түүний гэрч нь үүнээс урьд зөвхөн өөрийн сайн сайхан тусын тулд өндөр дээд язгуур эсвээс нирваан хутгийг олсу гэж байсан бодол өдгөө өөрчлөгдөж тэр төдийхнийг чухалчлан явснаар бусдын тус байтугай өөрийн тус хэргээ ч бүтээж чадахгүй гэдгээ ухаарна.

Зөвхөн өөрийн тусыг чухалчлах төдийгээр сайн үр дүнд хүрэхгүйг лавтай ухаарах нь их төрөлхтний мөрд суралцах нэгэн нөхцөл болно. Үүний дээр ганцхан өөрөө зовох бус надтай адил энэ хорвоогийн хамаг амьтан зовлонгийн хүлээсэнд хүлэгдэн зовох жамыг ухааран хамаг амьтныг энэрэн нигүүлсэж хайрлах сэтгэл хамт төрсөн байх хэрэгтэй аж. Чингэж эдгээр нөхцлүүд бүрдсэний дараа их нигүүлсэхүй сэтгэлийн эрхэнд орсон бодьгаль эх болсон хамаг амьтныг зовлонгоос гаргахын тулд хамгийг болшоогч бурханы хутгийг олсу хэмээх эрхэм дээд зорилго бүхий бодь сэтгэлийг эгүүсгэснээр их төрөлхтний үүдээр орно хэмээжээ.

Их төрөлхтний анхааран авах мөрийг дараах эрдмийн ёсоор нотлон буулгажээ. Их хөлгөнөө суралцах ёсыг товчоолвоос:

а. Их хөлгөнөө орохуйн үүд – бодь сэтгэлийг эгүүсгэх

б. Бодисадвын явдалд суралцах ёсон

б. Бодисадвын явдалд суралцах ёсноо:

1. Их хөлгөнөө нийтэд суралцах ёсон

2. Ялангуяа нууц тарнийн хөлгөнөө суралцах болой.

1. Их хөлгөнөө нийтэд суралцах ёсонд

/а/ Өөрийн үндсийг боловсруулах "зургаан чинад хүрэхүйд" суралцах ба

/б/ Бусдын үндсийг боловсруулах "дөрвөн хураангуйд" суралцана.

Тусгайлан сүүлийн хоёр чанад хүрэхүйд суралцах ёсонд Амарлингуй сэтгэл болон Үлэмж үзэхүй хоёр болой. Эдгээрийн дараа нууц тарнийн хөлгөнөө орж суралцах бөгөөд энд өөрийн биеийг бурханы лагшинтай ялгалгүй болгож бясалгах "Эгүүсгэхийн зэрэг "болон өөрийн ухааныг бурханы таалал болгож бясалгах маш гүн нарийн егүзэр болох "Төгсгөхүйн зэрэг" нууц тарнийн мөрүүдэд шамдах болно. Гэхдээ нууц тарнийн ёс дээрх судрын ёсноос илүү нарийн гүн гүнзгий мөр тул дээрх ёсноос илүү чанд ёс суртахуун, дээд бодь сэтгэл, гүн нарийн оюун ухааныг

сав болсон цагт энэ суралцах үндэс бүрддэг байна.

Ийнхүү гурван төрөлхтний мөр хэмээх гэгээрэхүйн хутагт хүрэх энэ увдис нь хэдийгээр "гурван мөр" гэж үзүүлсэн боловч чухамдаа нэг л хүний ухааны мөрийг эгэл энгийн түвшингээс дээш дээш ахиулан хөгжүүлсээр оюун ухааны эрхэм дээд түвшинд хүргэх буюу бурханы хутаг олох нэг л замд хөтөлжээ. Чингэж гурван мөрөөр дагуулсан учир нь хөтлүүлэгч шавийн ухааны чадалд харгалзуулсан аж.

Их хөлгөний мөрд бага дунд болон нийтийн мөрүүд гишүүн болж багтах бөгөөд эцсийн зорилго, хүрэх газар бол зөвхөн гагц "хамгийг болгоогчийн хутаг" буюу "үл хөдлөх нирваан хутаг" ажээ. Хураангуйлан хэлвээс, "Их бодь мөрийн зэрэг" болвоос бурхан багшийн үндэслэн айлдсан бодь хутаг буюу гэгээрэхүйн хутагт хүрэх арга зам, билиг ухаан бүхнийг хүмүүний оюуныг боловсруулах гурван үе шатаар дамжуулан судалж шинжлэх нэг мөрд нэгтгэсэн, оюун ухааны өндөр хөгжлиийн мөн чанарыг арга билгийн үүднээс нотлон буулгасан судар тарнийн онол, бясалгалын их эрдмийг цогцлоосон оюуны охь шим бүтээлийн нэг бөлгөө.

В. Бодь мөрийн зэрэг ба Монголчуудын бүтээл

Богд Зонхава "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэхүү их бүтээлээ эдүгээгээс зургаан зууны өмнө туурвисан хэдий ч Цаст Түвдийн орноос эх авсан түүний номын цагаан буяны их мөрөн өдгөө хүртэл үргэлжлэн зөвхөн Цаст Түвдөд төдийгүй энэ Замбу тивийн олон улс орны хүн ардын сэтгэл санаа, оюун ухааныг дээшитгэн тэтгэх нэгэн их ундрага болон иржээ.

Үүний нэгэн гэрч нь зөвхөн энэ бүтээлийн талаар Цаст Түвдийн болоод бусад улс орны цаг цагийн их мэргэд дээдсийн туурвиж бүтээсэн олон зуун бүтээлүүд хэдийгээр он цагийн эрхээр бүрэн хадгалагдаж ирээгүй ч өдгөө болтол уламжлагдан аман хөтөлбөр, судар бичиг, сургалт боловсролоор дамжин иржээ. Мөн олон хэл дээр орчуулагдаж, судалгаа шинжилгээний эргэлтэнд орж, дэлхийн олон орны эрдэмтэн мэргэд болон соёлт хүн төрөлхтний анхааран авах эрдмийн орны нэгэн болж чаджээ.

Монголчууд энэ бүтээлтэй бараг зохиогдсон тэр цагаас эхлэн танилцаж сэтгэл оюун юугаа гэгээрүүлэх увдис болгож ахуй амьдрал, ёс суртахуун, хүмүүжил боловсролдоо хэрэглэх гарын авлага зэргээр авч хэрэглэсэн төдийгүй уг увдисыг улам гүнзгийрүүлэн судалж нарийн утга учрыг дэлгэрүүлэн элдэв эш үндэс, учир шалтгаан, амьдрал ахуйн бодит

жишээ зэргээр улам баяжуулсан бодь мөрийн ухааныг олон талаас шинжиж тайлбарласан бодь мөрийн зэргийн "Хөтөлбөр бичиг", "Анхааран авах бясалгал", "Элдэв үлгэр домог", "Түүх гарвал", "Тэмдэглэл", "Зүүлт тайлбар", "Үг утгын тайлбар", "Гүн дэлгэр номлол" болон бүр ном хаялцах арга ухааны үүднээс тайлбарлсан "Эцсийн шинжлэл" гэх зэрэг олон хэлбэрийн бүтээлийг монголчууд бидний ухаантан өтгөс дээдэс туурвиж үлдээжээ.

Америкийн эрдэмтэн судлаач Роберт А.Ф.Турмэн бээр "Их бодь мөрийн зэрэг зохиогдсон зургаан зуу шахам жилийн турш түүнийг чухалчлан суралцагч нар нь голдуу Түвд болон Монголчууд байжээ" [5] гэж тэмдэглэсэн нь нэгийг өгүүлнэ. Монголын эрдэмтэн мэргэд Зонхав богдын олон бүтээл зарлигийг шимтэн суралцаж оюун ухаанаа гэгээрүүлэх нэгэн сурвалж болгож ирсний нэг нь энэ бүтээл билээ. Монголчуудын туурвисан Бодь мөрийн зэргийн бүтээлүүд олон боловч цагийн эрхээр бүрэн уламжилж ирээгүй байна.

Энд зарим нэгэн бүтээлийг дурдваас: [6] Хүрээний их хамба Агваанхайдүвийн "Бодь мөрийн зэрэг-амгалант мөрийн увдис" (byan chub lam gyi rim bei bde lam gei), Сүмбэ хамба Ишбалжирын "Бодь мөрийн зэргийн дөт мөр" (lam rim byan chub nye lam), Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн "Мөрийн зэргийн хөтөлбөр-Ухааны харанхуйг арилгагч" (lam rim gyi khred blo yei mun sel), Цорж Агваанцэрэнгийн "Судар тарнийн нийтийн мөрийн зэргийг бясалгах ёсон-Сэтгэлийн шимийг баригч" (mdo sngags tun mon gei lam gyei rimba skhong tshul yed kyei bcud len), Цахар гэвш Лувсанцүлтимийн "Мөрийн зэргийн дөрвөн эрдмийн номнол" (lam rim cheba bzhe yi rnam bzhag bshad pa), Цэмбэл гүүшийн "Их бодь мөрийн зэргийн таалал утгыг тодорхой үзүүлэхүй" (lam rim chen moi dgongs don gsalbar bsdan pa), Угалзын лам Лувсанжамцын "Бодь мөрийн зэргийг анхааран авахуйг шүлэглэсэн шид бүтээлийг татагч" (byanchub lam gyi rim bei nyams len tshegs bcad ma dngos grub ngagug byed), Чойнзод ламын "Бодь мөрийн зэрэгт оюунаа судлахуй-Хамгийг болгоогчийн сайн мөр" (byan chub lam gyi rimkala blo sbyon tshul gun mkhyen lam bsang), Сайн ханы Лувсандорж гавжын "Бодь мөрийн зэргийн эцсийн шинжлэл-Эрхэм зарлигийн далайд орох хөлөг онгоц" (byan chub lam gei rim bei mtha'a dpyod gsung rab rgya mtshor ajug bei gru khzings), Бари лам Дамцигдоржийн "Бодь мөрийн зэргийн хөтөлбөр-Тус амгалангийн сайн мөр" (byan chub lam gyi rim bei khred yeid), Оргиочийн лам Лувсанбалдангийн "Бодь мөрийн зэргийн зүрхэн оньс бүхнийг хураангуйланургуулсан бясалгахын ёсон-

[5] *The Great Treatise of the Stages to the part of the Enlightenment, 2000 USA 15-р тал*

[6] *С.Гомбожав "Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл" 1959 УБ*

Ялгуусаны сайн мөр" (byan chub lam gyi rim bei snyin po gnad kun bsdus nai shar sgom bya tshul rgyal bei lam sang), Жалханз хутагт Дамдинбазарын "Мөрийн үндэс-Буяны садны аймаг" (lam gyi rtsaba bshes gnyin bsden tshul gyi skor), Нанзаддорж аграмбын "Их бага мөрийн зэргийн тэмдэглэл" (lam rim che chung spyei zin bris), Баарин Дарамдалагийн "Их бодь мөрийн зэрэгт чухал ишлэгдсэн эртний үлгэрүүдийг нэгтгэн эмхэтгэсэн чухал хэрэгтэй үлгэр туужийн хотол хураангуй" (byan chub lam rim chen mola nye bar mko bei sngon abyung gei dbe rnams phogs geig tu bsdus ba gdam rgyud nyer mkho gun btus), Эрэн хамбын "Бодь мөрийн зэргийн үлгэрүүд" (lam rim dbe – chos), Халхын засаг Энхдэлгэрэнгүйн зохиосон "Бодь мөрийн зэргийн анхааран авахуйн үг утгыг тодорхой өгүүлэгч" гэх зэрэг олон арван бүтээлүүд байна.

Эл бүтээлийг Монголчууд өөрийн эх хэл дээрээ XY-XYI зууны үеэс орчуулж хэрэглэж ирсэн бөгөөд гар бичмэл болон модон бард сийлэн Их хүрээ, Бээжин, Буриад газар орноо хэвлэн олон нийтэд түгээж байжээ. Энэхүү Бодь мөрийн зэргийн уламжлалт сайхан монгол орчуулгын талаар гадаад орны эрдэмтэн судлаачид тухайлбал Германы нэрт эрдэмтэн В.Хэйссиг, Энэтхэгийн эрдэмтэн Локеш Чандра нар тусгайлан судалгааны бүтээл туурвисан байна. ⑦

Эдүгээ цагийн Монголын эрдэмтэн судлаач нар өвөг дээдсээс уламжлан ирсэн энэхүү номын цагаан буяныг үргэлжлүүлэн орчин цагийн эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулж, хэл шинжлэл, түүх гарвал, гүн ухаан зэрэг олон талаас шинжлэн судалж байна. Эл бүтээлийн талаар академич Д.Цэрэнсодном, академич Д.Дагвадорж, доктор профессор Чой.Лувсанжав, доктор Д.Ёндон, доктор, гавж Ш.Сонинбаяр, доктор Ж.Тэрбиш болон зохиолч яруу найрагч О.Дашбалбар, эрдэм шинжилгээний ажилтан Б.Мягмарсүрэн, С.Баянцагаан, Т.Цэндсүрэн нарын зэрэг орчин цагийн монголын олон арван эрдэмтэн судлаач нар зохиол бүтээлээ туурвисан байна.

Монголчууд Цастын орны номын мэргэд сайчуудтай эртнээс эрдэм соёлын эрхэм сайхан баридлага харилцаатай ирсэн бөгөөд Зонхава богд хэмээх эрдэмтэй нэгэн Цастын орноо мэндэлж эрдэмд гарамгай болсныг дуулж түүнтэй ном эрдмийн харилцаа тогтоохоор сайн ерөөл талбиж, заллага айлтгаж байсан түүхтэй. Өлзий орших болтугай.

Шашны Их Сургуулийн багш, гавж Намнан овогт Түмээхүүгийн Булган

⑦ *W.Heissig "On the Mongolian translation of the Lam-rim chenmo" (Wiesbaden 1954) and "Byryat Annonations on Lam-rim" (New Delhi 1973) by Lokish Chandra*

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ ОРШВОЙ

Удиртгал бүлэг

Багш Манзушир бурханаа мөргөмү.[1]

Сая живаа сайн буян хотол чуулж мэндэлсэн лагшинт
Саршгүй олон амьтны эгээрлийг хангагч зарлигт
Сац хамаг мэдэгдэхүүнийг ёсчлон болгоосон таалалт
Сартваахь Шагжа язгуурын Эрхэм танаа тэргүүн юүгээр мөргөмү [2]

Ханьцашгүй багш таны шавийн манлай
Хамгийг болгоогчийн зохионгуй бүхнийг үүрэгч
Хэмжээлшгүй олон ертөнцөд хувилан сайтар бүжигч
Хүндлэлт Майдар, Манзушир танаа мөргөмү [3]

Машид онохуйяа бэрх "Ялгуугсадын эх" судрын утгыг
Магадтай болгоон тайлбарлагч - Замбуу тивийн чимэг [4]
Хутагт Нагаржуна, Асанга хэмээн гурван газраа
Хотол алдаршсан та бүгдийн өлмий дор мөргөмү

Их тэрэгчин хоёроос сайтар дамжин ирсэн
Энгүй гүн үзэл, агуу их явдал мөрийн
Эндүүрэггүй төгөлдөр шимийг хураасан
Эх увдисын хүү санг баригч Цогт Адиша танаа мөргөмү [5]

Энгүй уужим эрхэм зарлиг бүхнийг харагч нүд
Эрхэм хувь сайт нирваанд зорчих олмын дээд
Энэрэнгүй явдал, мэргэн арга ухаанаар
Эгнэгт гэгээрүүлэгч - буяны садан бүхнээ биширэн мөргөмү [6]

Одоо цагт егүзэрт хичээгч нарын сонсох бага,
Олныг сонсовч анхааран авч шим болгож ухаарсан нь үгүй
Олонхи нь эрхэм зарлигийг алагчаалахуйн нүдээр үзэж
Онч номын утгыг ухаанаар ялгахын чадалгүй болсон тул

Эрхэм номын аньс бүхэн төгс бүрэлдсэн дээд увдис
Энгүй мэргэд баясахын мөр лүгээ хагацсаныг үзээд
Их тэрэгчний энэ замыг номнохуй яа
Эгэл миний сэтгэлд дүүрэн баяр төрмүй зэ

Аливаа хязгаарыг баримтлах харанхуйд үл хөлхөгдөн
Авир сайн муут ялгагч оюуны чадал төгөлдөр болоод

Ахуй чөлөө учралт сайн шүтээнээ ач туст болгохоор хичээгч
Асар хувь төгөлдөр тэд бүхэн нэгэн үзүүрт сэтгэлээр анхааран сонсогтун

Ялгуусан бурханы эрхэм зарлиг бүгдийн хураангуй аньс, их тэрэгчин Нагаржуна, Асанга хоёрын гаргасан зам журам, хамгийг болгоогчийн газраа зорчих дээд төрөлхтний номын ёсон, гурван төрөлхтний анхааран авах эрэмбэ мөрийн зэрэг бүгдийн хоцролгүй товчоон - Бодь мөрийн зэргийн үүднээс хувь төгөлдөр амьтныг бурханы газраа хөтлөх увидас алин бүхэн энд номнох ном болой.

Цогт Налиндарын хийдийн мэргэд нараас "багшийн хэл ариун, шавийн үндэс ариун, номнох ном ариун" хэмээх гурван ариуны үүднээс ном номнохыг таалсан байдаг. Мөн хожмын цагт "Брэ Камалашила"-д дээдийн ном дэлгэрснээр тэндхийн мэргэд бээр ном зохиогчийн эрдэм, номын эрдэм, түүнийг хэрхэн номнох, сонсохын ёс гурвыг урьд нь одуулвал их чухал хэмээн болгоожээ. Ихэд алдаршсан энэхүү хоёр ёсноос удаахыг дагаж номнож үйлдмү.

Тийнхүү бодь мөрийн зэргээр хөтлөхөд дөрвөн зүйл:

I. Номын үндэс ариуныг үзүүлэхийн тухайд зохиогчийн эрдмийг үзүүлэх
II. Увидаст бишрэл төрүүлэхийн тухайд номын эрдмийг үзүүлэх
III. Хоёр эрдэм төгөлдөр номыг хэрхэн сонсох болон номнох ёсон
IV. Бодит увидасаар шавийг хөтлөхийн зэрэг болой.

I. Зохиогчийн (Адиша богд) эрдэм

Энд үзүүлэх ерөнхий увидас болвоос Майдарын гэгээний зохиосон "Илт онохуйн чимэг" [7] болой. Чухамхүү энэ үесийн гол ном бол "Бодь мөрийн зул" [8] билээ. Тийм учраас үүнийг зохиогч нь эдгээрийг зохиогч болой. Тэрээр их багш Дивангарашризана буюу Цогт Адиша хэмээн даяар алдаршжээ.

Түүний эрдмийг гурван зүйлээр өгүүлэх нь:

А. Хотол чуулсан язгуурт мэндэлсэн ёсон
Б. Тэрхүү бие шүтээн дээр эрдмийг эрхшээсэн ёсон
В. Эрдмийг эрхшээн шашнаа тусыг зохиосон болой

1.Хотол чуулсан язгуурт мэндэлсэн ёсон:

Их дуун хөрвүүлэгч Нагцоон зохиосон *“Наян шүлэгт магтаал”* [9]-д:

Дорно зүгийн Сахорын дээд газар
Түүнээ нэгэн их гүрэн буй
Бигрманибура хэмээх буюу
Түүний нийслэлд асар том хааны орд харш буй

Түүнийг “Алтан дуазт” хэмээх буюу
Эрх дарх, эд баялаг төгс эдлэл зэрэг нь
Хар хятадын Донхун хаан лугаа адил,
Тэр гүрний хаан нь Гивабал,

Түүний хатан Балму Одсэржан хэмээх
Хаан хатан хоёр гурван хөвгүүнийг эрхшээсэн,
Бадманинбу (Бадмаанямбуу) болоод Давининбу (Даваанямбуу),
Балжининбу (Балжиннямбуу) хэмээх гурав болой

Хааны хөвгүүн Бадманинбу нь
Таван хатан, есөн хөвгүүнтэй аж
Хөвгүүний ууган нь Содномбал
Эдүгээ их мэргэн Данашири хэмээн алдаршжээ

Бага хөвгүүн Балжининбу нь
Гэлон (аяга тахимлаг) Бирузандра болой
Дунд хөвгүүн Давининбу болвоос
Эдүгээ миний тойн богд багш мөн хэмээн айлдсан мэт болой.

Б. Эрдмийг эрхшээсэн ёсноо хоёр:

1. Олныг болгоох эшийн эрдэмд сурсан ёсон
2. Ёсчлон бүтээх онолын эрдэмд сурсан ёсон

1. Эшийн эрдэмд сурсан ёсон: *“Магтаал”*-аас:

Хорин нэгэн сүүдэртэй байхдаа
Ид хавын жаран дөрвөн эрдэм ба
Урлахуйн ухааны хамаг орон болон
Сайтар найруулсан хэл болоод
Шалгадаг ухаан бүхнээ мэргэшсэн мөн хэмээн айлдсан мэтээр

Хорин нэгэн сүүдрийн дотор гадаад, дотоод нийтийн ухааны орон болох дуун ухаан, учир шалтгааны ухаан, урлахуйн ухаан, тэжээхүйн ухаан хэмээх дөрвөн эрдмийн орноо суралцан боловсорч мэргэдийн манлай болжээ.

Ялангуяа арван таван сүүдэр тухайлахын үед "Язгуурын дусал" [10] хэмээх шастарыг ганц удаа сонсоод хашир мэргэн гэж алдаршсан тэрсүүд нэгэнтэй ном хаялцан ялан дийлснээр яруу алдар хотол даяар улам дэлгэрсэн болой" хэмээн Долунба мэргэн айлджээ.

Чингээд Хар уулын сүмд морилох зуур Егүзэрийн эрх баялагт, Цогт Жидор (Хэважра) бурханы нигуурыг болгоогч, Очирт дагинасаас эш бошгийг олсон Рахулагувда багшаас төгс төгөлдөр авшиг буюу нууц тарнийн номын эрхийг олж Ишсанвидорж хэмээх нууцын алдрыг хүртжээ. Хорин есөн сүүдрийн дотор шид бүтээлийг олсон олон багшийн мэлмийн өмнө Очирт хөлгөнөө суралцсаар хамаг эрхэм гол ном, увдис бүхнээ мэргэн нэгэн болов. Гэвч нэгэн удаа "нууц тарнийн номд би гагцаар мэргэн болов" хэмээх бодол ургаж гэнэ. Гэтэл дагинас нар урьд өмнө хэзээ ч үзээгүй, сонсоогүй олон номыг зүүдэнд үзүүлсэнд таалал нь мохож нөгөө бодол нь арилсан гэдэг.

Багш нар болон ядам бурхад илт болон зүүд аль нэгэнд үзэгдэж ирээд "тойн хувраг болвоос шашин амьтанд агуу их тустай болно" хэмээн айлтгасан ажээ. "*Магтаал*"-аас:

Таны багш тань
Найрлагын мөрийг эрхшээгч хэмээн
Олонд ихэд алдаршсан нэгэн

хэмээсэн адилаар, Палчэнгийн аймгийн Их батад агч, Винайг баригч Шиларагчида хэмээх найрлагын мөрд оршигч, зөвхөн хоосон чанарын бясалгалыг эрхшээгч нэгнийг багшид шүтэж, тойн хувраг болжээ. "Бал Мармэ зод иш" буюу "Цогт билгэ билгүүний зулыг баригч" хэмээн алдаршив.

Гучин нэгэн сүүдэр хүртэл бэлэг чанарын хөлгөн буюу дотоод ухааны дээд, доод аймаг савын ном эрдэмд суралцан боловсорчээ. Ялангуяа "Одандабүри" хэмээх газар арван хоёр жилийн турш Дхармарагчида багшаар "Өвөрмөц их номлол" хэмээх номыг хөтлүүлж заалгавай.

"Язгуурын дөрвөн аймгийн ном"-д машид мэргэшиж, аймаг тус тусын зөвшөөрөх, эс зөвшөөрөх тэргүүтэн авч орхих ёсны нарийн ялгалыг хоорондоо нь холилдуулалгүй болгоожээ. Тэр мэтээр өвөр бусдын аймгийн тогтсон тааллын далайн чанадад хүрснээр эш номын хамаг аньс бүхнийг эндүүрэлгүй таалалдаа багтаасан болой.

2. Ёсчлон бүтээх онолын эрдэмд сурсан ёсон :

Ер бурханы эшийн ном бүгдээр их эрдэнийн гурван аймаг савд хураагдах учраас онолын ном ч бүгдээр их эрдэнийн гурван суртгаалд багтах бөлгөө. Тэдгээрээс ёс суртахууны суртгаал нь бясалгалын болон билгийн суртгаал зэрэг бусад эрдэм бүгдийн суурь шүтээн мөн хэмээн эрхэм зарлиг болон тааллын тайлбар сэлтээс олонтаа сайшаасан буй.

Иймээс эхлээд ёс суртахууны суртгаалд суурилсан онолын эрдэм төгөлдөр байх шаардлагатай.

а: Ёс суртахууны суртгаалд гурван зүйл:

1) Тус тус гэтэлгэгчийн санваар төгөлдөр асан талаар
2) Боди садвын санваар төгөлдөр асан талаар
3) Очирт хөлгөний санваар төгөлдөр асан талаар болой.

1) Тус тус гэтэлгэгчийн санваар төгөлдөр талаар "*Магтаал*"-д:

Та, Сонсоод сонсогчийн хөлгөний үүднээ ороод
Савгаа хайрлах сарлаг адил ёс журмаа сахиж
Ариун явдалт цог төгөлдөр аяга тахимлагийн дээд
Архад, винайг баригчийн мөр дор мөргөмү хэмээн айлдсан мэт.

Хэдий ганц ширхэг саваг нь (сүүлний хялгас) модонд торж орооцолдоход анчин ирээд амийг хөнөөх гэж байсан ч ширхэг савгаа таслахгүй амиараа дэнчин тавин савгаа хайрлах сарлаг адил аяга тахимлагийн санваар хүртээд ам авсан ширхэг тангараг бүхнийг сахидаг байсан учир ам авсан суртгаалын их суурь дээр хэрхэснийг хэлээд яахав. [11] Суртгаалын нарийн суурь өчүүхэн ганц нэгийг хүртэл амь лугаа тэнцүүлэн сахиснаар, их архад, винайг баригч болсон болой хэмээн магтсан тэр мэт болой.

2) Бодисадвын санваар төгөлдөр асан талаар: *"Магтаал"*-д:

Чанад хүрэхүйн (барамид) аймагт ороод та
Үлэмж сэтгэл тань асар ариусан гэгээрч
Бодь сэтгэлээр амьтан бүхнийг үргэлж болгоов
Ухаан төгс, нигүүлсэхүй сэтгэлт танаа мөргөмү хэмээсэн адил бөлгөө.

Асрахуй, нигүүлсэхүй сэтгэлийн үндэст- бодь сэтгэлийг төрүүлэх олон увдис ялангуяа Сэрлинба багшийг шүтэж байгаад Майдар, Манзушир бурханаас Асанга, Шантидэва нараар уламжлагдан ирсэн эрхэм дээд увдиснаа үргэлжид суралцжээ.

Энэ талаар *"Магтаал"*-д:

Өөрийн тусыг ясал орхиж бусдын тусыг
Ая зөндөө зохиогч тэр болвоос миний багш буюу

хэмээн айлдсан мэтээр өөрөөсөө илүү бусдыг энхрийлэх бодь сэтгэлийг таалалдаа мэндлүүлжээ.

Ийнхүү ерөөхүй бодь сэтгэлээс мэндэлсэн орохуйн бодь сэтгэл хийгээд бодисадвын агуу их явдалд суралцаж ам авсан тангараг суртгаал бүхнээ чандлан сахиж сайн явдалт бодисадвын цаазын хязгаараас үл хэтрүүлэн зохиожээ.

3) Очирт хөлгөний тангараг төгөлдөр асан талаар "*Магтаал*"-д:

Очирт хөлгөний үүдээр орсон та бээр
Өөрийгөө бурханд үзэх болон очирт тааллыг төгс болгоов
Егүзэрийн эрх баялагт Авадүдэва болон
Байви зэргийн заншил ёсыг барин зохиосноо мөргөмү

хэмээн айлдсан мэтээр өөрийн биеийг бурхан гэж үзэх "эгүүсгэхийн зэрэг" болон очирын таалал хэмээх "төгсгөлийн зэрэг"-ийн бясалгал самадийн эрдмийн дээд зэрэгт хүрсэн учраас "егүзэрийн эрхэм" хэмээн сайшаагджээ.

Нэн ялангуяа цаазын хязгаараас хэтрэлгүй тангарагийг ёсчлон

сахисан талаар "*Магтаал*"-д:

Санан дурдах ба ухамсар бат бээр
Санах, ухамсарлах ухаан төгөлдөр болж
Ёс бусын суртахуунд санаа үл урвуулав
Элдэв арга зальгүй, сэрэмжлэх санахын ухаантай тул
Уналын хир халдаагаагүй билээ Та хэмээн айлдсан мэт болой.

Ийнхүү гурван санваарын суртгаалд ам аван тангараг тавихдаа эрэлхэг баатрын дүрээр бус хэрхэн ам авсан дагуу явж цаазын хязгаараас хэтрүүлэлгүй сахин зохиожээ. Хааяа өчүүхэн төдий алдаа нэгэн гарваас түргэнээс түргэн өөр өөрийн жич заслын зан үйлээр ариусган зохиосон амой.

Энэ адилын үйлс зохиолууд нь эрхэм зарлигийн увдисыг ухаарагч нарын баяслыг төрүүлэх намтар зохиол мөн хэмээн мэдээд дээдсийг даган суралцаарай.

б. Бясалгалын суртгаал төгөлдөр асан ёсноо хоёр зүйл буй.

1) *Нийтийн ёсноо бясалгалын суртгаал төгөлдөр асан нь*: Нийтийн ёсноо амарлингуй сэтгэлийн үүднээс сэтгэлээ эдлэх чадлыг эрхшээсэн байна.

2) *Нийт бусын ёсоо бясалгалын суртгаал төгөлдөр асан нь*: Нийт бусын бясалгалын суртгаал болох "эгүүсгэх зэрэг"-ийг машид баттай эрхшээсэн ажээ.

Улмаар тарнийн ёсны явдлыг зургаан жил, мөн гурван жилээр зохиожээ. Тэр цагт Үржан Хандын орны дагинасын дуу эгшгийг сонсож таалалдаа болгоож байсан гэдэг.

в. Билгийн суртгаал төгөлдөр асан талаар

1) *Нийтийн ёсноо* амарлингуй үзэхүй хоёрыг хослон барилдуулсан үлэмж үзэхүйн бясалгалыг эрхшээсэн ажээ.

2) *Нийт бусын ёсноо* төгсгөлийн зэргийн ялгавартай бясалгал эрдмийг эрхшээжээ. "*Магтаал*"-аас:

Нууц тарнийн номын ёсоор бол найрлагын мөрт болох нь тодорхой

хэмээн айлдсан мэт болой.

В. Шашнаа тус зохиосон ёсноо хоёр:

1. *Энэтхэгт (Хутагтын орон) зохиосон ёсон*
2. *Төвдөд (Цастын орон) зохиосон ёсон*

1. Энэтхэгт зохиосон ёсон

"Цогт Очирт суудал" хэмээх их бодь суваргын дэргэд буруу өгүүлэгч тэрсүүд нарыг гурван удаа номоор ялан дийлж бурханы шашин номыг хамгаалжээ.

Өөрийн аймгийн дээд, доод номын ёсноо гарсан үл онох, буруу онох, эргэлзэх доноголзох зэргийн муу хир бүхнийг арилгаж шашин номыг дээшитгэн зохиожээ. Иймийн учир аймаг бүгдээр ялгалгүй оройн шүтээнд өргөн хүндэлсэн аж. *"Магтаал"*-д:

Их бодь суврагын дэргэд
Хотлоор хуран цуглахад
Өвөр бусдын хамаг аймгийн дотор
Буруу тогтсон таалаар эсэргэлдэгч бүхнээ

Арслангийн хүрхрэх дууг дуурсган
Тэр бүгдийн тархийг хатаавай хэмээсэн ба
Одандабүри хэмээх сүмд
Зуугийн хагастай гурван зуун хувраг

Брэкамалашила хэмээх хийдэд
Зуу шахам хувраг тойдыг
Язгуурын дөрвөн аймаг болгон бүрдүүлэв
Аймгийн дээрэнгүй омгийг та үл таалав

Магада хэмээх орон газрын
Дөрвөн аймаг бүхнээ
Бурханы дөрвөн нөхөр
Хотол олны оройн зэндмэни болов

Та бээр хамаг арван найман аймгийн
Оройн шүтээн болсон учир
Хамаг бүгдээр эш зарлигийг дагав хэмээн айлдсан мэт болой.

2 .Төвдөд зохиосон ёсон:

Лхалама Хувон тэргүүтэн (Төвдийн хаадууд) бээр Дуун хөрвүүлэгч Жазон Сэнгэ, Нагцо Цүлтэм жалба нарыг даpаалан Энэтхэгт илгээх зэргээр ихэд хичээн шамдаж дахин дахин урин заллага айлтгаснаар Жанчүв Од хааны үед Атиша богд заларчээ. [12]

Тэрээр (Төвдийн) Ари дод буюу дээд Ари хэмээх газар морилоход "Дээдийн номыг тэтгэн зохиогтүн" хэмээн соёрхол талбиснаар судар тарнийн аньс бүхнийг нэгтгэн, анхааран бясалгахын мөрд жигдрүүлсэн гол ном болсон "Бодь мөрийн зул" зэргийг туурвихын үүднээс бурханы номыг дэлгэрүүлэн зохиовой.

Тэрээр Арид гурван жил, Нитанд есөн жил, Үйзан болон бусад газраа таван жилийн турш хувь төгөлдөр шавь нарт судар тарнийн ном увдис бүгдийг зааж, балархай болсон номын ёсыг шинээр байгуулж, өчүүхэн төдий байсан ёсыг арвижуулж, буруу оносны хирээр бүрхэгдсэн ёсыг сайтар цэвэрлэн их эрдэнийн дээдийн номын ёсыг хир буртгаас арилган зохиожээ.

Цастын орноо бурханы ном анх дэлгэрэх үед Балдан Шивацо болон Ловон Бадамсамбава нарын гаргасан ёсон эхэлж үүссэн билээ. Энэ үест хоосон чанарыг ухаарах аньсыг олоогүйгээс үүдэн аргын талыг хэт басамжлах явдал гарч байв.

Сэтгэлд ургасан атхаг сэжиг бүхнийг үгүйсгэн үзэгч хятадын хамба Хуушаан зэргээс номын ёсыг хиртүүлэх явдал гаргав. Эдгээрийг Их ловон Камалашила сайтар няцааж, бурханы тааллыг нотлон буулгасан машид их ачтай болов.

Хожуу дэлгэрэлтийн үед ч тантрын номын утгыг буруугаар баригч бандида, егүзэр хэмээн хөөрөмшигч зарим нэгэн дээдийн номын язгуур болсон зөв ёс суртахууны талаар буруу баримтлал гаргасныг Атиша богд болгоон сайтар няцааж чаджээ.

Мөн буруу үзлээр баригчдын баллаж үйлдсэнийг залруулан засах зэргээр дээдийн номыг хуурмаггүйгээр дээшитгэн зохиож Цастын орон бүхнийг лагшингийн ачаар тэтгэн зохиожээ.

Бурханы тааллыг тайлбарлах ном шастарыг туурвихад гурван хотол чуулсан нөхцөл бүрдсэн байх ёстой аж. Үүнд:(1) Мэдэгдэхүүн болсон ухааны таван орноо мэргэжсэн байх; (2) Үнэхээр туулсан бурханаас огт завсаргүйгээр дамжиж ирсэн зарлигийн утгыг бясалган болгоосон увидас төгс байх; (3) Ядам бурхадын нигуурыг болгоож зарлиг зөвшөөлийг авсан

байх" эдгээр ажгуу. Тэдгээрээс ганц нэг нь байхад ч ном шастар туурвиж болох авч гурвуул бүрдвээс хотол чуулган төгс болох учиртай. Их богд энэ гурвууланг эрхшээсэн бөлгөө.

Ядам бурхад түүнийг даган барьсан талаар "*Магтаал*"-д:

Цог төгөлдөр Живадорж (Хиважра) хийгээд
Дамцэггодви жалбу (Трисамаяавиюухаража) хийгээд
Баатар Жигдэн ванчүг (Арьяабал) хийгээд
Жому Жэвзун долма (Дарь эх) тэргүүтний

Нигуурыг болгоон зөвшөөл олсон тул
Зүүд болон илт болгоолдоо
Гүн гүнзгий хийгээд
Агуу их дээдийн номыг
Үргэлжид хүртсэн мөн хэмээн зарлигласан мэт болой.

Багшаас ирсэн дамжлагын хувьд нийтийн хөлгөн ба их хөлгөний хоёр дамжлага байсан. Тэдгээрт билгийн чанад хүрсэн хийгээд нууц тарнийн хөлгөн хоёр буй. Эхэнд үзэл онолын дамжлага хийгээд явдал мөрийн дамжлага хоёр буй. Удаахад Майдараас дамжсан хийгээд Манзуширээс дамжсан дамжлага гээд нийт гурван дамжлага буй. Нууц тарнийн хувьд Богд бээр таван ёсны дамжлага, бас бус тогтсон тааллын дамжлага, адистидийн дамжлага, элдэв увдисын дамжлага тэргүүтэн олон дамжлага лугаа төгөлдөр байжээ.

Бодитой хүртээсэн багш нарын талаар "*Магтаал*"-д:

Үргэлжид шүтсэн багш нар хэмээвээс
Шандива, Сэрлинба болон
Бхадрабодхи хийгээд Занашири зэрэг
Шид бүтээлийг олсон олон буй

Ялангуяа Нагаржуна гэгээнээс
Нэгээс нөгөөд уламжлан ирсэн
Гүн гүнзгий хийгээд агуу их явдлын увдисыг
Та эрхшээсэн мөн хэмээн айлдсан мэт

шид бүтээлийг олсон арван хоёр их багштай байсан хэмээн

алдаршжээ. Үүнээс ч олон багш нартай байжээ. Ухааны таван орноо мэргэн болсныг дээр номносон болой. Иймээс энэ багш бээр бурханы тааллыг сайтар нотлон буулгаж чадсан ажгуу. Эл богдын олон шавь нар Энэтхэг (Жагар), Хачи (Кашмир), Үржин (Оддияана), Балба, Төвд зэрэг орноо төрөн гарчээ.

Тэдгээрээс Энэтхэгт алдаршсан эрхэм шавь нар гэвэл Богд лугаа таалал сацуу их бандида Бодава, Дарма-агара-мади, Умсэнгэ (Мадхяасинха), Саяннинбу (Кситигарба) дөрөв бөлгөө. Заримууд нь Шинэн Санва (Митригухяа) лугаа тав гэж ч үздэг.

Төвдийн Аригаас дуун хөрвүүлэгч Ринчэнсанбу, Нагцо болон лхалам Жанчүв-Од нар, Зангаас Гаргэва, Гойхүгва, Лхазай нар, Лхобараг нутгаас Чагватичаг, Гиважон нар, Хам нутгаас Налжорва чэнбу, Гонбава, Ширавдорж, Чагдар Донба нар; Үй буюу төвөөс Хү (Хүдэн Зундуй жүндүн), Ог (Ог Лэгвиширав), Бром (Бромдонбо Жалбижунай) гурав зэргийн шавь нар төржээ.

Тэдгээрийн дотроос богд ямагтын үйлсийг дэлгэрүүлэн зохиох дамжлагын эхийг баригч нь Дарь эхээс эш бошигт Бромдонбо Жалбижунай эрхэм болой. Эдгээр нь зохиогчийн эрдмийг товч хураангуйлан өгүүлсэн бөгөөд дэлгэрэнгүйг их намтар цадиг зэргээс мэдээрэй.

II. Увдист бишрэл төрүүлэхийн тухайд номын эрдмийг үзүүлэх

"Бодь мөрийн зул" болбоос энэхүү номын үндсэн гол увдис мөн болой. Богдын зохиосон олон ном шастар байдаг боловч төгс төгөлдөр үндэс адил нь "Бодь мөрийн зул" ажгуу. Судар, тарни хоёулангийн аньс бүхнийг хураангуйлан үзүүлснээрээ өгүүлэгдэхүүний хувьд төгс төгөлдөр, сэтгэлээ ариусгах явдлыг эрхэмлэн номлосон учир гарт авахад хялбар, их тэрэгчний ёсноо мэргэшсэн хоёр их багшийн увдисаар чимэглэсэн тул бусад ёсноос ч илүү ялгамжаатай болой.

Энэ номын увдисын дөрвөн эрдэм: [13]

А. Хамаг шашин (дээдийн ном) бүгдийг харшуулахгүй онох эрдэм
Б. Хамаг эрхэм зарлигийг увидас болгож ургуулсан эрдэм
В. Ялгуугсадын тааллыг амар хялбар олох эрдэм
Г. Их гэмт явдлаас өөрийгөө буцаах эрдэм

А. Хамаг шашныг харшуулахгүй онох эрдэм нь :

Шашин гэж юу вэ? Энэ талаар “Билгийн зулын агуу их тайлбар”–т: “Шашин болвоос тэнгэр хүмүүний эрхэм дээд рашаан хутгийг олохыг хүсэгч нарын төгс мэдэх, тэвчих, илт онох, бясалгах ёстой тэдгээр эрдэм ухааныг үнэн зөвөөр заасан Ялж төгөлдөр нөгчигсөн бурханы эрхэм зарлиг болой” хэмээн бурханы сайн номлол зарлиг тэр бүгд шашин болохыг тодорхойлжээ. . [14]

Тэр бүгдийг харшуулалгүй онох гэдэг энэ бүх зарлиг бүгдээр нэг л бодгалийн бурхан болох зам мөрийг заасан болой гэж ухаарах явдал юм. Чингэхдээ нэг хэсэг нь мөрийн гол үндсийг заасан бол нөгөө хэсэг нь мөрийн гишүүнийг заасан байдаг. [15]

Ер бодисадва нарын таалал зорилго болвоос ертөнцийн тусыг бүтээх явдал билээ. Тэд нар гурван язгуурын шавь нарыг ч дээш дэгтрэн татахын тул тэдгээр гурван мөрд суралцах шаардлагатай болдог.

“Бодь сэтгэлийн тайлбар”-аас:

Өөрөө магадлан мэдээд
Бусдад магадлан мэдүүлэхийг хүсэж
Үргэлжид эндүүрэлгүй болгоон
Машид орох буюу Мэргэд хэмээжээ.

Мөн “Тийн тайлбар”-т:

Аргаас гарсан түүний уг далд мөн
Түүнийг номноход ч бэрхтэй хэмээн

өөрөө ёсчлон эс мэдвээс бусдад зааж чадахгүйг учирлажээ.

Гурван хөлгөний мөрийг мэдэх явдал бодисадвын таалал зорилгыг бүтээх арга болдог. Энэ талаар Майдар гэгээн бээр: “Амьтны тусыг бүтээгч нар мөрийг мэдснээр л ертөнцийн тусыг бүтээн зохиох” хэмээн айлджээ.

“Ялгуусадын эх судар”-т: “Бодьсадва нар алин Сонсоод сонсогчийн мөр, Өөрөө ялгуугсны мөр болон Бурханы мөр алин бүгдийг эгүүсгэн үйлдэх бөгөөд, хамаг мөрийг мэдэж үйлдэх болой. Тэдгээрийг төгс төгөлдөр болгоход тэдгээр мөрийн үйлийг ч үйлдэх буюу” хэмээн айлджээ. Иймээс

их хөлгөнтэй учирвaас бага хөлгөний аймаг савд суралцан бүү үйлд хэмээн өгүүлвээс харшлах болно.

Их хөлгөний мөрөөр ороход нийтийн болон нийт бусын гэсэн хоёр мөр буй. Нийтийн гэдэг нь бага хөлгөний аймаг саваас номносон ном тул тэдгээрийг орхиж яахин болох. Тиймээс гагцхүү өөрийн тусын тулд нирвааны амгаланг чухалчлах зэрэг бодлоос бусад бодол ухаан бүгдийг их хөлгөнийхөн ч анхааран бясалгах хэрэгтэй.

Их хөлгөний маш дэлгэрэнгүй аймаг саваас гурван хөлгөн гурвууланг дэлгэр номлохын учир ийн бөлгөө.

Тэрчлэн "Үнэхээр туулсан бурхан" гэдэг зөвхөн ганц нэг гэмээ барсан хийгээд ганц нэгхэн эрдэм олсон төдийгөөр бус харин хамаг гэмийн язгуураас ангижирсан, хамаг эрдмийн язгуурыг төгсгөсөн нэгэн байх хэрэгтэй билээ. Тиймээс бурханыг төрүүлэх их хөлгөн ч гэм бүгдээс гэтлэх хийгээд, эрдэм бүгдийг бүтээхэд зориулагдах учир бусад бүх хөлгөний тэвчил, онолын эрдмийн язгуур бүгдээр их хөлгөний мөрд хураагдана.

Ийм учраас эрхэм зарлиг бүгд бурханы хутгийг бүтээх их хөлгөний мөрийн гишүүн болж хураагдана. Гэм нижгээдийг барах юм уу, эрдэм нижгээдийг бүтээж үл чадах бурханы зарлиг ерөөс үгүй билээ. Их хөлгөний ном тэр бүгдийг бүтээж чадахгүй гэж үгүй буюу.

Хэдийгээр бага хөлгөний аймгаас үзүүлсэн мөрүүд их хөлгөнөө суралцахад хэрэг боловч тарнийн хөлгөнөө суралцахад судрын ёсны мөрүүд нийтийн мөр болох ёсгүй. Учир нь мөрүүд хоорондоо таарахгүй шүү дээ хэмээвээс, Ингэвээс бүр зохисгүй болно. Судрын аймгийн мөрийн гол агуулгад бодь сэтгэлийг төрүүлэх болон зургаан чанад хүрэхүйд (барамид) суралцах явдлууд багтана.

Эдгээр явдлыг хэзээ үргэлжид шүтэх хэрэгтэй талаар *"Цогт очирын үзүүр"*-д айлдахдаа:

Амьжиргааны тухайд ч
Бодь сэтгэлээ орхиж бүү үйлд хэмээсэн ба
Зургаан барамидын явдлыг хэзээ ч орхиж бүү үйлд хэмээжээ.

Мөн тарнийн олон номд ч ийн зарлигласан буй. Ханьцашгүй дээд егүзэрийн хот мандалд орох олон үед ч, нийтийн болон нийт бусын хоёр санваар хоёуланг барих хэрэгтэйг айлдсан буй. Түүний эхнийх нь бодисадвын санваар болно.

Санваар авна гэдэг гурван шагшавадын суртгаалын үүднээс бодисадвын суртгаалд суралцахаар ам авах явдал юм. Бодь сэтгэлийг төрүүлсний дараа, ам авсан суртгаал дагуу суралцахаас өөр ангид зам их хөлгөнөө үгүй билээ.

"Дорж ханд" болон *"Самбуди"*, *"Дорж зэму"* зэрэг тантруудад:

Гадаад болон нууцын гурван хөлгөнөө
Дээдийн номыг хоцороолгүй барьсугай

хэмээн Амитаба бурханы тангараг барихийн үед айлдсан мэтээр тарнийн санваарыг авахдаа хүртэл тангараглах хэрэгтэй.

Эдгээрт зөвшөөрөх, хориглох зүйлийн хувьд харилцан адилгүй байгааг үзээд халуун, хүйтэн мэт бүгдийг харшуулан бариваас маш бүдүүхэн ухаарсны тэмдэг биз ээ. Зарим нэгэн тусгай зөвшөөрөх, хориглох тохиолдлоос бусад нөхцөлд эрхэм зарлигууд машид зохилдон нөхөрлөнө. Ийм учраас гурван хөлгөн юмуу таван мөр хэмээн дээш дээшээ явахдаа доод доод хөлгөний мөрийн суурь эрдэм бүгдийг гүйцээж бүрдүүлэх хэрэгтэй. Чанад хүрсэн мөрийн талаар *"Ялгуусадын эх судар"*-аас:

Өнгөрсөн, эдүгээ, ирээдүйн алив бурхад
Энэхүү чанад хүрсэн замаар мөн Бусдаар бус

хэмээн зарлигласан мэтээр бурханы хутагт хүрэх зам мөрийн гол мод мөн тул түүнийг орхиж болохгүй билээ. Эл учрыг Очирт хөлгөнөөс ч олонтоо зарлигласан тул судар, тарни хоёулангийн нийтийн зам болой. Үүний дээр нууц тарнийн ёсны нийт бусын мөр, авшиг, тангараг санваар болон хоёр зэргийн егүзэр зэргийг нэмвээс Бурханы хутагт зорчих явдал улам түргэн болно.

Нийтийн мөрийг орхивоос их алдаа эндүүрэл гарна. Энэ мэтийг эс ухаарваас ганц нэгхэн номыг барагтайхан мэдсэн болж бусдыг тэвчихэд ч хүрдэг. Ялангуяа дээд хөлгөнөө муухан сүжиг төрвөөс улмаар бага хөлгөний аймаг сав болоод билиг барамидын аймгийг огоороход ч хүрэх зэргээр их алдаа гарна. Тарнийн ёсонд ч тантрын доод гурван аймаг тэргүүтнийг тэвчихэд хүрэх их гэм буруутай барилдаж болно. Түүний үйлийн үрд машид хүнд нүгэл болох дээдийн номыг тэвчсэн үйлийн их

түйтгэрийг хураана. Энэ талаар дараа номносу.

Тиймээс итгэлт дээдсийг шүтэж эрхэм зарлиг бүгдээр нэгэн бодигалийн бурхан болох нөхцөл болдог жам ёсыг сайтар мэдэж эдүгээгээс анхаарах авах зохистой зүйлээ анхааран авч чухалчлан бясалгаарай.

Хараахан лавтай авч орхиж чадаагүй зүйлээ ч өөрийн муу чадалд шалтаглан огооролгүй хэзээ нэгэн цагт бодьтой авч орхихын үүднээс тэдгээрийг анхааран авна гэж бод. Чингээд тэдгээрийн үндэс болгож буян хураах, нүглээ наминчлах, бас ерөөл талбиж үйлдээрэй.

Чингэвээс удалгүй оюун ухааны хүч дээшлэн дээшилсээр тэр бүгдийг анхааран бясалгах чадалтай болно. Буяны садан Донба Рпнбучэ гэгээн бээр ч "Хамаг амьтаныг тэгш дөрвөлжин мөрөөр хөтлөхөө мэдэгч миний багш" [16] хэмээсэн эл үгийг ихэд сайтар шинжлүүштэй бөлгөө. Ийнхүү энэхүү увдис судар, тарнийн гол утга бүхнийг нэг бодигалийн бурхан болгох мөрд хураан хөтлөх учраас л хамаг шашныг харшлуулахгүй онох эрдэм төгөлдөр бөлгөө.

Б. Хамаг эрхэм зарлигийг увдис болгож ургуулсан эрдэм

Ер бурханы эрхэм зарлиг болвоос тонилохуй хутагийг (нирваан) хүсэгч нарт орон үесийн болоод ашдын амгаланг бүтээх арга болдог билээ. Алин эндүүрлээс хагацсан, авч орхихын орон бүхнийг заагч багш болвоос зөвхөн Бурхан болой. Үүнийг *"Дээд дамжлага"*-аас:

Ялгуулсан бурхадаас үлэмж мэргэн энэ ертөнцөд хаана ч үгүй буюу
Ямагт эрхэм дээд чанарт болохыг хамгийг болгоогч л болгоох, бусад бус
Тиймээс Их арш өөрийн барьсан алив судрын аймгийг бүү хутга
Чадагчийн ёсыг эвдвээс дээдийн номноо хорлол үйлдсэн болох хэмээн айлджээ.

Тиймээс ялгуусадын айлдсан зарлиг буюу их эрдэнийн судар, тарнийн аймгууд бүгд увдисын дээд мөн билээ. [17]

Гэвч хожуу үеийн шавь нар мэргэдийн үнэн зөв тайлбар болон дээдсийн увдисыг шүтээгүй хэрнээ өөрийн зоргоор зарлигийг оролдох болсноор таалал утгыг мэдэхгүйд хүрчээ. Иймээс л "их модон тэрэгчин" мэргэд бээр эрхэм зарлигийн утгыг тайлбарлан шастар увдисуудыг зохиоход хүрчээ.

Хэрвээ үнэхээр зөв увдис мөн болвоос л их гол номуудыг ухаарах зол заяаг хайрлах учиртай. Гэвч тухайн увдисыг хичнээн сурч судлавч зарлиг болон тааллын их тайлбар зэргийн утгыг ухааруулах зол заяаг хайрлаж чадахгүй байгаа буюу эсвээс тэдгээртэй үл зохилдох зам мөрийг заах аваас ердөө л орхих зохистой.

Мөн гол ном гэдэг бясалган авах увдисгүй зөвхөн номлолын төдий зүйл гээд, бясалган авах увдис, шим утгыг заасан ном гэдэг тусдаа байдаг мэтээр ухааран, өөрт номносон дээдийн ном болон бүтээл хоёр тус тусдаа гэж хоёр янзаар үзэх явдал бий. Иймэрхүү санаа нь хиргүй судар, тарни болоод хиргүй тааллын тайлбар шастар зэрэгт биширэх хүндлэх сэтгэл төрөхөд тотгор учруулна.

"Дотоод утгыг үл заан (гол зүйлээ заагаагүй), гадаад ухаарлын торыг таслах (бусдын бурууг хэлэх) төдий" хэмээн тэдгээрийг басамжлахын орноо бариваас номыг тэвчсэн үйлийн түйтгэрийг хураахыг мэдээрэй. Ийм учраас нирвааныг хүсэгч нарт гол номууд л хуурмаггүй дээд увдис болох нь тодорхой. Гэвч бидний оюун ухаан сул дорой учраас увдисын дээд болсон үндсэн гол ном тэр бүгдийг шүтэж, ухаарч үл чадах бөлгөө.

Гэвч дээдсийн увдиснаа шүтэн байж тэдгээрийг магадалж эрэлцсү хэмээн увдисыг эрэх хэрэгтэй. Гол номууд гэдэг гадны торыг таслах төдий тул шимгүй гээд, увдис номууд дотоодын утгыг зааснаар дээд буюу хэмээн бүү бариарай.

Их бүтээлчин Жанчүвринчэн бээр: "Увдис оллоо гэдэг алганы толио төдий дэвтрийг ухаарснаар хэлэх бус. Эрхэм зарлиг бүхнийг увдис гэж ухаарахад оршино" хэмээжээ. Атиша богдын шавь Гомбаринчэн лам бээр: "Атиша багшийн увдисаар бие, хэл, сэтгэл нэгэн суудал дээр үнсэн товрог болох учир одоо л гол ном бүхнийг увдис мөн хэмээх ухаарал төрлөө" хэмээсэн адилаар ойлгох хэрэгтэй шүү.

Донба Ринбучи гэгээнээс: "Олон ном үзсэн гэвч ном үйлдэх ёс гэж тусдаа хэмээн ойлговоос эндүүрсэн хэрэг мөн" хэмээн айлдсан мэтээр өнө удаан ном үзсэн хэдий ч ном үйлдэх ёсыг огт ойлгоогүй хэрнээ ном үйлдэх хүсэл төрлөө гээд өөр тийшээ асууж сураглаж явагч нар дээр өгүүлсэн мэт ухаараагүйн гэмээр уршигдсан хэрэг ээ.

Дээдийн номыг тодорхойлон *"Абхидхармакоша"*-гаас:

Бурханы дээдийн ном хоёр зүйл бөгөөд
Эшийн болон онохуйн мөн чанарт бөлгөө хэмээн айлджээ.

Ийнхүү эшийн ном (заах) болоод онохуйн ном (бүтээх) хоёроос бусад үгүй бөлгөө. Эшийн ном болвоос гарын авлага буюу номын ёсыг зааж үзүүлсэн мөн. Онохуйн ном болвоос зааж үзүүлсэн номыг хэрхэн ёсчлон бүтээх явдлыг үзүүлсэн бөлгөө. Энэ хоёр ном учир шалтгаанаар нөхцөлдөж төрдөг.

Үлгэрлэвээс, Морь уралдуулахад эхлээд уралдах газраа сунгах хэрэгтэй. Чингэж гэмээ нь морио уралдуулдаг буюу. Харин нэг газар сунгачихаад нөгөө өөр газар уралдуулчихвал өөр тийш хадуурч давхиад элэг доог болно шүү дээ. Үүнтэй адил сонсох санах үест нэгэн зүйл хийгээд бүтээх бясалгах үест бас өөр нэг зүйлийг бүтээнэ гэж хаанаас байх вэ.

Энэ талаар *"Бясалгалын төгсгөлийн эрэмбэ"*-ээс: "Тийнхүү сонсох, санахаас төрж гарсан билигээр оносон тэдгээрийг бясалгалаас төрсөн билгээр бясалгаж үйлдэнэ. Бусдаар бус. Морио сунгаад дараа нь уралдуулах мэт" хэмээн айлдсан буй.

Тийнхүү энэхүү увдис нь эрхэм зарлиг болон тааллын тайлбараас үзүүлсэн мөрийн аньс бүхнийг буяны садныг шүтэх ёсноос эхлэн амарлингуй сэтгэл, үлэмж үзэхүй ухаан хүртэл багтаан хураангуйлж эдгээр бүгдийг агуулан бясалгах шаардлагатай газарт агуулан бясалгах, шинжлэн бясалгах хэрэгтэй газарт тус тус ажиглах ухаанаар шинжлэн бясалгах эрэмбэ зэргийг нэгтгэн хөтөлсөн учраас эрхэм зарлиг бүгдийг увдис болгон ургуулсан болой.

Чингэлгүй мөрийн биеийг үе, шат бүрэн гүйцээлгүй зарим нэг зүйл дээр тус тус онох ухаанаар шинжлэлгүй бөөнтгөн бясалгаваас гол номоо увдис болгож чадахгүйгээр үл барам тэдгээрийг "гадны ухаарлын тор таслах" төдийгөөр хязгаарлаж огоороход хүрнэ.

Гол номоос үзүүлсэн тэдгээр утгыг ихэвчлэн тус тус ажиглах оюунаар шинжлэх шаардлагатай байдаг тул бясалгахын үест орхивол тэдгээрийг увдисын дээд гэж үзэх ухаан яаж төрөх билээ. Тэдгээрийг эрхэм дээд

увдис биш гэвээс тэдгээр зарлиг зохионгуйгаас илүү увдисын эзнийг хэн олох билээ.

Ийнхүү судрын аймгийн гүн гүнзгий, агуу дэлгэр тааллын тайлбар зэргийг увдист ургуулж чадваас гүн гүнзгий тантрын аймгийн тааллын тайлбар зэрэг гол номын ёсыг төвөггүй увдист ургуулж чадна. Улмаар тэдгээрийг эрхэм увдис гэж барих ухаан ч төрнө. Мөн тэдгээрийг бодитой увдис бус гэж үзэх номд араараа зүглэх буруу сэжиг бүхнийг үлдээлгүй няцаах болно.

В. Ялгуусадын тааллыг амар хялбар олох эрдэм

Эрхэм зарлиг болон тааллын тайлбар сэлт нь эрхэм дээд увдис бөлгөө. Гэвч төгс боловсроогүй, эхлэн оролдогч нар дээдийн увдисыг шүтэлгүйгээр тэдгээрт суралцавч тааллын утгыг олж чадахгүй. Суралцахаар оровч өнө удаан, их бэрхшээлтэй учирна. Харин багшийн увдисыг шүтвээс л амар хялбар утгыг онох билээ. Иймээс энэхүү увдис л зарлиг, шастарын утгыг амар хялбар оноход туслана. Эл учрыг тухайн үед дэлгэрэнгүй номнох болой.

Г. Их гэмт явдлаас өөрийгөө буцаах эрдэм

Бурханы ном зарлиг бүхэн ил далд алив утгаараа зөвхөн бурхан болох арга замыг заасан гэдгийг ухааралгүй, нэг хэсгийг бурхан болох арга гэх, нөгөө хэсгийг бурхан болохын тотгор гэх ба сайн муу, зохих зохихгүй, дээд, доод ном гэх мэтээр алгачаалж үзэх, түүнчлэн бодисадва нар үүнийг сурах хэрэгтэй, түүнийг сурах хэрэггүй гэх мэтээр огоорч орхих зэргээс уршигдаж номыг тэвчсэн нүглийн үйл хураадаг болохыг *"Цагаан линхуа"* болон *"Үнэнч өгүүлэгчийн бүлэг"* зэрэг судраас айлджээ.

"Тийн хүлэгчийг хураангуйлсан судар" -аас: "Жамбал! Дээдийн номыг тэвчсэн үйлийн түйтгэр нарийн буюу. Жамбал! Түүнчлэн залрагсдын айлдсан зарлигийн заримыг сайн хэмээн санах, заримыг муу хэмээн санаваас номыг тэвчсэн болой.

Алин номыг тэвчигч тэрбээр номыг тэвчсэнээр түүнчлэн заларсныг басамжилсан мөн. Хуврагийг муу хэлсэн болно. Энэ зохих болой. Энэ үл зохих болой хэмээсэн нь ном тэвчсэн болой. Үүнийг Бодисадва нарт тухайлан айлдсан болой. Үүнийг Сонсоод сонгогч нарт тухайлан айлдсан

болой хэмээвээс номыг тэвчсэн болно. Үүнийг өөрөө ялгуусадын тухайд айлдсан болой хэмээвээс номыг тэвчсэн бопно. Энэ нь бодисадва нарын сургаал бус .болой хэмээвээс номыг тэвчсэн болно" хэмээн айлджээ. Номыг тэвчсэн гэм нүгэл маш хүнд болох талаар:

"Бясалгалын хаан судар"- аас:

Хэн бээр Замбу тивд буй
Хамаг субрагыг эвдэж сүйтгэснээс
Хэн бээр судрын аймгийг тэвчиж үйлдсэний
Хилэнц тэр л үлэмж илүү

Хэн бээр Ганга мөрний элсний тоотой тэнцэх
Хэрсүү мэргэн Архадыг алж хөнөөснөөс
Хэн бээр судрын аймгийг тэвчсэний
Хилэнц нүгэл түүнээс үлэмж илүү хэмээн айлджээ.

Ер номыг тэвчих үйлнээ олон зүйл боловч дээр өгүүлсэн зүйл ихэвчлэн тохиолдох тул хичээж тэвчээрэй. Дээр өгүүлснийг ухаарсан төдийд л нүглээс буцах тул өөрийгөө гэмт явдлаас хамгаалах утга тийн буюу.

Тэрхүү ухаарлыг олохын тул *"Үнэнч өгүүлэгчийн бүлэг"* болон *"Цагаан линхуа"* зэргийг олонтаа шагайж, номыг тэвчих бусад зүйлийн талаар *"Тийн хүлэгчийг хураангуйлсан судар"* тэргүүтнээс ухаж мэдээрэй.

III. Хоёр эрдэм төгөлдөр номыг хэрхэн сонсох болоод номнох ёсон

А.Сонсохуй ёсон
Б.Номнохуй ёсон
В.Төгсгөлд нийтээр үйлдэх ёсон

А. Сонсохуйн ёсноо гурав:

1. Ном сонсохын тус эрдмийг санах
2. Ном хийгээд өгүүлэгчнээ хүндлэл үйлдэх
3. Сонсохын бодит ёсон

1. Ном сонсохын тус эрдмийг санах: [18]

"Сонсохуйн цоморлиг"-оос:

Сонссоноор ном юмсыг мэдэх
Сонссоноор хилэнцийг буцаах
Сонссоноор ёс бусыг тэвчих
Сонссоноор зовлонгоос тонилохуйг (нирваан) олох хэмээсэн ба

Хэрхэн өрхөөр лавтай битүүлсэн гэрийн
Харанхуй нөмөрсөн орон зайд
Харах нүд төгөлдөр байлаа ч
Хэзээд дүрс хэлбэрийг үл үзэх тэр адил

Эрхэм язгуурт төрсөн
Эгэлгүй ухаантай хүмүүс хэдий ч
Энэ л нүгэл хийгээд буяны номыг
Эс сонсвоос мэдэж үл чадах

Үзэх нүд төгс болвоос
Үнэн дүрс юмсыг хэрхэн үзэх адил
Энэчлэн буян хийгээд нүглийн номыг
Сонссоноор тийн мэдэх мөн хэмээсэн ба

"*Төрөл дарааллын цадиг*"-аас: [19]

Алин нэгийг сонссоноор сэтгэл сүжиглэх
Сайтар бясалгах, бат чанарт болох
Ухаан төрөх хийгээд мунхаг үгүй болох тул
Өөрийн хувийг түүнээ зарах нь зохистой

Сонсох болвоос мунхагийн харанхуйг арилгах зул
Хулгайч дээрэмчин үл хулгуух дээд эд хөрөнгө
Балай мунхагийн дайсныг дарагч илд зэвсэг
Увдис ухааныг заагч эрхэм нөхөр билээ

Үгүйрч доройтовч үл орхигч садан
Хорлол үгүй гасланг дарагч эм
Их гэмийн омгийг дарагч дээд садан
Алдар нэр цог жавхлангийн дээд хүү сан мөн

Дээдэстэй учрах төрөлхтний дээд
Чуулганы дотроос мэргэд биширэх мөн хэмээсэн ба,
Сонссоны үрээр бүтээл шимт болох
Төрөхийн сүргээс төвөг багатай гэтлэх буюу

хэмээн айлдсан зэргээс сонсохын тус эрдмийг зүрхний мухраас сүсэглэн санаарай.

Мөн "Бурхан заларна" гэдэг өдрийн од шиг чухаг нэгэн билээ. Тэр адил түүний ном ч ховор чухаг учир их эрдэнэ адилд үзэх хур мэдэл (1); даруй түргэн хамт төрсөн ухааныг дээш дээш арвижуулах учир нүд адилд үзэх хуран мэдэл (2); билгийн нүдтэй болсноор үнэмлэхүй болон янагуухи юмсыг мэдрэх тул гэгээн хур мэдэл (3); эцэст нирваан хутаг болон их бурханы хутгийг хайрлах учраас их тус эрдэмтэйд үзэх хур мэдэл (4); болон эдүгээгээс дээрх хоёрын үндэс-сэтгэл амарлихуй хийгээд үлэмж үзэхийн амгаланг төрүүлж үйлдэх тул амлашгүй нүгэлгүйн хур мэдэл (5) гэсэн таван хур мэдлийн үүднээс сонсох хэрэгтэй" гэж *"Бодисадвын газар"*-аас айлдсан дагуу сонсохын тус эрдмийг тунгааж санаарай.

2. Ном хийгээд номыг өгүүлэгчнээ хүндлэл үйлдэх

"Газрын зүрхтний судар" - аас:

Үргэлжид сүжиглэн биширч номыг сонс
Түүнийг басамжлан доромжилж бүү үйлд
Ном өгүүлэгчийг тахиж үйлдэхдээ
Түүнээ бурхан адилын хур мэдлийг үүсгэ

хэмээсэн мэт бурхан адил үзээд арслант ширээ тэргүүтнээ өргөн хүндлэх бөгөөд үл биширэх санаа зэргийг тэвчих мөн. *"Бодисадвын газар"*-аас "Ерөөс муу сэтгэл гаргахгүй хийгээд номыг өгүүлэгчийн таван орныг сэтгэлдээ үл бодох" зэргийн үүднээс айлдсан дагуу сонсох хэрэгтэй.

Үүнд "дээрэнгүй сэтгэл гаргахгүй" гэдэг нь цаг цагтаа сонсох, өргөн хүндлэх, айлтган хүндлэх, үл уурлах, дагаж бүтээх, гэм үл эрэх гэсэн зургаан байдлаар сонсох болой. "Басамжлах сэтгэл барихгүй" гэдэг нь ном хийгээд ном өгүүлэгчнээ биширэх, тэр хоёрыг үл басамжлан үзэх болой. "Таван орныг сэтгэлдээ санахгүй" гэдэг нь шагшаавадаа доройтуулсан,

доод язгуурт, муу зүхэлт, муу олон үгт, ширүүн үгт бөгөөд муухай өгүүлэгч тул үүнийг сонсохгүй хэмээн орхих болой.

"Төрөл дарааллын цадиг"-аас:

Машид доор суудалд суух
Усхал номхон цогийг үүсгэх
Төгс баясалт нүдээр харах
Үгийг рашаан хүртэх адил

Бишрэнгүйг үүсгэн
Нэгэн үзүүрт сэтгэлээр мөргөх
Чин сүжигт хиргүй сэтгэлээр
Өвчтөн оточийн үгийг сонсох адил
Өргөн хүндэлж номыг сонсохтун! хэмээн айлдсан мэт болой.

3. Сонсох бодит ёсноо хоёр зүйл:

а. Савны гурван гэмийг тэвчих
б. Зургаан хур мэдлийг шүтэх

а. Савны гурван гэмийг тэвчих

Амыг хөмөрсөн сав (1), амыг дээш харуулсан ч хир буртагтай сав (2), хир буртаггүй хэдий ч ёроол нь цоорхой сав (3) байх аваас, тэдгээрт тэнгэрийн хур буувч сав дотор үл тогтох, тогтсон ч хир буртгаар бохирдсон тул уух тэргүүтний хэрэгцээ хангахгүй болох, хир буртгаар бохирлогдоогүй ч дотроо тогтохгүй савирч барагдахад хүрдэг.

Түүнтэй адилаар, ном сургуулийн хүрээнд суувч чихээ үл тавих (1) (үл сонсох), тавьсан ч буруугаар барих юм уу язгуур сэтгэл нь гэмтэй байх (2), эдгээр гэмүүд байхгүй ч сонсохын цагт үг, утга зэргийг баттай барилгүй мартах зэргээр доройтуулваас (3) ном сонсох, сурахын их тус гарахгүй тул тэдгээрийг орхих хэрэгтэй.

Дээрх гурван гэмийн ерөндөг юу болох талаар "Судар"-аас: "Машид, сайтар сонсож сэтгэлдээ баригтун" хэмээн гурван үгээр айлдсан болой.

Мөн "Бодисадвын газар"-аас: "Бүхнийг мэдэх, хүсэх нэгэн үзүүрт эрмэлзэлтэй байх, чихээ тавих, сэтгэлээр сүслэх, хамаг сэтгэлээс хичээн сонсох хэрэгтэй" хэмээн айлдсан дагуу болой.

б. Зургаан хур мэдлийг шүтэх

1. Өөрийгөө өвчтөн адилд үзэх хур мэдлийг үүсгэх талаар:

"*Бодичарияватара*"-д:

Эгэл нэгэн өвчин тусахад ч
Эмчийн үгийг дагах хэрэгтэй тул
Элдэв шунал тэргүүтэн олон хортой өвчнөөр
Эгнэгт энэлэгчийг хэлээд яах вэ хэмээжээ.

Энэ мэт өнөд удаан, эдгэхэд бэрхтэй, хатуу бэрх зовлонг үүсгэгч өвчин болсон шунал хүсэл тэргүүтэн нисваанисаар (муу сэтгэл) цаг үргэлжид өвдөж шаналж ирсэн тэрхүү байдлаа таньж мэдэх хэрэгтэй. Гамбави гэгээнээс: "Яг үнэндээ бид ингэж өвчилсэн учраас тийнхүү чанх буруугаар сэтгэнэ. Гурван хорын архаг өвчинд баригдан их халуун өвчинд энэлж байгаагаа бид огт мэдэхгүй л явна" хэмээн айлджээ.

2. Номыг өгүүлэгчнээ буяны садан оточ хэмээх хур мэдлийг үүсгэх:

Үлгэрлэвээс хий, шар тэргүүтэн их архаг өвчинд баригдаад ирэхийн цагт мэргэн оточ эмчийг хайж, түүнтэй учрахад их баяр хөөр болж юу хэлснийг сонсон бишрэн хүндэлдэг адилаар ном заасан буяны садныг ч тэр адилаар хайж, олсон хойноо алба үүрэг гэж бодолгүй, шүтээн адилд барьж юу айлдсаныг бүтээж, бишрэн хүндлэх ёстой.

"*Их эрдэнийн эрдмийн хураангуй*"-д:

Тэр адилаар эрхэм бодисадва багшийг эрэхдээ
Сэтгэл баттай шударгуу байж мэргэн гэх омгоо дарж
Өвчтэй хүн хүнд өвчнөөс хагацахын тул эмчийг шүтэх адил
Алгасаралгүй буяны садныг өргөж үйлдсүгэй хэмээн айлдсан ёсоор болой.

3. Дагуулан зааснаа эмийн хур мэдлийг үүсгэх нь

Өвчтөн хүн оточийн найруулсан эмийг машид нандигнан хэрэглэдэг тэр адил ном өгүүлэгчийн айлдсан увдис болоод дагуулан заасан номыг эрхэм тустай хэмээн үзэж ихэд хичээнгүйлэн анхааран авах буюу. Умартах зэргээр шимийг барж үл үйлдэх бөлгөө.

4. Хичээн анхаарч авснаар өвчин илааршихын хур мэдлийг үүсгэх нь

Өвчтөн хүн оточийн найруулсан эмийг эс ууваас өвчин эс эдгэрэх гээд хэрэглэдэгтэй адилаар ном өгүүлэгчийн үзүүлсэн увдисыг анхааран эс авбаас шунал зэргээ дарж чадахгүйг ухаарч хичээнгүйлэн анхааран авах хэрэгтэй. Эс чингэвээс баахан олон үгийг хураан цуглуулсан мэт болно.

Хулгана яр гарах, хөл гар хугарах зэрэг өвчин тусахад ганц нэг тун эм уугаад ямар ч тус болдоггүй. Түүнтэй адил бид нар тэргүүлшгүй цагаас нисваанисын суурьт архаг өвчинд эзлэгдэн ирсэн тул ганц нэгхэн увдисын үгийг анхааран авахаар зогсохгүй хувь бүгд бүрдсэн мөрийн увдисыг оюун ухаанаар шинжлэн усны үргэлжлэл адилын хичээл шамдлаар хайж олох хэрэгтэй билээ. Их мэргэн Зандра Гомигийн "*Наминчлах магтаал*"-д:

Сэтгэл гэдэг үргэлжид мунхран
Өнө удаан өвчний суурь болж ирвэй
Хулгана яр болон гар хөл хугарах үед
Ганц нэг тун эмийг уугаад юу тус болох хэмээн айлдсан мэт болой.

Тиймээс өөрийгөө өвчтөн гэж бодох нь маш их чухал аж. Тийн бодож чадвал бусад бодол ухаанууд төрж ирдэг. Харин түүнийг үг төдий одуулваас нисваанисыг арилгах увдисын хэрэг үл бүтэж сонсох төдий нэгэн болно. Эмчээ эрж олчихоод өгсөн эмий нь эс ууваас өвчнөөс үл гэтлэх бөгөөд зөвхөн эмийн жорыг уншигч өвчтөн хэвээр үлдэнэ шүү.

"*Бясалгалын хаан судар*"-аас:

Өвдөж шаналан биеэр зовох хүмүүс болон
Үй олон жил нэг ч гэтлэх аргагүйгээр
Өнөд удаан нисваанисын өвчнөөр өвдсөн тэдгээр бүгд
Өвчнөө эдгээхийн тулд эмчийг тухайлан эрэлцэх буюу

Дахин дахин түүнийг эрж хайсаар
Эмчлэх аргатай мэргэн нэгийг олох
Тэр бээр их энэрэх сэтгэлийг өвөрлөн
Энэ эмийг хүртсү хэмээн өгөх

Өгсөн олон сайн эм тэдгээрийг аваад
Өвчин анагаах тэдгээр эмийг эс ууваас
Эмч ч яахин үл уршигдах, эм ч яахин гэмтэх вэ
Өвчтөн тэр өөрөө л гэмт болох буюу

Тэр адил энэ номын тойн хувраг болоод
Эрдэм чадал, бясалгал, авшиг бүгдийг мэдсэн хирнээ
Бясалгаж дадуулахаар хичээж юунд эс үйлдэнэ вэ
Өнөөдөр эс хичээвээс хэзээ гэтлэх вэ хэмээсэн ба

Хэдий би эрхэм сайн номыг номловч
Та нар сонсож үнэхээр эс судалваас
Эмийн манхаг барьсан өвчтөн нар
Өөрийн өвчнийг анагааж эс чадахын адил хэмээжээ.

"*Бодичарияаватара*"-д:

Өөрийн биеэр эдгээрийг судалж үйлд
Үг төдийг өгүүлснээр юу бүтээх вэ
Эмийн жорыг унших төдийгөөр
Өвчтөнд тус хүргэх бил үү хэмээсэн учир болой.

Тиймээс хичээн шамдаж өвчнөөсөө салах бодлыг төрүүлээрэй хэмээсний хичээл шамдах гэдэг буяны садны заасан авч орхихуйн орон бүгдийг гарын авлага болгох ба түүнийг хэрхэн үйлдэхийг мэдэх явдал юм. Чингэхийн тулд түүнийг сонсох учиртай. Сонссоны дараа ухаарал төрдөг жамтай. Сонссон зүйлээ хэр чадлаараа гарын авлага болгох л тун чухал билээ.

Энэ талаар "*Сонсохуйн цоморлиг*"-т:

Хэдий сонссон зүйл олон ч
Сайн ёс суртахуунаар эс хашваас
Тэр ёс суртахуун хожим муушаагдах ба
Тэр сонссон зүйл хотол чуулсан болохгүй

Хэдий сонссон зүйл өчүүхэн ч
Сайн ёс суртахуунаар хашиж байваас
Тэр хоёр хожмоо машид сайшаагдах бөгөөд
Тэр сонссон зүйл хотол чуулсан болно

Алин сонссон мэдснээр өчүүхэн
Ахин бас ёс суртахуунаар дульхан аваас
Ашид тэр хоёул муушаагдах агаад
Авир ёсоор арчаагүй мууд тооцогдох

Алин олныг сонсож мэдээд
Ахин бас ёс суртахуунтай явбаас
Ашид энэ хоёр сайшаагдах бөгөөд
Авир ёсон эрхэм болох бөлгөө хэмээсэн ба

Сайн зарлигийг сонсож шимийг мэдэх хийгээд
Самади бясалгалын зүрхэн болгон авсан ч
Алин сэрэмжгүй хөөрцөглөн одогч тэдгээрт
Анхаарч сонсож ухаарахын их тус гарахгүй

Алин хутагтын үзүүлсэн номд баясан
Тэрчлэн бие, хэлээр үйл үйлдэхдээ
Тэдэнд болгоомжтой хандах сайн нөхөр
Эрхтэнээ боомтолвоос сонсох ухаарахын чанадад хүрнэ хэмээжээ.

"*Үлэмж сэтгэлийн шаардлага судар*"-т ч:

Юу ч бүтээсэнгүй одоо би яана хэмээн
Үхэхийн цагт нялхас гаслах
Үнэн язгуурыг олсонгүй гэж ихэд шаналах
Өгүүлэхдээ баясахын гай энэ буюу хэмээгээд

Өөрийн бясалгах эрдмээ доройтуулагч
Өгүүлэхдээ баясахын гэм гэдэг
Өөрөөс бусад баатрын эрдмийг өгүүлэгч
Өнөөх ший жүжгийн үзэгч адил аа

Бурмын модны хальсанд ямар ч амт шим үгүй
Баясал төрүүлэх амт нь дотроо оршдог билээ

Хальсыг идсэн хүмүүн бээр бурмын сайхан амтыг
Хэзээ ч мэдэрч чадахгүй билээ

Хэрхэн тэр хальс гэдэг өгүүлэх ярих бөгөөд
Харин амт шим гэдэг утгыг ухаарах гэсэн үг
Учир иймээс өгүүлэх ярихаа огоорон
Үргэлжид анхааран сэтгэлдээ утгыг тунгаагтун хэмээн айлджээ.

5. *Тэрчлэн залрагсан бурхадыг дээд төрөлхтөн хэмээн үзэх хур мэдлийг үүсгэх нь.* Номыг айлдагч Ялж төгөлдөр нөгчигсөн бурханыг дуртган санаж бишрэх болой.

6. *Номын ёсон өнөд оршихийн хур мэдэл үүсгэх нь.* Энэ адилын номыг сонссон буянаар ертөнцөд бурханы үзүүлсэн ном өнө орших байгаасай хэмээн санах болой.

Түүнчлэн номыг сонсох буюу номнох үед өөрийн сэтгэлээ нэг тийш хандуулаад номоо нөгөө тийш хандуулаад хичнээн ч номнолоо гэсэн хэрэг тус болохгүй тул өөрийнхөө сэтгэлд л баттай буулгахын тухайд сонсох хэрэгтэй билээ.

Үлгэрлэвээс хацар нүүрэн дээр хир толбо байна уу, үгүй юү гэдгээ мэдэхийн тулд толинд нүүрээ харж улмаар хир толбоо арилгадаг мэт өөрийн явдал мөрд гэм байна уу, үгүй юу гэдгийг ном сонсож номын толинд толидон байж миний сэтгэл ийм болжээ гэдгээ сая таньснаар сэтгэл өвдөж эхлэнэ. Чингээд саар муугаа засах, сайн эрдмийг бүтээхээр ном эрдэмд суралцдаг билээ.

"*Төрөл дарааллын цадиг*"-аас:

Өөдгүй муу явдалт өөрийн дүрээ
Өршөөлт номын толинд тодхон үзээд
Ичиж зовох сэтгэлдээ хөтлөгдөн
Эрхгүй номд зүглэх болов би хэмээн

Судасагийн хөвгүүн бээр Бодисадва Даваагаас иин ном айлтгахад түүний санаа номын сав болсныг болгоон бодисадва тэрээр түүнд ном заасан гэдэгтэй адил буюу. Хураангуйлваас "Би бээр амьтан бүхний тусын тулд бурханы хутагийг олсугай. Түүнийг олохын тулд түүний үндэс шалтгааныг бүтээх ёстой. Мэдэх хэрэгтэй. Мэдэхийн тулд ном сонсох

хэрэгтэй учраас ном үзсүгэй" хэмээх сэтгэлийг бий болгоно. Ном сонсохын тус эрдмийг санаж урам зориг ороод савны гурван гэмийг тэвчиж номыг сонсох болой.

В. Номнохуйн ёсноо дөрөв:

1. Ном номнохуйн тус эрдмийг санах
2. Багш хийгээд номоо өргөн хүндлэх
3. Ямар санаа бодол болон үйл ажлаар номнох
4. Номнох, эс номнох орны ялгаа

1. Ном номнохуйн тус эрдмийг санах

Ном заахдаа олз хүндлэл, нэр алдар, эд баялаг зэргийг горилолгүй зааваас тун их тустай билээ. "Үлэмж сэтгэлийн шаардлага судар"-т: "Майдар аа, Эдгээр хорин зүйл болвоос эд баялаг, олз хүндлэл үл тооцох номын өглөг тэдгээрийн тус эрдэм болой.

Хорин зүйл юун хэмээвээс дараах буюу, (1) дурдан санах ой төгс байх, (2) сэтгэх чадвар төгөлдөр байх, (3) оюун ухаан төгөлдөр байх, (4) бат тогтвортой байх, (5) билиг ухаан төгөлдөр байх, (6) ертөнцөөс нөгчихсөн ухааныг даган мэдэх, (7) хүсэл шунал багатай, (8) уур омог багатай, (9) эргүү мунхаг багатай байх, (10) чөтгөр орших зай чөлөө багатай, (11) ялж төгөлдөр нөгчихсөн бурхад таалах, (12) хүмүүн бусууд түүнийг сахих, (13) сахиусан тэнгэрүүд түүнийг хамгаалах, (14) садан бусууд түүнийг үл хорлох, (15) элгэн саднууд үл орхих, (16) үнэн үгт болох, (17) аюулгүй байдалд орших, (18) сэтгэл үргэлж амар байх, (19) мэргэд сайчуулд сайшаагдах, (20) түүний номын өглөг буян хожим хойно ч дурсагдах буюу" хэмээх тэргүүтнээр олон судраас айлдсан тус эрдмийг зүрхний мухраас санан сүслэх болой.

Дээрх "Бат тогтвортой" хэмээснийг Шантидэва гэгээний "Суртгаалын хураангуй"-д "шинээр төрөх сүсэг" гэж орчуулсан буй. Харин зарим хуучин орчуулгад "хичээл зүтгэл" гэж буулгасан үзэгдэнэ.

2. Багш болоод номоо өргөн хүндлэх

Ялж төгөлдөр нөгчихсөн бурхан багш бээр "Ялгуугсадын эх "судар номоо айлдах үест олбог ширээг бэлдсэн тэр адилаар бэлтгэнэ. Ном

болвоос бурхадын ч хүндлэл бишрэлийн орон мөн учраас номд гүн хүндэтгэлтэй хандаж багшийн эрдэм болоод зарлигийн ач тусыг санан бишрэх болой.

3. Ямар сэтгэл санаа болон үйл ажлаар номнох

Сэтгэл санааны хувьд "Лодойжамцын айлтгасан судар"-т үзүүлсэн дагуу таван хур мэдэлтэй байх хэрэгтэй. Үүнд өөрийгөө эмч, номоо эм, ном сонсогчоо өвчтөн, түүнчлэн залрагсан бурхадыг дээд төрөлхтөн гэж үзэх ба номын ёсон өнөд удаан оршисугай хэмээх бодол санааг агуулна. Мөн нөхөртөө асрах хайрлах сэтгэлээр хандана.

Харин бусад надаас илүү гарчихвий хэмээн атаархах бодол, хойш тавьдаг залхуурал, дахин дахин номнохоос уйдах, өөрийгөө магтаж өөрөөлийг муушаах, ном дэвтрээ харамлах, хоол хувцас зэрэг эд таваар горьдох зэрэг буруу бодлыг тэвчих бөлгөө.

Өвөр бусад бүгдээр бурхан болж гэгээрэхийн тулд номын энэ буян миний амгалан жаргалын эд баялаг болсугай хэмээн санах болой.

Үйл ажлын хувьд цэвэр ариун байхын үүднээс угаал үйлдэж хиргүй дээлийг өмсөөд сэтгэлд таатай ариун газар зүгт номын ширээ суудлыг барина.

Шумнасыг эслэн таслах тарнийг амны уншлага болговоос эргэн тойрон зуун багцадын дотор шумнас болоод шумнасын аймгийн тэнгэрүүд үл дөтлөх бөгөөд дөтлөвч хорлол хүргэж чадахгүй хэмээн "Лодойжамцын айлдсан судар"-т айлдсан тул эл тарнийг уншаарай.

Чингээд нүүр дүүрэн баясалтай, утгыг ухааруулах үлгэр жишээтэй, нотолгоо баримт, эш үндэс төгөлдөр заах хэрэгтэй.

"Дээдийн ном цагаан линхуа"-д:

Мэргэн бөгөөд атаархах санаа үгүй
Элдэв утга төгс яруу үгээр заа
Залхуу хойргоо эгнэгт тэвчиж
Алжааж уйдах санааг хэзээ ч бүү гарга

Мэргэдийн үл таалах бүгдийг тийн тэвчиж
Хань нөхөддөө асрахуйн хүчийг бясалга
Өдөр шөнөд дээдийн номоос суралц
Мэргэн тэр бээр түм буман жишээ татан

Нөхдөө бишрүүлэн бас баясгаж чадах
Түүнээ өчүүхэн ч шунал ерөөс үгүй
Идээ ундаа эд төхөөрлөг болоод
Дээл хувцас, ор дэр, номын баринтаг ба

Өвчнийг анагаах эм танг ч үл горилох
Эргэн нөхөрлөгч нараас юу ч үл гуйх болой

Тэрчлэн мэргэд бээр үргэлжид өөрийн болон
Тэдгээр амьтан бүгдийн тусад бурхан бүтээж
Тус хүргэхээр ертөнцөд заасан алин ном эдгээр
Миний амгалангийн хамаг эд болтугай хэмээн сана хэмээн айлджээ.

4. Номнох, эс номнох орны ялгаа

"Винайн судар"-т: "Эс айлтгаваас бүү үйлд" хэмээн айлдсан мэт айлтгал хүсэлт тавиагүй нөхцөлд үл номнох бөгөөд айлтгал тавьсан байлаа ч сав болох эсэхийг шинжнэ. Харин сав мөн аваас айлтгаагүй байсан ч номнож болно.

"Бясалгалын хаан судар"-т:

Хэдий танд айлтгаж хүссэн ч бай
Номын өглөг үйлдэхийн тулд
Ихэд сайн сурсан юм надад үгүй хэмээн
Энэ үгийг эхлээд өгүүлж үйлдэх

Хэдий та мэргэн байлаа ч
Хамгийг болгоогч таны өмнө
Хаанаас би номнож чадах билээ гэж
Хэрсүүлж та өгүүлж үйлдээрэй

Шуудхан номнож бүү үйлд
Сав эсэхийг шинжих тань
Хэрвээ сав болохыг таньваас
Айлтгал өчөөгүй байсан ч номносугай хэмээжээ.

Мөн "Винайн судар"-т айлдахдаа: "Суугаа нэгнээ босож зогсоод бүү ном заа. Хэвтэх нэгнээ сууж бүү ном заа. Өндөр суудалд суугаад доод суудалд сууж бүү заа. Сайн муу тэр дагуу болой. Өмнө одогчийн араас одон бүү номно. Замаар явагсдад хажуугаас очиж бүү номно.

Толгойгоо битүү ороосон, халхавч нөмрөгөөр битүүлсэн болон элгээ тэвэрсэн, хүзүү шилдээ гараа солбисон зэрэгт бүү номно. Толгойгоо гэдийлгэсэн, малгай өмссөн, титэм тавьсан, элдвийн эрхээр ороосон зэрэг нөхцөлд бүү номно. Их заан, морь хөлөглөх, сүйх тэрэгнээ явах зэргийн үест болон гутал өмссөн үест бүү номно. Мөн гартаа таяг, шүхэр болон илд, мэс, хутаг зэрэг зэвсгийн зүйл барьснаа болон хуяг дуулга агссан нэгнээ бүү номно" хэмээжээ.

Харин дээрх тохиолдлууд гараагүй нөхцөлд номнож болох аж. Энэ бүгд эрүүл саруул хүний хувьд тийн үйлдэхийг айлджээ.

В. Төгсгөлд нийтээр хэрхэн үйлдэх ёсон

Номнох, сонсохоос төрсөн буян бүхнээ орон үес болон эцэс хойдын ерөөлийн орноо баттай сүслэн зориулж үйлдэнэ. Энэ адилын ёсоор ном номнож сонсож сурваас ганц нэг тасалгаа төдий ч гэсэн тус эрдэм номносон дагуу эргэлзэлтгүй төрнө.

Ном номнох, сонсох ёсыг зөвөөр үйлдэж чадваас ном болоод номыг өгүүлэгчнээ үл биширэх зэргийн урьд хураасан муу үйлийн түйтгэр арилна. Шинээр хураах залгамжаа тасрахад хүрнэ.

Номнох, сонсох ёсыг зөвөөр буулгаж чадваас номносон увдис маань ч өөрийн сэтгэлд тус болохыг болгоон урьдын дээдэс мэргэд үүнээ тун хичээнгүйлэн иржээ. Ялангуяа энэхүү увдиснаа бүр ч их хичээнгүйлэн зохиожээ. Энэ бол агуу увдис билээ. Үүнээс та ухаарал олж сэтгэл бодлоо өөрчилж чадахгүй бол хичнээн гүн дэлгэр номыг заалгавч "бурхан нь буг болж буулаа гэдэг" шиг нөгөө ном нь эргээд муу сэтгэлийн хань болж одох явдал олонтаа үзэгдэнэ.

Тиймээс "шинийн нэгнээс алдаа гаргахгүй бол арван таван хүртэл" хэмээн хэлцдэгтэй адил сонссон заасанаа эрдмийн мөр болгодог энэхүү ёсноо ухаантан мэргэд шамддаг билээ.

Номнох сонсохын боломж гарах бүрийд шамдах ба наанадаж хүсэл эрмэлзэлтэй байх хэрэгтэй. Увдисыг заахын тулд удиртгал болгон өгүүлсэн минь энэ билээ. Энд үг олон болчихвий гээд гол голыг хураангуйлан үзүүлэв. Дэлгэрэнгүйг бусад эх сурвалжуудаас болгоох ажаам.

Увдисын удиртгалыг номновой.

ҮНДСЭН БҮЛЭГ

IV. БОДИТ УВДИСААР ШАВИЙГ ХЭРХЭН ХӨТЛӨХ ЗЭРЭГ

А. Мөрийн язгуур - Буяны садныг шүтэх ёсон [20]
Б. Шүтэж сэтгэлээ хэрхэн судлах зэрэг

А. Мөрийн язгуур – Буяны садныг шүтэх ёсон

1. Ойлголт төрүүлэхийн тул өчүүхэн дэлгэрэнгүй номнох
2. Бясалгах ёсыг хураангуйлан үзүүлэх

1. Ойлголт төрүүлэхийн тул өчүүхэн дэлгэрэнгүй номнох:

"*Шимийн магад хураангуй*" -гаас:

Язгуурт оршсон бодгаль тэрбээр
Дээд буяны садныг шүтэж үйлдэх хэмээсэн ба [21]

Долбава гэгээний эмхэтгэсэн "*Бодова гэгээний зарлиг зөвшөөл*"-өөс:

Хамаг увдис бүгд гарахын үүд нь
Дээд буяны садныг үл орхих явдал мөн

хэмээсэн мэтээр шавийн үндсэнд нэгэн зүйл эрдэм төрөх, нэгэн зүйл гэм хорогдохоос эхлээд хамаг сайн амгалан төрөхийн орон нь эрхэм буяны садан багш мөн бөлгөө. Тиймээс эхлээд түүнийг шүтэх ёсон тун чухаг ажгуу.

"*Бодисадвын аймаг сав*" [22] -аас: "Товчилвоос бодисадвын хамаг явдлыг эзэмших, огоот төгсгөх, улмаар чинад оройд хүрэх, газрын эрдэм олох, тэсвэр, бясалгал, илт мэдэл, тогтоол самбаа, зориулга ерөөл болоод бурханы хамаг номыг эзэмших, төгс төгөлдөр болох зэрэг тэд бүгд багшид л харгалзана. Багш язгуур болно. Багшаас үүднэ. Багш төрөхүйн орон мөн. Багш төрөн түгээгч болно. Багш төрүүлнэ. Багш арвижуулна. Багшид гавьяарна. Багш үндэс шалтгаан болно" хэмээн айлджээ.

Бодова гэгээн бээр ч: "Тийн гэтлэхүйн хутгийг (нирваан) бүтээхэд ч багшаас илүү их хэрэгтэй нь үгүй. Энэ насны ажпыг бүтээхэд ч багшгүйгээр

үл бүтэх билээ. Тиймээс дөнгөж сая нэг муу заяанаас мултарчихаад огт явж үзээгүй замаар явах болоход чинь багшгүй бол яахин одох билээ" хэмээн айлджээ.

Чингээд буяны садныг шүтэх ёсноо зургаан зүйл:

а. Шүтээн буяны садны бэлэг чанар
б. Шүтэгч шавийн бэлэг чанар
в. Тэр бээр хэрхэн шүтэх ёсон
г. Шүтэхийн тус эрдэм
д. Эс шүтэхийн гэм
е. Утгын хураангуй

а. Шүтээн буяны садны бэлэг чанар

Ер эрхэм зарлиг тааллын тайпбар сэлтээс хөлгөн тус тусын ёсны дагуу олон зүйлийг айлдсан буй. Гэхдээ эл үест гурван төрөлхтний мөрд зэрэгчлэн дагуулж улмаар их хөлгөний мөрд хөтлөгч буяны садан нэгнийг багш хэмээмой. Энэ талаар "*Судрын чимэг*"-ээс айлдахдаа:

Номхон (1), Амарлингуй (2), Чухал амарлингуй (3),
Эрдмээр үлэмж (4), Хичээнгүй (5), Ном эшээр баян (6),
Хоосон чанарыг машид оносон (7), Өгүүлэхдээ мэргэн (8),
Энэрэнгүйн эзэн (9), Уйтгарыг тэвчсэн (10) буяны садныг шүт хэмээжээ.

Энд шавь хүн бээр арван эрдэм төгөлдөр буяны садан багшийг олж шүтэх учиртайг зарлиглажээ. Хэрвээ өөрөө номхроогүй (боловсроогүй) бол бусдыг номхруулах аргагүй гэж айлдсан байх тул, бусдыг номхруулах багш тэрээр эхлээд өөрийн үндсээ номхруулсан байх шаардлагатай.

Чингэвээс "номхон (боловсрох) байх гэж юу вэ. Зөвхөн тухайн тухайн үед хийх ёстой бүтээлийг үйлдэж онолын эрдэм гэж нэрийдсэн ганц нэгэн зүйл сэтгэлд орших төдийгөөр тодорхойлж болохгүй. Харин нийт бурханы номтой зохилдсон тийм нэгэн аргаар сэтгэлээ номхруулсан байх хэрэгтэй.

Тэрхүү арга болвоос магадтайяа ёс суртахууны суртгаал (винай) тэргүүтэн их эрдэнийн гурван суртгаал (ёс суртахууны, бясалгалын, билгийн суртгаалууд) бөлгөө.

"*Винай*" гэдэг ёс суртахууны суртгаал болохыг "*Тус тус гэтэлгэгч судар*" -аас:

Насан турш хичээж шамдан байж
Залахад бэрхтэй сэтгэлийн морины аман жолоог
Зохилдох хазаараар хазаарлан ташуурдаж чадваас
Тус тус гэтлэх гэдэг энэ буюу хэмээсэн ба

Мөн "*Эшийг тийн ялгагч*"-аас:
Номхроогүй шавийн хазаар энэ мөн

хэмээсэн мэтээр эмнэг хангалыг сургагч бээр сайн хазаартай байж эмнэг түүнийг номхруулдагтай адилаар, эмнэг догшин морь шиг сэтгэл маань ёс бусын буруу зүг рүү одоход түүнийг хазаарлан зогсоох хэрэгтэй. Чингэж зохистой зүг рүү хөтлөх ёс суртахууны суртгаалд олонтаа хичээн суралцсанаар сэтгэлийн морийг номхруулж чаджээ.

"Амарлингуй" нь тэр мэт сайн муу явдалд орох буцахаа санаж бас ухамсарлан мэдээд сэтгэлээ дотогш амарлиулан барьсан бясалгалын (самади) суртгаал төрснийг өгүүлжээ.

"Чухал амарлингуй" нь сэтгэлээ үйлэнд эдлэх (өөрийн эрхээр эдлэх) амарлингуй сэтгэлд түшиглэн үнэмлэхүй утгыг тус тус шинжлэх билгийн суртгаал эзэмшсэнийг өгүүлжээ. Гэхдээ эдгээр гурван суртгаалаар сэтгэлээ номхруулсан онолын эрдэм төдийг олсноор хязгаарлаж болохгүй. Үүний дээр эшийн эрдмээр төгс төгөлдөр байх хэрэгтэй.

Иймээс гурван аймаг савын номыг олонтаа сонссон учраас "эшээр баян" болох аж. Буяны садан Донбова бээр: "Их хөлгөний багш бээр үйл ажлыг номноходоо агуу ихийг ухааран гарын авлага болгож чадсан бөгөөд эгэл доодоос эхлээд хэнд юу заавал таарах гэдгийг мэдэрсэн номыг заагч нэгэн байх хэрэгтэй" гэжээ.

"Хоосон чанарыг онох" нь билгийн суртгаалын онцлог болох хоосон чанарыг онох талаас буюу хоосон чанарыг илт болгоохыг голлон үзүүлжээ. Хэрвээ тиймгүй байсан ч эш болон онолоор ухаарсан байх учиртайг айлджээ.

Энэ мэтээр эш онол төгс төгөлдөр боловч шавиасаа доогуур юмуу эсвэл тэнцүүхэн байж таарахгүй. Иймд эрдмээр үлэмж илүү байх шаардлагатай. Зашэ гэгээний "*Цоморлиг*"- оос:

Доод нэгнийг шүтвээс доройтох адил
Тэнцүү нэгнийг шүтвээс байрандаа байх
Эрхэм дээдийг шүтвээс л эрхэм дээд болюу
Тиймээс эрхэм дээдийг шүтсүгэй би

Ёс суртахуун, чухал амарлингуй болоод
Эрхэм дээд билиг төгөлдөр болсон
Аливаа эрхэм дээдийг шүтвээс
Эрхэмээс ч илүү эрхэм дээд болох хэмээжээ.

Пүчүнва гэгээн бээр: "Дээдэс сайчуулын намтар цадигийг сонсож дуулаад багш түүн рүү нүдээ нээн харсан билээ" хэмээсэн буй.

Тааши гэгээн бээр: "Миний нүдний шүтээн болвоос Радингийн өтгөс мэргэд билээ." хэмээсэн мэт үлэмж эрдэмтэй нэгэн рүү нүдээ нээн харах хэрэгтэй шүү. Дээрх зургаан эрдэм нь өөрөө олсон эрдэм бөлгөө. Бусдыг даган байж олсон эрдмүүд үлдсэн хэсэг эрдэм бөлгөө.

Энэ тухай "*Судар*"-аас:

Бурхад хилэнцийг усаар үл угаах
Амьтны зовлонг гараар үл арилгах
Өөрийн ухааныг ч бусдад үл шилжүүлэх
Номын чанар үнэнийг зааснаар л гэтэлгэн зохиох

хэмээн айлдсан мэт хуурмаггүй үнэн зам мөрийг амьтан бусдад зааж, дагуулан барихаас өөрөөр хилэнцийг усаар угаах зэргээр үл үйлдэх буюу.

Энэ үест дөрвөн зүйл эрдэм буй. "Өгүүлэхдээ мэргэн" нь хэрхэн хөтлөн заахын арганаа мэргэн болоод шавийн ухаанд утгыг шигтгэх уран чадвартай болой.

"Энэрэнгүй" нь ном заах сэтгэл ариун байх буюу элдэв олз ашиг, нэр хүнд горилолгүйгээр асрах, энэрэх сэтгэлийн үүднээс ном заах болой. Бодава гэгээнээс Жан ава-д ийн өгүүлрүүн " Лимогийн хөвгүүн ээ, Хичнээн ч удаа ном номнолоо гэсэн, би сайн байна шүү гэж бүү бод. Зовлонгүй амьтан нэг ч байхгүй гэж айлдсан нь үнэн байна даа" хэмээжээ.

"Хичээл шамдлагатай" байх гэдэг бусдад туслах эрмэлзэл зориг болой.

"Уйтгараа тэвчих" гэдэг дахин дахин номнохдоо үл алжаах буюу ном номнохдоо хатуужил тэсвэртэй болохыг илэрхийлжээ.

Бодава гэгээнээс: "Гурван суртгаал, хоосон чанарыг онох ухаан, их энэрэнгүй сэтгэл эдгээр нь гол таван эрдэм болно. Бидний Шанзүн багшид сонссон зүйл тийм ч олонгүй, уйсахдаа тэсвэр байхгүй, ачийн хариуг бодох зэрэг байхгүй ч дээрх таван эрдэм байсан учраас дэргэдээ ирсэн хэн бүхнээ тус хүргэх бөлгөө.

Няндан багшид мэргэн цэцэн үг огт байхгүй билээ. Харин ном номнохдоо хүн бүхэн миний хэлснийг ухаарахгүй байх вий гэж сэтгэл зовдог байж. Гэвч таван эрдмийг эрхшээсэн учраас дэргэдийн хэн бүхнээ ач тус хүргэв хэмээн айлджээ.

Харин суртгаалыг биелүүлж бүтээгээгүй хэрнээ тэдний эрдмийг өгүүлж магтах зэргээр өөрийн амьжиргаагаа бүтээдэг нэгэн буяны садан байж таарахгүй. Зандан модыг магтан амиа тэжээгч нэгнээс зандан модыг хэрэглэгч нэгэн бээр "Танд тэр мод чинь байна уу" гэж асуухад "Байхгүй ээ" гэж хариулдагтай адил ямар ч утгагүй үг төдий зүйл болдог учиртай.

"Бясалгалын хаан судар"-аас:

Хожмын цагт санвааргүй олон
Аяга тахимлагууд төрж
Олонтоо сонсохыг л хүсэх болно
Ёс журмыг сайшаан өгүүлэхээс бус
Ёс журмыг тус болгож хэрэглэх үгүй болох

хэмээн бясалгал, билиг, тийн тонилохуй гурав дээр ч мөн ийн болохыг

Хэрхэн зарим нэгнүүд
Аяа, Зандан мод гэдэг энэ шүү
Ийм сайхан энхэр үнэртэй гэхчилэн
Зандан модны эрдмийг өгүүлэх

Тийнхүү магтан сайрхах
Зарим хүмүүсээс,
Зандан модтой ижилсэх юм байна уу гэж
Заримууд асууж лавлахад

Нөгөө хүн ийн хариулах
Амиа тэжээхийн тулд
Үнэрт модыг сайшаан өгүүлэхээс бус
Үнэндээ надад тэр үнэр чинь байхгүй гэх

Үүнтэй адил егүзэрт үл хичээж
Ёс журмыг магтах төдийгээр амьдрагч нар
Хожмын цагт гарч ирэх бөгөөд
Тэдэнд ёс журам үгүй буюу

хэмээн бусад гурав дээр ч мөн адил болохыг айлджээ.

Чингээд тонилохуйн хутгийг бүтээх буяны садан - багш гэдэг ашдын үйл хэргийг бүтээгч үндэс болдог учраас багшийг шүтэхээр хүсэгч нар эдгээрийг ухаарч бэлэг чанар төгөлдөр нэгнийг олж шүтэх хэрэгтэй билээ. Мөн олон шавиар шүтүүлэхийг хүсэгч нар ч гэсэн эдгээрийг мэдэж аваад тэрхүү бэлэг чанар төгөлдөр байхын төлөө хичээж шамдах хэрэгтэй шүү.

Цагийн эрхээр эдгээр эрдмүүд төгс төгөлдөр болсныг олоход бэрхтэй тул хэрхэх вэ хэмээвээс "*Бунсан бээр айлтгасан судар*"-аас:

Ганц өрөөсөн дугуйтай модон тэргэнд
Хэдий морь хөллөсөн ч замд явдаггүйн адил
Бүтээлийн хань нөхөр байхгүй бол
Амьтан хүн шид бүтээлийг олох гэж үгүй билээ

Тэрээр ухаантай, сайхан намбатай, цэгц журамтай
Язгуур гарал сайтай, ном буянд хичээнгүй шамдалтай,
Авхаалж самбаа ихтэй, зоригтой, усхал дөлгөөн,
Яруу сайхан өгүүлэгч, өглөг буянд эрэмгий, нигүүлсэх сэтгэлтэй,

Өлсөх цангахын зовлонд болон муу сэтгэл төрөхөд тэсвэртэй
Бярман болон ертөнцийн тэнгэр бусдыг үл шүтэгч
Ядуу гуйлгачинд болон ач тус хүргэснээ ачийг хариулагч
Чухаг дээд гурвыг сүсэглэгч нөхөр байх хэрэгтэй буюу

Энэ адилын эрдэм төгөлдөр нэгэн
Эл цөвүүн цагт олдоход ховор тул
Эрдмийн дөрөвний нэг хувь, эсвээс наймны нэг хувьт
Тэр адилыг сайшаасан тул тийм нөхрийг шүтсүгэй хэмээн бэлэг чанар

төгөлдөр шүтэх нөхөр маань наанадаж наймны нэг хувийн эрдэмтэй нөхөр байхыг айлджээ. Багш дээр ч мөн ийм байх ёстой гэж Жову богд айлдсаныг Долба гэгээний эмхэтгэсэн “Бодавагийн зарлиг зөвшөөл” бүтээлд үзүүлсэн тул бэлэг чанар төгс төгөлдөр байх гэдэг бэрх, хялбар алин боловч наанадаж найман хувийн эрдэм төгөлдөр байх хэрэгтэй ажээ.

Б. Шүтэгч шавийн бэлэг чанар

Шүтэгч шавийн талаар “*Дөрвөн зуут*”-аас:

Төв шударга(1), ухаан төгс (2), тусад хэрэглэгч (3) нь
Сонсохуйн сав хэмээн номнов
Өгүүлэгчийн эрдмийг өөр байдлаар
Үл урвуулан сонсох төдийгүй [23]

хэмээсэн мэт гурван ном төгөлдөр аваас ном сонсохын сав болдог буюу. Тэр гурав бүрдвээс номыг өгүүлэгчийн эрдмүүдийг эрдэм гэж үзэхээс бус гэмтэй гэж үл үзэх бөлгөө. Түүгээр зогсохгүй сонсогчийн эрдмийг ч бусад хүмүүс эрдэм гэж үзэхээс бус гэмтэй гэж үзэхгүй болно.

Харин савны бэлэг чанар эс бүрдвээс номыг өгүүлэгч буяны садан хичнээн ариун байсан ч сонсогчийн гэмийн эрхээр гэмтэйд тооцогдож улмаар номногчийн буруу тал ч зөв зүйтэй мэтээр харагдаж болохыг “*Тайлбар*”-аас айлджээ.

Хэдийгээр бэлэг чанар төгөлдөр бүрдсэн буяны садан нэгийг оллоо ч гэсэн түүнийг тийн болохыг таньж мэдэхэд бэрхтэй. Тийн гэж бодоод шүтэх үед ч эдгээр бэлэг чанарууд бүрдсэн байх хэрэгтэй.

Үүнээс “төв шударгуу байх” гэдэг зүгийн уналгүй байх (туйлшралгүй байх) явдал юм. Харин тийм явдалтай аваас түүндээ дийлдээд сайн талыг харахаа байж улмаар сайн номын утгыг олохгүйд хүрдэг.

“*Төв үзлийн зүрхэн*”-ээс:

Туйлширч унах сэтгэлийн энэлгээнээс болж
Төв амарлингуйг хэзээ ч оножү үл чадах хэмээн айлдсан мэт. [24]

“Туйлширч унах“ гэдэг өөрийн ёсноо шунан тачааж, бусдын жам ёсноо уурлах болой. Ийм зүйл өөрийн чинь сэтгэлд буй эсэхийг шинжээд орхих хэрэгтэй.

"Бодисадвын тус тус гэтлэхүйн судар"-аас "Өөрийн хүслийг огоорон багш дээдсийн гол ном зарлигийг сонсож бишрэн үйлдэх" хэмээн айлдсан буй.

Энэ төдийгээр болох уу хэмээвээс хэдий төв шударгуу байвч сайн номлол, зөв мөр мөн үү, эсвээс буруу номлол, хазгай мөр үү гэдгийг ялгаж салгаж мэддэг оюун ухааны хүч мөхөс бөгөөс сав болж чадахгүйд хүрнэ. Тиймээс тэр хоёроо ялгадаг ухаан төгөлдөр байх хэрэгтэй. Чингэвээс шим тусгүй зүгийг орхиж шимтэй зөвийг барьдаг болно.

Тэр хоёроор болчих уу хэмээвээс тэр хоёр бүрдсэн хэдий ч үзмэрийн ном сонсож байгаа юм шиг үл хичээх аваас сав болохгүйд хүрнэ.

"Тайлбар"-аас: "Ном хийгээд номыг айлдагчнаа бишрэх болон сэтгэлээ тушаах" хоёрыг нэмээд тав болгон айлджээ. Ингээд номыг чухалчлан тусад хэрэглэх, сонсохын цагт сэтгэлээ сайтар тушаах, ном хийгээд номыг өгүүлэгчнээ их бишрэн хүндэтгэх, буруу номыг орхиж зөв номыг барих дөрөв болой.

Эдгээр дөрвийн зохилдох нөхцөл нь ухаан төгөлдөр байх явдал буюу. Харшлах шалтгааныг огоорох гэдэг төв шударгуу орших болой. Багшаар хөтлүүлэх номынхоо бүрэн, бүрэн бус эсэхийг нягтлаад бүрэн аваас баясаж сурах, бүрэн бус аваас дараа гүйцээж авахын нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Суурь нэр эдгээрийг мэдсэн хэрнээ эдгээрийн бэлэг чанарыг үл ухаарваас шинжих бодол орж ирэхгүй тул их үйлээс няцах вий.

В. Шавь багшаа хэрхэн шүтэх ёс

Сав төгөлдөр болсон шавь бээр дээр номносон дагуу бэлэг чанар төгс, эс төгс болохыг сайтар шинжлээд бэлгэ чанар төгөлдөр багшаас ном зарлигийн ачийг хүртвээс зохистой.

Энэ талаар гэвш Долбова болон Санпүва нарын таалал өөр өөр байдаг. Санпүва олон багшийг шүтэж, заасан бүхнийг сонсдог байж. Хамаас ирэх зам дээр нэгэн уваш ном зааж суухад тэрээр түүнийг сонсохоор очжээ. Нөхөд нь "сонсохоор юм биш" гэж цааргалахад тэрээр "Та нар бүү ингэтүгэй, надад хоёр их хэрэг тус байна" гэсэн гэдэг.

Гэвш Долбова бээр дөрөв таваас хэтрэхгүй цөөхөн багшийг шүтдэг байсан гэдэг. Бодова, Гомборинчэн хоёр багш бээр дээрх хоёрын алин нь сайн болох талаар айлдахдаа: "Гэмтэй гэж хардаг, олигтой сүсэг бишрэл

төрөөгүй, сэтгэл ухаан боловсроогүй үед, гэвш Долбовагийн ёс нь илүү зохимжтой тул тэр мэт үйлдээрэй" хэмээжээ. Энэ ёс нилээд дэлгэр үзэгдэх тул энэ дагуу үйлдээрэй.

Чингээд зарлигийн ачийг хүртээгч ерөнхий болон ялгамжаатай төгс төгөлдөр увдисаар оюун ухааныг сайтар хөтлөгч буяны садныг хэрхэн шүтэх ёсноо хоёр зүйл:

1) Сэтгэлээр шүтэх ёсон
2) Үйл ажилаар шүтэх ёсон

1) Сэтгэлээр шүтэх ёсноо гурав:

а) Шүтэх сэтгэлийг ерөнхий үзүүлэх нь
б) Ялангуяа язгуур болсон - сүсэглэх сэтгэлийг үзүүлэх
в) Зарлигийн ачийг санах - бишрэх сэтгэлийг үзүүлэх

а) Шүтэх сэтгэлийг ерөнхий үзүүлэх нь

"Гол модон байгуулах судар"-аас "Есөн сэтгэлийн үүднээс буяны садныг бишрэн хүндлэх учиртай" хэмээн хамаг шүтэх сэтгэлийн товчоог тэдгээрт багтаан айлдсан буй. Тэдгээрийг хураангуйлваас дөрвөн зүйл болно.

"Цэцэн хүү" адилын сэтгэл гэдэг өөрийн эрхийг орхиж багшийн эрхэнд орох болой. Цэцэн хүү болвоос алив ажил үйл хийхдээ өөрийн дураар оролгүй эцгийн нигуурыг хардаг агаад эцгийн заасан хэлсэн дагуу явдаг мэтээр буяны садны нигуурыг харах болой.

"Эдүгээгийн бурхадын илт болгоогч бясалгал"-аас: "Тэрээр өөрийн хамаг эрхээ орхиж, буяны садны ухаанаар явах болмой" хэмээжээ. Гэвч энэ адилаар явахдаа бэлэг чанар төгс нэгнээ чингэхнээс бус, хэн дуртайд хамраа дөрлүүлэх бус хэмээн айлдсан буй. [25]

"Очир адилын сэтгэл" гэдэг бие биенээ садан лугаа ялгалгүй баттай үзэх буюу. Муу нөхөр, чөтгөр шумнас зэрэг хэн нэгнээс болж салж холдох хэрэггүй. Дээрх *"Судар"*-аас: "Улааныг харж урвалзахгүй, шарыг үзэж шарвалзахгүй" хэмээн айлджээ. [26]

"Газар адилын сэтгэл" гэдэг багшийн өгсөн үүрэг ажил юу бүхнийг үүрэх сэтгэл буюу хамаг үүрэгт ажлыг үүрэхээсээ үл шантрах явдал ажгуу. Бодова гэгээн бээр Жан-а-ва гэгээний шавь нарт хандан: "Миний багш

буяны садан энэ адилын бодисадва лугаа учран, зарлигчлан бүтээж байгаа та бүгд их буянтай ажээ. Эдүгээ ачаа үүрэг гэж үзэлгүй, оройн чимэг шүтээн гэж үзэгтүн" хэмээн айлдсан мэтээр болой. Зургаан зүйлээр үүрэг үүрэхээс *"Эргэн тойрны уул адил сэтгэл"* гэдэг ямар ч зовлон бэрхшээл тохиолдоход үл хөдлөх болой. Жан-а-ва гэгээн Рүгва-д залрах үед даарснаас болж Гомбо Ёндонбар хэмээх бүтээлчний лагшин чилээрхжээ. Тэрээр Шоннү Дагва ламтанд бараалхаж явах суухыг айлтгаж гэнэ. Шоннү Дагва бээр: "Амгалан суудалт, асар ялгуусан орд харшид заларчихаад яах нь вэ. Их хөлгөний буяны садныг шүтэж ном сонсох гэдэг эдүгээгээс цааш олдохгүй тул тогтож суугтун" хэмээн түүнд айлдсан адил буюу.

"Ертөнцийн боол адилын сэтгэл" гэдэг хамаг муу үйлийг эдлэвч сэтгэл огт гутрахгүй бүтээх явдал аж. Их бандида Адиша болон дуун хөрвүүлэгч нар морилох зуур нэгэн их шороо шавхайтай газар бууджээ. Гэтэл Донбова гэгээн хувцсаа тайлан шаврыг арилгаад хаа нэгтэйгээс хуурай цагаан шороо авч ирж дэвсжээ. Улмаар Жову богдын өмнө мандал өргөсөнд Жову гэгээнээс "Аяа! Тань шиг шавь Жагарт нэг байсан билээ" гэж айлдсан гэдэг.

"Тууржуур адилын сэтгэл" гэдэг нь омог болоод их омог бүгдийг лавтай тэвчин, өөрийгөө багшаасаа доорд барих болой. Гэвш Донбова бээр: "Омгийн цөгцөнд эрдмийн ус тогтохгүй" хэмээжээ. Жан-а ва гэгээн бээр: "Хаврын цагт өндөр уул толгодын оройн өвс ногоорох нь уу, өчүүхэн намхан хормой бэлийн өвс ногоорох нь уу хараарай" хэмээн зарлигласан гэдэг.

"Хөлөг адилын сэтгэл" Багшийн ажил машид үйлдэхэд бэрхтэй бас үүрэхэд хүнд байсан ч түүнийг дуртайяа үүрэх бөлгөө.

"Нохой адилын сэтгэл" Багш загнан аашлавч түүнд үл уурлах мөн. Долүнба гэгээн бээр бурхан урлаач гэвшийг уулзах болгондоо загнадаг байж. Түүний шавь Нягмова бээр: "Энэ хүн багш бид хоёрыг дандаа л загнаж байх юм. Та түүнийг загнаж болдоггүй юм уу" гэхэд "Багш минь намайг ингэж загнах тоолонд Хируга бурханы адистид тэр төдийгээр надад оршдог юм" гэж хариулсан мэт болой.

"Найман мянгат"-аас ч: "Хэдий номыг өгүүлэгч бээр номыг хүсэгчийг загнах, үл тоомсорлох мэтээр үзэгдэвч, та түүнтэй зөрүүдлэж бүү үйлд. Харин улам номоо чухалчлан биширч, залхалгүйгээр араас нь дагаарай" хэмээн айлджээ.

"Хөлөг онгоц адилын сэтгэл". Багшийн ажил үйлд үргэлжид тусалж одох ирэхээс үл уйдах болой.

б) Ялангуяа язгуур болсон - Сүсэглэх сэтгэлийг үзүүлэх

"*Гончог Далала тогтоол*"-оос:

Эхлээд сүсгийг эх ундарга адил төрүүлж
Эрдэм бүгдийг сахин арвижуулж үйлдэх
Элдэв сэжиг арилж далайгаас гэтлэх
Сүсэг болвоос сайн амгалангийн тэмдэгт хот мөн

Сүсэг болвоос хиргүй тунгалаг сэтгэлийг үүдэгч
Омог арилсан бишрэх сэтгэлийн язгуур буюу
Сүсэг болвоос эд баялаг, хүү сан хийгээд хөлтний эрхэм
Гар адил буяныг хураагч үндэс мөн хэмээжээ.

"*Арван номт судар*"-аас:

Ашид хөтлүүлэн магад тонилохуй яа
Аливаа хөлгөний дээд нь сүсэг буюу
Арга иймээс ухаантан мэргэд бээр
Анхнаас сүсгийг даган орж шүтвэй

Үл сүслэх хүмүүн түүнээ
Үлэмж буяны ном үл төрөх буюу
Хөрөнгө нь галд хөнөөгдсөн
Хөх ногоо хэрхэх адил бөлгөө хэмээжээ.

Донбова гэгээн Адиша богдоос "Төвдөд бясалгал бүтээл хийдэг хүн олон байх юм. Гэхдээ ялгамжаатай эрдэм чадал олсон нэгэн ерөөс төрөхгүй юм" гэж гайхан асуужээ.

Адиша богд бээр: "Их хөлгөний эрдэм их бага төрөх гэдэг бүгд багшид харгалздаг юм. Танай төвдүүд багшийгаа эгэлд үзэхээс цаашгүй тул яаж төрөх билээ" гэсэн гэдэг. Богдоос "Адиша та увдис айлдана уу" гэж өндөр дуугаар айлтгахад "Ха, Ха! Миний чих сайнаас сайн шүү!" гэж хөхрөөд "Увдистай болно гэдэг сүжигтэй байх юм шүү дээ. Сүслэгтүн, сүслэгтүн!" хэмээн айлдсан учир сүжиглэх сэтгэл маш чухал бөлгөө.

Ер нь чухаг дээдэд, үйлийн үрд, дөрвөн үнэнд сүжиглэх зэрэг олон зүйлийн сүжиг байдаг ч энэ үест багшаа сүсэглэх сэтгэл болой.

Чингээд шавь хүн багшаа хэрхэн үзэх талаар "Очирваань авшиг хүртээгч тантр"-аас: "Нууцийн эзэн! Шавь хүн багшаа хэрхэн үзэх вэ хэмээвээс, Ялж төгөлдөр нөгчихсөн бурхантай адилд үзэх буюу.

Түүний сэтгэл тэр адил болвоос
Үргэлжид буян төрөх буюу
Тэр л ертөнц бүхний
Тусыг туурвигч бурхан болох" хэмээжээ. [27]

Их хөлгөний судрын аймгаас ч бурхан адилд үзэх хуран мэдэл төрүүлэхийг зарлиглажээ. Винайн судраас ч тэр адил зарлигласан буй. Хэдий чинээ багш нараа бурхан адилд үзэж чадваас төдий чинээ гэмтэйд үзэх атхаг сэжиг арилж харин эрдэм чадлыг бодох ухаан төрнө гэсэн утга мөн. Тиймээс тухайлан багшаа бодохдоо аливаа буруу сэжгийг огоорон эрдэм тусыг бодох ухаанаар бясалгах учиртай.

Мөн дээрх "*Тантр*"-аас: [28]

Багшийг эрдмийн талаас барь
Гэмийн талаас хэзээ ч бүү барь
Эрдмийг бариваас шид бүтээлийг олох
Гэмийг бариваас шид бүтээл эс бүтэх хэмээн айлдсанаар үйлдээрэй.

Энэ мэтээр багшийн эрдмийн хувь их боловч түүнд байгаа өчүүхэн гэмийн талаас сонжвоос өөрт шид бүтээлийн тотгор ирдэг байна. Тиймээс гэмийн хувь их байлаа ч гэмийн талаас сонжихгүй, эрдмийн талаас барьж сүсэглэж чадваас өөрт шид бүтээл гарахын үндэс болдог аж.

Хэрвээ сэрэмжгүйгээс буюу олон нисваанисын эрхээр сэжиглэж буруутгах санаа төрвөөс тэр цагт наминчлан боомтлохоор шамдаарай. Чингэж чадваас аажимдаа хүч нь багасгах болно.

Тийнхүү ёс суртахуун, олныг сонссон, сүсэг бишрэл тэргүүтэн эрдмийн зүгийг ухаандаа барьж багшийнхаа эрдэм ухааныг санаж бодоорой. Энэ мэтээр бодож чадваас бага сага гэм үзэгдэвч эрдмийн зүгийг ухаандаа барих учир сүжигт тотгор учрахгүй.

Үлгэрлэвээс, өөрийн чинь дургүй хүн эрдэм ихтэй боловч, түүнийг гэмтэй гэж үзэх бодол чамд хүчтэй байдаг учраас л түүнийг эрдэмтэйд үзэх бодлыг чинь хааж байдаг. Мөн хэдий надад гэм олон байвч өөрийнхөө

ганц нэг эрдмээ гайхуулах бодолдоо эзлэгдээд өөрийн гэмээ ухаарах бодлыг дардагтай адил болой.

Адиша гэгээн "Төв үзэлтэн" (мадхъямика) байжээ. Харин түүний багш Сэрлинба багш бээр "намба дүрсийг үнэнд баригч-сэтгэлийн төдийтний үзэлтэн" (ёгачара) байж. Ийнхүү үзэл онолын үүднээс үзвэл багш шавь хоёрын хооронд дээд доодын ялгаа байжээ.

Гэсэн хэдий ч хамгийн гол их хөлгөний мөрийн зэрэг болон бодь сэтгэлийн увдис зэргийг тэр л багшаа шүтэн байж олж хүртсэн учраас Сэрлинба багшийгаа бусад багш нарынхаа дотроос ханьцашгүй багш хэмээн дээдлэн шүтсэн түүхтэй.

Эрдмийн талаас барилгүй гэмийн талаас сонжих аваас ёс жудаг цалхайрхад хүрнэ. Тиймээс нэгэн бадаг төдий ном заалгаснаас дээшихийг ялгалгүй багш хэмээн үзэх хэрэгтэй.

"Чухаг дээдийн үүлэн судар"-аас: "Багшийг шүтвээс буян арвижиж хилэнц хорогдохыг ухаар. Их сонссон, бага сонссон болон мэдсэн, эс мэдсэн, ёс суртахуун төгөлдөр, төгөлдөр бус алин байлаа ч багшаа бурхан адилд үзэх бодол ухааныг төрүүл.

Хэрхэн бурханаа баясах, сүжиглэх адилаар багшдаа сүсэглэн баясаарай. Багшаа хэрхэн хүндэтгэж өргөн дээдэлсэн түүний хэрээр бурхан болох бөгөөд буян гүйцээгүйн буян гүйцэх, нисваанисаа бараагүй нь барах, баясгалан амгаланг олох, буяны номтой зохилдон орших ба нүгэлтэй үл зохилдон оршмой".

"Дагшулжан айлтгасан судар"-аас: "Гэрийн эзэн! Бодисадва нар эш ном хүртэх, амны уншлага хийхээр чухалчлах болон өглөг, ёс суртахуун, тэсвэр, хичээнгүй, бясалгал, билгүүн зэрэг эрдэм юугаа төгөлдөр болгохын тухайд бодисадын мөрийн буяныг төгөлдөр хураах ганцхан шүлэг номыг сонссон, эш хүртсэн, авсан тэр л багшаа тэд номын ёсоор бишрч үйлддэг билээ.

Хэдий чинээ нэр, үг, үсэг юу нэгээр шүлэглэн үзүүлсэн тэр тоотой галбад тэр багшаасаа буцалгүйгээр олз омог, хүндэтгэл бишрэл, өргөл тахил бүгдээр дээдлэн хүндэлсээр ирсэн байхад, Гэрийн эзэн та, багшаа багш гэж төгс төгөлдөр эс хүндэлвээс ёс бусьн зүйл болох тул бусдыг хэлэхийн хэрэг юун" хэмээн айлджээ.

в) Зарлигийн ачийг санах-Бишрэх сэтгэлийг үзүүлэх

"Арван номт судар" -аас:

Би болвоос өнөд удаан орчлонд тэнэгчдийг эрэлцэн ологч
Би болвоос өнөд удаан мунхагаар хөлхөгдөгсдийг нойрноос сэрээгч
Би болвоос орчлонгийн далайд живэгсдийг татан гаргагч
Би болвоос муу мөрд зүглэгчдэд сайн замыг заагч

Би болвоос орчлонгийн гянданд хүлэгдэгсдийг гэтэлгэгч
Би болвоос өнөд удаан өвчинд нэрвэгдэгсдийн эмч оточ
Би болвоос хүсэл шунал тэргүүтний машид дүрэлзэх галыг
Унтраагч хурын үүлэн адил хэмээх хур мэдлийг үүсгэх болой

хэмээсэн ба *"Гол модон байгуулах судар"* - аас:

Шонну Норсон!
Буяны садан нар намайг хамаг муу заяанаас аврагч болой
Хоосон чанарын номыг ухааруулагч болой
Жаргал зовлонгийн замыг ялган заагч болой

Хотол сайн явдлыг увдислагч болой
Хамгийг болгоогчийн хот балгадын мөрийг заагч болой
Хамгийг болгоогчийн оронд хүргэгч болой
Номын төв далайд орогч болой

Гурван цагийн мэдэгдэхүүний далайг үзүүлэгч болой
Хутагтын чуулганы хот мандлыг заагч болой
Буяны садан нь цагаан зүгийн ном бүгдийг
Арвижуулан үйлдэгч болой
хэмээн даган дурдаж уйлан үйлдвэй хэмээсэн мэт санаарай.

Буяны садан багш бүгдээ өөрсдийн толгой дээр залан багшийнхаа намба төрхийг сэтгэлдээ бодон, хэлэндээ дээрх үгийг өгүүлж тэдгээрийн утгыг нэгэн үзүүрт сэтгэлээр санаж үйлдээрэй. Дээрх судрын тэдгээр үгсийг хамтатган найруулаарай. *"Гол модон байгуулах судар"* -аас:

Энэ болвоос миний буяны садан-номыг өгүүлэгч
Хамаг ном эрдмийг заан үзүүлэгч минь буюу
Бодисадвын явдал мөрийг төгөлдөр номногч
Та мөн хэмээх нэгэн үзүүрт сэтгэлээр энд ирэв ээ

Миний ээж адилаар эдгээр эрдмийг төрүүлэх
Эрдмийн сүүгээр хөхүүлэгч буурай ээж адил
Бодь мөрийн гишүүнийг төгс бясалгагч буюу
Элдэв хорлолыг няцаагч буяны садан билээ

Өтлөх, үхэхээс гэтэлгэгч эмч оточ адил
Хурын рашааныг буулгагч хурмаст тэнгэр адил
Наран, саран мэт буяны номыг дэлгэрүүлэгч
Амарлингуйн зүгийг гэрэлтүүлэгч тунгалаг наран адил

Дайсан болоод нөхөрт уул адил бөгөөд
Далай мэт үл хямрах сэтгэл төгөлдөр
Сайтар мэргэшсэн сэлүүрчин адил хэмээн
Энэ адилын сэтгэлээр Норсон би энд ирэв ээ

Бодьсадва миний ухааныг төрүүлэгч
Бурхадын хөвгүүний бодь явдлыг үүсгэгч
Эдгээр л миний буяны садан бурхан хэмээн сайшаагдсан
Энэ адилын буяны сэтгэлээр энд ирэв ээ

Ертөнцийн аврагч баатар адил бөгөөд
Итгэлт сартваахи аврагч нь та мөн
Эдгээрийг надад өгөгч амгалангийн нүд та мөн хэмээн
Энэ адилын сэтгэлээр буяны садныг өргөн хүндэлсүгэй

хэмээн шүлэглэн дуулсан адилаар санах бөгөөд Норсон бээр ийнхүү өөрөө орчуулан уншдаг байжээ.

2. Үйл ажилаар шүтэх ёсон

"Багшийн тавин шүлэг"-ээс:

Энд олныг хэлэхийн хэрэг юун
Багшийг баясуулах алин бүгдийг үйлд
Үл баясган үйлдэх бүхнийг тэвч
Тэр болон түүнээ шамдан шинж

Шидийг бүтээгч багшийг даган барь хэмээн
Очирыг баригч ямагт айлдсан тул
Таньж бариад байгаа бүхнээрээ
Багшийг огоот баясуулж үйлд хэмээн айлдсан мэт.

Товчлон хураавaас баясгах бүхнийг бүтээх ба үл баясгах бүхнийг тэвчихээр шамдах болой. Гурван үүднээс баясгах буюу (1) эд өлөгийг өргөх, (2) бие хэлээр өргөн хүндлэх, (3) зарлигчлан бүтээх болой.

Тэр талаар *"Судрын чимэг"*-ээс:

Олзоор хүндлэх, өргөн хүндлэх ба
Бүтээлийн үүднээс буяны садныг шүтсүгэй хэмээсэн ба
Батад агч ийн үзүүлж бүтээсэн түүгээр
Тэр л сэтгэлээр үнэхээр баясуулж үйлд хэмээн айлджээ.

а) Эд өлөг өргөх: *"Багшийн тавин шүлэгт"*-ээс:

Өөрийн тангарагт багшдаа
Өглөг бус хөвгүүн, эхнэр ба
Өөрийн амь биеэ үргэлжид өргөх хэрэгтэй тул
Төгс эдлэл өргөхийг хэлээд яах вэ хэмээгээд

Тэдгээрийг өгвөөс бурхан бүгдэд
Үргэлжид өргөл өргөхтэй адил
Түүнийг өргөснөөр буяны чуулган болох тул
Буяны дотроос шид бүтээлийн дээд болно хэмээн айлдсан мэт болой.

Мөн Лагсорва гэгээнээс: "Сайн нь байсаар атал тааруу муугаа өргөвөөс тангараг доройтно. Багш түүнийг баясгах юм уу, муушаахгүй болвоос гэм гарахгүй" гэж зарлиглажээ.

"Багшийн тавин шүлэгт"-ээс:

Барагдашгүй болтугай гэж сэтгээд
Өчүүхэн төдий сэтгэлд зохистой байсныг
Үлэмж ялгамжаатай чанарт болгон урвуулсан
Тэр хийгээд түүнийг л багшдаа өргөсүгэй

хэмээсэнтэй зохилдуулан өргөөрэй.

Багш болвоос шавийн буян хураах эрхэм дээд орон учраас тийнхүү бодож өргөх хэрэгтэй юм. Харин багшийн зүгээс тэдгээр зүйлд шунан омтгойрох ёсгүй. Шарава гэгээнээс: "Эд өлөг төдийд үл шунан номлол

бүтээлд баясах нэгнийг багш хэмээх мөн. Түүнээс буцваас нирваныг бүтээгч багш болж чадахгүй" гэжээ.

б) Бие хэлээр өргөн хүндлэх: Угаал өргөх, лагшинг илэх, хир хөлсийг цэвэрлэх, дэргэдийн бараа болох, багшийн эрдмийг өгүүлэх тэргүүтэн болой.

в) Зарлигчлан бүтээх: Хэрхэн айлдаж зарлигласан ёсоор харшуулалгүй бүтээх явдал нь эрхэм чухал болой.

"Төрөл дарааллын цадиг" -аас:

Тусалсны хариуд тахиж үйлдэнэ гэдэг
Тушаасныг зарлигчлан биелүүлэх явдал мөн хэмээн айлджээ.

Хэрвээ багшийн зарлигийн дагуу бүтээх хэрэгтэй болоход шүтсэн багш маань зохисгүй замд хөтлөх юм уу, гурван санваар лугаа харшлах ажилд оруулвал хэрхэх вэ хэмээвээс, Энэ талаар *"Винайн судар"*-т: "Ном бусыг өгүүлвээс буцааж үйлдээрэй" хэмээжээ.

"Чухаг дээд үүлэн судар"-аас: "Буян аваас түүн лүгээ зохилдон үйлдэх, нүгэл аваас үл зохилдон үйлдэх" хэмээсэн тул түүнийг тушаасан байсан ч сонсохгүй байж болно. Үл зохилдох зүйлд орохгүйн талаар "Арван хоёрдугаар төрлийн намтар"-т тодорхой буй. Гэхдээ эдгээрээр шалтаглан багшийгаа үл бишрэх, басамжлах, муушаах зэргээр авирлаж болохгүй.

Энэ талаар *"Багшийн тавин шүлэгт"*-ээс:

Зохистойгоор эс чадваас
Чадахгүй түүнээ үгээр хариул

хэмээсэн мэтээр ажиглаж сайтар үйлдээд үл орох мөн. Тэр мэт шүтэхийн цагт *"Судрын чимэг"*-ээс:

Түүний номын тушаалыг биелүүлвээс
Эрдэм төгөлдөр болох
Буяны садныг сайтар шүтнэ гэдэг

Эд өлөгөөр бус хэмээн айлдсан мэтээр номын тушаалыг биелүүлэх нь чухал. Бодова гэгээн бээр: "Ананд бээр Бурхан багшийн дэргэдийн бараа бологч явахын үед бурханы зөвшөөрөлгүй хувцас баринтаг өмсдөггүй, бурханы идээний үлдэгдлийг иддэггүй, гэнэт бурханы мэлмийн

өмнө одох хэрэг гарсан ч бурханыг хүндэлсү хэмээн заавал зөвшөөрөл айлтгаж байсан зэрэг нь ирээдүйн шавь нарыг болгоосон хэрэг. Бид нар өчүүхэн төдий ч ном бүтээгээгүй хэрнээ ганц нэг аяга тагшныхаа их багын хэмжээгээр болсон болоогүйгээ ярьж суудаг чинь алсдаа ялзрахын шинж шүү хэмээн айлдсан буй. [29]

Хэдий хугацаанд шүтэх ёстой вэ гэвээс, Бодова гэгээнээс: "Өөрт ганц нэг хэрэг гарахаар асуучихаад, тэр хэргээ бүтээчихээд өөр тийшээ явах зохисгүй тул ойр холын хэр хэмжээг тааруулан уртасгаж бүтээх хэрэгтэй" гэж айлдсан дагуу буюу.

г) Буяны садныг шүтэхийн тус эрдэм:

Бурханы хутагт ойртох, Ялгуусад баясах, буяны саднаар үл хоосрох, муу заянд үл унах, муу үйл болон муу сэтгэлд дийлдэхэд бэрхтэй болох, бодисадвын явдалтай үл харшлах, дурдан санах сэтгэл баттай болох учраас эрдмийн чуулган улам дээшлэн дээшлэн одсоор орон үесийн хийгээд алс хэтийн хэрэг бүхэн бүтэх болно. Багшаа хүндэлж дээдлэх сэтгэлийн болон үйл ажлын буяныг хурааснаар өвөр бусдын тусыг үйлдэн буяныг хотол чуулган дүүргэх болой.

Тийн болохыг *"Гол модон байгуулах"*-аас: "Язгуурын хөвгүүн ээ, Буяны саднаар огоот ээлэгдсэн бодисадва нар муу заянд үл унах болой.

Буяны саднаа санагч бодисадва нар бодисадвын санваартай харш зүйл үл үйлдэх болой. Буяны саднаар тэтгүүлэгч бодисадва нар ертөнцөөс үлэмж илүү бөлгөө. Буяны саднаа өргөн хүндлэгч бодисадва нар хамаг явдлаа үл умартан бүтээх болой. Буяны саднаар огоот хүрээлэгдсэн бодисадва нар үйл болон нисваанисаар үл чадагдах мөн" хэмээсэн ба "Язгуурын хөвгүүн ээ, Ялж төгөлдөр нөгчихсөн бурхад бээр буяны садны араас дагагч бодисадва нарыг таалан баясах бөлгөө.

Хамгийг айлдагч нар буяны садны үгнээс үл гарч бодисадва нартай ойртож шадарлах болой. Буяны садны үгнээ үл тээнэгэлзэгч түүнтэй буяны садан шадарлах буюу. Буяны саднаа сэтгэлээсээ салгалгүй санаж байваас хамаг хэрэг илт бүтэх болой" хэмээжээ.

"Санаанд багташгүй нууц"-аас: "Язгуурын хөвгүүд болоод язгуурын охид та бүхэн машид бишрэлтэйгээр багшдаа залбиран шүтэж, бараалхан шадарлаж, дээдлэн хүндэлж байгаарай. Ингэж буяны номыг сонсвоос сэтгэл ч буянтай, ажил үйлс ч буянтай сайн болно.

Улмаар буяныг туурвин буяны зүг одох тул буяны нөхөд ч хүндлэх болмой. Нүгэл үйлдэхээ больж буян хийх болно. Өвөр бусдыг зовоохоо байна. Өвөр бусдыг даган сахих болсноор ханьцашгүй бодийн мөрийг гүйцээн төгсгөнө. Улмаар буруу мөрд орогч амьтан бүхэнд тусалж чаддаг болно. Ийнхүү бодисадва нар багшийг шүтэн байж хамаг буяны чуулганыг төгс хураадаг ажгуу хэмээжээ.

Мөн буяны саднаа дээдлэн хүндэлснээр муу заяанд амсах байсан үйлүүд энэ насанд бие сэтгэлийн өчүүхэн зовлонг эдлэх юм уу, эсвээс зүүдэнд амсах төдийгээр арилж барагдах ба тоолшгүй олон бурхдад тахил өргөл өргөх буянаас ч илүү их тус эрдэм төрдөг ажээ.

"Газрын зүрхтний судар"-аас: "Түүнийг шүтснээр тоолшгүй олон галавт муу заяанд тэнэж одуулах байсан муу үйлийн үрүүд энэ наснаа хижиг өвчин тусах буюу эсвээс ган зуд тохиолдох зэрэг бие сэтгэлд бага шиг хорлол ирэх төдийгээр арилах буюу багаар гэхүл зэмлэл (баалуулах) хүртэх эсвээс зүүдлэх төдийхнээр арилах болно.

Тийнхүү өдрийн хугас төдийд шүтэж үйлдсэн буян нь хэмжээлшгүй олон бурхдад буяны язгуурыг хүсэн тахил өргөлийг өргөсөн болон суртгаалыг сахиснаар төрдөг буян бүхнийг ч сүрээрээ дарна. Багшаа дээдлэн хүндэлсний буян санаанд багташгүй билээ" хэмээгээд "Бурхадын цаглашгүй их эрдэм рид хувилгаан бүхэн ч үүнээс л үүднэ гэж үзээрэй. Тиймээс багшаа бурхан адилаар залбиран шүтэж, бараалхан шадарлаж, дээдлэн хүндэлсүгэй" хэмээн айлджээ.

"Төрөл дарааллын цадиг"-аас:

Дээдэс багш нарын хэнээс ч холдолгүй
Усхал дөлгөөн зангаар багшийг шүтэж үйлд
Түүнтэй шадарлан ойртвоос эрдэм боловсрол
Тухайлан тушаахгүй ч аяндаа наалдах болмой хэмээн айлджээ.

Бодова гэгээн бээр: "Эгэл бид нар дээлээ гандаж гутлаа цоортол дэмий баахан гүйхийн их гэмтэй. Гандсан дээлээ газар сэгсрэхэд шавар шороо наалдахаас бус алт эрдэнэс наалдахгүйтэй адил буяны садан түүний эрдмийг наалдуулалгүй, ганц нэг өө сэв төдийг олж наагаад ирж байна шүү. Түр нэг гүйсэн төдийгээр түүний эрдэм наалдана гэж үгүй" хэмээн айлдсан буй. [30]

д) Эс шүтэхийн гэм :

Багшид шавь орчихоод шүтэх ёсоо буруудуулваас энэ насандаа олон янзын өвчин зовлон, ад донгоор хөнөөгдөх ба хойд насандаа хэмжээлшгүй их муу заяаны зовлонг цаглашгүй их хугацаанд амсахад хүрнэ.

"Нууцын эзний авшгийн тантр"-аас: "Ялж төгөлдөр нөгчихсөн бурхан аа! Багшаа басамжлан доорд үзэгч тэдгээрийн тийн боловсрох үйлийн үр ямар болох вэ? хэмээсэнд Бурхан зарлиг болруун: Нууцын эзэн ээ, Тэнгэр сэлт ертөнцийнхэн айж цочих билээ. Ийн бүү өгүүлэгтүн. Гэвч, Нууцын эзэн ээ, Өчүүхэн нэгнийг өгүүлсү. Бодисадва нар анхааран сонсогтун.

Барагдашгүй зовлонт Аюус там зэрэг
Алин там байдгийг би номносон билээ
Тийм л оронд орших хэмээн өгүүлжээ
Тэгэхдээ бас тоолшгүй галваар наслах

Тиймийн учир ямар нэг байдлаар
Хэзээ ч түүнийг басамжилж бүү үйлд хэмээсэн ба

"Тавин шүлэгт"-ээс:

Багшаа муушаагч тэрээр
Хижиг өвчин хулгана яр болон
Ад дон, эмгэг зовлон, хорлол зэрэгт
Ихэд баригдан үхэхэд хүрэх

Хаан, гал, хорт могойн болон
Усны аюулууд, дагинас, хулгайч хийгээд
Ад дон болон буруу зүгийн эздүүдэд
Алуулан хөнөөлгөж тамд одох болой

Хэзээ ч багш нарынхаа
Хамаг сэтгэлийг хямруулж бүү үйлд
Хэрвээ мунхаглан үйлдсэн аваас
Халуун тамд чанагдах нь лавтай

Аймшигтай аюус там тэргүүтний
Ахуй ёсыг номнон үзүүлсэн билээ
Багшаа муушаан доромжлогч нар л
Баттай тэнд оршихийг номновой хэмээжээ.

Их мэргэн Шандэвагийн туурвисан *"Данагийн зохиосон бэрхийн тайлал"*-аас :

Ганцхан шүлэг ном заасан байсан ч түүнийг л
Гагцхүү багш гэж эс үзвээс
Адгуус нохойн төрөлд зуунтаа төрөх ба
Алуурч махчины доод төрөл авах хэмээжээ.

Тэрчлэн төрөх байсан эрдмүүд үл төрөх ба төрсөн эрдмүүд доройтон алга болдог аж.

"Эдүгээгийн бурхадын илт мэдлийн бясалгал"-аас: "Хэрвээ тэрээр түүнд нэрмэхийн сэтгэл болон тэмцэлдэх уурлахын санаагаар хандсан л бол эрдэм олно гэж хэзээ ч үгүй. Бурхан адилд үзэхгүй бол мөн тийн болой. Гурван хөлгөний бодгаль болон ном заасан аяга тахимлаг нарыг бишрэн хүндэлж багш буюу бурхан адилд үзэх сэтгэл эс гаргаваас тэрээр олоогүй эрдмээ олох болон олсон эрдмээ барахгүй байна гэхийн газаргүй болно. Үл биширвээс үнэн ном балрах болой" хэмээн айлдсан мэт.

Нүгэлт садан болон хилэнцэт нөхөртэй нөхөрлөвөөс эрдэм чадал аяндаа хорогдож цөөрөөд харин хамаг гэмүүд улам нэмэгдсээр хүсээгүй муу бүхэн гарч ирдэг тул хэзээ ямагт тэвчих хэрэгтэй билээ.

"Дурдан санахуйг чухал агуулах судар"-аас: "Хилэнцэт нөхөр болвоос урин, шунал, мунхаг сэтгэл бүгдийн суурь бөлгөө. Тэрээр хорт мод адил" хэмээжээ.

"Гаслангаас нөгчихүй"-гээс ч: "Бодисадва нар муу нөхрөөс л айх хэрэгтэй. Галзуу заан тэргүүтнээс айх хэрэггүй. Учир нь эдгээр нь бие махвод төдийг л эвдэх. Харин муу нөхөр бол сайхан сэтгэл болон сайн буян хоёуланг хөнөөдөг аюултай. Тэр хоёрын нэг нь бие махводыг эвдэвч муу заянд хүргэж чадахгүй. Харин нөгөө нь номын биеийг эвдлээд муу заянд лавтай хүргэх чадалтай буюу" хэмээжээ. *"Үнэнчийн бүлэг"*-ээс:

Хилэнцэт нөхрийн могойд хэн нэгэн сэтгэлээ хатгуулчихаад
Хэзээд буяны садны хор тайлах эмийг орхиж огоорвоос
Хэдий тэдгээр чухаг дээдийн номыг сонсовч
Хоохой хөөрхий! Сэрэмжгүй явсаар их халил хаднаас унах хэмээсэн ба

Зашэ гэгээний *"Цоморлиг"*-оос ч:

Үл сүслэх, харамлах, шунахайрах,
Худал өгүүлэх, хов жив зөөх ба
Ухаантантай үл нөхөрлөх болон
Нүгэлт хүмүүнтэй ханилах зэргийг бүү үйлд

Хэдий хилэнц үйлдэгч бээр
Хилэнц үл үйлдэгч нэгнээ шүтлээ ч
Хилэнц үйлдэхийн санаа төрснөөр
Хэрэггүй муугаа улам нэмэх

Шүтэх ёсгүйг шүтсэн хүмүүн бээр
Түүний гэмээр гэмтэн болох бий
Хор түрхсэн сумыг хуйванд хийхэд
Хор түрхээгүй ч хуйванд нэвчихтэй адил хэмээн айлджээ.

Нүглийн садан хэнийг ч шүтлээ гэсэн урьд хураасан "өөрчлөн болон цаазын амлашгүй нүглүүд" үл хорогдох бөгөөд харин урьд хураагаагүй нүгэл шинээр нэмэгдэж ирдэг юм шүү.

Гэвш Донбава бээр: "Адгийн муу нэгэн хичнээн сайн хүнтэй нөхөрлөвч дунд зэргээс хэтэрдэггүй. Харин хамгийн сайн хүн адгийн муутай нөхөрлөвөл амархан адагт очино" хэмээн айлдсан буй.

е) Утгын хураангуй

"Багшийн бясалгал" (егүзээр) хэмээн алдаршсан эдгээр увдисыг дээр өгүүлсэн дагуу ухаарах хэрэгтэй. Ганц нэгхэн удаа бясалгах төдийгөөр тус болохгүй. Үнэн сэтгэлийн мухраас үнэхээр буян ном үйлдэе гэвэл эндүүрэлгүй хөтлөгч эрхэм дээд багшийг өнө удаан шүтэх чухал.

Чадхава гэгээнээс: "Багш шавь бололцох үед буцах явдал тохиолдоно шүү" хэмээсэн мэт шүтэх ёсоо мэдэхгүй шүтснээр ахиц гарахгүй улмаар гэмших явдал ч тохиолдоно. Буяны садныг шүтэх энэхүү номын аймаг юунаас ч илүү эрхэм чухал ашдын үйл хэргийн язгуур учраас ерөнхий зүйлийг эрхэм зарлиг болон тааллын тайлбар зэргээс эш татаж, ухаарахад хялбар болгон сэтгэлдээ буулган, эрхэм зарлигийн утганаа шамдагч дээдэс мэргэдийн зарлиг номоор чимж байгуулав. Дэлгэрэнгүйг бусдаас мэдээрэй.

Бид нар муу сэтгэлдээ баригдсан учраас багш шүтэх ёсыг үл ухаарах бөгөөд ухаарсан ч дахин дахин үл үйлдэнэ.

Үүнээс уршигдан ном сонсогч нарт багшийг шүтэх ёсноо харгалзах алдаа унал их гаравч түүнийг наминчлах, хорих зэргийн ухаан төрөх нь ховор билээ. Иймд дээр өгүүлсэн дагуу тус эрдэм, гэм нүглийг ухаарч дахин дахин санаарай. Урьд төрөлдөө шүтэх ёсыг ёсчлон эс үйлдсэн бүхэндээ сэтгэлийн мухраас наминчилж, хорих явдлыг олонтаа үйлд.

Номын сав байхын буян номыг өөрсдөө шамдаж бүтээ. Бэлэг чанар огоот төгөлдөр буяны садныг дахин дахин бясалга. Хэзээ бурханы хутагт хүртэл энэ адил багшийг даган барихын үндэс болсон буяныг хурааж, ерөөл олонтаа тавь.

Энэ ёсоор үйлдвээс их удалгүй чин зоригийн манлай болсон бодисадва Дагду-ү болонд буяны садныг бэдрэхдээ үл ханагч Шоннү Норсан адил болох болой.



БЯСАЛГАХ ЁСОН

2. Бясалгах ёсыг хураангуйлан үзүүлэх

а. Бодитой бясалгах ёсон

б. Бясалгалын талаарх буруу бодлыг няцаах

а. Бодитой бясалгах ёсноо:

1) Жинхэнэ бясалгалын үест үйлдэх зүйл
2) Бясалгалын завсрын үест үйлдэх зүйл

1) Жинхэнэ бясалгалын үест үйлдэх зүйлд гурав:

а) Бэлтгэл ажил
б) Бодит суурь (ажил)
в) Төгсгөлийн ажил

а) Бэлтгэл ажил :

Зургаан зүйлийн бэлтгэл ажил буй. Эл бэлтгэл ажлын увдис Сэрлинба багшаас уламжилжээ. Орон гэрээ сайтар цэвэрлэх (1), лагшин, зарлиг, тааллын шүтээнийг сайтар жигдлэх (2), тахилаа хөдөлгөөнгүй засаж үзэсгэлэнтэй сайхнаар бэлтгэнэ.

Мөн "Сонсогчийн газар" (Нинса)-аас "нойр, мунхагийн түйтгэрээс сэтгэлээ сэргээхийн үест, янагш чинагш агуулах болон өөрийн дур хүсэл тэргүүтний хилэнц түйтгэрээс сэтгэлээ ариусгахын тухайд ширээ буюу жижиг суудал зэргийн дээр завилж суухыг" зарлиглажээ.

Амгалант дэвсгэр суудал дээр биеэ тэгшитгэн цэхэлж, бүтэн буюу хагас завилгаагаар суух (3), аврал итгэлийг одуулан бодь сэтгэлийг сэтгэлдээ баттай ижилсүүлэх (4), өмнийн огторгуйд агуу их явдал болоод гүн гүнзгий үзлийн дамжлагын багш нар болон бурхан, бодисадва, хутагтууд, сонсоод сонсогч, өөрөө ялгуусад, зарлигийн тушаалтан, номын сахиус нар нөхөр сэлтийн хамт хэмжээлшгүй олноор оршвой хэмээн санаад "буяныг хураахын орон"-ыг тодорхой байгуулна (5)

Ингээд мөрийн эрдмүүд сэтгэлд төрөхийн зохилдох шалтгаан болсон "буяныг хураах" ба харшлах шалтгаан "түйтгэрийг арилгах"-аар орохдоо хамтрах нөхцлийг бүрдүүлэлгүйгээр зөвхөн бодит нөхцөл төдийхөнд

хичээвэл мөрийн эрдмүүд төрөхөд бэрхшээлтэй болдог. Иймээс хураах, арилгахын аньс бүхнийг багтаасан "долоон гишүүнт увдис"-аар сэтгэлээ ариусгах (6) хэрэгтэй.

(1) Мөргөлийн гишүүн: *"Гурван үүдийг хамтатган мөргөх"* талаар *"Хутагт сайн явдлын ерөөл"-өөс:*

Хэдүй бүхий арван зүгийн ертөнцийн орноо
Хэдүй гурван цаг дор одогсон "Хүмүүний арслан"
Хоцрол үгүй тэдгээр бүгдэд би бээр
Хамаг бие, хэл, сэтгэлээр сүслэн мөргөмү

хэмээх нэгэн шүлгээр айлджээ. Энд зөвхөн ертөнцийн нэг зүгт орших бурхад юм уу, эсвээс нэгэн цагийн бурханаа бус арван зүгт орших буюу урьд заларсан, ирээдүйд залрах, эдүгээ заларч байгаа бурхад бүгдийг сэтгэлдээ бодоод, бусдыг даган дуурайсан бус үнэн сэтгэлийн мухраас гурван үүднээс бишрэн мөргөжээ.

"Нэг л бурханд мөргөхөд хэмжээлшгүй их буян хураадаг тул тийн олон бурхадыг сэтгэлдээ бодоод мөргөхөд чухам ямар болохыг хэлээд яах вэ" гэж Ловон Эшэдэ номносон буй. *"Гурван үүд тус тусаар мөргөх":*

а/ Биеэр мөргөх нь,

Сайн явдлыг хүсэх ерөөлийн хүчээр
Сайвээр ажрагсад сэтгэлд илт үзэгдэхүй еэ
Сац орны тоосны тоот биеэ сайтар бөхийлгөж
Сайхи хамаг ялгуусад танаа бишрэн мөргөмү

хэмээх тэргүүтэн нэгэн шүлгээр өгүүлжээ. Цаг зүг бүхнээ багтсан бурхан бүгдээр сэтгэлийн орноо илт байгаа мэтээр бодоод өөрийн биеийг орон дэлхийн нарийн, бүдүүн тоосны тоотой тэнцүүлэн хувилгаад мөргөх болой.

Тэрхүү орон газрын сайн явдалд машид сүжиглэж шинэ эрдэм хүчийг олох, түүгээр сэтгэл өдөөгдөн буй хэрэг болой. "Нэгэн биеэр мөргөл үйлдэхэд их буян хураадаг тул тэр төдий чинээ биеэр мөргөл үйлдсэний буян машид их болно" хэмээн Ловон Эшэдэ бээр айлджээ.

б/ Сэтгэлээр мөргөх нь,

Нэгэн тоосны дээр тоосны тоотой бурхадууд
Бурхадын хөвгүүдийн төв дунд залрах ба
Тэр цагт номын огторгүй хоцрол үгүй бүгдээр
Хамаг ялгуусад бээр дүүрэхийг хүсмүй

хэмээсэн нэг шүлгээр айлджээ. Нарийн, бүдүүн ялгалгүй ганцхан тоосны үзүүр дээр оронгийн тоос бүгдийн тоотой сацуу бурхадыг бодисадва нөхдөөр хүрээлэгдсэнийг төвд залаад тэдгээрийн эрдмийг даган дурдах сэтгэлийг эгүүсгэх болой.

в/ Хэлээр мөргөх нь,

Магтаж баршгүй сайшаалын тэдгээр далайг
Яруу эгшгийн гишүүн далайн дуу бүхнээр
Хамаг ялгуусадын эрдмийг сайтар өгүүлж
Хамаг сайн бээр одогсодыг би бээр магтмой

хэмээх нэгэн шүлгээр айлджээ. Сайшааж баршгүй орны эрдмийг сайшаахдаа нижгээд нижгээд биенээ хэмжээлшгүй толгой байна гэж бодоод нижгээд нижгээд толгойд хэмжээлшгүй олон хэлийг хувилгалаа гэж бод. Энэ мэтээр үйлдээд яруу эгшгээр өгүүлнэ. Энэ үесийн "Эгшиг" хэмээсэн нь магтахын нэр бөгөөд түүний нөхөр болох хэлээр хэлж байгаа явдал юм. "Далай" гэдэг нь олон тоо билээ.

(2) Тахилын гишүүн: а) "*Хэмжээт тахил*"-ыг өргөх нь,

Цэцэгсийн үзэсгэлэн, эрхэсийн эрхэм хийгээд
Жингэнэхүй, сүрчихүй, шүхрийн дээд хийгээд
Гэгээн зул ба утагч хүжсийн анхилам сайхнаар бээр
Ялгуусад тэдгээрийг сайтар тахисугай

Дээд өмсгөлүүд, дээд үнэр болон
Сүмбэр уул сацуу хэмгэрэгүн, замбулзахуй хийгээд
Ялангуяа хэтийдсэн байгуулал зохиол дээд бүхнээр
Ялгуусад тэдгээрийг тахиж үйлдсү

хэмээсэн хоёр шүлгээр айлджээ. *"Цэцэгсийн үзэсгэлэн"* гэдэг тэнгэр хүмүүний орны гайхамшигт тансаг цэцэгс болой. *"Эрхэсийн эрхэм"* гэдэг олон зүйлийг цэцгийг хэлхэж салаавчлан холбоод тэр хоёул бодитой юм уу, урласан бүгд болой.

"Жингэнэхүй" гэдэг утаст үлээвэр, цохилуур, хангинуур хөгжим болой. *"Сүрчихүй"* нь анхилуун үнэрт түрхлэг болой. *"Дээд шүхэр"* нь шүхрийн дотроос эрхэм болой. *"Дээд зул"* нь тос, хүж тэргүүтэн үнэр анхилуун тунгалаг гэрэл ба зэндмэнэ их эрдэнийн тунгалаг гэрэл болой.

"Утагч хүжис" нь найруулсан хүж ба үнэртний зүйлс болой. *"Дээд өмсгөл"* нь хувцас бүгдийн дээд болой. *"Дээд үнэр"* гэдэг нь хүжсийн үнэрт усыг тахилын ус болгож өргөснийг хэлэх бөгөөд гурван мянган ертөнцөд үнэр нь анхилах үнэрт ус тэргүүтэн болно. *"Хэмгэрэгүн", "замбулзахуй"* нь анхилуун тансаг хүжсийг талхлан үнэртэн болгоод боож багласан буюу хот мандлыг зурж, будаг талхаар чимэглэн зуу давхарлах юм уу сүмбэр уул сацуу давхарласныг хэлнэ.

"Байгуулал" гэдэг дээр өгүүлсэн бүгдээр төгс төгөлдөр цогцолсон болохыг хэлнэ. Их зонхидоо гоёж хээлсэн тахилууд багтана.

б/ Хэмжээлшгүй тахилыг өргөх нь

Агуу их тэнсэлгүй аливаа тахил тэдгээрийг
Асар ялгуусан бүгдэд бас хүсмүй
Сайн явдалд биширсэн хүч юүгээр
Сайвээр ялгуусадаа мөргөж тахисугай

хэмээх нэгэн шүлгээр өгүүлжээ. Хэмжээт тахил гэдэг нь ертөнцөд багтаж болох тахилууд юм. Харин энэ үест бодисадва тэргүүтний адистид хүчээр элдэв янзаар санаанд багташгүй олон болгон хувилгасан тахил өргөлүүд багтана.

Сүүлийн хоёр мөрөөр дээд хоёрын дутууг гүйцээн өгүүлж мөргөх, тахих үесийн санаа бодлын орныг заажээ.

(3) Хилэнцээ наминчлах гишүүн. Үүнийг,

Тачаангуй, урин, мунхагийн эрхээр
Бие, хэл хийгээд тэрчлэн сэтгэлээр
Үйлдсэн хилэнц нүгэл алив тэр бүхнээ
Тус тус наминчилмуй би хэмээсэн нэг бадгаар өгүүлжээ.

Гурван хороор суурь хийж бие тэргүүтэн гурван үүдээр нүгэл үйлддэг билээ. Мөн чанарын хувьд өөрөө үйлдсэн буюу тэр нүгэлд өөрөө бодитойгоор орсон, бас бусдыг үйлдүүлэхээр оруулсан, бусдын үйлдсэнээ даган баяссан зэрэг энд багтана. Тэдгээр бүгдийг нийтэд *"алив тэр бүгд"* хэмээн хураангуйлжээ.

Тэдгээрийн гэм бурууг санаж урьд хийсэндээ гэмшин хойшдоо хорих сэтгэлээр зүрхний мухраас наминчилваас урьд үйлдсэн үйл арвижихаа больж хойшдоо ч гарах залгамжаа нь тасарна.

(4) Даган баясах гишүүн. Үүнийг,

Арван зүгийн хамаг ялгуусад ба бурханы хөвгүүд
Өөрөө ялгуусад болон суралцагч, суралцан төгсөгчид зэрэг
Энгүй олон амьтны буян юу буй
Эдгээр бүхнээ даган баясму би

хэмээх нэгэн бадаг шүлгээр илэрхийлжээ. Эдгээр таван бодгалийн үйлдсэн буяныг санаж, ядуу гуйлгачин хүн хүү сан олсон адилаар баясах болно.

(5) Номын хүрд эргүүлэхийг айлтгах гишүүн. Үүнийг,

Алин арван зүгийн ертөнцийн зул болон
Бодь хутагт бурханыг олгосод
Тэдгээр итгэлт бүхнээс Би
Тэнсэлгүй хүрдээ эргүүлэхийг айлтгамуй

хэмээсэн нэгэн шүлгээр илэрхийлжээ. Энэ нь арван зүгийн орон дэлхий дээр бодийн хутаг олчихоод байгаа бурхад болоод үл шунах, үл төрөх таалллыг олчихоод өнөд удалгүй залрах бурхадаас бие лагшинаа хэдий орон дэлхийн тоотой хувилгаж ном эрдэм заахын соёрхолыг айлтган тавьж буй хэрэг юм. "Бодь хутагт тийн хүрсэн бурхад" хэмээн унших хэрэгтэй хэмээн ловон Ишдэ айлдсан байдаг.

(6) Соёрхол талбих гишүүн. Үүнийг

Гаслангаас нөгчихүйг үзүүлэхээр таалагч та бүхнээ
Хамаг амьтны тус амгалангийн тухайд
Газар орны тоосон тоотой галавт залрахыг
Алгаан хавсарч залбирмуй би

хэмээх нэгэн бадаг шүлгээр илэрхийлжээ. Арван зүгийн орноо гаслангаас нөгчихүй ёсыг үзүүлэгч нарт хандан алс хойчдоо болон ахуй үес бүхэнд

амьтан бүхнийг амраан жаргуулахын тулд газар дэлхийн тоосны тоотой сацуу галавт гаслангаас нөгчихүй ёсыг үзүүлэлгүй, бие лагшинаа хэмжээлшгүй их олноор хувилган заларч байхын соёрхол талбих бөлгөө.

(7) Зориулга ерөөл талбих гишүүн. Үүнийг,

Мөргөх, тахих, наминчлах хийгээд
Даган баясах, айлтгах, соёрхол талбих зэргээр
Өөрийн хураасан өчүүхэн буян бүгдээ
Их бодь хутгийг олохын тулд зориулмуй

хэмээх нэгэн бадагт өгүүлжээ. Дээр өгүүлсэн зургаан гишүүнээр хураасан буян тэргүүтнээ хамаг амьтан нийтийн тусад зориулан, туулсан бурхан болохын үндэс болгож хүчтэй ерөөлийн сэтгэлээр түүнд зориулах мөн. Чингэж чадваас хэзээ ч хийсэн буян барагдахгүй болой.

Ийнхүү эдгээр бүгдийн утгыг ухааран, бусад зүйлд сэтгэл алгасралгүйгээр, заасан дагуу аажим аядуу бүтээх аваас хэмжээлшгүй их буяныг хураах болно.

"Мөргөх", "тахих", "айлтгах", "даган баясах", "соёрхол талбих" таван гишүүн нь буян хураахын зохилдох нөхцөлийг бүрдүүлдэг. "Наминчлах гишүүн" нь харшлах шалтгаан хилэнц түйтгэрийг арилгадаг. "Даган баясах" гишүүн нь нэг талаас өөрийн хийсэн сайн буяндаа даган баясдагаараа өөрийн буяныг ч арвижуулдаг.

"Зориулга ерөөл" нь хураах, арилгах, арвижуулах хэмээх гурван буян өчүүхэн бага байсан ч тэрээр машид их болгохын дээр завсарт нь үр нь барагдах, хаягдах зэргийг хэзээ ч гаргуулахгүй болгодог.

Товчлон хэлбээс дээрх долоон гишүүн нь хураах, арилгах, үл барагдуулан арвижуулах гэсэн гурван буянд багтана.

Үүний дараа бодож санаж буй зүйлээ тодорхой болгоод "Мандал" өргөнө.

"Буяны саднаа үл бишрэхээс эхлээд "хоёр би-г үнэнд бүтсэнээр барих" хүртэлх элдвийн эндүү ташаа бодол бүгдийг түргэн хорих хийгээд буяны саднаа сүслэн бишрэхээс эхлээд "би-үгүй" хоосон чанарыг олох хүртэлх энгүй зөв ухаан бүгдийг амар хялбар төрүүлэн, гадаад, дотоодын саад зэтгэр бүгдийг түргэнээ амирлуулан адистэдлэн соёрх" хэмээн чин сэтгэлээсээ дурдан олонтаа соёрхол талбих болой.

б) Бодит суурийн үест бясалгах ёсон

1. Ерөнхий бясалгах ёсон
2. Энэ үесийн бясалгах ёсон

1. Ерөнхий бясалгах ёсон

Энэхүү "Бясалгал" хэмээн алдаршсан нэгэн болвоос сэтгэл юугаа буяны зоригдолт орноо (вишай) дахин дахин тогтоож тухайн орноо дадуулан судлах явдал бөлгөө.

Тэргүүлшгүй цагаас бид сэтгэлээ өөрийнхөө эрхэнд оруулж чадаагүй, харин өөрсдөө сэтгэлийнхээ эрхэнд явсаар ирсэн бөлгөө. Сэтгэл маань ч нисваанис тэргүүтэн муу хилэнц түйтгэрийг даган явж хамаг гэм буруу бүгдийг үйлдэж иржээ. Иймээс л сэтгэлээ өөрийнхөө эрхэнд оруулж, өөрийн хүссэнээр буяны бодол зоригдолд тогтоох, улмаар эзэмшиж эдлэхийн тулд бясалгал бүтээх шаардлагатай болно.

Аливаа тухайлсан бодлоо бясалгахдаа өөрийн бодох ёстой буяны бодлын тоо хэмжээ энэ төдий хийгээд дэс дараалал тийм байна гэсэн тооцоогоо орхих юм бол хэрхэн хүссэнээр буяны бодлоо эзэмшихэд их тотгор учирна. Эхнээсээ уршигдвал хамаг буяны ажил гэмтэй болж одох буй.

Тиймээс аливаа бясалгах зүйлийнхээ тоо хэмжээ, дэс дараалпыг магадлан мэдэх хэрэгтэй. Чингээд бясалгах ёстой зүйлээсээ бусад зүйлийг барихгүй хэмээх хатуу ам өчиг нэгийг ав. Бясалгах ёстой зүйлээ илүү дутуу эсэхийг дурдан санах болон ухамсарлах ухаантай хамтатган нөхөрлүүлж бясалгаарай.

2. Энэ үесийн бясалгах ёсон

Эхлээд шүтэхийн тус эрдэм, түргэн бурханы хутаг олох зэрэг хийгээд эс шүтэхийн гэм буруу, хойд насны зовлон зэргийг санана. Улмаар багшийн талд ямар ч гэм бурууг санахгүй хэмээх хориглох сэтгэлийг олонтаа баримтлан ёс суртахуун, бясалгал, билиг оюуны суртгаалууд болон сонсох зэрэг өөрийн онох ёстой эрдмийг санаж тунгалаг сэтгэлийн байдалт сүжиг төрөх хүртэл бясалгана. Тэрчлэн над тус болсон, тус болох зарлигийн ач зэргийг дээрх судрын аймгаас дурдсан дагуу санаж зүрхний угаас бишрэл төрөх хүртэл бясалгана.

в) Төгсгөлд хэрхэн үйлдэх

Хураасан буянаа "Хутагт сайн явдлын ерөөл" (Санжод монлам), "Далан ерөөл" (Монлам дүжү-ба) тэргүүтний үүднээс орон үесийн болоод эцэс хойдын ерөөлийн орноо дурдатган зориулж үйлдэнэ.

Энэ мэтээр өглөө үүр, үдээс өмнө, үдээс хойш, үдэш гэсэн дөрвөн тасалгаагаар бясалгана. Эхний үест ихэд удаан баривал живэл, дошигролын эрхэнд ороход хялбар байдаг. Сураад дадаад ирэхээр бусдын эрхшээлд ороход бэрх болдог тул эхэндээ богино тасалгаагаар олон дахин үйлд. Бясалган бодох дур ороод ирэхээр түр завсарлаж дараа үргэлжлүүлэхийн чин хүслээр орхих хэрэгтэй.

Ер нь сураад дадаад ирэхээр ор дэрээ харахаар огиудас хүрэх мэт болдог хэмээсэн буй. Нилээд баттай болоод ирэхээр хугацаагаа уртасгана. Энэ бүхнийг хийхдээ хэтэрхий хатуу чанга, эсвэл хэтэрхий султгахын гэмээс хагацуулан бясалгах учиртай. Чингэж чадваас хэтэрхий их алжаах ядрах, живэх, дошигрох зэргийн саад тотгор багасан амарлих болмуй за.

2) Бясалгалын завсарт юу үйлдэх

Ер нь эргэл мөргөл хийх, амны уншлагаа унших гээд олон ажил гарч болно. Ийм тохиолдолд ч гол нь тунгийн үесийн бясалгах ёстой гол бодолдоо шамдаж байх хэрэгтэй. Тун тайлж завсарлах үест бясалгаж бодож байгаа зүйлээ дурдан санах болон ухамсарлах хоёроо "мануулалгүй" зоргонд нь орхивол бясалгалын хүч чадал машид суларна.

Тиймээс завсарлах үест тэр тухай заасан ном судрыг шагайж, сайтар санах авах чухал. Эрдэм төрөхийн зохилдох нөхцөп болсон буяныг хураах болоод харшлах болсон нөхцөп хилэнц нүглээ арилгахаар олон үүднээс хичээх мөн. Бүхний суурь болсон алин ам авсан санваар тангарагтаа санан дурдахын үүднээс шамдах буюу. Бодлын орон дээрээ сэтгэлээ төвлүүрэх, ёс жаягаа сахих, буян хураах эдгээр гуравт багтаан "гурван хуйлруулагч" хэмээх нэрийн дор хөтлөх ёсон ч буй.

Мөн амарлингүй сэтгэл болоод үлэмж үзэхүй ухаан хоёр хялбархан төрөхийн үндэс болсон дөрвөн буяны чуулганаа суралцах хэрэгтэй. Үүнд:

а) Эрхтэний (харах эрхтэн тэргүүтэн 6 эрхтэн) үүдийг хориглох

б) Ухамсартай эдлэх

в) Идээний хэмжээг барих

г) Үл хэвтэн бясалгалд шамдах ба хэвтэхийн цагт юу үйлдэх.

а. Эрхтэний үүдийг хориглоход тав:

а/ Юугаар хориглох вэ. Дурдан санахыг ямагт сахих ба дурдан санаж үргэлжид шамдах хэрэгтэй. Эрхтэний үүдийг хориглох явдал нь бясалгах орноо мартахгүй дахин дахин санах сэтгэлээс эхлэнэ. Улмаар бясалгах орноо үргэлжид санаж түүнээ бишрэх сэтгэлийг дадуулна.

б/ Юуг хориглох вэ. Зургаан эрхтэнээ болой.

в/ Юунаас сэргийлэх вэ. Сэтгэлд зохистой, зохисгүй зургаан орноос болой.

г/ Хэрхэн хориглоход хоёр зүйлээс:

(1) Эрхтэнээ сахих гэдэг нь. Орон (мэдэгдэхүүн) болон эрхтэнд шүтэж зургаан "тийн мэдрэхүй" төрдөг. Тэдгээр бий болсны дараа сэтгэлд зохистой, зохисгүй зургаан зургаан "гол сэтгэл" төрнө. Тэдгээрээс болж тачаах, уурлах зэргийн сэтгэлүүд (сэтгэл хөдлөлүүд) бий болдог байна. Тиймээс тэрхүү сэтгэлүүдийг төрүүлэхгүйн төлөө ихэд хичээнгүйлэн сахих явдал ажээ.

(2) Зургаан эрхтэнээ хориглон бүтээх нь. Энэ нь үзэх харах үест аливаа нисваанис төрж болох орноо эрхтэнээ алдаж орхихоос сэрэмжлэн хориглох явдал юм. Мөн "эрхтэнээ хориглох" гэдэгт зургаан орныг "бэлгэдэлд болоод ил тэмдэгтэд үл барих" болон умартах зэргийн нисванис ихдэснээс болж муу сэтгэл төрөх үед ч хориглон бүтээх явдлууд багтана.

"Бэлгэдэлд барих" гэдэг харах ёсгүй өнгө дүрс зэргийг орон болгох буюу аливаа гарсан үзэгдэл болгоныг сэтгэлдээ илтээр үзэх болой.

"Ил тэмдэгтэд барих" гэдэг зургаан мэдрэхүйн дараагаар тачаал, уур, мунхаг гурав төрүүлэх орныг дотоод сэтгэлдээ барих болон илт хараагүй, мэдрээгүй хэрнээ бусдаас сонсоод тэдгээрийг атхаглах сэжиглэх зэрэг багтана.

д/ Ямар хориг боомт олох вэ. Аливаа муу бодлоос сэтгэлээ ангижруулан хамгаалж, буянт сэтгэл болон эсвээс "эш үл үзүүлсэн" сэтгэл болгож чадсанд агуулагдах учиртай. "Эс түйтгэрлэгдсэн эш үл үзүүлснээ" хамааруулж байгаа нь сэтгэлээ буяны бодолд цаг бусаар орших зэргийн явдал мөрийг бодолцсон үе юм.

б) Ухамсартай эдлэх

1. *Эдлэгдэхүүн суурь*
2. *Түүнийг ухамсарлан эдлэх*

1. Эдлэгдэхүүн суурьт хоёр:

а) Хөдөлгөөн төгөлдөр таван үйл
б) Явдап төгөлдөр таван үйл

а) Хөдөлгөөн төгөлдөр таван зүйл. *"Биеийн үйл"* нь хот орон, сүм хийд зэргийн газраа нааш цааш одох ирэх болой. "Нүдний үйл" гэдэг өмнө сэтгэлдээ санаагүй элдэв орон юмсыг үзэж өчүүхэн мэдэх болон өмнө сэтгэлдээ бодоод үзэж сайтар мэдсэн болой.

"Үе мөч, гар хөлийн үйл" гэдэг гар хөл, үе мөчөө сунгаж хумих болой. "Номын хувцас, бадар аяганы үйл" нь номын гурван хувцас, бадар аяга зэргийг эдлэх, хэрэглэх, хадгалах болой. "Бинавад идээний үйл" нь идэх, уух тэргүүтэн болой.

б) Явдал төгөлдөр таван үйл. Сүм хийдэд эдлэх таван үйлээс: *"Биеийн үйл"* нь хийд оронд суух, ном буяны газар бараадан одох, номын тулд замд гарах, ном буян зохилдсон хийдийн багш, оронгийн эздийн өмнө шавилах, олбог ширээний дээр завилан суух зэрэг болой.

"Хэлний үйл" нь эрхэм арван хоёр эрхэм зарлигаас хүртээгүй эш лүнгээ хүртэх, цээжилж тогтоох, хүртсэнээ амны уншлага болгох, бусдад заах, хичээн шамдахын тухайд бусадтай хамтран асуух, хэлэлцэх зэргээр өгүүлэх болой.

"Сэтгэлийн үйл" нь шөнийн тунгийн завсарт хэвтэх, аглагт одож сонссон номынхоо утгыг бодох, есөн сэтгэлээр бясалгал үйлдэх, улэмж үзэхүйд хичээж үл ярих, халуун цаг болон ядрах үед цаг бусаар унтахаас больж сэрэх, босох болой.

"Өдөр шөнийн хоёр үйл" гэдэг өдрийн болоод шөнийн эхэн адаг хоёрт унталгүй сууж, бие хэлний үйлийг үйлдэнэ.

"Хэвтэх" гэж айлдсан хэдий ч шөнийн хийх үйл буюу зөвхөн сэтгэлээр хийх бясалгал үйлийг заажээ.

2. Эдгээр арван явдлыг ухамсартай эдлэх: Хөдөлгөөнт болон

явдалт аль нэг үйлийг туурвихдаа эхлээд заавап тэрхүү үйлээ дурдан санаж бас анхаарал сэрэмжгэй үйлдэнэ. Ямар байдалтай, бас ямар ёстой намба төрхүүдийг энэ хоёрт баригдан шинжигдэх учраас энэ дагуу оножь, ухаарах хэрэгтэй. Энд дөрвөн зүйлийн намба төрх буй.

1. Биеийн үйл тэргүүтэнд суурилсан тэдгээр арав ямаршуу намба байдалтайг шинж гэж заасан тэр байдлаар таньж мэднэ. Жишээлбэл, одох, ирэхийн үйлийг үзэхдээ "Винай"-гаас явах, ирэхийг хэрхэн зарлигласныг мэдээд одоо цагт ингэж үйлдэх хэмээн ухамсарлах болой.

2. Аль зүг ямар байдалтай байгааг шинжихдээ тэр зүгийн намба байдал ёсыг шинжих мөн. Жишээлбэл, зорчихын цагт арилжаа наймаа, архи дарсны зэрэг таван муу орноо зорчилгүй түүнээс бусад газраа зорчих ёстойг мэдээд, тухайн цагт ухамсарлан үйлдэх мөн.

3. Алин цагийг ямар байгааг шинжихдээ тэр цаг үеийн тэрхүү байдлыг шинжих мөн. Жишээлбэл, үдээс өмнө явж болох, үдээс хойш явж болохгүй гэдгийг мэдээд тэр дагуу явах агаад тэр цагийг ухамсарлан авах мэт болой.

4. Аливаа ямар нэгэн үйлийг чухам ямар байдалтай гэдгийг шинжихдээ тэр нэгэн байдлаар, тэр дагуу шинжиж үйлдэх явдал буюу. Жишээлбэл, одохын цагт машид болгоомжлон өөр айл руу явсугай хэмээн одохын суртгаалд юу заасан билээ гэх мэтээр санаж үйлдэх мэт болой.

Товчилвоос, өдөр, шөнийн нийт ажил юу байгааг санаад тэдгээрээс үйлдэх ба эс үйлдэхийг ялган, орох буцахын үед ч одоо үйлдэх үү, үгүй юу гэдгээ, үүнийг, түүнийг үйлдэх зэргээр хамаг бүгдийг ухамсарлан мэдэх шаардлагатай. Чингэж чадваас энэ насанд элдэв эндэл алдаанд орохгүй, үхэвч муу заяанд үл унах, мөрийн онол, эрдэм олоогүйг олохын үндэс буяныг хураана хэмээн зарлиглажээ. Эдгээрт бүх эрхтэний үүдийг хориглох хоёрын талаар Асанга хутагтын судраас иш татан, утгыг тайлсны ёсоор үзүүлэв. Буян ном үйлдэхдээ энэ хоёрт хичээнгүйлвээс бусадтай адилгүй ахиц амжилт их гарна.

Ялангуяа ёс суртахуун огоот ариусах бөгөөд амирлангуй сэтгэл, үлэмж үзэхүйн ухаан хоёрт багтах сэтгэлийг зөв оносон самади бясалгал амар хялбар төрөх учиртайг зарлигласан тул шамдаж хичээгээрэй.

в) Идээний хэмжээг барих

"Хэтэрхий багадуулахгүй байх" Хэтэрхий багадуулбал өлсөж, тамир тэнхээ дордох зэргээр буяны ажилд хүч чадалгүйтэхэд хүрэх тул маргааш

хоол идэх хүртлээ өлсөхгүй байх хэмжээгээр идэх явдал болно.

"Хэтэрхий ихдүүлэхгүй байх" Ихдүүлвээс ачаа ачсан мэт хэт хүндрэх, амьсгаа гаргаж оруулахад бэрхтэй болох, нойр их хүрэх, юм хийж чадахаа болих зэргээр муу сэтгэлээ тэвчиж чадахгүй нөхцөлд хүрнэ.

"Идээ хоол шингэж эохих нь" Идээ хоолноос үүдсэн хуучин таагүй амсуурга арилж, шинээр таагүй амсуурга төрөхгүй болно.

"Муу сэтгэлгүйгээр" идээ хоолоо тохируулваас буруу гажуу зүйл гарахгүй бөгөөд таатай амгалантай мэдрэмж төрнө.

Эдгээр нь хоол идээнд шунамхайрахын эсрэг ерөндөг шүтэх болон тэдгээрээс үүдэх гэм бурууг санаж явахтай холбоотой юм. Ер нь гурван янзын гэм гарахыг санана.

"Эдлэж хэрэглэснээс шалтгаалж гарах гэм" Сайхан өнгө, үнэр амттай ямар ч идээ байлаа гэсэн шүдээрээ хазаж, шүлсээрээ дэвтээсний дараа бөөлжис мэт болохыг санах буюу.

"Идээ хоол шингэсний дараа үүдэх гэм" Тэрхүү идээ шөнө дунд юм уу үүрээр шингэж мах, цус болж боловсордог. Зарим хэсэг нь баас, шээс болж биеийн бөгсөн хэсэгт орших бөгөөд өдөр тутам түүнийг гаргах хэрэгтэй болдог.

"Тэрхүү идээнээс болж олон төрлийн өвчин үүдэх" зэргийг санах хэрэгтэй.

Идээг эрж хайснаас үүдэх таван гэм буй.

Буй болгохын тухайд гарах гэм. Хоол унд болоод тэдгээрийн үндэс нөхцлийн төлөө халуун хүйтэнд олонтаа зүтгэж чармайж байж бүтээдэг. Тэднээ бүтээж эс чадваас энэлж шаналахын зовлон эдэлнэ. Эсвээс бүтсэн байсан ч булаалгах дээрэмдүүлэх, шим тэжээлгүй болчих вий гэх зэргээр айж сэжиглэх, бас үргэлж харж хамгаалах зэргээр хүчтэй хатууг туурвин зовлон эдэлнэ.

Садан хамаатан доройтох гэм. Тэдгээрийн тулд эцэг хөвгүүд өвөр хоорондоо хэрүүл тэмцэл хийх ч явдал гарна.

Ханахаа үл мэдэх гэм. Шунал улам нэмэгдсээр хаад ноёд хоорондоо өрсөлдөн байлдах их зовлонг амсахад хүргэнэ.

Өөрийн эрхгүйн гэм. Бусдын хоолыг булаагч нар эзэрхэн ноёрхохын тухайд бусадтай байлдаж их зовлон амсаж эдэлнэ.

Гэмт явдлаар уршигдах гэм. Хоол ундны тухайд гурван үүдээр нүгэл хилэнц хураагаад үхэхийн цагт нөгөөхөө санаж гэмшсээр үхэх буюу. Үхсэн хойноо муу заяанд унах бий. Хэдий тийм ч зарим талаар тус эрдэм бий.

Идээ хоол шүтэж байж бие оршдог билээ. Гэвч тэр төдийхнээр идээ ундыг шүтнэ гэвэл бас учир дутагдалтай. Бие орших байж л зөв ариун явдлыг бид бүтээж чадна.

Өглөг өргөгч, өглөгийн эзэд нар арьс махаа баран байж олсноо, маш их үр ашгийг хүсэмжлэн байж өглөг болгож өргөсөн тэдгээрийг эдлэхдээ тэдний санасан хүссэн тэрхүү их үр ашиг нь ёсоор бүтэх болтугай хэмээн ерөөж хэрэглэх ёстой.

"Өглөгийн эзнээ туслах сэтгэлийг барих буюу би өнөөдөр биеийн хорхой тэргүүтнийг эд идээгээр хураах ба ирээдүйд та нарыг номоор хураана гэх зэрэг хамаг амьтны тусыг бүтээхийн сэтгэлээр эдэлж хэрэглэх" учиртайг "Суртгаалын хураангуй"-д айлдсаныг санаарай.

"Буяны садны захидал"-аас:

Амны идээг эм адилд ухааран
Шунал, хилэнгээ арилгахын тухайд шүт
Гайхуулахын тухайд, омог дээрэнгүйн тухайд ч бус
Гоо сайхны тухайд бус, зөвхөн биеэ тэтгэхийн тулд
хэмээн айлдсан буй.

г) Үл хэвтэн бясалгалд шамдах ба хэвтэх цагт хэрхэн үйлдэх.

"Буяны садны захидал"-аас:

Ухааны язгууртан нар, өдрийн туршид болоод
Шөнийн тунгийн эхэн төгсгөлийг өнгөрөөгөөд
Хэвтэхэд ч үргүй болно гэж айлдаагүйг санаж
Тэр хүртэл туурвисугай хэмээжээ.

Өдөр бүхэлдээ хийгээд шөнийн эхний, эцсийн хоёр хувийг жинхэнэ бясалгалын үе болгоод завсарлагын үеэр хэрхэн үйлдэхийг үзүүлсэн билээ.

Босох суухын таван түйтгэрээс сэтгэлээ төгс ангижруулах явдал тун чухал болохыг дээр номносон билээ. Эл явдал болоод эрхтэний үүдийг сахих, ухамсарлах, эдлэх гурав нь жинхэнэ бясалгалын үе болон завсарлага үе хоёуланд байх боловч энэ үест тунгийн завсарлагаар бариарай.

Хэвтэх явдал нь тунгийн завсарлагын үест тохирно. Тэр үед дэмий бүү өнгөрөө. Хэрхэн үйлдэх хэмээвээс өдөр шөнийг гурван хувь хуваасны

эхний хэсэгт буяныг үйлдэн цагийг өнгөрөөгөөд, дунд үес ургахын цагт хажуулдаж бие махводоо нойроор дэгжээж тэнхрүүлэх учиртай.

Чингэж бие махвод тэвээрээд ирвэл буяны зүгт хичээх, шамдах хоёр үйлийг сайтар үйлдэхэд хялбар болох учраас тус эрдэмтэй. Тэр цагт орон гэрээсээ гадагш гарч гар хөлөө угаагаад дотогш орж баруун талаараа хажуулдан зүүн хөлөө баруун хөлний дээр ачиж арслан адил хэвтэх болой.

Арслангийн адил хэвтэх нь: Адгуус амьтны дотроос арслан болвоос биеийн сүр жавхлан ихтэй, сэтгэлийн тэнхээ чадал үлэмж баттай тул чанад бусдыг ялж дийлдэг ажгуу. Үл хэвтэж бясалгалд шамдахдаа бусдыг сүрээрээ дарагч арслангийн адил хэвтэх ажгуу. Энэ нь бирд, тэнгэр, хүслийг эдлэгч нарын хэвтэртэй адилгүй. Тэдгээр амьтад залхуурагч, хичээл шамдал сул, бусдыг сүрээрээ дарах чадалгүй билээ.

Нөгөө талаас бол арслан адил баруун талаараа хажуулдах явдал угаасаа бие махвод алжааж сулрахгүй, нойрсож унтавч санаснаа мартахгүй, гүн зузаан нойронд автахгүй, хилэнцэт муу зүүд зүүдэлдэггүй жамтай. Чингэж хажуулдаагүй байдалд дээрх дөрвөөс буцаж гэм бүхэн гарна. *Хажуулдах үеийн бодолд дөрвөн зүйлээс:*

Гэгээн тунгалаг хур мэдэлтэй байх. Гэрэл гэгээтэй сайхан зүйлийг сайтар бодож санан тунгалаг гэгээн сэтгэлтэйгээр хэвтэж нойрсоно. Чингэвэл нойрноос сэрэхийн цагт ч харанхуйлах зэрэг байдал гарахгүй.

Дурдан санах. Нойрсох хүртлээ утга төгөлдөр ном буян, сайн сайхан зүйлийг сонссон, санасан, бясалгаж байснаа эргэж олонтаа дурдан санана. Чингэвэл унтаж байх үед ч гэсэн сэрүүн байх үеийнх шиг ном буянд сэтгэл үргэлжид орших буюу нойрсох үедээ ч буян хураадаг болно.

Ухамсарлах. Тэр мэт дурдан санах зэргийн үест ямар нэг муу сэтгэл гарч ирвэл ухамсарлан мэдээд зөнд нь тавилгүй тэвчиж үйлдэнэ.

Сэрж босохын хур мэдэлд гурван зүйл:

1. Нойронд байнга автах сэтгэлд дарлуулахгүй тулд хичээнгүйлэн гөрөөс шиг хөнгөн нойрсож сурах болой. Чингэж сурваас нойронд автахгүй, босох цагаа хэтрүүлэхгүй сэрж чаддаг болно.

2 "Аяа! Би бурханаас зөвшөөрсөн хэвтэх ёс бүгдийг бүтээсүгэй" хэмээн түүнийг бүтээхийн тулд ихэд хичээн дурлах болой. Чингэвээс бурханаас зөвшөөрсөн арслангийн байдлаар хэтрүүлж бас дутаалгүй хэвтдэг болж сурна.

3. Хэрхэн би буян ном бүтээхээр хичээж өнөөдөр хэвтээгүй ч маргааш

ч энэ адилаар үйлдсү хэмээн санана. Чингэвээс номд тэмүүлэх сэтгэлийн үргэлжлэл үл тасрах ба хааяа нэг мартах ч улам дээш арвижуулахаар хичээж чармайдаг болно.

Нойр, хоолны энэхүү дэглэмд алдаа гаргалгүй, ашиг тустай болгон хэрэглэж заншвал олон зүйлээр цагаа дэмий өнгөрөөдөг байдлаас гарч чадна. Үүнийг Хутагт Асанга бээр судраас эш татаж айлдсан тэр ёсоор номновой.

Чингээд тухай тухайн үеийн нийт бусын бодит суурь (гол зүйл)-ийн бясалгалаас бусад нөхцлүүд буюу бэлтгэл хийх, бодит суурийг бясалгах, төгсгөлийг үйлдэх, завсарлагааны үйлдэл зэрэг эдгээр бүх үйл ажлууд эндээс эхлээд үлэмж үзэхүй ухаан хүртэлх бүх бясалгалд хамт явна. Бясалгалын завсарлагад юу хийхийг номновой.

б. Энэхүү бясалгах ёсноо буруу сэжигийг хорих

Эрхэм зарлиг тааллын тайлбар болон гол номуудыг увдис болгож ухаандаа ургуулж чадаагүй зарим нэгэн бээр, "мөрийг бясалгах цагт дахин дахин шинжлэх хэрэггүй, зөвхөн тогтоон бясалгах л хэрэгтэй. Учир нь тус тус оногч ухаанаар дахин дахин шинжлэх явдал зөвхөн сонсох, санахын үест байх ёстой. Мөн атхаглах гэдэг бэлэг тэмдэгт болгон барих учраас бурхан болоход тотгор болсу" гэх мэтээр өгүүлэх бий.

Энэ мэт өгүүлэх нь бясалгалын увдисыг ерөөс ухаараагүй хайш яйш, дэмий үг шүү. *"Судрын аймгийн чимэг"*-ээс: "Энэ үест анхан сонсоход дулдуйдан ёсчлон сэтгэлдээ бодох бодол төрнө. Ёсчлон сэтгэлдээ бодож дадуулснаас үнэн утгыг онох билиг оюун төрнө" хэмээжээ.

Үүнээс үзвэл сонссоны утгыг "санахаас төрсөн ухаанаар" ёсчлон сэтгэлдээ тунгааж, улмаар үнэн утгыг илт оносон "бясалгалаас төрсөн ухаанаар" олно гэж айлджээ.

Иймд эхлээд алин бясалгах гол утгаа бусдаас сонсож, бусдын хүчээр таньж мэдэж авна. Цаашлаад сонссон утгаа эш ном болон учир шалтгааны үүднээс өөрөө эргэцүүлэн бодож өөрийн хүчээр таньж мэднэ. Улмаар сонсох, санахын үүднээс ч мэдэж болно. Явсаар эргэлзэх бодлоос бүрэн ангижирч дахин дахин ижилсүүлж тунгааж бодох чадал суух тэр үед дадаж бясалгах болж ирнэ.

Бясалгалд дахин дахин "шинжлэх бясалгал" болоод шинжлэлгүй "тогтоох бясалгах" гэсэн хоёр зүйл буй.

Бясалгал бүгдийг "тогтоох бясалгал болно" гэж үзвэл, "үлгэрлэвээс

ганцхан тариан толгой барьчихаад тариа бүгд энэ мөн" гэж хэлсэнтэй адил болох биз ээ.

"Сонссоноос төрсөн ухаан"-ы урьд "сонсохуй" төрөх хэрэгтэйн адил "санаснаас төрсөн ухаан"-ы урьд "санаа" төрдөг учиртай.

"Бясалгалаас төрсөн ухаан"-ны өмнө нь ч "бясалгал" төрдөг учиртай аж. Тэр (бясалгалаас төрсөн) ухаан чинь бясалгалаас төрдөг бөлгөө. Бясалгалаас төрсөн ухааны өмнө гарч ирэх бясалгал чинь санаанаас төрсөн ухааныг дадуулж бясалгалснаар буй болдог бөлгөө.

Иймээс л санахаас төрсөн ухаанаас, бясалгалаас төрсөн ухаан төрнө хэмээн айлджээ. Хичнээн олныг сонсох тусам түүнээс төрөх ухаан төдий чинээ олон гарна. Тэр хичнээн олон байна төдий чинээ санах нь олон болно. Тэр санах нь хичнээн олон болоход түүнээс төрөх ухаан төдий чинээ олон болно. Тэр хэдий чинээ олон болоход анхааран авч бясалгах нь төдий чинээ олон болно. Тийм бясалгал хэдий олон болно гэмийг буцаах, эрдмийг бүтээхийн ёсон олон болно гэсэн үг.

Тиймээс бясалгал хийхэд сонсох, санах хоёр хамгийн гол хүчин зүйл хэмээн зарлиг тааллын тайлбар зэргээс айлджээ. Сонсох, санахыг нутлан буулгахдаа дадуулж бясалгахын тухайд бус зөвхөн "Гадна талын тээнэгэлзлэл торыг таслах" төдий гэж ухаарч тэдэнтэй барилдуулалгүй, өөр байдлаар бясалгаваас "морио сунгахдаа нэгэн газар сунгачихаэд уралдуулахдаа нөгөө өөр газар уралдуулахтай" адил болно.

Тийн өгүүлвээс утга учиргүй болох бөгөөд гурван ухаан зэрэгчлэн төрнө хэмээсэн нийт эрхэм зарлигийн агуулгатай зөрчилдөнө. "Зам мөрд эндүүрэлгүй зорчиход олон юм сонссоны хэрэггүй" хэмээх шалиг яриаг ч зөв гэх үзэгдэнэ. Гэвч эдгээр нь учрыг мэдээгүйн шинж шүү.

Судар тарнийн аймгийн номыг олонтаа судалсан нэгэн бээр огт ном шүн үзээгүй нэгэнтэй хоёул одоо ном хаялцлаа гэхэд бясалгал бүтээлийн их багын талаар ярихын хэрэггүй биз дээ. Ном сонсож сургууль хийсэн бүтээлчин тэр бээр өслөн баригч буруу ёсыг үтэр түргэн хөөн зайлуулж чадна.

Гэвч сонсох, санахын ухаанаар магадласан түүнээ нэгтгэн бясалгах төдийгөөр бясалгалаас төрсөн ухаан мөн гэж үзэхгүй ч бясалгал мөн гэхэд юунд харшлах билээ. "Харшилна" гэж байгаа нь "даяны анхдугаар орны бясалгал олоогүй эгэл хүнд ерөөс бясалгал төрөхгүй" гэж байгаа хэрэг ээ.

"Хүсэлт" ертөнцөд байх цагт газрын өндөр дээд эрдмийг олох тэр үетэй харгалзуулж бясалгалаас төрсөн ухаан төрнө гэж номносноос бусад тохиолдолд "бясалгалаас төрсөн ухаан төрөхгүй" хэмээн *"Авидхарма"*-гаас

олонтаа айлджээ. Чингээд "Бясалгал" хэмээх юу болох талаар билиг барамидын тайлбар "Тодорхой үг" хэмээх бүтээлд "Бясалган үйлдэх гэдэг сэтгэлээ түүний хувьт болгох буюу сэтгэлээ тийм мөн чанарт болгохыг хэлнэ" хэмээн тодорхойлсны дагуу ухаараарай.

Жишээлбэл, сүсгийг бясалгах; нигүүлсэхүйг бясалгах гэдэг нь сэтгэлээ яг тийн болгож өөрчилж байгаа хэрэг юм. Их дуун хөрвүүлэгч нар заримдаа "бясалгалын мөр" гэж хөрвүүлсэн байна.

Зарим тохиолдолд "Илт онохуйн чимэг"-ээс: "Үзэх болоод дадуулах мөр" хэмээн "дадах, дадлагажих" гэсэн утгаар хөрвүүлсэн нь үзэгдэнэ.

Мөн Майдар гэгээн бээр:

Магад гарахуйн гишүүн болоод
Үзэхийн мөр ба бясалгахын мөр ямагт нь
Дахин дахин бодож санах,
Тунгаах, магадлан мэдэх, дадлагажих мөр

хэмээн их хөлгөний хутагтын бясалгалын мөр ч ялгалгүй дахин дахин санах, тунгаах, онож мэдэх явдал байдгийг айлджээ. Үүнээс ажиглахад судлах болон бясалгах хоёрыг харш гэвээс инээдэм наадмын орон болох нь ээ.

Сүсгийн бясалгал, дөрвөн цаглашгүйн бясалгал, бодь сэтгэлийн бясалгал, мөнх бусын бясалгал, зовлонг бясалгах гэх мэтийн дахин дахин судалж шинжлэх ёстой хэмжээлшгүй олон бясалгал байдгийг зарлигласан байна.

"Бодисадвын явдалд орохуй" болон *"Суртгаалын хураангуй"*- аас: "Өөрийн сэтгэлдээ дадуулж үйлдэхийн тухайд туурвилаа би" хэмээсэн нь энэ хоёр шастарт номлосон мөрийн зэрэг бүхэн бясалгах, дадуулах мөр болохыг тодорхойлжээ.

"Суртгаалын хураангуй"-гаас: "Тиймээс бие, эдлэл, буянаа насан үргэлжид өгөх, сахих, ариусгах, арвижуулах алин хэргийг дадуулан үйлдээрэй" хэмээн бие, төгс эдлэл, буяны язгуур тус тусыг өгөх, сахих, ариусгах, арвижуулах зэрэг дөрөв дөрвөн зүйл бүгдийг бясалган дадууп хэмээн айлдсан учир бясалгал гэдгийг хэтэрхий бага зүйл гэж бүү баригтун.

"Атгаг бүгдээрээ бэлгэст барих тул бурхан болохын тотгор болно" гээд "Тус тус онох бясалгал бүгдийг орхих хэрэгтэй".гэдэг энэхүү чанх буруу үзэл нь хятад хамба Хуушааны ёс юм. Эл ёсыг амарлингүй болон үлэмж үзэхүйн аймагт хориглож номлоно.

Гол номд бишрэл төрөхийн тотгор болоод буруу бодол эндээс үүджээ. (Тэрээр) Эдгээр гол номын утгыг зөвхөн тус тус онох утгаар шинжлэх хэрэгтэй гээд бясалгахын үест шинжлэх, ажиглах хэрэггүй гэж үзжээ. Дээдийн ном сэвтэхийн их шалтаг энэ буюу.

Эрхэм зарлиг болон тааллын их тайлбар зэргийг увдис болгон ухаарч чадаагүйгээс тайлбарлахаас өөр зүйл үгүй буюу.

Чингээд мөрийг бясалгахад "шинжлэх бясалгал" (ажиглах) ба "тогтоох бясалгах" (төвлөрүүлэх) гэсэн хоёр зүйл буй. Чухам ямар мөрийг шинжлэх бясалгал гэх, ямар мөрийг тогтоох бясалгалд багтахыг номлож үйлдсү. Буяны саднаа сүсэглэх, чөлөө учрал их ач тустай болон олоход бэрхтэйг санах, мөнх бусыг санах, үйлийн үр, орчлонгийн гэм эргүүг бодох, бодь сэтгэлийг бясалгах зэрэг нь шинжлэх бясалгалд багтана.

Эдгээрийг бясалгахад зоримог хүчтэй ухаан, өнө удаан хугацааны сэтгэлийн хичээнгүй чадал зайлшгүй хэрэгтэй. Эс чингэвээс сөрөг тал болох тул үл бишрэх тэргүүтнийг хорьж чадахгүйд хүрнэ. Ийм ухааныг олж авна гэдэг зөвхөн дахин дахин тус тус шинжлэх бясалгалаас хамаардаг учиртай. Үлгэрлэвээс, Шунах орныхоо гуа сайхан шинжийг хэтэрхий дөвийлгөх явдал ихэдвэл хомхой шунал улам ихээр нэмэгдэх адил. Мөн дайснаа үзэн ядахын сэтгэлийг өөгшүүлвээс уур хилэн улам ихээр дүрэлздэгтэй адил.

Иймээс дээрх мөрийг бясалгахад ухааны орны намба байдал тодорхой, тодорхой бус байх нь гол бус, ухааны орон хүчтэй хатуу, өнө удаан байх нь гол учраас шинжлэх бясалгалыг үйлдэнэ. Сэтгэлээ нэгэн бодол дээр барьж чадах буюу нэгэн бодол дээр хүссэнээрээ сэтгэлээ эдэлж чадах амарлингуй сэтгэлийг бүтээх тэргүүтний үест дахин дахин шинжлэх гэвэл сэтгэл тогтож чадахгүй учраас тэр үед "тогтоох бясалгал" хэрэгтэй болно. Үүнийг "амарлингуй болон үлэмж"-ийн үест номнох болой.

Энэ ёсыг ухааралгүйгээр "мэргэд болвоос зөвхөн шинжлэх бясалгалыг үйлдэх буюу Гусали бээр зөвхөн тогтоох бясалгалыг үйлдэнэ" гэж өгүүлвээс зохисгүй болно. Тус тусдаа хоёуланг үйлдэх хэрэгтэй буюу. Мэргэд ч амарлингуй сэтгэл тэргүүтнийг бүтээнэ. Гусали бээр ч буяны саднаа хүчтэй сүсэглэх тэргүүтнийг бүтээх хэрэгтэй шүү.

Бясалгалын энэхүү хоёр ёсоор тус тус онохын үүднээс бясалгал үйлдэх учиртайг судар, тарнийн аймаг хоёуланд олонтаа зарлиглажээ. Энэ ёсоор үл бясалгах юм уу багахан үйлдвээс мөрийн амин сүнс болсон хиргүй оюун ухаан үл төрнө. Өчүүхэн бага төрөвч ухаан дээшээ үл арвижиж газрын ахицаа гарахгүйд хүрнэ.

“Мөрийн бүтээлийн туйлд хүрнэ” гэдэг “ухааны дотроос хамгийг болгоогч ухааныг олох мөн” хэмээн Ловон Махол бээр тодорхойлсон мэтээр үнэмлэхүй болоод янагуунхи мэдэгдэхүүн бүгдийг холилгүй оножмэдэх ухаанд хүрнэ.

Тиймд зам мөрийг хичнээн бясалгавч мартах ихсэж, санах багасаж улмаар авч орхихыг ялгах ухаан доордоод ирвэл зам мөр буруудаж байгаагийн шинж гэж сайтар ойлгоорой.

Чухаг дээд гурав тэргүүтний олон онцгой сайн эрдмүүдийг мэдэх, тэднээ сүсэглэх сэтгэл улам нэмэгдэх, орчлонгийн зовлонг таньж мэдсэнээр сэтгэл улам уйсч гансрах, нирвааны тус эрдмийг олон талаас дахин дахин бодох, түүнд сэтгэл хүчтэй хатуу татагдах, бодь сэтгэл, зургаан барамид тэргүүтний сонин гайхамшигт явдлыг ухаарч ойлгох, тэднээс үл буцах сүсэг, дуршил төрөх, шамдаж орох гэх мэтийн нэмэн нэмэн одох эрдэм бүгдээр зөвхөн тус тус ажиглах оюунаас үүдсэн эрхэм зарлигийн утгыг шинжилсэн бясалгалд харгалзах ажгуу

Иймээс ухаантан мэргэд та бүхэн бусдад хөтлөгдөлгүй энэ ёс дагуу тууштай бүтээгээрэй.

Бясалгах ёсыг багахан мэдэгч зарим нэгэн “Тус тус шинжлэх явдлыг ихэсгэж судалваас нэг бодол дээр төвлөрөх, нэгэн үзүүрт бясалгал төрөхөд саад учруулж тогтоох бясалгал баттай төрөхгүйд хүрнэ” хэмээлддэг. Урьд байгаагүй сэтгэлээ нэгэн бодолд төвлөрүүлэн өөрийн эрхээр эдлэх чадал олох бясалгалыг шинээр төрүүлэх гээд олон зүйлийг ажиглаж шинжлэнэ гэвэл тогтоох бясалгал төрөхүйд хүрнэ.

Тийм нөхцөлд тухайн бясалгалыг зөвхөн тогтоох бясалгал мөн гэвэл үүнийг би ч бас зөвшөөрнө. Харин энэ адилын бясалгалаас өмнө ажиглах, шинжлэх явдлыг ихэсгэснээр бясалгалд саад тотгор болно гэж үзвээс бясалгал бүтээх ёсны талаар ‘Их тэрэг”-ний тааллын тайлбар номд ерөөс ухаараагүйг илтгэнэ.

Энэ мэтийг үлгэрлэвээс, ухаант уран дархан хүн алт, мөнгө зэргийг ахин дахин галд хайлуулах, ахин дахин усаар угаах зэргээр хир буртгаас арилгах, машид сайн зөөлрүүлэх зэргээр үйлдэж хэрэглэхэд бэлэн болгодог. Ингээд ээмэг тэргүүтэн гоёл чимгийг хүссэнээрээ урвуулан урладаг билээ. Үүнтэй адилаар юуны түрүүнд муу сэтгэл болон дөт муу сэтгэл зэргээс үүдэх буруу явдлууд болон тэдгээрийн алжаас гэм зэргийг тус тус онох ухаанаар бясалгана.

Чингэхээр сэтгэл энэлэн шаналах, санаа зовох, эсвэл уйсах гансрахын бодлууд төрж ирнэ. Ийм сэтгэл бодол ургаснаар, алтыг галд

хайлуулж хир шороог арилгах адил буруу зүгийн бодлууд сэтгэлээс зайлж гарна. Мөн буяны садны эрдэм ухаан болон чөлөө учралын ач тус, чухаг дээд гурвын эрдэм чадал, буяны үйлийн үр, бодь сэтгэлийн тус эрдэм тэргүүтнийг тус тусын аймгаас заасан дагуу тус тус онох ухаанаар дахин дахин бясалгана.

Бясалгаж сураад ирэхээр сэтгэл зөөлөн дулаан, тунгалаг саруулхан байдалтай болно. Ийм байдалтай сэтгэл нь усанд угаасан алт адил цагаан зүгийн замд илт баяртай зүглэх агаад буян номоор сэтгэл чийглэгдэх болно. Амарлингуй, үлэмж хоёрыг бүтээгч хэн бүхэн сэтгэлээ үүнд тушаавaас төвөггүй бүтнэ. Ийм учраас энэ адилын шинжлэх бясалгал болвоос үл атхаглах бясалгалыг бүтээх эрхэм дээд арга болдог билээ.

Ийн болохыг Хутагт Асанга бээр: "Үлгэрлэвээс, уран дархан, түүний шавь нар алт, мөнгөний хир буртгийг арилгахын тухайд цаг цагт галд хайлах, усаар угаах зэргээр үйлдсээр гоёл чимэг хийж болохоор зөөлрүүлж ашиглахад бэлэн болгодог нь хэнд ч тодорхой билээ. Цаашлаад уран дархан, урлахуйн ухаанд мэргэшсэн түүний шавь нар шиг, хэн ч гэсэн сэтгэлээ ямар ч үед хомхой сэтгэл зэргийн хир буртаг руу үл зүглүүлэн, нисваанис зэрэг таагүй муу сэтгэл рүү ерөөс үл хандуулж харин буяны зүгт илт баясан илт зүглэн илт баясан одно.

Бясалгалч тэрээр сэтгэлээ амарлингуй болоод үлэмж үзэхүйн зүгт тус тус лавтай нийлүүлнэ. Тэр зүгт машид ойртон лавтай барилдуулж түүнээс огтхон ч үл хөдлөх үл салах буюу. Хэрхэн санасан утгаа үнэхээр бүтээхийн тухайд л одох болой" хэмээн айлджээ.

"Бясалгалын харшлах шалтгаан" Сэтгэлээ нэгэн бодол дээр баттай тогтоон бясалгахад хоёр зүйлийн харшлах шалтгаан учирдаг. Эдгээрийг "живэлт" (үлбийх) ба "дошигрол" (хөөрөмших) гэдэг.

Чухаг дээд гурвын эрдэм чадлыг мэдэрсэн ухаан хүчтэй баттай ухаан өнөд удаан оршвоос живэлтийг таслахад хялбар болдог. Живэлтийг буцаах ерөндөгт эрдэм чадлын ухаарал болон сэтгэлд урам зориг, хүч чадал нэмэх магтаал сайшаалын бодлууд багтана хэмээн олон мэргэд айлджээ.

Мөнх бус болон зовлон зүдгүүр зэрэг гэм буруугийн талаас ухаарах сэтгэл хүчтэй, өнө удаан байх аваас дошигролыг таслахад хялбар дөхөмтэй болдог ажээ.

Дошигрол нь хүсэл шуналын аймагт багтах сэтгэлийн алгасрал мөн тул түүний ерөндөг болгож уйсах сэтгэлийг сайшааж олон ном судраас айлдсан байна.

Тиймээс буяны саднаа сүслэх сэтгэлийг төрүүлэхээс эхлээд орохуйн бодь сэтгэлийг бясалгах хүртэлх эрдмүүдийг хэдий чинээ олонтаа дадуулж бясалгах тусам мэргэд баясах баттай бясалгал улам амар хялбар төрдөг ажээ.

Тогтоох бясалгалаар зогсохгүй шинжлэх бясалгалыг төрүүлэхэд ч живэлт, дошигрол хоёроос ангижирч бясалгах шаардлагатай.

Энэхүү увдисыг дамжуулж өгсөн дээд үеийн ухаантан мэргэд бээр тухай тухайн үеийн бясалгалын орны бодол санааг гүнзгийрүүлэн тайлбарлахын тулд судар, тайлбар хоёулангаас үзүүлсэн тухайн эш номын утга ухааныг багшийн хүртээсэн увидастай нийлүүлэн бодолдоо нэрж, басхүү урьд өмнө гарсан зарлиг зөвшөөл зэргээр нэмж чимэглээд бүгдийг зааж иржээ.

Ямар ном заахаа мэдэгч нэгэн бээр ямар ном сонсохоо мэдэгч нэгнээ ном заалаа гэхэд ч шавийн ухааныг боловсруулж гүн бодрол бясалгалыг суулгаж өгнө гэдэг тийм амаргүй шүү гэж хэлцдэг нь яах аргагүй үнэн билээ.

"Одоо бол бодох үе" гээд овойж шовойж суух төдийгөөр бас болохгүй. Чингэвээс "сонсох санахын цаг" болоод "баясалгалын цаг" гэж олон номд айлдсан болон "бясалгалын үе" гэсэн хоёрыг ч харшуулан барих буруу бодолд хүргэнэ шүү.

Гэхдээ номнол бүгдийг бясалгал гэх явдал ертөнцөд хааяа нэг үзэгдэх тул бүгдийг бясалгалын үндэстэй гэж үзэх нь алдаанд хүрч мэднэ.

Эрхэм зарлиг бүгдийг увдист ургуулах, эс ургуулах гэдэг зөвхөн энэхүү бясалгах ёсыг зөв ухаарсан, ухаараагүй хоёртой шүтэлцээтэй бөлгөө. Харин номын аймаг савд суралцаагүй хүмүүст энэ зүйл хамаарахгүй.

Харин судар тарнийн их номыг олон жил судалсан хүмүүс зам мөрийг бясалгахын цагт урьд өмнө өөрсдөө үзэж байсан тэрхүү номын зүгтээ татагдах үзэгдэх тул дэлгэрэнгүй сайтар номлох хэрэгтэй байна. Гэвч үг олон болох вий гэж бодоод энэ төдийгөөр хязгаарлая. Бясалгах ёсны талаарх буруу бодлыг хорьж номнов.

ЧӨЛӨӨ УЧРАЛЫГ САНАХ

Эдүгээ багш бээр дээр үзүүлсэн ёсоор буяны садныг ёсчлон шүтэгч шавь түүнээ хөтлөхийн зэргийг ёсчлон заах хэрэгтэй болно. Ийнхүү багшийг шүтэж оюунаа судлахуйн зэрэгт хоёр :

1. Чөлөөт шүтээний шимийг авахаар шаардах
   а. Чөлөө учралыг танин барих
   б. Түүний хэрэг ихтэйг санах
   в. Олоход бэрхтэйг санах

а. Чөлөө учралыг танин барих:
1) Чөлөө
2) Учрал
а) Өөрийн таван учрал
б) Бусдын таван учрал

1) Чөлөө: *"Их эрдэнийн эрдмийн хураангуй"* -гаас:

Ёсыг сахиснаар адгуус амьтны элдэв олон төрөл болон
Найман чөлөөгүйг тэвчиж, тэрбээр чөлөөг үргэлжид олох хэмээн айлдсан мэт найман чөлөөгүй орноос хагацсан учраас чөлөөтэй болно.

Найман чөлөөгүй орны талаар "Садангийн захидал"- д айлдахдаа:

Буруу үзлийг баригсад ба
Адгуус, бирд, тамд төрөгсөд,
Бурханы зарлиг үгүй бөглүү хязгаарт төрөгсөд
Малиг махчин болоод хэлгүй дүлий,

Урт наст тэнгэр зэрэг алин тэдгээрт
Төрсөн хэмээгчид чөлөөгүйн найман гэмт буюу
Тэдгээр лугаа хагацваас чөлөөг олох тул
Тэдгээрт төрөхийг буцаахын төлөө шамдан зохио хэмээжээ.

Тэр мэт дөрвөн нөхөр үл орших бөглүү хязгаар орон (1), хэлгий дүлий, ам хамар тэргүүтэн эрхтэн үе гишүүн төгс бус (2), хойд урьд нас, үйлийн үр, чухаг дээд гурвыг үгүйсгэн баригч буруу үзэлтэн (3), бурхан

залраагүйгээс түүний ном зарлиг оршоогүй (4) зэрэг дөрвөн зүйлээс эхний хоёр ба суулчийнх нь авч орхихын ухааны чадал үгүй болохыг, гутгаар нь дээдийн номд сүжиггүй болохыг үзүүлжээ.

Гурван муу заянд ном буяны ухаан төрөх нь машид бэрхтэй. Өчүүхэн нэг төрөвч зовлондоо дийлдээд бүтээж үл чадах аж.

Урт наст тэнгэрийн талаар "Садангийн захидлын тайлбар"-т өгүүлэхдээ "урт наст тэнгэрт хур мэдэлгүй ба дүрс үгүй гэсэн хоёр зүйл тэнгэр буйг" номлосон байна.

"Найман чөлөөгүйн тухай дамжлага яриа"-нд: "Хүслийн ажлаар үргэлжид алсгасрах Амармагийн тэнгэр багтахыг" ч номножээ. "Хур мэдэлгүй" гэдэг нь дөтгөөр самади орны "Их урт" хэмээгдэх орны багтах хот балгадаас аглагт орших бөгөөд тэнд төрмөгц үхэхээс бусад үед сэтгэл (гол) болон сэтгэлээс гарах (нөхөр) сэтгэлийн хөдөлгөөнөө хааж их олон галбаар тэнд амьдардаг" гэж *"Авхидхарма"*-гаас айлджээ .

Дүрсгүй оронд ажрагч хутагт нарыг чөлөөгүй гэж тооцох нь зохисгүй. Харин тэнд төрсөн эгэл төрөлхтөн бодь мөрийг бүтээхийн хувьгүй учир чөлөөгүй хэмээмой. Үргэлжид алгасрах Амармагын тэнгэртэй адилд үзсэн буй. Тийнхүү тэдгээрийг чөлөөгүй гэсэн нь *"Садангийн захидлын тайлбар"*-т: "Найман орон тэдгээрт буяныг үйлдэх чөлөө үгүй тул чөлөөгүй хэмээжээ" хэмээсэн утга буюу.

2) Учрал: *а) Өөрийн таван учрал:*

Хүмүүн ямагт (1), төв газар төрсөн (2), эрхтэн бүрэн төгс (3),
Үйлийн эцсээс эс буцсан (4), орноо сүжигтэй (5)" хэмээжээ.

Эдгээрээс Төв газар төрөх (2) гэдэг дөрвөн нөхөр орших газарт төрнө. Эрхтэн бүрэн төгс (3) гэдэг хэлгий дүлий бус, үе гишүүн, нүд чих тэргүүтэн эрхтэн гүйцэд болой. Үйлийн эцсээс буцсан (4) гэдэг завсаргүй нүгэл үйлдсэн юм уу, үйлдэхүйд оруулаагүй болой. Орноо сүжигтэй (5) гэдэг сансар хийгээд нирвааны цагаан зүгийн ном бүгд төрөх орон болсон номхотхуун ёсноо сүсэглэх болой. Энэ үест номхтохуун хэмээх нь гурван аймаг савын ном болой.

Эл таван учрал нь өөрийн үндсэнд хураагдан ном бүтээхийн шалтгаан болдог учраас өөрийн учрал хэмээжээ.

б) Бусдын таван учрал :
Бурхан заларсан (1) ба дээдийн номоо заасан (2),
Дээдийн ном орших (3) ба түүнээ дагуулан оруулах (4)
Зүрхнээс бусдыг энэрэх (5) болой хэмээжээ.

Бурхан залрах буюу заларсан (1) гэдэг тоолшгүй гурван галвын буяныг хурааж бодь хутагт хүрсэн буюу илт туулсан бурхан болсон болой. Дээдийн номоо заах (2) гэдэг Бурхадын болон түүний шавь Сонсоод сонсогчийн номоо заасан болой. Дээдийн ном (3) орших гэдэг бурханы хутаг олоод номоо заснаас эхлээд гаслангаас нөгчихүй хүртэл үнэмлэхүй дээдийн номыг илт үйлдэж бүтээлийн ном доройтоогүй ёсыг өгүүлжээ.

Түүнээ даган орсон (4) гэдэг номыг болгоогч тэрээр төрөлхтөн ардуудад дээдийн номыг илт үйлдэх хүч чадал байгааг мэдээд хэрхэн оносон мэдсэнээ зааж, дагуулан оруулахыг хэлнэ. Бусдыг зүрхнээсээ энэрэх /5/ гэдэг өглөг буян үйлдэгч өглөгийн эзэд бээр номын хувцас тэргүүтнийг өгөх болой. Эдгээр тав бусдын үндсэнд байх бөгөөд ном буяныг бүтээхийн хувь мөн тул бусдын учрал хэмээжээ.

"Сонсогчийн газар" -т номносон мэтээр бусдын учралаас эдүгээ дөрөв нь бүрэн үзэгдэхгүй боловч дээдийн номыг заагч нар болон номд даган орогч нар байгаа тул зохилдох учралууд бүрэн байна.

б. Түүний хэрэг ихтэйг санах

Ашидын амгаланг бүтээх ариун ном буяныг бүтээлгүй зөвхөн үхэхээс наашхи жаргалыг бүтээх, зовлонг арилгахаар хичээх явдал адгуусанд ч байдаг тул хэдий сайн төрөлд төрсөн ч адгуустай ялгаагүй болюу.

"Шавийн захидал "- аас:

Хэрхэн тугал гүнзгий худгийн амнаас гараад
Атга өвс, балга уснаа сэтгэл шунан явсаар
Олсон олзгүй халил хад руу унахын адил
Амьжиргааны төдий жаргалыг бүтээх тэр мэт хэмээсэн буй.

Ер тэр мэтээр номыг бүтээх, ялангуяа их хөлгөний зам мөрийг бүтээхэд төрөл бүхэн тохирдог бус. Чухамхүү дээр үзүүлсэн тийм л шүтээнийг олох шаардлагатай.

"*Шавийн захидал*"-д өгүүлэхдээ:

Бурханы мөрийг бүтээж амьтны Сартваахь болох хувь заяаг
Сэтгэлийн их хүчит хүмүүн төрөлхтөн олохоос бус,
Алин тэр мөрийг тэнгэр, лус ч үл олсон бөгөөд
Асура, гарьд, тарнийг баригч, мэам-жэ, дочи ч олох бус хэмээсэн ба

"*Хэвлийд орохуй*"-гаас: "Хүмүүний төрөлд төрөхөд хэдий хэмжээлшгүй зовлонтой ч гэсэн дээд төрөл учраас сая жива галавт ч олоход бэрхтэй билээ. Тэнгэр үхэхдээ, бусад тэнгэртээ та нар сайн төрөлд төрсүгэй. Сайн төрөл нь хүний төрөл болой" хэмээдэг нь тэнгэр хүртэл энэ төрлийг ерөөлийн орон болгодгийг харуулж байна.

Мөн урьд хүмүүн төрөлд байхдаа мөр судлахын авьяас суусан зарим нэг Хүсэлт тэнгэрүүдэд анхандаа үнэнийг үзэхийн хувь гарч болох ч, дээд ертөнцийн тэнгэрийн төрөл дээр хутагтын мөрийг анхлан олно гэж байхгүй. Хүсэлт тэнгэр нь дээр номносон мэт чөлөөгүй оронд тооцогдоно.

Иймээс зам мөрийг анхлан бүтээх эрхэм дээд нь хүмүүн заяа мөн. Тэрчлэн Муухай дуут тивийнхэн тангараг сахилын шүтээн болдоггүй учир үлдсэн гурван тивийг сайшаасан буй. Тэдний дотроос Замбу тивийн шүтээнийг илүүтэй сайшаасан буюу.

Энэ адил сайн төрлийг олчихоод юунд дэмий өнгөрөөнө вэ би. Үүнийг дэмий өнгөрөөвөөс өөрөө өөрийгөө хуурч мэхэлж, моншрохоос илүү юу билээ. Муу заяа тэргүүтэн чөлөөгүй орны олон хавцлыг дамжин дамжсаар, түүнээс ганцхан удаа гэтэлсэн энэ хэргээ бүтээлгүй, дахин түүнээ буцаж одвоос тарниар моншрч эргүүтсэн адил, ухаангүй болов уу би гэх зэргээр олон талаас дахин дахин тунгааж бясалгах хэрэгтэй.

Хутагт Баву бээр:

Алин олсон түүгээр орчлонгийн
Чанад хүрэх хөрөнгийг мэндлүүлмү
Цогт бодь хутгийн дээд хөрөнгө бөгөөд
Зэндмэнь эрдэнээс ч үлэмж илүү

Үргэлжийн эрдэнэт хүний төрлийг
Хэн үргүй дэмий үрэх билээ хэмээжээ.

“Бодисадвын явдалд орохуй”-гаас:

Энэ адилын чөлөөг олчихоод
Буянд дадаж эс үйлдвээс би
Үүнээс хуурмаг бусад үгүй
Түүнээс тэнэг бусад үгүй билээ

Хэрвээ түүнийг мэдсээр би
Мунхаглан хойшлуулж сааруулбаас
Үхэл ирэхүйн цагт
Уй гаслан ихэд босох мөн

Тэсэхүйеэ бэрх өнө удаан тамын галд
Миний бие шатан түлэгдэхэд
Баршгүй гэмшлийн гал дүрэлзэн
Энэлэн шаналах нь осол омтоггүй мөн

Машид олоход бэрх их хэрэгтэй газрыг
Түр нэг сайн золоор олчихоод
Өөрөө ухан мэдсээр хэр
Хожим там түүнээ хөтлөгдвөөс л

Тарниар мунхран эргүүтэх мэт
Тэнд би юу ч санахын завдалгүй барагдах
Юунд мунхарснаа ч би үл мэдэх
Миний дотор юу нэгэн байна даа хэмээжээ.

Донбо гэгээн Жан-а-ва-гаас: “Чөлөө учралт хүний биеийг олсноо санадаг уу” гэхэд Жан-а-ва тааллын дээдэд барьдаг гээд:

Ашид өөрийн эрхээр зохилдон орших
Алин түүнийгээ хэрвээ өөрийн болгож эс үйлдвээс
Халил хаданд унаж бусдын эрхэнд орох тул
Хожим хэнээс юугаа гуйх билээ

хэмээн *“Орохуй”*-гаас айлдсаныг дахин дахин уншиж тааллын дээдэд зохиожээ. Тэр мэт эцэс хойдоо бодсон ч их тустай төдийгүй, орон үесээ бодсон ч өндөр язгуур, эд баялаг, хотол чуулган, нөхөр сэлтийн уг үндэс болсон өглөг, ёс журам, тэсвэр тэвчээр зэргийг энэ шүтээн дээр л амар хялбар бүтээх жамыг ч санах хэрэгтэй.

Гэвч тэрхүү өндөр язгуур болон тонилохуйн хутагт хүргэх их хэрэгтэй энэ төрлөө, тэдгээрийг бүтээх уг үндэс болгохоор шамдалгүй, өдөр шөнөд шамшааж үйлдвээс их эрдэнийн тивээс гар хоосон буцахтай адил болно шүү. Хойшдоо ч амгалангаар хоосорч чөлөөт шүтээнийг олохгүйд хүрнэ. Түүнийг эс олвоос зовлонг эдлэхэд л тулах тул, түүнээс тэнэг зүйл байна уу хэмээн сана.

Хутагт Баву бээр:

Алин сайн буянаар дээшилсэн хүмүүс
Тоолшгүй галваар хураасан хирнээ
Эдүгээ мунхаглан буяны хүү сангаа
Өчүүхэн төдий эс арвижуулваас

Тэд ертөнцийн чанадад одоод
Барагдашгүй гаслангийн гэрт орох,
Их эрдэнийн тивд хүрсэн худалдаачин
Гар хоосон өөрийн гэртээ эгэх мэт

Арван цагаан буяны мөргүй бол
Хожмоо олно гэж үгүй,
Хүнийг олоогүй буян түүгээр
Яаж амгалант болох тэр зовлонт мөн

Тэгээд ч алсдаа хуурмаг үгүй бус
Түүнээс илүү мунхаг үгүй хэмээжээ.

Тийнхүү тунгаан бодсоны эцэст шимийг авах хүслийг үүсгэх хэрэгтэй.

"Бодичаряаватара"-аас:

Түүнээ хөлсий нь төлөөд
Эдүгээ өөрийн тусыг бүтээхээр оруул
Тус болохгүй юманд
Бүгдийг өгч үл болох хэмээгээд

Хүмүүний онгоцыг шүтэн
Зовлонгийн их далайгаас гарах
Эл онгоцыг хожмоо олоход бэрхтэй тул
Эргүүтэн цагийг нойроор бүү өнгөрөө хэмээсэн мэт.

Бодова гэгээний "Үлгэр ном"-оос: "Өт хорхой мөргөл хийх, хулан унах, Замбаагийн загас, арвайн гурил" хэмээсэн мэтийг санан шимийг авах хүслийг үүсгэх болой. [31]

в. Олоход маш бэрхтэйг санах

Тэрхүү чөлөөний талаар *"Эшийн суурь"*-аас:

Муу заянд үхэл егүүтгэн тэнд төрөх нь их шороо тоос адил
Тэндээс сайн заянаа төрөх нь хурууны үзүүрээр авсан тоос адил
Хоёр сайн заянаас үхэл егүүтгэн муу заянд одох нь их шороо адил
Түүнээс сайн заянд төрөх хурууны хумсны үзүүрээр авсан тоос адил

хэмээсэн тул сайн заяа болоод муу заяа хоёулангаас олоход бэрхтэй болой. Тийн олоход бэрхтэй гэдэг чухам юунаас хэмээвээс,

"Дөрвөн зуут"-аас:

Ихэнх хүмүүс дээдийн бус зүгийг барин
Тиймээс эгэл төрөлхтөн ардын
Ихэнх нь тамд лавтай одох

хэмээсэн мэт сайн заянд төрсөн хүмүүсийн ихэнх нь арван хар нүгэл тэргүүтэн муу зүгийг барих нь олон тул түүгээр муу заянд одох буюу.

Бас Бодисадвад уурласан агшин хэдий чинээ байна, төдий чинээ тоотой галавт аюус тамд суух хэрэгтэй байхад урьд олон төрөлдөө хураасан хилэнцийн үрийг эс сөхөөсөн, еөндөгөөр эс дарсан зэргээр бидний сэтгэлд их нүгэл буй тул муу заянд олон галавт суухыг хэлэх хэрэг юун. Гэвч урьд хураасан муу заяаны үр үндсийг арилгаж шинээр хураах үүдийг хаагаад байвал сайн заянд хүрнэ.

Гэвч ингэх нь машид ховор ажээ. Тийн эс чадваас муу заянд одох ба тэнд одвоос буяныг үл үйлдэн харин үргэлжид хилэнц нүгэл үйлдэх тул олон галавт сайн заяаны нэр төдийг ч үл сонсон, олоход бэрхтэй болно.

"Бодичарияаватара"-гаас:

Миний энэ адилын явдлаар
Хүний биеийг ч үл олох
Хүний биеийг эс олвоос
Буян үгүй гагц нүгэлт болох

Алин буян үйлдэхийн хувьтай ч
Буян ном эс үйлдсэн би
Муу заяаны хамаг зовлонд төөрөх
Тэр цагт би юу хийх билээ

Сайн буяныг үл үйлдэн
Саар муу нүглийг тухайлан хураавaас
Сая живаа тоот галавт ч
Сайн заяаны нэрийг ч үл сонсох

Тийн болохыг Ялж төгссөн бээр,
Их далайд хөвөх буулга модны нүхнээ
Яст мэлхийн хоолой таарах мэтээр
Хүнийг олоход бэрхтэйг зарлиглажээ

Ганцхан агшинд үйлдсэн хилэнцээр
Аюус тамд суух ёстой болохоор
Тэргүүлшгүйгээс орчлонд хураасан хилэнцээр
Сайн заяанд үл одохыг хэлэх хэрэг юун хэмээжээ.

Хэрвээ муу заяаны зовлонг амсаж байхдаа л урьд хураасан муу заяаны үйлээ барчихвал сайн заяанд төрөх тул гэтлэхэд юунд бэрхтэй билээ хэмээвээс. Тэрхүү зовлонг амсаж эдэлж байхдаа даруй даруйд нүгэл хураадаг тул муу заяанаас үхэл югүүтсэн ч муу заяанд дамжих тул гэтлэхэд бэрхтэй билээ.

Тэр төдийг амсаад
Тэрээр үл гэтлэх ба
Энэ мэт түүнийг амссаар,
Бусад хилэнц ч амархан төрөх хэмээжээ.

Ийнхүү олоход бэрхтэйг санасны эцэст энэхүү төрлөө буруу явдалтай холивоос машид амархан шимийг барахыг мэдээд, дээдийн номыг бүтээж цагийг өнгөрөөх болтугай хэмээн шимийг авах ухааныг төрүүлнэ. *"Садангийн захидал"*-аас:

Их далайд хөвөх буулганы нүхнээ
Яст мэлхий учрахаас ч илүү
Адгуснаас хүн ямагтыг олоход бэрхтэй тул
Хүний эрхээр дээдийн номыг туурвиж үр ашигтай эдлэ

Алин их эрдэнээр хээлсэн алтан хайрцагны
Алимад муу хирийг арчин цэвэрлэхээс илүү
Алин хүмүүний төрөлд төрчихөөд хилэнцийн үйлээр
Амьдрах тэр л хамгийн их мунхаг мөн хэмээсэн ба

"Шавийн захидал"-аас:

Олоход бэрхтэй хүний төрлийг олчихоод
Тухайлан сэтгэл юугаа тэр ямагтад таацуулан зориул хэмээжээ.

Налжорва гэгээн бээр Жан-а-ва-д өчүүхэн төдийг айлдсу гээд, "чагнасанд энэхүү чөлөө, учрал олоход бэрхтэй шүү" гэж айлджээ.

"Панюл хэмээх орноо Лхүндүжон (Аяндаа бүтэгч) хэмээх их хот байжээ. Тэр хот дайснаа эзлэгдэн өнөд удаж бас эвдэрч сүйрчээ. Хотынхоо төлөө сэтгэл зовж явдаг нэгэн өвгөн байж. Нэг удаа тэрээр өөрийн хотоо эргүүлж авлаа гэж сонсоод явж чадахгүй хирнээ богино таягаа нааш цааш эргэлдүүлэн Лхүндүвжонгоо оллоо, энэ маань зүүд биш байгаа хэмээн баярлан хашгирсан адилаар чөлөө учралыг олсондоо баярлан ном буяныг бүтээх хэрэгтэй" хэмээн Бодова гэгээн айлдсан мэт тийм ухаан төрөн төртөл бясалгаарай. [32] Чөлөө учралт шүтээний шимийг авах бэлэг чанар төгөлдөр ухааныг бүрдүүлэхэд дөрвөн зүйлийг санах хэрэгтэй буюу.

Үүнд:

1/ Түүнийг бүтээх шаардлага. Хамаг амьтан амгаланг хүсэн зовлонг үл хүсэх нь ав адил. Амгаланг бүтээх, зовлонг арилгах гэдэг зөвхөн дээдийн номноо харгалзах мөн.

2/ Бүтээж чадах. Гадаад нөхцөл буяны садан багш ба дотоод нөхцөл чөлөө учрал төгөлдөр тул болой.

3/ Энэ насанд бүтээх шаардлага. Эдүгээ эс бүтээвээс олон төрөлд чөлөө учралыг олохуй яа бэрхтэй билээ.

4/ Эдүгээгээс бүтээх хэрэгтэй. Хэзээ үхэх нь болзоогүй мөн.

Гуравдугаар зүйлээр хойд төрөлдөө ном буян үйлдэнэ хэмээх орхидог залхууг хорисон мөн. Дөрөвдүгээрт энэ наснаа бүтээх хэрэгтэй атал жил, сар, хоног нөгчөөн үл бүтээн маргааш бүтээнэ хэмээн үл орох залхууг хорино. Чингэж тэр хоёрыг түргэн бүтээхүйд багтаан гурван зүйлд багтааж болно.

Үхэхүйг санах ёс энэ үест хамаарахгүй боловч үг ихдэх тул хожим өгүүлэх болно.

Энэ мэт олон талаас санаваас оюуны чадал нэмэгдэх тул дээр номносон дагуу бодож эс чадваас чөлөө учралын мөн чанар юу болох, орон үес болоод эцэс хойдийн үүднээс чухал хэрэгтэйн ёс, үндэс болон үрийн үүднээс олоход бэрхтэй ёс зэргийг хураангуйлан тааруулж дээр өгүүлснээс авч бясалгаарай.

Үг үндэсний үүднээс олоход бэрх гэдэг нь ер амгалант заяа, сайн төрлийг олоход ч ёс суртахуун зэрэг ариун буян нэгнийг заавал бүтээсэн байх хэрэгтэй. Ялангуяа төгс төгөлдөр чөлөө учралыг олоход асар ариун ёс суртахуунаар суурь тавьж, өглөг өгөх зэргээр нөхөрлүүлэн, хиргүй ерөөлөөр завсрыг нь залгуулах зэргээр буяны үндэс маш их хэрэгтэй ажгуу.

Гэтэл тэр адилын үндсийг бүтээх явдал машид ховор үзэгдэх тул түүгээр жишээд түүний үр болсон ерөнхий сайн төрөл болоод ялгамжаат чөлөө учралт шүтээнийг олох бэрхтэй болохыг санаарай.

Үрийн үүднээс олох бэрхтэй нь үл зохилдох язгуурт муу заяаны амьтан лугаа харьцуулахад сайн заяанд очих нь өдрийн од шиг. Зохилдох язгуурт сайн заяаны амьтан лугаа харьцуулахад ч ялгамжаат чөлөөг олсон нь машид ховор байгааг бодоорой.

Үүнийг ихэд чухалчлан Гэвш Долбова бээр: "Бусад ном бүхэн эндээс эхлэх мөн" хэмээн айлдсан ёсоор шамдах буюу. [33]



ГУРВАН ТӨРӨЛХТНИЙ МӨР

2. Хэрхэн шимийг авах ёсноо хоёр:

а. Мөрийн ерөнхий агуулгыг магадлан мэдэх

1) Эрхэм зарлиг бүхэн гурван төрөлхтний мөрд хураагдах ёсон

2) Гурван төрөлхтний үүднээс зэрэгчлэн хөтлөх учир шалтгааныг үзүүлэх

1) Эрхэм зарлиг бүхэн гурван төрөлхтний мөрд хураагдах ёсон:

Бурхан багш бээр эхлэн бодь сэтгэлийг эгүүсгэн, улмаар буяныг хураах, эцэст нь туулсан бурхан болсон тэр бүхэн зөвхөн амьтны тусын төлөө бөлгөө. Айлдсан ном бүгд ч зөвхөн амьтны тусыг л бүтээх буюу. Түүний бүтээх амьтны тус болвоос орон үесийн өндөр язгуур болоод алс хэтийн тонилохуйн хутаг (нирваан) гэсэн хоёр зүйл ажээ.

Орон үесийн өндөр язгуурыг бүтээхээс эхтэй айлдал зарлиг бүгд бага төрөлхтөн буюу бага төрөлхтөн лүгээ нийтийн номын аймагт зүй ёсоор багтах аж. "Ялгамжаат бага төрөлхтөн" болвоос энэ насны ажлыг ихэд тухайлалгүй, хойд төрлийн өндөр язгуурын хотол чуулганыг чухалчлан, тэдгээрийн үндсийг бүтээхээр шамдагч байдаг. *"Мөрийн зул"*- аас:

Алин нэг байгаа арга юугаар
Орчлонгийн амгалан жаргалан төдийг
Өөрийн тусад чухалчлан үйлдэгч
Төрөлхтөн түүнийг бага хэмээн мэд хэмээжээ.

Тонилохуйн хутагт хоёр зүйл буй. Орчлонгоос гэтлэх төдий тонилохуй хутаг ба хамгийг болгоогч бурханы хутаг болой. Сонсоод сонсогч ба Өөрсдөө ялгуусадын номоос эхтэй айлдал зарлиг бүгд дунд төрөлхтөн буюу дунд төрөлхтөн лүгээ нийтийн номын аймагт зүй ёсоор багтана.

Дунд төрөлхтөн гэдэг даяар орчлонгоос уйдаж түүнээс гэтлэхээр тонилохуйн хутгийг өөрийн тусад олюу хэмээгээд түүнийг олох арга болсон гурван суртгаалд суралцахаар орогч ажгуу. *"Мөрийн зул "*-аас:

Орчлонгийн амгалангаас араараа зүглэн
Хилэнцийн үйлээс буцахын мөн чанарт

Алин өөрөө л амарлихуйг чухалчлагч
Төрөлхтөн түүнийг дунд хэмээмой хэмээжээ.

Жовужийн *"Явдлын хураангуй зул"*-д айлдсанаар:

Нууц тарни ба билгийн чанад хүрэхүйд
Шүтэн байж бодь хутгийг бүтээх хэмээн,
Багш бурхад зарлигласан тул
Түүний утгыг энд бичиж үйлдсү хэмээн айлдсан мэт.

Хамгийг айлдагчийн хутагийг бүтээх арганаа "нууц тарнийн их хөлгөн" ба "билгийн чанад хүрэхүй их хөлгөн" гэсэн хоёр буй. Их төрөлхтний номын аймагт тэр хоёр хураагдах ажгуу. Их төрөлхтөн гэдэг их нигүүлсэхүй сэтгэлээр бусдын эрхнээ урвасан учир хамаг амьтны зовлонг арилгаж үйлдэхээр бурханы хутгийг олюу хэмээж "зургаан барамид" болон "хоёр зэрэг" тэргүүтнээ суралцагч мөн болой. *"Мөрийн зул"*-аас:

Өөрийн үндсэнээ агч зовлонгоор (жишин)
Өрөөл бусдын зовлон бүхнийг
Үлдээлгүй арилгахыг үнэхээр хүсэгч
Төрөлхтөн тэр нь дээд мөн буюу хэмээжээ.

Энэ төрөлхтөн бодь хутгийг бүтээхийн арга болгож билгийн чанад хүрэхүй болон тарнийн хөлгөн хоёуланд суралцах ёсыг дараа өгүүлнэ.

Гурван төрөлхтний агуулгын талаар *"Ашид буулган хураангуйлсан"*-д:

"Мөн гурван бодгаль буй. Санваартай бус, санваартай бусын буст багтах ёс суртахууныг үнэхээр барин сахигч ч буй. Сонсоод сонсогчийн ёс суртахууныг үнэхээр барин сахигч ч буй. Бодисадвын ёс суртахууныг үнэхээр барин сахигч ч буй. Тэдгээрээс эхнийх нь бага төрөлхтөн, удаах нь дунд төрөлхтөн, гутгаар нь дээд төрөлхтөн буюу" хэмээсэн нь дээрхтэй утга нэгэн мөн. Үүнээс өөрөөр бага, дунд, их төрөлхтнийг олон үүднээс тодорхойлсон буй. *"Мөрийн зул"*-ын адилаар *"Авидхармын тайлбар"*-т айлдахдаа: "Ловон Егнин (Васубанду) бээр ч гурван төрөлхтний бэлэг чанарыг айлдсан буй. Бага төрөлхтний дотор энэ насыг чухалчлах ба хойд насыг чухалчлах хоёр буй. Гэвч энэ үест хоёр дахь нь гол бөгөөд өндөр язгуурын аргыг эндүүрэлгүй барьсан учраас болой" гэжээ.

2) Гурван төрөлхтний үүднээс зэрэгчлэн хөтлөх учир шалтгааныг үзүүлэх:

а) Гурван төрөлхтний мөрийн үүднээс хөтлөх утга
б) Тэрхүү зэргээр хөтлөх учир шалтгаан

а) Гурван төрөлхтний мөрийн үүднээс хөтлөх утга

Гурван төрөлхтөн хэмээн номносон хэдий ч их төрөлхтний мөрийн зэрэгт бусад хоёр төрөлхтний мөр хоцролгүй хураагдсан тул тэр хоёр нь их хөлгийн мөрийн хувь буюу гишүүн болно. Ловон Даян бээр :

Янагуухи бодь сэтгэлийг бясалган
Үл хөнөөх, үнэнийг мэдэх,
Өглөг өгөх, ариун явдлаар явах,
Барьсан бүхнээ өгөх зэрэг
Тэдгээр сайн заяаны явдал мөн

Орчлонгийн зовлонг үнэхээр мэдээд
Тэвчихийн тухайд үнэний мөрийг бясалгах ба
Хоёр амлашгүйг тэвчих
Энэ нь амарлингуйн явдал мөн

Эдгээр бүх анхааран авах зүйлүүд
Магад гарахуйн мөрийн гишүүн мөн
Ном бүхэн хоосон чанартайг ухаарснаар
Амьтныг нигүүлсэх усны үргэлжлэл гарах
Мэргэн аргын хязгаарлашгүй явдал
Магад гарахуйн дээд явдал мөн хэмээн айлджээ.

Чингэхлээр энэ үед орчлонгийн амгалан төдийг бүтээхийг зорилгоо болгогч-бага төрөлхтний мөр болоод зөвхөн өөрийн тусад орчлонгоос тонилохуйг (нирваан) чухалчлагч-дунд төрөлхтний мөрд хөтлөх бусаа.

Тэр хоёрыг багтаасан нийтийн зарим нэг мөрийг их хөлгөний мөрд хөтлөхийн өмнөх шат буюу их төрөлхтний мөрийг судлахын гишүүн болгож үйлдэнэ.

Тиймд дээр номносон мэт шимийг авахыг хүсвээс шим авах ёсыг

"Төв үзлийн зүрхэн"-ээс:

Хэн нэг бээр хулс зэгс мэт
Шимгүй эдгээр биеэ
Бусдын тусын тулд зориулан үйлдвээс
Гайхамшигт хэргийг бүтээгээгүй гэх үү

Нигүүлсэл төгөлдөр дээдэс бээр
Агшин нилээд нижгээдээр өтлөн үхэх
Өвчний суурь болсон эдгээр биеийг
Бусдын амгалан жаргалангийн суурь болгох

Дээдийн номын зул бадрах
Чөлөөгүй наймаас салсан энэ чөлөөнд
Дээд төрөлхтний явдлаар
Үртэй тустайг үйлдвээс зохистой хэмээсэн мэт.

Хулс зэгс мэт шимгүй, өтлөх, өвдөх зэрэг зовлонгийн уурхай болсон өөрийн энэ биеийг их төрөлхтний сайн явдлаар өдөр шөнөд өнгөрөөж олсон хэргээ бүтээсүгэй хэмээн санаад их хөлгөнөө орох хэрэгтэй. Чингэж эхнээсээ их хөлгөнөө хөтлөгдөх зохистой атал юуны учир бага, дунд төрөлхтний нийтийн мөрийг судлах хэрэгтэй вэ? хэмээвээс тэр хоёр лугаа зохилдох нийтийн мөрийг судлах явдал их төрөлхтний мөр төрөхийн удиртгал шат бөгөөд чингэх учрыг номнох болно.

б) Тэр мэтийн зэргээр хөтлөх учир шалтгаан:

1. *Бодит учир шалтгаан*
2. *Хэрэг зорилго*

1. Бодит учир шалтгаан. Их хөлгөнөө орохуйн үүд нь эрхэм бодь сэтгэлийг эгүүсгэх явдал билээ. Тэрхүү сэтгэл үндсэнд төрснөөр буюу "*Бодичарияаватара*"-гаас:

Бодь сэтгэл төрсөн тэр агшинаас
Орчлонгийн гянданд хүлэгдэж ядарсан амьтад
Сайвээр залрагсдын хөвгүүн хэмээн өгүүлэгдэх хэмээсэн мэтээр

Бурханы хөвгүүн буюу Бодисадва хэмээн алдаршиж тэр сацуу бие

шүтээн нь их хөлгөнөө багтдаг ажгуу. Харин тэрхүү сэтгэлээ доройтуулбаас их хөлгөний сүргээс гардаг аж. Тиймээс их хөлгөнөө орохыг хүсэгч хэн бээр олон үүднээс бодь сэтгэлийг эгүүсгэхээр шамдах хэрэгтэй.

Түүнийг төрүүлэхийн тулд эхлээд уг сэтгэлийн тус эрдмийг бясалган бодож зүрхний мухраас тус эрдэмд дурлах сэтгэлийг арвижуулах, улмаар долоон гишүүнт ба авралыг одуулах хэрэгтэй гэж бодь сэтгэлийн мөрийн зэргийн их шастарууд болох "Бодичарияаватара", "Шиксасамучаяа" зэрэгт айлдсан буй.

Тэрхүү айлдсан тус эрдмийг хураангуйлваас хоёр зүйл. Орон үесийн болон алс хэтийн тус эрдэм болой.

Эхнийхэд муу заяанд үл унах ба сайн заяанд төрөх хоёр буй. Энэ сэтгэл төрснөөр урьд хураасан муу заяаны олон муу шалтгаан арилах, хойшид хураахын үргэлжлэл тасрах, урьд хураасан сайн заяаны үйл улам арвижих, шинээр хураах сайн үйл ч өдөөгдөн барагдахын хязгааргүй болно.

Алс хэтийн үйл хэрэг болсон тонилохуй болон хамгийг айлдагчийн хутаг зэрэг ч энэ л сэтгэлд шүтэн байж амар хялбар бүтэх мөн. Өмнө нь орон үес болон алс хэтийн тус эрдмийг олох завсаргүй нэгэн хүсэл эрмэлзлэл төрүүлэхгүй бол, тэдгээр тус эрдэм бодь сэтгэлээс гарах тул бодь сэтгэлд шамдсу хэмээн өгүүлэвч үг төдийд урвах тул өөрийн үндсийг шинжлэн тодруулаарай.

Иймд өмнө нь ч өндөр язгуур ба тонилохуйн хоёр тус эрдмийг олох хүсэл үүсгэснээр л бага болон дунд төрөлхтний нийтийн сэтгэлийг судлах хэрэгтэй болой.

Тэр мэт хоёр тус эрдмийг олохын хүсэл төрүүлж тус эрдэмтэй сэтгэлийг бясалгаж орох хэрэгтэй. Тиймээс бодь сэтгэлийн үндэс болсон асрахуй ба их нигүүлсэхүй сэтгэлийг үүсгэх шаардлагатай. Чингэхдээ би өөрөө амгалан жаргалангаар хоосорч, зовлонд нэрвэгдэн орчлонд тэнэж яваагаа санаж шар үсний нүхээ хөдөлгөх бус харин бусад амьтан орчлонд тэнэн, амгалан жаргалангаар хоосорч, зовлонгоор нэрвэгдэж байгаад л тэсэлгүй сэтгэл өвдөж зовох болой.

"Бодичарияаватара"-д айлдахдаа:

Ийнхүү амьтан хүн урьд өмнө
Өөрийнхөө тусад ч энэ адилын сэтгэлийг
Зүүдэндээ ч эс зүүдэлсэн тул
Бусдын тусад хаанаас төрөх хэмээжээ.

Тиймд бага төрөлхтний үест өөртөө муу заяаны зовлон буух ёсон, дунд төрөлхтний үест өндөр язгуурт ч зовох бөгөөд амарлингуйн амгалан байхгүйн ёсыг санан, цаашлаад садан болсон амьтан бүхнийг өөрийн байдлаар жишэн бясалгаснаар асрахуй ба нигүүлсэхүй сэтгэл төрөхийн үндэс гарна.

Түүнээс бодь сэтгэл төрөх тул бага, дундын нийтийн санааг судлах явдал болвоос завсаргүй бодь сэтгэл төрөхийн арга болохоос, тусдаа өөр мөрд хөтөлж байгаа бус аа. Мөн тэр хоёрын үест аврал одуулах, үйлийн үрийг санах зэргийн үүднээс (буяныг) хураах, (нүглийг) арилгах үйлд олон үүднээс шамдах зэрэг нь бодь сэтгэлийн удиртгал болж, үндэс ариусгах арга болсон долоон гишүүнт ба авралыг одуулах зэрэгтэй зохилдох тул тэдгээрийг мөн л уг сэтгэл төрөхийн арга гэж ухаараарай.

Энэ үест бага дунд төрөлхтний номын аймгууд ханьцашгүй бодь сэтгэл төрөхийн гишүүн болох ёсыг багш нар сайтар ухаарч, шавь нар ч танин мэдээд судлах бүртээ тэдгээрийг санан, бодь сэтгэл төрөхийн гишүүн болгон судлахыг машид эрхэмлэх нь чухал билээ.

Эс чингэвээс их хөлгөний мөр болоод тус тусын мөрүүд хоорондоо барилдлагагүй болоход хүрнэ. Их төрөлхтний мөрд бодитой хүрэхийн зуур бодь сэтгэлийг лавтай эс олвоос уг сэтгэл төрөх тотгор гарах болуужин. Мөн түүнийг хүртэл их хэрэг тусаас доройтон одох тул үүнээ шамдан үйлд. Тэр мэт бага, дунд мөрийг судлан, их төрөлхтний үед номносон дагуу сайтар судласаар засваргүй бодь сэтгэлийг үндсэндээ яавч төрүүлж үйлд.

Чингээд тэр сэтгэлээ баттай болгохын тухайд нийт бусын авралыг өмнө нь одуулан ерөөхүйн бодь сэтгэлийг зан үйлээр авсугай. Ерөөхүйг зан үйлээр аваад түүний суртгаалд хичээн суралц. Цаашлаад зургаан барамид, дөрвөн хураангуй зэрэг бодисадвын явдалд суралцах хүсэл эрмэлзлэлийг олонтаа үүсгэ. Зүрхний мухраас суралцъю хэмээх хүсэл төрвөөс орохуйн асар ариун (бодь сэтгэлийн) санваар нэгнийг авагтун.

Язгуурын унал зэргээр халдаахгүйн төлөө амиа дүйцүүлэн сахих ба их, бага цувиралт гэм хирээр халдаахгүйн төлөө шамдан хэрвээ халдваас уналын жич заслыг ёсчлон айлдсан дагуу үйлдэн сайтар арилган зохио. Цаашлаад ерөнхий зургаан барамидад суралцах, ялангуяа сэтгэлээ юу хүссэн буяны зоригдолдоо эдэлж чадахын тухайд сэтгэл амарлиулахын мөн чанарт бясалгалын суртгаалд сайтар суралцах ёстой.

"Мөрийн зул"-д: "Илт мэдэлтэйн тулд амарлингуйг үүсгэх" гэсэн нь бэлэгдэл төдий юм. Жовужэ бээр бусад тохиолдолд буюу үлэмж үзэхүй

төрүүлэхийн тухайд гэсэн утгаар айлдсан тул түүний тухайд л амарлингуй сэтгэлийг бүтээх болой.

Мөн "би-д баригч" хоёр мунхагийн хүлээсийг таслахын тул "би-үгүй" буюу хоосон чанарын үзлийн утгыг лавлан мэдэж, бясалгах ёсыг эндүүрэлгүй судлаад билгийн мөн чанарт үлэмж үзэхүйг бүтээж үйлдэх буюу.

Тиймээс "Ёс суртахууны суртгаалд амарлингуй сэтгэл ба үлэмж үзэхүйд үл хамаарах орохуйн санваарын суртгаалаас өмнө суралцах суртгаалууд багтах ба бясалгал буюу сэтгэлийн суртгаалд амарлингуй сэтгэл багтаж үлэмж үзэхүй нь билгийн суртгаал болно" гэж "Мөрийн зулын тайлбар"-т айлджээ.

Өөрөөр хэлбэл амарлингуйгаас доошхи мөрүүд нь "аргын хувь" буюу, бинавадын буяны чуулган, янагуухи үнэнээ шүтэгч мөр, агуу их явдлын мөр болох бөгөөд ялгамжаат гурван билгийг төрүүлэх нь "билгийн хувь" буюу, бэлэг билгүүний буяны чуулган, үнэмлэхүйд шүтэгч мөр, гүн гүнзгий мөрийн зэрэг болдог учиртай. Тиймээс тэдгээрийн эрэмбэ зэрэг, тоо тооцоог мэдэх хэрэгтэй.

Мөн арга билиг хос бус болвоос бодь хутгийг эс бүтээх тул машид сайн магадлан таниарай. Тийнхүү "галууны хаан" бодисадва тэрээр бурханы газрын эрдмийн их далайд зорчихдоо агуу их аргын хувийг бүрдүүлсэн янагуухи үнэний шүтсэн даль жигүүр болон хоосон чанар буюу "хоёр би-үгүй"- г сайтар оносон үнэмлэхүй үнэнээ шүтсэн хос даль жигүүрээ дэлгэн дэвэн дэвсээр одсу. Харин хугархай далавчтай шувуу мэт мөрийн ганц нэг хувийг барьж үл одно. *"Төв үзэлд орохуй"- гаас:*

Янагуухи, үнэмлэхүйн цагаан даль жигүүрээ дэлгэн
Ялгуун сайхан "Галууны хаан" төрөл сүргээ түүчээлэн
Яруу гайхамшигт буяны салхин хүчээр
Ялгуусадын эрдмийн далайн чанадад одмой хэмээсэн мэт болой [34]

Чингэж нийтийн мөрөөр сэтгэлээ боловсруулсны дараа магадтай тарнийн хөлгөнөө орох хэрэгтэй. Түүнээ орвоос хоёр буяны чуулганыг түргэн төгсгөн чадах буюу. [35]

Хэрэв тэр төдийгээс хөдлөхгүй, зохих чадлыг тааруулан орохыг эс дурлаваас тэрхүү мөрийн зэрэг дээшлэх төдийгөөс цаашгүй. Нууц тарнийн хөлгөнөө орвоос ер хамаг хөлгөн болоод ялангуяа нууц тарнийн ёсноо машид их шамдах учиртайг айлджээ.

Тиймд урьдаас ялгамжаатай буяны садныг шүтэх ёс нэгнийг даган барих, тэрчлэн тарнийн аймгийн угаас гарсан авшигаар үндсээ боловсруулах, тухайн авсан тангараг санваар бүгдийг амь дүйцүүлэн ёсчлон сахина.

Ялангуяа язгуурын унал зэрэг тусваас дахин авч болох ч, шим шамшаагдах ба эрдэм төрөхөд машид бэрхтэй болох тул язгуурын уналаар халдаахгүйн төлөө шамдах, халдваас наминчлах боомтлох зэргээр арилгах ёстой. Тангарагаа сахих явдал нь мөрийн суурь болой.

Цаашлаад тарнийн доод аймгийн "бэлгэст егүзэр" болон дээд аймгийн "эгүүсгэхийн зэргийн егүзэр" алин нэгнээ сайтар хөтлүүлэн суралц. Түүний дараа тарнийн доод аймгийн "бэлгэсгүй егүзэр" болон дээд аймгийн "төгсгөлийн зэргийн егүзэр" алин нэгнээ сайтар суралц.

Энэ мэт мөрийн гол агуулгыг *"Мөрийн зул"*-д айлдсан ба мөрийн эрэмбэ зэргийг ч тэр адил хөтөлжээ. Их Жову гэгээн бээр бусад ном шастартаа ч ийн айлдсан байна.

"Их хөлгөний мөрийн бүтээлийн хураангуй"-гаас:

Санаанд багташгүй ихийг эрхшээгч
Ханьцашгүй бодь хутгийг олохыг хүсэвч
Бодь хутгийг бүтээсэнд харгалзах тул
Бүтээхээр шимийг зөнд нь авч үйлд

Чөлөө учрал хотол чуулсан биеийг
Машид олоход бэрхтэйг олчихсон хэдий ч
Хожмоо олоход ч мөн бэрхтэй тул
Бүтээлд шамдан хэрэг тустай болгож үйлд хэмээгээд

Хэрхэн хоригдол хүн шоронгоос
Дутаах боломж гарах үед
Хэрэг ихтэй ч бусадтай орооцолдолгүй
Тэр орноос дутаан гардаг мэт

Орчлонгийн энэ их далайгаас
Гэтлэх боломж ирсэн энэ үед
Бусад ажилд ороолдолгүй
Орчлонгийн гэрээс гарч үйлд хэмээн

Авралыг одуулах, үлэмжийн шагшаавад,
Ерөөлийн сууринаа оршисноор

Бодисадвын санваарыг машид барин
Зургаан барамид тэргүүтэн

Бодисадвын явдал бүхнийг
Юу чадахын зэргээр ёсчлон үйлд хэмээн
Арга билгийн шим алин ба
Амарлингуй, үлэмж үзэхүйн егүзэрийг бясалга хэмээжээ.

"Бясалгалын чуулганы бүлэг"-ээс:

Анхлан их нигүүлсэхүйн хүчээс төрөх
Туулсан бодийн сэтгэлийг батад эгүүсгэ
Орчлонгийн төгс эдлэл амгаланд бүү шуна
Үргэлжид шунахаас араар зүглэ

Сүжиг тэргүүтэн эдээр хотол чуулах
Багш бурхан хоёрыг ижил хүндэтгэ
Түүний заасан тангараг төгөлдөр байж
Огоот судлахаар машид хичээ

Хумх болоод нууцын авшигийг
Багшийн ачаар төгс олж хүртээд
Бие, хэл, сэтгэлээ ариусгах
Бүтээлчин тэр шид бүтээлийн сав

Бясалгалын гишүүнээс мэндлэх
Буяныг төгс хураснаар
Түргэн шид бүтээлийг олохын тул
Тэр мэт арвис тарнийн ёсоор орших мөн хэмээжээ.

2. Хэрэг зорилго

Хэрвээ бага, дунд төрөлхтний номын аймгууд их төрөлхтний удиртгал болвоос их төрөлхтний мөрийн зэргийг үйлдвээс л болууижин. Бага, дунд төрөлхтний нийтийн мөр гэж нэрийдэх хэрэг юун хэмээвээс, гурван төрөлхтөн гэж тус тус ялган хөтлөхөд хоёр их хэрэг буй. Үүнд :

а. Бага, дунд төрөлхтний нийтийн ухаан суугаагүй байж, өөрийгөө их төрөлхтөн гэж омогших омгийг дарна. Энэ нь бага, дунд, их ухаантан гуравт ч тустай. Дээд хоёр төрөлхтөн ч өндөр язгуур болон тонилохуйг тусад

хэрэглэнэ. Иймээс хөтлөгч дунд болон их төрөлхтөнд ч тэр хоёрын санаа бодлыг сургах заах явдал гэм болохгүй, эрдэм болох учиртай.

Бага төрөлхтөн хэрнээ дээрээс судлавч дээд ухаан үл төрөх ба доод шатаа орхивоос юу ч үгүй болно. Дээд хувьтнаа нийтийн мөрийг зааж судлуулваас өмнө төрчихсөн болон өмнө төрөөгүй байсан эрдмүүд үтэр түргэн төрдөг. Ийнхүү доод мөрүүд төрснөөр дээд мөрүүдэд хөтлөгдөх учир өөрийн мөрөөс холдохгүй болно.

б. Ухааны зэргээр хөтлөх шаардлагатай талаар "Тогтоолын эрх баялагт хааны айлтгасан судар"-т Зэндмэнэ эрдэнийн мэргэн бээр хэрхэн зэндмэнийг зэрэгчлэн шинжлэх үлгэрээр жишин үлгэр утга хоёрыг зарлигласан буй. Үг ихдэх вий хэмээгээд бичсэнгүй.

Хутагт Нагаржуна бээр:

Анхлан өндөр язгуурын ном
Дараа нь магад тонилохуйд сурах
Алин ийнхүү өндөр язгуурыг олоод
Зэрэгчлэн магад тонилохуй ирэх

хэмээн өндөр язгуур ба тонилохуйн мөрөөр зэрэгчлэн хөтлөгдөх учиртайг айлджээ.

Хутагт Асанга бээр ч: "Бас Бодисадва нар нь зэрэгчлэн буяны зүгийг үнэхээр бүтээхийн тухайд нялхсын ухаантай амьтнаа эхлээд хялбар номыг заан, хялбар увдист дагуулан оруулна. Тэдэнд дунд зэргийн ухаан суухыг мэдээд дунд номыг заах, дунд увдис үзүүлж, дунд зэрэгт дагуулан оруулна. Тэд их ухаант болохыг таниад гүн гүнзгий номыг заан, нарийн увдисыг үзүүлж, дээд мөрд дагуулан оруулдаг. Амьтны тусыг бүтээхийн зэргийг ёсоор буулгасан энэ болой" хэмээн айлджээ.

Хутагт Аръяадэва (Пагвалха) бээр "Явдлын хураангуй зул"-даа: "Эхлээд билиг барамидын ухаанд суралцаад дараа нь тарнийн номд орох ёсыг дараалан бүтээх хэрэгтэй. Тэдгээрийн утгыг хураваас,

Үйлийг анхдагч бодгалис
Дээдийн мөрд орохдоо
Шатны эрэмбэ адилаар явах
Эл аргыг Туулсан бурхад айлджээ хэмээгээд

"Дөрвөн зуут" -даа:

Эхлээд буянт бусыг буцаах
Завсарт өөрийгөө буцаах
Эцэст хамаг үзлийг буцаах
Алин түүнийг мэдвээс мэргэн

хэмээн мөрийн эрэмбийг магадлахыг айлджээ.

Мөн Мэргэн багш Махол бээр:

Хувцасны хирийг арилгахаар үлгэрлэн
Эхлээд өглөг тэргүүтэн үг яриагаар
Сэтгэлийг сайтар хөдөлгөх бөгөөд
Дараа нь номыг бодуулж үйлд хэмээжээ.

Энэ эшийг их багш Чандракирти ч гол болгон мөрийн эрэмбийг магадлан зохиож бясалган дадуулж байв. Энэ мэтээр мөрд орох эрэмбийг ихэд эрхэмлэдэг байсан учир түүнийг сайтар таньж бариарай.



б. Шимийг авах бодит ёсноо гурван зүйл:

(I) Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах
(II) Дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах
(III) Их төрөлхтний мөрийн зэрэгт оюунаа судлах

(I) Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлах

А. Бага төрөлхтний сэтгэлийг бодитой судлах
Б. Тэрхүү сэтгэл төрөх хэмжээ
В. Түүний талаарх буруу атхагийг арилгах

А. Бага төрөлхтний сэтгэлийг бодитой судлах

МӨНХ БУСЫГ САНАХ

1. Хойд төрлийг чухалчлах ухааныг төрүүлэх
2. Хойд төрөлд амгалантай байх аргыг шүтэх

1. Хойд төрлийг чухалчлах ухааныг төрүүлэх

а. Энэ ертөнцөд удаан оршихгүй үхэх ёсыг дурдан санах
б. Хойд төрөлд хэрхэн одох хоёр заяаны жаргал зовлонг санах

а. Энэ ертөнцөд удаан оршихгүй үхэх ёсыг дурдан санах

1) Үхэхийг дурдан санаагүйн гэм
2) Үхэхийг бясалгахын тус эрдэм
3) Үхэхийг санах ухааныг хэрхэн үүсгэх
4) Үхэхийг дурдан санаж бясалгах ёс

1) Үхэхийг дурдан санаагүйн гэм

Чөлөө учралт шүтээний шимийг авахаар ороход дөрвөн чанх буруугаас мөнх бусыг мөнхөд барьдаг чанх буруу нь хамгийн эхний хорлох үүд болдог. Түүнээ гадаад ба дотоодын гэсэн хоёр зүйл буй. Гадаад мөнх бусууд үхэх жамтай атал үл үхэх хэмээн атгагласнаар хорлолын үүд болдог.

Эдүгээгээс явсаар эцэстээ нэгэн цагт үхэл ирнэ гэдэг бодол хэнд ч байдаг. Харин өдөр бүр өнөөдөр үхэхгүй, өнөөдөр үхэхгүй гэж үхэхгүй гэдэг бодолтой явсаар үхэлдээ тулдаг билээ. Тэрхүү бодлын ерөндөгийг сэтгэлдээ саналгүй, тэр л бодлоор түйтгэрлэгдвээс энэ насандаа байх юм шиг санагдана. Тэр зуур энэ ч, тэр ч хэрэгтэй хэмээн энэ насны жаргалыг бүтээх, зовлонг арилгах арга төдийхнийг бодсоор, хойд нас, тонилохуй хутаг, хамгийг болгоогчийн хутаг зэрэг их хэрэгтэй тустай зүйлд анхаарах ухаан төрөхгүйд хүрнэ. Ийм учраас ном буянд зүглэх ухаан ч үл гарна.

Хааяа сонсох, санах бясалгах боловч энэ насны тухайд зориулах тул юухан хээхэн буяныг үйлдэвч чадал өчүүхэн болж, түүний дээр хилэнц нүгэл болон буруу явдал лугаа холилдуулах тул муу заяаны үндэстэй барилдахгүй байх ховор.

Заримдаа хойд насаа бодож бүтээх байвч, дараа зэрэгчлэн бүтээсү гээд хойш саарууулан залхуурч үл орох ба унтах, ууж идэх, шалиг дэмий яриа зэргээр алгасран цагийг нөгцөөх зэргээр ихэд хичээж шамдан ёсчлон үл бүтээх бий.

Тийнхүү амь бие өнө удаан орших мэтээр хууртаад олз хүндлэл зэрэгт омтгойрон шунал тачаал нь улам чангарч, түүнд нь тотгор, саад учрууллаа хэмээн сэжиглэж, уур омог улам дүрэлзэж, тэдгээрийн буруу гэмийг үл үзэн мунхарна.

Тийн мунхарч осолдоход уур хилэн, атаа жөтөө найдангүй зэрэг хүчтэй хатуу муу сэтгэл нисваанисууд улам дошгирон усны үргэлжлэл мэт гарч ирнэ.

Түүнээс бие, хэл, сэтгэлийн арван хар нүгэл, завсаргүй ба шадар хилэнц, дээдийн номыг тэвчсэн зэрэг нүгэлт үйлүүд, хүчтэй хатуу муу заяаны зовлон зэрэг маш их хүчтэй муу явдлууд өдөр тутам улам нэмэгдэх буюу. Тэдгээрийн ерөндөг болгож сайшаан айлдсан дээдийн номын рашаанаас арааргаа зүглэн өндөр язгуур болон тонилохуйн хутгийн амийг тасалж, хатуу ширүүн, халуун зовлонтой орноо үхэхийн гэмээр ялагдах муу үйлээр хөтлөгдөх тул түүнээс бусад мунхагийн үүд юу байх билээ.

"Дөрвөн зуут"-аас:

Алин гурван ертөнцийг эрхшээж
Өөрөө үхлийн эзэн болсон нь үгүй
Бодитой тэр байсаар атал нойрсвоос
Түүнээс мунхаг бусад юу байна вэ хэмээсэн ба

"Бодичарияаватара"-гаас:

Байгаа бүхнээ орхидог хувь ёсон байтал
Тэр бүхнийг эс ухаараад би
Садан болоод дайсны тусын тул
Элдвийн хилэнцийг үйлдэх хэмээжээ.

2. Түүнийг бясалгахын тус эрдэм

Үхлийг дурдан санах бодол баттай төрвөөс, үлгэрлэвээс, өнөөдөр ч үхэж болзошгүй хэмээн лавтай бодогдож ном буяны санаа бага сага төрөхөөс эхлээд элгэн садан, эд баялагтай ханилахгүйгээ ойлгож тэдгээрт шунахаа больж ирнэ. Өглөг тэргүүтний үүднээс шимийг авах хүсэл аяндаа зонхилох болно.

Олз хүндлэл, алдар нэр зэрэг ертөнцийн сайн сайхны тухайд шамдах бүхнийг хомхруус хийсэх мэт ямар ч шимгүй худал хуурмагийн орон болохыг мэдээд нүгэлт явдлаас буцна. Авралыг одуулах ба ёс журмыг сахих зэрэг сайн үйлс бүхнийг үргэлжид бишeрч, хичээж хураадаг болох учир шимгүй бие тэргүүтнээ дээд зэргийн шимтэй болгон аваад дээд хутаг руу өөрөө авирах болно. Бусад амьтныг ч мөн тийш хөтлөх учир түүнээс илүү их хэрэг юу байх билээ. Тийн учрыг олон жишээгээр сайшаажээ.

"Гаслангаас нөгчихсөн их судар"-гаас:

Тариалан бүхний дотроос намрын тариа дээд
Мөр бүхний дотроос үхрийн мөр дээд
Хур мэдэл бүхний дотроос мөнх бус буюу үхэхийн хур мэдэл дээд мөн
Түүгээр гурван ертөнцийн шунал мунхаг омгийг дарах мөн хэмээжээ.

Мөн:

Нисваанис гэмт явдал бүхнийг нэгэн зэрэг дарагч алх
Хамаг сайн буян бүгд нэгэн дор бүтээх их үүд гэх зэргээр сайшаажээ.

"Цоморлиг"-оос:

Энэ биеэ өвсний сав мэт ухаарах ба
Мөн юмс үзэгдлийг зэрэглээ адилд мэдээд

Шумнасын цэцгэн мэсийг энд л тасалж
Үхлийн эзэн бээр үзэвч цаашаа одох хэмээсэн ба

Өтлөхөө үзэх ба өвдөхийн зовлон
Сэтгэлээс хагацах үхлээ үзээд
Шорон адилын чанга гэрийг тэвчвээс
Ертөнцийн эгэлүүд хүслээ огоорч чадах бил үү хэмээжээ.

Товчилвоос төрөлхтний тусыг бүтээх цаг нь ялгамжаат чөлөөт шүтээнийг олсон энэ цаг буюу. Бид ихэнхдээ муу заянд төрж явсан бөгөөд сайн заянд төрсөн нь өчүүхэн ганц нэг төдий. Ихэнхдээ чөлөөгүй оронд өнгөрөөсөн тул тэнд ном буян бүтээхийн зав чөлөө олдоогүй билээ. Хэдийгээр бүтээх боломжтой сайн заяаг олсон ч ном буяныг ёсчлон эс бүтээдэг нь өнөөдөр үхэхгүй гэдэг бодлоос ургадаг.

Тиймээс үхэхгүй гэж бодох бодол нь доройтол бүгдийн үүд ажгуу. Түүний эрөндөг болсон үхэхийг санах нь сайн сайхан хотол чуулган бүгдийн үүд болох бөлгөө.

Энэ мэт нь үүнээс өөр гүн гүнзгий ном, бясалгах зүйлгүй хүмүүсийн бясалгал төдий юм аа гэх юм уу, бясалгал мөн боловч эхлээд бага шиг бясалгахаас бус үргэлжид бодохын хэрэггүй гэх зэргээр барилгүйгээр эхэн завсар эцэс бүхэнд энэ л хэрэгтэй шүү гэж зүрхний мухраас лавтай шийдэж бясалгаж үйлдээрэй.

3. Үхэхийг санах ухааныг хэрхэн үүсгэх

Энхэр садан тэргүүтнээ ихэд хайрлахын эрхээр тэднээсээ салж хагацах вий гээд сэжиглэн айх явдал бий. Энэ бол зам мөрд огт хамааралгүй үхлээс айх ердийн үзэгдэл юм. Гэвч энэ үесийн үүсгэх сэтгэл энэ бишээ. Тэгвэл чухам ямар бодол вэ хэмээвээс. Үйл нисваанисын эрхээр төрөл авсан бүхэн үхлийг гэтлэхгүй нь магадтай.

Үхлээс айдаг ч гэсэн түр мартах бий. Гэвч хойд төрлийн тусад муу заяаны үндсийг хорих, өндөр язгуур болон тонилохуйн үндсийг бүтээлгүй үхчихвий гэж айх чухал юм. Тийм л айх цочих бодол төрснөөр тэдгээрийг бүтээхэд хүрдэг тул үхэх цагт айхын хэрэг юун. Тэдгээр үйлсийг эс бүтээвээс орчлонгоос ер гэтлэхгүй бөгөөд ялангуяа үхэхийн цагт муу заянд унах зэргээс айн ихэд гэмшин шаналана.

"Төрөл дарааллын цадиг"-аас:

Хичнээн хянавч оршиж үл чадах
Юугаар ч засаж үл болох
Аймшигтай орилон чарлан тэр үед
Түүнээ тус болох юу байх

Тэр мэт ертөнцийн жамыг ухааран
Хүмүүс нүгэл хилэнц үйлдсэндээ гэмших
Буяны үйлийг ч сайтар эс үйлдэв гээд
Хойд наснаа зовлон гарах хэмээн сэжих

Үхэх болсон үед айж моншроод
Юуханд ч миний сэтгэл гэмшин шаналах,
Тэр цагт юу хийснээ ч би эс санах,
Буяны үйлийг дадуулан чадаад
Буян номыг үйлдсэн бол үхлээс хэн айх билээ хэмээжээ.

"Дөрвөн зуут "-аас:

Би чинь хэзээд үхнэ шүү хэмээх бодол
Алин хэдийд ч магад байх аваас
Түүгээр аюулаас гэтлэх учраас
Үхлийн эзнээс ч яахин айх хэмээжээ.

Ийнхүү бие болоод эд баялгаасаа түргэн хагацах зайлшгүй гэж мөнх бусыг дахин дахин санаваас тэднээс салахгүй гэдэг горил, шунал буцах болно. Мөн тэднээсээ сална гэдэг сэтгэлийн шаналангийн эрхээр үхлээс айх явдал ч төрөхгүй .

4. Үхэхийг дурдан санаж бясалгах ёс

Гурван язгуур, есөн шалтгаан, гурван шийдвэрийн үүднээс бясалгах болой. Түүнээ гурав:

а) Магадтай үхэхийг санах
б) Хэзээ үхэх магадгүйг санах
в) Үхэх цагт номоос бусад юу ч үл туслахыг санах.

а) Магадтай үхэхийг санахад гурав:

1. Үхлийн эзэн магадтай ирэхэд ямар ч шалтгаанаар буцаах аргагүйг санах. Ямар ч бие төрөл авлаа гэсэн үхэл ирдэг жамтай.

"Мөнх бусын цоморлиг"-оос:

Алин Бурхад, Өөрсдөө ялгуусад ба
Бурхадыг сонсоод сонсогч нар ч
Энэ бие лагшинаа орхин зохиодог тул
Эгэл төрөлхтнийг хэлэх хэрэг юун хэмээжээ.

Ямар ч орноо оршсон үхэл ирдэг жамтай талаар мөн түүнээс:

Хаана ч оршсон үхлээр үл дийлдэх
Газар зүг байхгүй бөгөөд
Гэгээн завсарт үгүй, далайд ч үгүй
Уулсын завсарт оршивч үгүй хэмээжээ.

Өнгөрсөн ирээдүй ямар цагт ч амьтан үхлээр дарагдах нь ялгалгүйг түүнээс:

Шалтгаан үр дагавар юу байгаа
Бүгдээр энэ биеэ орхиод одох буюу
Энэ бүхэн эвдрэхүй мөнийг мэргэд болгоожээ
Ном үзэн сайтар суралцаж үйлд хэмээжээ.
Үхлийн эзнээс дутааж үл чадах ба тарни зэргээр буцааж чадахгүй.

"Хаанд увдислахуй"-гаас: "Үлгэрлэвээс машид хатуу чийрэг, шим үндэс төгөлдөр, эвдрэхгүй, хагарахгүй, салахгүй машид барьцалдсан дөрвөн орой нь тэнгэрт тулан, газар хөдөлгөх их уул дөрвөн талаас нүүж ирээд үндэс ёзоор, мод мөчир, навч цэцэг, амьтан адгуус бүхнийг талхлан сүйдлэхэд бултаж зугтаах, бяр хүчээр буцаах, эд таваар, тарни, эм зэргээр буцаах гэдэг хялбар бишээ.

Үүнтэй адил Их хаанаа! Дөрвөн их аюул эдгээр ирэх бөгөөд зугатаах дутаах хүчээр буцаах, эдээр буцаах эд болон тарни эмээр буцах нь хялбар бус. Дөрөв алин буй хэмээвээс өтлөх, өвдөх, үхэх, доройтох буюу.

Их хаан аа! Өтлөх нь идэр залууг дарахаар ирэх, өвдөх нь эрүүлийг дарахаар ирэх, доройтох нь хотол чуулган бүхнийг дарах, үхэл амийг дарахаар ирнэ. Тэдгээрээс дутаах, хүчээр буцаах, эдээр буцаах, эд тавaар, эм тарниар амарлиулах хялбар бус болой" хэмээжээ.

Гамбава гэгээнээс: "Одоо л үхэлээс айх хэрэгтэй. Үхэл ирэхэд цочихгүй байх хэрэгтэй атал бид түүнээс буцаж одоо айдаггүй хэрнэ үхэл ирэхэд цээжээ самардах юм даа" хэмээжээ.

2. Насанд нэмэгдэл байхгүй, байнга хорогдож байдгийг санах

"Хэвлийд орохуй"-гаас: "Одооноос сайтар амгалантай хамгаалваас өдгөө зуун наслах юм уу өчүүхэн илүү амьдарч болох хэмээсэн мэт нас уртаслаа гэхэд тэр төдий хүрэх. Тэр хүрч болох ч түүний завсар насаа барах нь машид түргэн. Жил гэдэг сараар одон барагдах, сар ч хоногоор барагдах, хоног ч өдөр, шөнөөр барагдана. Тэд ч өглөө үдшээр барагдсаар насны хэмжээ улам богиносох. Мөн урьд өмнө олонтаа барагдахыг үзсээр, бас үлдсэн хэдэн наснаа нэмэгдэх агшин ганц ч үгүй, өдөр шөнө бүхэнд завсаргүй хорогдон хорогдсоор байна" хэмээжээ. *"Бодичарияаватара"*-гаас:

Өдөр шөнө зогсолт үгүйгээр
Энэ нас үргэлжид хорогдох бөгөөд
Нэмэгдэл гэж ирэхгүй учир
Энэ адилаар би үхэхгүй гэж үү хэмээн айлдсан мэт.

Тэр мэтийг олон үлгэрийн үүднээс санаж болно. Оёдол нэхмэл хийх үед утсаа сүвлэх хэдий ч нэг л мэдэхэд утас барагдахтай адил, яргачин хонь малыг ярганы газар туух алхам тутам үхэлдээ улам ойртох ба хүчтэй ус мөрний үргэлжид урсах урсгал болон өндөр уулнаас буусан ус адил нас барагдан одно. Малчин шилбүүрээ далайхад мал адгуус өөрийн эрхгүй өөрийн нутагтаа хүргэгдэх адил өвдөх, өтлөх зэргээр өөрийн эрхгүй үхлийн эзний өмнө хөтлөгдөх жамыг олон үүднээс бясалгаж үйлд.

"Цоморлиг"-оос:

Оёх шидэх зүйлээ дэлгэж
Ойлдох утсаа сүвлэн шагласаар
Учиг үзүүрт тулж барагдах адил
Оюунт хүний амь нас мөн тийн буюу [32]

Үлгэрлэвээс магад цаазлуулагч нар
Алхам, алхам орхих бүртээ
Алуурчны өмнө дөхөх мэт
Хүний амь ч тэр адил бөлгөө

Усан мөрөн буух хүчит урсгалыг
Хэрхэн буцааж болдоггүй тэр адил
Хүний одсон насыг
Жич яахин буцаах билээ

Бэрхтэй бас богино чанарт
Тийн бас зовлон төгөлдөр
Түргэн агаад эвдрэх жамт
Усанд бэрээгээр зурсан адил

Үлгэрлэвээс малчин шилбүүрээ дохиход
Мал адгуус нутагтаа эргэх мэт
Тийнхүү өвдөж, өтөлсөөр л хүмүүс
Үхлийн эзний өмнө хүрэх хэмээсэн мэт [36]

Жову гэгээн ч усны захад хүрээд мөнх бусыг бясалгахдаа "ус мяралзан урсах энэ адил" гэж хэлээд бясалгасан гэдэг.

"Их цэнгэлт судар"-аас:

Гурван ертөнц намрын үүлэн адил мөнх бус
Амьтны төрөх үхэх гэдэг жүжиг үзэх адил
Амьтны нас гэдэг огторгуйн цахилгаан мэт
Уулын уруу буух ус мэт түргэн гүйж одох хэмээх

зэрэг олон үлгэрийн үүднээс айлджээ. Тиймээс дотроо өчүүхэн ч гэсэн санаваас ухаарал нэгнийг олж чадна. Мөнх бусыг заагаагүй гадна талын үзэгдэл нэг ч байхгүй хэмээн айлдсан тул олон зүйлээр жишин дахин дахин бодвоос ухаарал төрнө

Өчүүхэн төдий ч эс тунгаан орхивоос тус болохгүй. Гамбава гэгээнээс: "Санаад эс гарлаа гэх буюу та нар, гэвч өдөр нь алгасрах шөнөд унтаж нойрссоор байгаагаа худлаа гэх үү" хэмээсэн гэдэг. Насны эцэст үхлийн эзнээр дарагдаад ертөнцийн чанадад одохоор барахгүй тэрний завсарт

явах, суух, хэвтэх гурвын алиныг үйлдсэн ч нас хорогдохгүй үе огт үгүй тул умайд оршихоос эхлээд, ганц ч агшин зогсолтгүй ертөнцийн чанадад нүүрээ харуулан одох мөн.

Мөн тэр зуур амьд явах ч өтлөх, өвдөхийн элчээр хөтлөгдөн үхэхийн тухайд л явсаар барагдана. Тиймээс амьд явах цагтаа хойд ертөнц рүү явалгүй сууна гэж баярлах аргагүй билээ. Үлгэрлэвээс өндөр хадны оройгоос унаж газарт хүрэхийн зуур үест баясах нь зохисгүйтэй адил.

Мөн *"Дөрвөн зуутын тайлбар"*-т эш болгон:

Хүмүүн баатар анхны шөнөдөө
Алин ертөнцийн умайд оршсон
Тэр цагаас эхлэн өдөр нэжгээдээр
Сааралтгүйгээр явсаар үхлийн эзнээ одох хэмээсэн ба

"Дөрвөн чанх бурууг хорьсон яриа" -наас:

Өндөр уулын оройгоос газар унаж
Эвдэрч сүйрэхийн завсар жаргал амсах бил үү
Төрөхөөс эхлээд үхэх хүртэл үргэлжид гүйх завсар
Амьтан хүн хэзээ жаргал олох вэ хэмээжээ.
Эдгээр нь түргэн магадтай үхэхийг үзүүлжээ.

3. Амьд байх цагт ч ном үйлдэхийн чөлөөгүйгээр магадтай үхэхийг санах:

Дээр өгүүлсэн насны хязгаарт хүрч болох авч зав чөлөө байхгүй. Хэрэггүй өнгөрөөсөн цаг өмнө нь олон, үлдсэн хугацаагаа мөн тийн нөгчөөнө. Дээр нь бусад олон алгасарлаар дэмий өнгөрөөх, идэр насаа завхруулаад өтлөхийн үес хүрэхэд бие сэтгэлийн хүч доройтон ном буян хийе гэж хүсэвч бүтээх чадалгүй болж, ном үйлдэх өчүүхэн ч чадалгүй болно.

"Хэвлийд орохуй"- гаас: "Түүнээс хагасыг нойроор барах мөн. Арван жил нь нялх үе. Хорин жил нь өсөх өтлөх үе буюу гаслан, харуусал, зовлон, сэтгэлийн зовиур хямрал зэргээр өнгөрөх. Биенд ирсэн олон зүйлийн өвчнөөр ч таслагдах" хэмээжээ.

"Дөрвөн чанх бурууг хорьсон яриа"-наас:

Хүмүүний насны дээд хэмжээ зөвхөн зуу хүрээд барагдах
Тэглээ ч эхлээд нялх байж эцэст хөгширч хэрэггүй болох,
Нойрсох өвдөх зэргээр цагийг барж хамаг горьдлогоо барах
Хүмүүний нас явахын цагт жаргалтай орших юу билээ хэмээжээ.

Чадгава гэгээнээс: "Жаран жилийг хоол унд, нойр, өвчин зовлонгоор барсаар ном буян хийх таван жил ч үлдсэнгүй" хэмээжээ. Тиймээс л энэ насны хотол чуулган бүгдээр зүүдний нэгэн хоромд амгаланг эдэлж сэрээд санахын адил үхэхийн цагт дурдах орон болж үлдэнэ.

Үхлийн дайсан тасралтгүй ирэх тул юунд энэ насны хуурамч мэхнээ баяснав хэмээн санаж ном буяныг үйлдэх хэрэгтэй хэмээн лавтай шийдэж үйлд. *"Төрөл дарааллын цадиг"*-аас:

Аяа ертөнцийн нисваанис гэдэг
Орших батгүй, баясаж үл болох
Гүмүда цэцгийн энэ цог ч
Дурдал төдий л болох

Энэ мэтээр амьтан орших атал
Төрөлхтөн айхгүй байдаг нь гайхмаар
Зам мөр бүгдийг үхлийн эзэн хориход
Сэжиглэлгүй машид баясан эдлэх,

Өвдөх өтлөх үхэхийн хорлогч дайсан
Их хүчитийг хорьж чадахгүй байсаар
Ертөнцийн чанадад доройтон одохдоо
Ухаантан хэн баясгалантай байх вэ

"Ганигаан захидал"-аас:

Энэрэх сэтгэлгүй үхлийн эзэн
Залуу насны хавыг дэмий алах
Алахаар илт хүрч ирэхэд
Мэргэн хэн болвоос сэрэмжлэх

Тэр тухайд их баатар тэсвэргүй тэрээр
Барагдашгүй авралтгүй сумаа
Хэзээ эс харвах хэдүй
Тэр хүртэл өөрийн хэрэгт шамд хэмээсэн мэт санаарай.

б) Хэзээ үхэх магадгүйг санах

Өнөөдрөөс цааш зуу наславч үхэл ирэх нь магадтай. Тэр завсар хэдэн хоног дээр ирэх батгүй тул өнөөдөр үхэх, эс үхэх алиныг ч мэдэж болохгүй буй заа. Гэвч үхэл байдаг шүү гэдгийг ухамсарлан өнөөдөр үхэх вий хэмээх бодлыг төрүүлэх хэрэгтэй.

Өнөөдөр үхэхгүй гэх юм уу, ер нь үхэхгүй хэмээх үл үхэх бодлыг бариваас энэ насанд амьдрах төхөөрлөгийг бэлтгэсээр, хойд насны амьдралын төхөөрлөгийг бэлтгэж завдахгүйд хүрнэ.

Тэр завсар эрлэгийн эзэнд баригдан, гаслантайяа үхэхэд хүрнэ. Өдөр тутам үхлийн бэлтгэлийг базааваас ертөнцийн чанадын олон хэргийг бүтээх ба амьд дээрээ түүнийг бүтээчихвэл сайн буюу. Үхлээ гэхэд улам илүү хэрэгтэй болно. Үлгэрлэвээс: Намайг ихэд хорлогч нэгэн их дайсан өдийгөөс төдий хугацаанд ирнэ гэдгийг мэдсэн ч харин чухам хэдэн хоног дээр ирэхийг эс мэдвээс өдөр бүр түүнийг харуулдахтай адил болно. Өдөр бүр өнөөдөр үхэх хэмээх юм уу наанадаж их зонхид өнөөдөр үхэх вий хэмээх ухаан төрвөөс хаана ч очсон хойд насны хэргийг бүтээх зэргээр энэ насны төхөөрөг бэлтгэлийг эс үйлдэнэ. Энэ санаа эс төрвөөс энэ насандаа байх юм гэж үзээд түүний бэлтгэлийг үйлдэхээс бус хойд насны хэргийг эс үйлдэнэ.

Үлгэрлэвээс: Нэгэн оронд өнө удаан сууна хэмээгээд түүний бэлтгэлийг хийх ба эсвэл энд суухгүй өөр тийш явна гэсэн хүн болвоос алин очих газрынхаа бэлтгэлийг хийдэгтэй адил. Тиймд өдөр бүр үхэл ирнэ хэмээх бодлыг төрүүлэх хэрэгтэй. Түүнээ гурван зүйл.

1. Замбуу тивийн нас батгүйг санах

Ер муухай дуут тивийнхний нас магадтай авч бусад тивийнхэн өөрсдийн насны хэмжээнд хүрэхгүй байх ч их зонхидоо баттай олон. Замбуутивийн нас машид батгүй бөгөөд анхандаа хэмжээлшгүй настай байсан ч явсаар бүр арван нас болтол богиносох аж. Одоо ч хөгшин залуу хэн ч үхэх нь болзоогүй байна.

Энэ талаар *"Авхидхарма"*-д:

Энэ нь батгүй адагтаа
Арван нас, анхандаа хэмжээлшгүй хэмээжээ.

"Цоморлиг"-оос:

Өглөө олон хүнийг харах
Үдэш зарим нь үл үздэгдэх
Үдэш олон хүнийг харах
Өглөө зарим нь үл үзэгдэх хэмээгээд

Эр эм ч олон бөгөөд
Идэр залуудаа ч үхэх
Түүнээ энэ хүн залуу хэмээвч
Амьдын баталгаа хаана байх

Заримууд умайдаа үхэх
Тэрчлэн зарим нь төрөх газартаа
Бас заримууд хоригдох зуур
Зарим нэг нь гүйж яваад

Заримууд өтлөөд заримууд залуудаа
Заримууд идэр залуудаа ч
Зэрэгчлэн лавтай одох ба
Жимс боловсроод унах мэт хэмээн айлдсан буй.

Багш болон найз нөхөд маань ч насны эцэст хүрэлгүй гэнэт гадаад дотоодын үхлийг шалтгаанаар бодсноо гүйцээлгүй үхэхийг харж бас дуулснаа сэтгэлдээ нийлүүлээд, би ч энэ адилын жамт гэдгээ дахин дахин санаж үхэхийн ухааныг яавчиг үүсгэ.

2. Үхэх шалтгаан маш олон, амьд явах шалтгаан цөөхнийг санах

Энэхүү амь насанд санаатай ба санаагүй хорлол олон байна. Хүмүүн ба хүмүүн бусын элдэв олон язгуурын ад тотгорын элдэв олон хөнөөл ба адгуусны язгуурын амь биеийг хорлогч элдэв хөнөөлд хэрхэн хөнөөгдөх ёс болон тэрчлэн дотоодын өвчин, гадаад байгаль махводын хямралаас болсон гамшиг зэргийг нягтлан санаарай.

Мөн бидний бие дөрвөн махводоос бүтэх бөгөөд тэдгээр инагш, чинагш нэг нэгэндээ хорлон үйлдсээр махводын тэнцвэр алдагдан ихдэх багадахын хувьт болсноор өвчин үүдэж амь насыг булаана. Ийм хорлол надтай хамт төрсөн болохоор амь биенээ сэтгэл итгэх газаргүй.

Тийм болохыг “Их нөгчигч судар“-аас: “Энэхүү амь нас үргэлжид дайснаар хүрээлэгдсэн тул агшин агшинаар доройтохоос бус арвижиж нэмэгдэх огт үгүй гэж ухаарах нь үхэхийн хур мэдэл мөн” хэмээжээ.

“Их эрдэнийн эрхи”- ээс:

Үхлийн эзний эрхшээлд орших
Улаан шуурган доторхи зул хэмээжээ.

“Садангийн захидал”-аас:

Нас гэдэг олон хорлолт салхинд туугдах
Усны хөөс адил мөнх бусын тул
Амьсгаа аван нойрсон унтаад
Сэрэхийн хувь олдсон бол гайхамшигт хэмээсэн ба

“Дөрвөн зуут”-д:

Чадалгүйн тул махвод бүхэн
Цуглаж нийлснээр төрөх бөгөөд
Харшлагч бүхнээ амгалант хэмээн
Үргэлжид барих зохисгүй буюу хэмээжээ.

Цөв таван цаг машид дэлгэрсэн тул урт наслан оршихын хүчит сайн үйлийг хураах маш ховор. Амны идээ болон эм тангийн ч чадал хомсдсон тул өвчин дарах чадал өчүүхэн. Хэрэглэгдхүүн хоол унд сайтар шингэн их махвод дэлгэрүүлэх хүч хомсдсон учир сайтар шингэхэд бэрхтэй болжээ. Шингэвч тус болох нь ховор.

Буяны чуулганыг хураах багадан гэмт явдал маш ихсэх учир урин тоолох хүч багадаж нас уртасах нь ховордоно. Амьд явах шалтгаан ч үхлийн шалтгаан болж урвана. Амьд явахын тухайд идээ унд, орон гэр, найз нөхрийг эрнэ. Гэвч мөн л хоол ундаа хэтэрхий ихдүүлэх эсвэл хэтэрхий багадуулах, үл зохихыг хэрэглэх, орон гэрээ нураалгах, найз нөхөддөө мэхлүүлэх зэргээр үхлийн шалтгаанд учрах тул үхэхийн шалтгаанд үл одох амьд явахын шалтгаан үгүй буюу. Мөн амьд явах гэдэг үхэхийн тусад орших тул амьдын шалтгаан олон ч түүнээ сэтгэл итгэхийн аргагүй.

"Их эрдэнийн эрхи"-д айлдахдаа:

Үхэх шалтгаан олон бөгөөд
Амьдрах нөхцөл машид цөөн
Тэдгээр бүгдээр үхэх тул
Тиймд үргэлжид ном буяныг үйлдэгтүн хэмээжээ.

3. Бие маш бялд өчүүхэн тул хэзээ үхэх магадгүйг санах

Бие нь усны хөөс мэт машид бялд өчүүхэн тул их хорлолын хэрэггүй. Өргөс хатгах мэтийн хорлолоос шалтгаалан амь нас эвдрэхэд хүрдэг тул хамаг үхэх шалтгаанд дарагдвал бүүр ч хялбар болно.

"Садангийн захидал"-д айлдахдаа:

Газар дэлхий сүмбэр уул далайд долоон наран ургаваас
Амьтан бүгд эдгээрт шатаж түлэгдэн
Үнсэн төдий ч үлдэхгүй болох тул
Машид бялд өчүүхэн болохыг хэлэх хэрэг юун хэмээжээ.

Тэр мэтээр санасны эцэст үхлийн эзэн амь биеийг хэзээ булаах нь магадгүй тул хойш тавилгүй яг одооноос эхлэн ном буяныг үйлдсүгэй гэдэг шийдлийг олонтоо үйлдэх хэрэгтэй. *"Ганигаан захидал"*-аас:

Үхлийн эзнийг хэн ч үл мэдэх
Гэнэт бууж ирэх тул
Маргааш гэж бодолгүй
Дээдийн номыг түргэн зохио

Үүнийг маргааш хийнэ хэмээх
Сайн хүний ажил биш
Хэдийд ч та өөрөө үгүй болох
Тэр өдөр лавтай ирнэ хэмээжээ.

Егүүзэрийн эрхэм Шризагда Мэдри Ананда бээр:

Газрын эзнээс зээлсэн биеэ
Хэдий өвчин зовлонгүй амар орших

Тэр цаг хүртэл шимийг нь ав
Өвдөх үхэхийн доройтлоос айлгүй нэгийг үйлд
Алин цагт өвдөх өтлөхийн зовлон зэргийг
Амсах болвоос тэр цагт яах билээ хэмээсэн мэт болой.

Гурван язгуур дотроос хамгийн чухал болох хэзээ үхэх магадгүйг санаж ухаанаа урвуулах энэ ямагт мөн тул шамдаж үйлдээрэй.

в) Үхэх цагт номоос бусад юу ч үл туслахыг санахад гурав

1. Тийнхүү ертөнцийн чанадад одох магадтайг мэдвэй. Тэр цагт садан хамаатан хичнээн их энэлж шаналж, энхрийлэн хайрлаж эргэж тойровч нэг нь хөтлөхийн газар үгүй.

2. Сэтгэлд зохистой эд баялгийн цогцос юу байлаа ч тоосон төдийг ч чирч чадахгүйн дээр хамт төрсөн арьс махаа ч орхих болохоор бусдыг хэлээд яах вэ.

3. Тиймд энэ насны хотол чуулган бүгдийг би өөрөө орхих ба тэд ч намайг орхино. Өөр ертөнцөд одох нь магадтай ирэх тул тэр нь өнөөдөр ч ирнэ гэж бодох буюу. Тэр цагт зөвхөн ном буян аврал итгэл өмөг түшиг болох ёсыг санаж үйлд.

"Ганигаан захидал"-аас:

Урьдын үйлийн эрхээр тийн боловсорч
Таныг огоот орхих болоход
Шинэхэн үйлээр дагуулан барилдаж
Үхлийн эзнээр татагдах цагт

Буян нүглээс өөр замаар
Амьтан бүгдийг жич буцааж
Хэзээ ч та үл чадах тул
Болгоон зохиож сайтар судлагтун хэмээсэн ба

Шри Загда Мэдри бээр :

Нэгэн бурхантай хэрхэн та учирсан ч
Өөр ертөнцөд залран дээшлэхийн үест
Дайсанд ялагдсан мэт уйлан гаслах
Хөвгүүн ч үгүй, хатан үгүй ганцаараа

Хувцас ч үгүй, садан ч үгүй
Хаан төр ч үгүй, орд харш ч үгүй
Хэмжээлшгүй өмөг хүчийг эрхшээсэн ч
Мэдэх ч үгүй, сонсох ч үгүй

Гав ганцаараа гагц бүслүүр дээсээр
Дагуулан татавч үл мэдэх
Товчилбоос түүний нэр төдий ч
Тэр цагт үгүй тул бусдыг хэлэх юун хэмээсэн мэт.

Тийнхүү чөлөө учрал хэрэг ихтэй, олоход маш бэрхтэй хэдий ч эвдрэхдээ машид хялбар үхдэг жамтайг дурдан санаж дараа дараачийн ертөнцийн ашдийн амгаланг бүтээж чадалгүйгээр зөвхөн үхэхээс наашхи амгаланг бүтээж зовлонг арилгах явдал нь хүн төдийгүй адгуусанд их зонхи байх тул тэдгээрээс үлэмж ялгаатай явдал нэгнээ орох хэрэгтэй билээ. Эс чингэвээс сайн төрлийг олсон маань олоогүйтэй адил болно.

"Бодичаряаватара"-гаас:

Адгуус ч бүтээж чадахаар
Ашиг багатай алин хэргийн тухайд
Олоход бэрхтэй чөлөө учралт хотол чуулган үүнийг
Үйлээр нэрвэгдэгсэд дарж үйлдэх хэмээн айлджээ.

Хэдийгээр төрөхөд бэрхтэй ч мөрийн суурь мөн тул шамдах хэрэгтэй. Бодова гэгээнээс: "Энэхүү мөнх бусыг бясалгал нь бидний шуналыг буцаана. Элгэн садан, эд баялаг зэрэг энэ насны шунал бүгдийг арилгана. Эргэлзээгүй элдэв ханьгүй гав ганцаараа насны хязгаарт аажмаар одохоо мэдэх, ном буянаас өөр юуг ч үйлдэхгүй хэмээх зэрэг энэ наснаа үл шунах бодлыг төрүүлнэ. Ийм ухаан эс төрөх хүртэл хамаг ном буяны зам мөр хаалттай гэсэн үг" гэж зарлиглажээ.

Долба гэгээнээс: "Дашрамд буян хураах, хилэнц арилгах, тэнгэр бурхан багшид соёрхол талбих, чин зориг баттай шамдлаар хичээж зуун жил наслах боловч хуриж үйлдсэн бүгд эс суухын (мөнх бус) жамтай тул яахнаа ч төрөл авах мөн" хэмээжээ.

Ганбава гэгээнээс "Бодлоо солих уу" гэж асуухад "Өмнөхөө давт", "Нэмэх үү" гэхэд "Нэмээд хэрэггүй" гэж айлдсан гэдэг. Тиймээс ухаандаа тунгааж чадвaас дээр номносон ёсоор бясалгах, эс чадваас гурван язгуур,

есөн шалтгааны үүднээс хир таарах ганц нэгийг барин цаазын тавцанаа туугдагсдад гоёл чимэг зүүсэн мэт энэ насны ажлаас шунал буцах хүртэл дахин дахин бясалгаарай.

Буяны садныг шүтэх, чөлөө учрал, мөнх бусын аймгууд эрхэм зарлиг, тааллын тайлбар сэлтэд байдаг ч тухайн тухайн үесийн бясалгал болгож судалваас бурханы тааллыг амар хялбар олох бөгөөд бусад үед ч энэ мэтээр мэдэж үйлдээрэй.



МУУ ЗАЯАНЫ ЗОВЛОНГ САНАХ

б. Хойд төрөлд хэрхэн одох хоёр заяаны зовлон, жаргалыг санах

Тийнхүү түргэн үхэх магадтай тул энэ насгаа суухын чөлөө байхгүй. Мөн үхсэн хойно ч үгүй. Удалгүй төрөл авдаг буюу. Хоёр заяанаас өөр бусдад төрөх газаргүй тул сайн заяа юм уу эсвэл муу заянд төрнө.

Тэнд төрөхөд өөрийн эрхээр бус харин үйл бусдын эрхээр төрдөг. Хар цагаан үйл хэрхэн хаяснаар төрөх ажгуу. Тиймээс хэрэв би муу заянд хаягдваас хэрхэх хэмээн муу заяаны зовлонг санах ёстой.

Нагаржуна гэгээн бээр:

Машид халуун, хүйтэн тамыг
Нэгэн өдөр ч санах
Өлсөж ундаасан эцэж турсан
Бирдийн зовлонг ч санах

Мунхагийн олон зовлонт
Адгуусыг үзэн санах
Тэдгээрийн үндсийг тэвчин жаргалын угийг үйлдэх
Олоход бэрхтэй замлингийн хүний биеийг

Олсон цагт муу заяаны үндэснээс
Онцгойлон хянан тасалж үйлдсүгэй хэмээсэн буй.

Энд нийт орчлонгийн болон ялангуяа гурван муу заяаны зовлонг бясалгах нь машид чухал билээ. Ийнхүү зовлонгийн далайд өөрөө унасан ёсыг бясалган бодсноор сэтгэл гансран, омог дээрэнгүй сэтгэл буцна. Нүглийн үрд зовлон гардгийг ухааран хилэнц нүглээс машид цээрлэнэ. Зовлонг үл хүсэн жаргалыг хүсэх ч тэр маань мөн л буяны үрд ирэхийг ойлгон буян бүтээхээр баясна. Өөрийн зовлонгоор жишин өрөөл бусдыг хайрлах нигүүлсэх сэтгэл төрөн, орчлонгоос сэтгэл уйдан тонилохуйн (нирваан) хутгийг чухалчлан үзэх болно. Зовлонгоос айснаар аврал итгэлийг хүчтэй баттай одуулах зэрэг анхаарал бясалгалын олон аньс хурсан их товчоон болмой.

Ийн болохыг "Бодичарияаватара"-д:

Зовлон үгүй бөгөөс магад гарах үгүй
Тиймээс тэрхүү сэтгэлийг баттай үүсгэ хэмээсэн ба
Басхүү зовлонгийн эрдэм нь
Уйдснаар дээрэнгүйг арилгах

Орчлонгийн амьтнаа нигүүлсэл төрөх
Нүглээс цээрлэн буянаа баясах хэмээгээд
Би машид айн цочоод
Өөрийгөө Самандбадраад өргөмү хэмээжээ.

Зовлонгийн эрдмийн талаар "Бодичарияаватара"-д айлдахдаа өөрийн үндсэнд байгаа зовлонгоор жишээлэн айлдсан буй. Гэвч амсах зовлон ч мөн энэ адил бөлгөө.

Тийнхүү муу заяаны зовлонг санахад гурав:

1) Там
2) Адгуус
3) Бирдийн зовлонг санах

1) Тамын зовлонг санах:

а) Их (халуун) тамын амьтан
б) Ойр орчмын там
в) Хүйтэн там
г) Энд тэндэхийн там

а) Их тамын амьтан

Эндээс (Дорждангаас) гурван түм хоёр мянган багцадын дор "Дахин сэргэх" там буй. Түүнээс дөрвөн мянган, дөрвөн мянган багцадаар тусгаарлагдан бусад долоо орщдог аж. Тийн найман там буйгаас:

/1/ *"Дахин сэргээх"* хэмээх тамын амьтад наана цаанаас хуран цуглаад үйлийн эрхээр бүтсэн элдвийн мэсээр зэрэгчлэн нэг нэгийгээ хатгаж сүлбэнэ. Чингээд муурч газар тэрийн унахад огторгуйгаас "тэд нарыг дахин сэргээ" хэмээх дуун гардаг аж. Тэгээд дахин босоод урьдын адил хатгалдах зовлонг хэмжээлшгүй ихээр амсч эдэлдэг байна.

/2/ *"Хар шугамт"* тамд тамын сахиулсан нар энд төрсөн амьтныг дөрвөн хэсэг, найман хэсэг болгон хуваахаар элдэв хар шугам татна. Татсан шугамын дагуу мэсээр цавчуулах, таслуулах зэргийн зовлонг эдэлдэг.

/3/ *"Хураан дарах"* тамд тамын сахиулсан нар тэдгээр амьтдыг нэг дор хуран цугларахын үест хоёр хацар мэт төмөр уулын хүрээнд шахан оруулна. Тэр даруй нөгөө хоёр уул мөргөлдөн шахахад тэдгээрийн есөн сүв бүхнээс нь цусан мөрөн буудаг аж.

Мөн хонь, адуу, том үхэр, арслан, барын нүүртэй адил хаднууд шахаж няцалдаг байна. Дахин цуглахад их төмөр хүрдний дотор оруулан чихрийн мод шиг няцлана. Дахин цуглахад дээрээс нь төмөр бул хавтанг унагаж, төмөр газарт таслах, хуваах, нүдэх, талхлах зэргээр тамалж зовооно. Тэр үест ч цусан их мөрөн буух болой.

/4/ *"Уухилан дуудах"* тамд тэдгээр амьтан орон хайн төмөр байшингийн дотор орно. Оронгуут тал талаас гал дүрэлзэн шатаана.

/5/ *"Ихээр уухилан дуудах"* тамд дээрхийн адил бөгөөд ялгаа нь хоёр давхар байшинд болой.

/6/ *"Халуун"* тамд тамын сахиулсан нар тамын амьтныг маш их хэмжээний халуун гал бадарсан буцалмал төмөр зэс байшингийн дотор оруулан чанаж буцалган загас шиг хайрна. Улайссан төмөр шор сэрээг бөгсөөр хатган толгойгоор нь гаргахад ам болон нүд, чихний хоёр хоёр сүв, шар үсний сүв бүхнээр гал бадарна. Улайссан төмөр газарт дээш доош харуулж улайссан төмөр алх зэргээр нүдэж балбан тамлах мөн.

/7/ *"Машид халуун"* тамд гурван үзүүрт шор сэрээг бөгсөөр хатган оруулахад зүүн баруун хоёр үзүүр нь хоёр мөрөөр, гол нь толгойгоор гарч ирнэ.Түүнээс болж ам тэргүүтэн есөн сүв бүхнээс гал дүрэлзэнэ. Машид улайсаж шатсан төмөр шилээврээр саваадаж дэлгэнэ. Буцалмал их зэс төмөр дүүрсэн тогоонд толгойгоор нь уруу харуулан чанаж дээш доош нааш цааш хөдөлгөнө. Тэр цагт арьс, мах, цус барагдан араг яс болох бөгөөд дахин гаргаж ирээд гал бадарсан төмөр газарт дэлгэнэ. Чингээд арьс, мах, цус ургангуут дахин оруулах болой. Үлдсэн бусад нь халуун тамтай адил.

/8/ *"Аюус"* тамд зуун багцадын цаана дорно зүгээс ихэд дүрэлзэн бадрах их галын хүчээр тэдгээр амьтны арьс, мах, судас, шөрмөс, яс бүгдээр зэрэглэн эвдрэн чөмгөндөө тултал шатна. Зулын гол шиг хамаг биенээ гал дүрэлзэн түгэх болой. Бусад гурван зүгт тэр адил бөгөөд дөрвөн зүгээс ирсэн гал энд нийлэх тул завсаргүй зовлон амсаж энэлэх шаналах

дуу гарах тэдийгээр л амьтан байна гэж танигдах тэдий. Мөн төмөр арагны дотор машид улайдсан нүүрс чулуу тулга дүүрэн байна.Төмөр газар дээрх их уулнаа авирах буухыг оролдоход амнаас хэлийг нь сугалж төмөр гадсаар гадаслан үхрийн шир шиг үрчлээ, хуниасгүй болтол татаж сунгана.

Мөн төмөр газарт гэдрэг нь харуулан тавиад төмөр бахиар амыг ангайлгаад улайссан молцогийг ам руу нь цутгах ба буцалмал зэсийг аманд цутгаснаар ам, хоолой, гэдэс дотрыг түлж шатаад хошногоор гарах болой.

Үлдсэн бусад нь машид халуун тамтай адил. Эдгээр зовлон нь бүдүүн нэгэн хорлол бөгөөд үүнээс олон нарийн элдэв зүйлийн хорлол буй. Хэдий хүртэл орших орны хэм хэмжээ, зовлон зэргийг "Газрын бодит суурь"-аас айлдсан ёсоор бичлээ. Тэдгээр зовлонг хэр зэрэг удаан амсаж эдлэх талаар *"Садангийн захидал"*-д

Тэр мэтийн зовлонг машид хэмжээлшгүй
Зуун сая живаа тоотой жилээр ч амсах мөн
Хэзээ нүгэл барагдах хүртэл
Тэр хүртэл амь лугаа үл хагацах болой

хэмээсэн мэт тэдгээр зовлонг эдлэх үйлийн чадал хэзээ барагдах тэр хүртэл амсах хэрэгтэй ажээ.

Хүний тавин насаар Дөрвөн Махараза тэнгэр нэг хоногоо хийдэг. Тийн гучаар нэг сар, тийн арван хоёроор нэг жил болгож тооцоод таван зуун жил болгоод Дөрвөн Махаразын насны хэмжээ гэж үздэг. Мөн тэр бүгдийг нэг хоног гээд тийн гучаар нэг сар, тийн арван хоёрыг нэг жил болгоод таван зуун жил хүрэхэд Дахин сэрэгч тамын насны хэмжээ болно.

Энэчлэн хүний насаар зуу, хоёр зуу, дөрвөн зуу, найман зуу, мянга зургаан зуугаар Гучин гурван тэнгэрээс эхлээд Бусдын рид хувилгааныг эрхэндээ үйлдэгч тэнгэрийг хүртэлх тэнгэрүүд тус тус нэг хоног хийнэ. Насны хэмжээний хувьд тэнгэр өөрийн насаар нэг мянга, хоёр мянга, дөрвөн мянга, найман мянган, нэг түм зургаан мянга хүрнэ.

Тийм хэмжээгээр Хар шугамтаас Халуун тамыг хүртэлх тамын амьтан тус тус нэг хоног хийж өөрийн насаар нэг мянгаас түм зургаан зуун мянга хүртэл насалдаг байна. *"Авхидармакоша"*-д:

Хүмүүний тавин жилээр
Хүсэлт тэнгэрүүдийн
Доод аймгууд нэг хонох
Дээшээгээ хоёр хоёроор урвах болой хэмээсэн ба

Дахин сэргэх тэргүүтэн зургаан там зэрэглэн
Хүсэлт тэнгэрийн насаар нэг хоногоо хийх
Тиймээс тэдгээрийн насны хэмжээ
Хүсэлт тэнгэр лугаа адил мөн

Машид халуун хугас галав хүрэх
Аюус там нь хагас галав хүртэл наслах болно хэмээжээ.

Эдгээрийг *"Газрын бодит суурь"*-аас ч мөн айлджээ.

б) Ойр орчмын там

Тэдгээр найман там тус бүр дөрөв дөрвөн хана, дөрөв дөрвөн үүдтэй. Гадуураа төмөр хүрээгээр хүрээлсэн ба тэдгээр нь дөрөв дөрвөн хаалгатай. Хаалга тус бүрийн орчимд дөрөв дөрвөн зүйлийн тамын амьтан буй. Галт нурам /1/ өмхийрсэн хүүрээр дүүрсэн балчиг буюу баас шээсний намаг /2/, хутга мэсэн зам /3/, болон хөлгүй нуур /4/ оршино.

/1/ *"Галт нурам"* далд халхлагдсан төдий байна. Орон хайсан тамын амьтад гүйж ирээд түүн рүү хөлөө шургуулах цагт арьс, мах, цус бүгдээр эвдрэх бөгөөд татахын цагт дахин ургадаг аж.

/2/ Түүний эргэн тойронд хүүр давхарласан мэт *"баас шээсний балчиг"* байх бөгөөд орон эрсэн амьтан тэднийг гаталж туулахаар ирээд толгойгоо далд ортол живж унадаг байна. Энэ балчигт "Хурц хошуут" хэмээгдэх өт хорхой амьдардаг бөгөөд тэдгээр нь арьс мах, гэдэс дотор, яс үсийг нүхлэн чөмгийг нь тултал өрөмддөг байна.

/3/ Тэр шавар балчигийн эргэн тойронд *"хутганы ирийг дээш нь харуулж тавьсан зам"* байх бөгөөд орон эрсэн амьтан тэнд очоод хөлөө тавиад арьс, мах, цус бүгдээ таслуулах ба дээш татваас дахин ургадаг байна. Түүний хажуугаар илдэн навчит ой цэцэрлэг орших ба орон эрсэн амьтан тэнд очоод түүний сүүдэрт суухад модноос илд цухуйж тэдгээрийн үе гишүүнийг цоолж цавчих болой. Мөн тэнд хүрэхэд төмөр нохой ирээд урд хойноос нь хазаж урах болой. Мөн тэдгээрийн эргэн тойронд Шалмали хэмээх төмөр модон цэцэрлэг байх бөгөөд орон эрсэн амьтан тэнд хүрч түүнээ авирна. Авирахын цагт өргөс нь үзүүрээ доош нь харуулах бөгөөд буухын цагт үзүүрээ дээш нь харуулах зэргээр үе гишүүн эрхтэн бүгдийг зүсэж хагалдаг байна. Тэнд "төмөр хошуут" хэмээх харцага шувуу байх бөгөөд тэрээр мөр толгой дээр сууж нүдний цөцгийг ухаж иднэ. Эдгээр зовлон нь мэсийн хорлолтой адил нэгэн зүйлд тооцогддог.

/4/ Шалмали цэцэрлэгийн хажууд *"хөлгүй мөрөн"* хэмээх буцалсан усаар дүүрсэн усан мөрөн байх бөгөөд орон эрсэн амьтан тэнд унаж дээш доош тэлчлэн түлэгдэнэ. Үлгэрлэвээс их галд буцлан даргилах усны дотор вандуй шидсэнтэй адил болой. Мөрөн усны хоёр эргээр гартаа бэрээ, дэгээ, тор барьсан хянагч нар суух бөгөөд гадагш гаргахгүй манана. Гадагш гарваас тор дэгээгээ шидэн барьж авчраад улайдсан их газарт гэдрэг түрүүлгэн харуулан хэвтүүлж юу хүсээв гэж шалгаана. Тэд "Бид юу ч үзэхгүй юу ч харахгүй байна. Харин их өлсөж цангаж байна" гэхэд улайдсан төмөр хайлмаг болон буцалмал зэс ам руу нь цутгана.

Эдгээрийг *"Газрын бодит суурь"*- аас номлосон дагуу болой. Ойр орчмын болон энд тэндэхийн хоёр тамд насны хэмжээ батгүй гэж түүнээс номножээ.

Гэвч хэзээ зовлон түүнийг амсах үйлийн чадал хэзээ барагдах тэр хүртэл тэдгээр оронд өнө удаан зовлон эдэлдэг болой.

в) Хүйтэн найман там

Их найман тамын оронтой зэрэгцэн нэгэн түмэн багцадын чинадад оршино. Эндээс (Дорж дан) гурван түм хоёр мянган багцадын дор Цэврүүт хэмээх байх бөгөөд түүнээс доош хоёр, хоёр мянган багцадаар тусгаарлагдан бусад долоо оршино.

/1/ *"Цэврүүт"* тамд их хүйтэн жавар үлээж хамаг бие цэврүүнд баригдаж хумигдсан болой.

/2/ *"Цэврүү хагарагч"* тамын ялгаа нь цэврүү нь хагарч хумигдсан болой.

/3/ *"Шүдээ ярзайлгагч"*,

/4/ *"Жихүд хэмээгч"* (Ай тий! тий! г.м) болон

/5/ *"Ачү хэмээгч"* тамуудыг гаргаж байгаа үг дуугаар нэрийджээ.

/6/ *"Удвал мэт хагарагч"* тамд маш их хүйтэн жавар үлээснээр өнгө нь хөхөрч ам нь тав зургаан удаа хагарах болой.

/7/ *"Линхуа мэт хагарагч"* тамд ялгаа нь хөхөөс хэтрээд улайж ам нь арав буюу түүнээс олон хагарсан болой.

/8/ *"Линхуа мэт их хагарагч"* тамын ялгаа нь арьс нь машид улайн ам нь зуу юм уу түүнээс ч олон хагарсан болой.

Тэдгээрийн эрэмбэ зэрэг хэмжээ зовлон зэргийг *"Газрын бодит суурь"*-д айлдсан дагуу болой.

"Төрөл дараалллын цадиг"-аас айлдахдаа:

Үгүйсгэх үзэлтэн хойд төрөлдөө
Орших орон нь түнэр харанхуй хүйтэн салхитай,
Тийн голдоо ортол хөлдөх аймшигт өвчнөөр баригдах тул
Надад туслахыг хүсэгч хэн бээр тийш очих вэ хэмээн

харанхуйд оршихыг айлджээ. *"Шавийн захидал"*-д ч:

Тэсэшгүй хүйтэнд яс нь хүртэл хөхөрч
Бие минь бээрч царцаж хөшөөд хөлдүүс болох
Олон цэврүү гарч хагарснаас төрсөн өт хорхойд
Хазуулан идүүлэх ба шар ус, яс чөмгөө барах

Арьс нь хатан, шүд нь ярзайн үс сүв нь салж одох
Нүд, чих, хоолой нь өвдөн хамаг биеэр хатгуулах
Бие болоод сэтгэлийн завсар зуур бүгд шаналж
Хүйтэн тамд машид орилон дуулах мөн хэмээжээ.

Хэдий хугацаанд эдгээр зовлонг амсах хэмээвээс хэзээ муу үйл тэдгээр барагдах хүртэл аж. *"Газрын бодит суурь"*-аас: "Хүйтэн тамд төрсөн амьтны насны хэмжээ нь их тамд төрсөн амьтнаас хойш хойшдоо хугас хугасаар оршихыг мэдээрэй" хэмээжээ. *"Авхидармын тайлбар"*-т судраас эш татан: "Гэлэн нар аа, Үлгэрлэвээс энэхүү Магада орны дэл будааны наян ачмагийг дэлээр овойлгон дүүргээд түүнээсээ ганцхан ширхэгийг л зуун жилийн дараа гаргаж хаяна. Гэлэн та нар түүгээр жишээд үз. Магада орны дэл будааны наян ачмаг бүгдээр дуусах тэр цаг түргэн байж болно. Харин Цэврүүтэд төрсөн амьтны насны хэмжээ хэд хүрэхийг би хэлж чадахгүй байна. Гэлэн нар аа, Цэврүүтийн энэ адилын хорин хувиар Цэврүү хагарагчийн нэг хувь болмой" хэмээснээс эхлээд дэлгэрэнгүйг "Гэлэн нар аа, Линхуа мэт хагарагчийн энэ мэт хорин хувиар Линхуа мэт их хагарагчийн нэг хувь мөн болой" хэмээн айлдсан тул тэр хүртэл наслах болой

г) Энд тэндэхийн там

Халуун болон хүйтэн тамын ойр орчинд байх бөгөөд хүний оронд ч байж болно гэж *"Газрын бодит суурь"*-д айлджээ.

"Эшийн суурь"-д айлдахдаа: "Их далайн эрэг хязгаарт ойрхон оршино" хэмээжээ. "Гэндэнсүрэнгийн тууж"-д мөн ингэж айлдсан буй. "Авидармын тайлбарт": "Эдгээр арван зургаан там нь амьтан бүгдийн үйлийн эрхээр илт бүтнэ. Энд тэндэхийн тамууд нь олны юм уу нэг хоёр амьтны тус тусын үйлээс илт бүтдэг. Тэдгээрийн намба төрх өвөрмөц олон байдалтай. Орших газар нь онч үгүй ч ус мөрөн уул хясааны завсар бас тэдгээрийн доор ч оршино" хэмээжээ.

Дээр номносон мэт тэдгээр оронд төрөх үндэс шалтгаан машид ойрхон бөлгөө. Өдөр дутам олныг хураах ба урьд хураасан маань одоо ч хэмжээлшгүй их байгаа тул сэтгэл амгалантай суухын арга үгүй буюу. Тэдгээрийг санаад айж цочих хэрэгтэй бус уу. Тэдэнтэй хамт амьдарч суугаа минь юу билээ. Ийм болохыг *"Бодичарияаватара"*-гаас:

Тамын үйлийг үйлдчихээд
Юунд энэ мэт амгалан сууна вэ хэмээсэн ба

"Садангийн захидал"- аас:

Хилэнцэт амьсгалаа хаагдах хүртэл
Цаг хугацааг нөгчөөгч нар
Хэмжээлшгүй тамын зовлонг сонсох хэрнээ
Хэзээ ч үл аюух тэр очирын чанарт буюу

Тамын зургийг үзэх бас тамыг сонсох,
Дурдан санах, унших ба дүрсэлж үзүүлсэн тэдгээр ч
Айдас хүйдсийг төрүүлж байхад
Барагдашгүй тийн боловсорсон үр эдлэхийг хэлэх хэрэг юун хэмээжээ.

Орчлонгийн зовлонгийн дотроос муу заяаны зовлонг тэсч баршгүй билээ. Түүний дотроос тамын зовлон эдэлж баршгүй нэгэн ажгуу. Нэг өдөр 300 хутга жадаар зогсолтгүй хатгуулах зовлон тамын зовлонгийн дэргэд юу ч биш. Ганц хувьд ч хүрэхгүй. Тамын дотроос Аюус тамын зовлон машид бөлгөө. *"Садангийн захидал"*-д айлдахдаа:

Амгалан бүгдийн дотроос шуналаа барсан тэр
Амгалангийн эзэн болох мэт
Тэрчлэн зовлон бүгдийн дотроос
Аюус тамын зовлон машид барагдашгүй

Энд нэг өдөр гурван зуун жадаар
Машид хүчтэй хатгуулах зовлон
Алин тэрээр тамын өчүүхэн зовлонтой ч
Жишиж үл болох буюу нэгэн хувьд ч үл хүрмой хэмээжээ.

Тэрхүү зовлонг үүсгэх үндэс шалтгаан болвоос зөвхөн бидний гурван үүдний гэмт явдал, нүгэл хилэнц мөн бөлгөө. Чингээд өчүүхэн төдий ч гэмт явдлаар халдаахгүйн төлөө байдаг чадлаар шамдваас зохистой.

Дээрхи шастараас:

Нүглийн үр эдгээрийн хөрөнгө болвоос
Бие, хэл, сэтгэлийн гэмт явдал тул та бээр
Яахнаа ч тоосон төдий үл халдаах
Түүний төлөө эрэмгий зоригоор хичээсүгэй хэмээжээ.

2) Адгуусны зовлонг санах

Адгуус амьтан их хүчтэй нь хүч багатайгаа алах, тэнгэр болоод хүмүүний эдэлгээ болох өөрийн эрхээр бус бусдын эрхэнд одож алуулах, зодуулах, хорлогдох зэргийн зовлонг эдэлнэ.

Тэнгэр хүмүүн лугаа хамт орших ба бусад оронд байхгүй гэж *"Газрын бодит суурь"*-д номножээ. *"Авхидармын тайлбар"*-т: "Адгуус нь хээр тал, гол, ус, огторгуйд зорчих эзэн болой. Тэдгээрийн орны язгуур нь их далай бөгөөд бас бус түүнээс цацарсан буй" хэмээжээ.

"Садангийн захидал"-д:

Адгуусны төрөлд аваад алагдах
Хүлэгдэх, зодуулах зэрэг элдвийн зовлон эдлэх
Амарлингүй буяныг тэвчсэн тэдгээр
Нэг нь нөгөөгөө барьж идэх нь барагдашгүй

Заримууд шүр сувд ба яс үс
Арьс махныхаа тухайд алагдах
Эрхгүй бусдууд анчин төрөөчний тарт болон
Тавьсан хавх торонд баригдаж эдлүүлэх хэмээжээ.

Эхний шүлгээр ерөнхий зовлон болоод хоёрдугаар шүлгээр ялгагдах зовлонг өгүүлжээ. "Зодуулах тэргүүтэн" хэмээсэн үгээр унаж эдлүүлэх,

дөрлүүлэх зэргийг хураангуйлсан ба хүмүүн ба хүмүүн бусууд алах тэдний эрхэнд орохыг хэлжээ. "Нэг нь нөгөөгөө идэх" гэдэг нь адгуусан төрлийн амьтад өвөр хоорондоо хөнөөлдөхийг өгүүлжээ "Амарлингуйн буян" гэдэг нирваан олох буян болой.

"Тэвчсэн" гэдэг машид тэнэг бөгөөд бодь мөрийн сав болохгүйг үзүүлжээ. "Анчин гөрөөчний гарт болон тавьсан" гэдгээр морь, үхэр, илжиг, заан, усны үхэр зэрэг таван зүйлийн амьтнаар эдэлгээ болохыг үзүүлжээ. Эдгээрийг *"Садангийн захидлын тайлбар"*-т айлдсан дагуу үзүүлвэй.

Үүний дээр харанхуйд болон усанд төрөөд тэндээ өтөлж үхэх, хүнд ачаа үүрч алжааж зовох, андислуулах, үсээ хяргуулах, хатгуулах зэрэг харилцан адилгүй олон янзаар зовж зүдэрдэг байна.

Ийнхүү алуулж хөнөөгдөх, өлсөж цангах, халуун хүйтнээр хатгуулах, элдэв янзаар анчин гөрөөчинд хороолгох зэргээр цаг үргэлжид аймшигтай яа зовохын үйлийг санаж сэтгэл гансран уйсах хэрэгтэй билээ. Насны хэмжээний талаар *"Авхидармакоша"*-д:

Адгуус амьтан нугуудын
Хамгийн урт нас нэгэн галав болой хэмээн

урт наст адгуус нь нэгэн галав хүрэх бөгөөд богино нь батгүй хэмээн номножээ.

3) Бирдийн зовлонг санах

Харамлах сэтгэл ихтэй амьтад бирд болж төрнө. Бирдүүд өлсөж цангасан, арьс, мах, цус бүгд нь хатсан түлэнхий хожуул мэт бөгөөд нүүр царай нь үсээр бүрхсэн, ам нь хатсан хэлээн унжуулсан байдаг аж. Түүнээ гурван зүйл:

а) *"Идээ ундаа нь гаднаас түйтгэрлэх"* Тийм бирдүүд булаг шанд далай цөөрмийн хажуугаар гүйлдэнэ. Тэр үед гартаа илд, жад, тонгорог барьсан амьтад гарч ирээд булаг шанднаас гадагш гаргахгүй хориглоно. Ус нь идээ бээр болж үзэгдэн уухын хүсэлгүй болгоно.

б) *"Идээ ундаа нь дотроос түйтгэрлэгдэх"* Ам нь зүүний сүвэгч төдий, амаа ангайсан, гэдэс сүвээ нь унжсан буй. Бусад тотгорлоогүй, өөрөө идээ ундааг олсон боловч идэж ууж чадахгүй болой.

в) *"Идээ ундааны түйтгэрт" "Галын эрхит"* хэмээх бирдүүд багтах ба тэдний идсэн уусан бүгд гал бадарч түлэгддэг байна. "Балчиг идэшт"

хэмээх бирдүүд баас шээс идэж уух бөгөөд ариун бусын бузар үнэр ханхалсан хортой хаягдаж гологдсон төдийхнөөр хооллоно. Заримууд өөрийнхөө махнаас таслан идэх бөгөөд ариун сайхан идээг ууж идэж чадахгүй.

Тэдгээрийн орны талаар *"Авхидхармын тайлбар"*-т: "Бирдийн хаан нь Эрлэгийн хаан (Яама) хэмээгдэгч мөн. Түүний орны язгуур нь Жалбу Хав (Ражгир) буюу. Энэ Замбу тивээс доош 300 багцадын цаана оршино.Тэндээс цацарч гарсан ч буй" хэмээн айлджээ.

"Садангийн захидал"-аас:

Бирдэд хүслээр бүтдэггүйн улмаас үүдсэн
Зовлон үргэлжид үл тасрах, үл арилах
Өлсөж цангах халах, хөрөх, алжаал зүдрэл айдас зэрэг
Машид барагдашгүй аюул зовлонг шүтэх

Заримууд зүүний сүвэгч төдий амтай
Уулын чинээ гэдэстэй ч өлсөж шаналах
Ариун бус хог хаягдал өчүүхнийг ч
Эдлэхийн чадал мөхөс болой

Заримууд яс арьс болсон нүцгэн шалдан бөгөөд
Дал модны дээд орой мэт хатаж гандсан мөн
Заримууд шөнө амнаасаа гал бадруулах ба
Гал бадарсан амандаа хоол идээ хийхийг хичээх

Олонхи язгуур заримууд идээ бээр, баас шээс
Цус нөж зэрэг ариун бусыг ч эс олох бөгөөд
Инагш, чинагш хацар нүүрээ цохилцон
Хоолойноос хөөс сахруулан боловсорсон идээ бээрийг хайх

Бирд нар дулаарахын цагт
Саран мандавч халууцах, өвөл нар гаравч бээрэх
Найлзуур мод ч үр үгүй болох ба бирдийн
Харах төдийд ус мөрөн ч хатаж ширгэдэг хэмээжээ.

Үүний эхний бадгаар ерөнхий зовлон болоод бусдаар нь өвөрмөц зовлонг үзүүлжээ. "Алжаал зүдрэл" гэдэг нь хоолны тухайд гүйх болой. "Айдас" гэдэг нь илд, нүдүүр мод, цалам барьсан амьтныг хараад айх болой. "Хог хаягдал" гэдэг нь гологдож үлдсэний нэр болой.

“Шөнө” нь шөнө амнаасаа гал гарах болой. “Гал бадарсныг ам руугаа хийх” гэдэг нь гал дүрэлзсэн идээг идэх. Нүдний хортой учраас хороор түлэх мэт амтат сэрүүн ус мөрнийг ч хатаадаг болой. Заримууд гал бадарч дүрэлзсэн чулуу нүүрсээр дүүрсэн мэт харна. Зарим нь элдвийн өт хорхойгоор дүүрсэн идээ бээрт усан мөрөн мэт үзнэ гэж тайлбаруудад номножээ.

“Шавийн захидал”- д айлдахдаа :

Тэсэшгүй ихээр цангасан тэр алс холын тунгалаг усыг хараад
Уухыг хүсэн тэр зүгт одож тэнд хүрэвч
Тэр бүгд үс хялгас, нялцгай дун хясаа холилдсон, өмхий ханхалсан
Идээ бээр, цус нөж, баас шээс дүүрсэн шавар балчигт ус болон хувирна.

Хаврын чийглэг зөөлөн салхи сэвшээх үлээх сэрүүн оргилыг зорин
Зандан галбирвасун ой ногоорон дуниартах Малаяа уулнаа хүрэвч
Тэр бүгд гал дөлд хучигдсан ой болон үзэгдэж
Шатаж түлэгдэж хугарч унасан хожуулын овоолго болох

Усан мөрний давалгаа хүчээ аван өндөрт цалгилан
Цайрах хөөс нь гялтагнан харагдах тэр зүгт хүрэхэд
Тэр бүгд халуун элс, манан будан, улаан салхи,
Догшин хуй салхи үймцэн эргэлдсэн говь цөл болох

Эндээ амар сууж хурын үүл гарахыг хүсэхүй еэ
Үүлнээс утаа тортог нүүрс чулуутай аянгын хур бууж
Оч цацруулсан очир бул чулуу дэлбэрэн асгарах
Алтан өнгөт цахилгаан эрхис улаан шар гүйдэл
болон биенээ хур болон буух

Халуунаар энэлэгчид цасан шуурга тавьсан ч халууцах
Хүйтэн жаварт бээрэгчид галд ээвч даарах
Машид барагдангүй үйл огоот боловсорсон учир хэээд мунхран
Энд үзэх элдэв зүйл энэ бүхэн буруугаар үзэгдэх

Зүүний сүвэгч төдий амтай, олон багцадын аймшигт гэдэстэй
Ядарч зовсон тэрээр их далайн усыг уувч
Хэдий гүн уужим хоолойтой ч цааш үл давах
Хортой амтай болохоор дусал усыг ширгээж хатаах хэмээжээ.

Насны хэмжээний хувьд *"Газрын бодит суурь"* болон *"Авхидарма"*-д айлдахдаа "хүний нэг сараар бирд нэг хоног хийгээд өөрийн насаар таван зуу хүрнэ" гэжээ.

"Садангийн захидал"-д:

Завсаргүйгээр зовлон эдлэх
Гэмт явдлын үйлийн цалмаар
Баттай хүлэгдсэн зарим амьтан
Таван мянга, нэг түмэн жил наславч үхэхгүй хэмээжээ.

Зарим бирд таван мянга, заримууд нэг түм хүрнэ гэж тайлбарт номножээ. Гурван муу заяаны биений хэмжээ адилгүй бөгөөд нүглийн эрхээр том бага элдэв зүйл болохыг *"Газрын бодит суурь"*-д айлдсан байна.

Тийнхүү муу заяаны зовлонг санахын зуур эдүгээ галт нурманд гараа шургуулж ганц нэг хоног суух, өвлийн хүйтэн жаварт мөсөн хонгилд хувцасгүйгээр төдий чинээ суух, ганц нэг өдөр хоол ундгүй байх зөгий хэдгэнэд хатгуулах төдийд тэсэхэд бэрхтэй байхад халуун, хүйтэн там, бирд болоод адгуус нэгэн нэгнээ идэх зэрэг амьд байхын аргагүй зовлон зүдгүүрийг би яаж тэсэх билээ хэмээн өнөөдрийн зовлонгоороо жишин маш их айж цочих сэтгэл төрөх хүртэл бясалган бодоорой.

Мэдсэн хэдий ч сэтгэлдээ нийлүүлж авахгүй юм уу эсвэл бага хугацаанд ганц нэг бодсноор тус болохгүй.

"Эшийн суурь"-аас: "Гунгаавын (Ананда) эгчийн хоёр хүү тойн болж ном үзэхээр явжээ. Гэтэл ганц нэг өдөр ном үзээд залхууран цааш үзэхээ больжээ. Монголжибү (Маудгаляаяана)-д хүргэсэнд мөн урьдын адил болов. Гунгаав бээр "Тэр хоёрыг жаахан хашраасу" хэмээн Монголжибүгээс хүсчээ. Монголжибү тэднийг зугаалуулж дагуулж яваад тамыг хувилган үзүүлэв. Бас хэрчүүлэх таслуулах тэргүүтний дууг сонсгон үзүүлэв. Амиа таслуулах тэргүүтэн зовлонг харуулав. Буцалмал хоёр том төмөр ширмийг үзүүлэв. "Энд хэн ирэх вэ" гэж асуужээ.

"Гунгаавын хоёр дүү тойн болчихоод залхууран цагийг нөгчөөх учир үхээд энд төрнө" гэж хариулжээ. Тэр хоёр машид айж цочин, "Хэрвээ үхчихвэл одоо орчих вий" хэмээлцээд Монголжибүгийн гэрт ирж юу болсныг өгүүлжээ. Ингээд Монголжибү бээр "Хоёр гэцэл ээ, эдгээр гэмүүд болоод бусад гэмүүд ч залхуугаас үүдэх тул хичээнгүйг туурвисугай" хэмээжээ.

Энэ дагуу тэр хоёр хичээнгүйг туурвихад хоол идэхээсээ өмнө тамыг санаваас идэж эс чадах ба идсэнийхээ дараа ч санаваас огиулж гаргадаг болжээ. Тэднийг салхилуулангаа өөр нэгэн оронд аваачив. Нэгэн зүгт тэнгэрийн хувилгасан ятга хөгжмийн дуу гарсанд түүнийг үзэхээр очив. Тэнгэрийн хөвгүүд байхгүй хэмжээлшгүй их орд харш тэнгэрийн охидоор дүүрэн байхыг харав. Тэнд тэнгэрийн хөвгүүд байхгүйн учрыг асуусанд "Гунгаавын ах дүү хоёр тойн болж хичээнгүйг туурвиснаар үхсэний дараа тэр хоёр энд төрнө" хэмээн өгүүлжээ.

Тэр хоёр баярлан Монголжибүд өгүүлсэнд "Хоёр гэцэл ээ, эдгээр тус эрдэм болоод бусад тус эрдмүүд хичээнгүйг туурвиснаар гарах тул түүнийг туурвисугай" хэмээсэн ёсоор хичээнгүйг туурвижээ.

Ийнхүү тэд ном үзээд "сайн заяанаас муу заяанд төрөх жам урьд харсан адилаар" эш номд айлдсан болохыг ухаарчээ.

Чингэвээс хутагт бид нар тэнгэр хүмүүний дотроос үхэл егүүтгэн гурван муу заяанд төрөх хэрэгтэй юу гээд сайхан зүст та хоёр таван зүйл амьтны орчлонд хэзээ нисваанисын үргэлжлэл эс тасрах хүртэл худгийн ховоо мэт эргэлдэн оршино хэмээв. Тэр хоёр сэтгэл гансран "Хойшид нисваанисын явдалд үл урвах тэр адилын номыг айлдан соёрх" хэмээн өчивэй. Монголжибү бээр ном номносноор дайснаа дарсны үрийг олвой" хэмээжээ.

Тиймээс мөрийг бүтээхээр залхуугаа огоорон хичээнгүйг туурвиж, сэтгэл юугаа нирваанд зориулаарай. Түүнийг олохын үндэс язгуур нь зовлонг бясалгах явдал хэмээн сайшаажээ. Бурхан амьд сэрүүн байхдаа үүнээс илүү зарлиг увдис айлдаагүй бөлгөө.

Энэ үеэт бага, дунд төрөлхтний бодол санаа зэрэгчлэн төрөх жамтай бөлгөө. Ухааны чадлаар тэрхүү ухаан бодол хэзээ төрөхийг хүртэл үргэлжид шамдан бясалгах хэрэгтэй.

Ниүсүрва гэгээнээс: "Тэдгээрт төрөхийн үндсийг урьд үйлдсэн үү, эс үйлдсэн үү, эдүгээ үйлдсээр үү, эс үйлдсээр үү, хойшид үйлдэх үү, эс үйлдэх эсэхээ шинжлэ. Хэрвээ урьд үйлдсэн, одоо үйлдэж байгаа, хойшдоо ч үйлдэхээр болвоос тийшээ одох нь лавтай.

Тиймээс хэрвээ тэнд төрвөөс "Би юу хийж чадах билээ" гэж цөл газарт аргаа баран толгойгоо шааж суугаа хүн шиг санан айж цочихын ухаан хэзээ төрөх хүртэл бясалга" хэмээн айлджээ.

Энэ тун чухал учир эдүүгээ сайн шүтээн дээрээ тэдгээрийг санан урьд хураасан нүглээ арилгах, хойшид орохыг багасгах бөгөөд урьд хураасан буянаа хүчтэй сайн ерөөлөөр жолоодон улам арвижуулах, шинээр

хураахын олон үүдээр орох зэргээр өдөр тутамд чөлөө учралт шүтээнийг хэрэг тустай болгож үйлд.

Өнөөдөр эдгээрийг эс санаваас муу заянд унахын цагт тэндээс аврах авралыг эрэвч эс олдох буюу. Тэр цагт үйлдвэр ба үйлдвэр бусыг авч орхихын ухааны чадалгүй болчихсон байна шүү.

"Бодичиряаватара"-гаас:

Алин хэзээ буян хийхийн хувь төгөлдөр байхдаа
Буян эс үйлдвээс би
Муу заяаны хамаг зовлонд баригдах
Тэр цагт юу хийж чадах билээ би хэмээсэн ба

Хэн нэгэн энэ их аюулаас намайг
Сайтар аварч чадах бол хэмээн
Ихэд айж цочин нүдээ бүлтэгнүүлэн
Дөрвөн зүгт аврал ивээлийг эрж үйлдэх

Дөрвөн зүгт аврал байхгүйг мэдээд
Төдөлгүй бүгдээр мууживарч унах
Тэр оронд аврал байхгүй тул
Тэр цагт яах билээ би

Тиймээс амьтны итгэл болсон Ялгуусад
Амьтныг аврахын тусыг туурвигч
Хүч ихт аймшиг бүхнийг арилгагч Танаа
Өнөөдрөөс эхлэн авралыг одуулмуй хэмээн айлдсан мэт болой.

Эдгээр ерөнхий нэгэн бөгөөд дэлгэрэнгүйгээр "Ойр санан дурдахуй" сударт байгаа тул лавлан үзэх хэрэгтэй. Дахин дахин үзэх хэрэгтэйн дээр үзсэн зүйлээ санах хэрэгтэй болой.

АВРАЛ ОДУУЛАХ

2. Хойд насанд амгалантай байх арганаа суралцахад хоёр зүйл

а. Шашнаа орохуйн дээд үүд – Авралыг одуулахуйг судлах
б. Хамаг сайн амгалангийн язгуур – Сэтгэл итгэмжлэх буюу сүсэглэх

а. Шашнаа орохуйн дээд үүд - Авралыг одуулахуйг судлах:

1) Алинаа шүтэн аврал одуулахын шалтгаан
2) Шүтэж аврал одуулах орон
3) Хэрхэн аврал одуулах ёс
4) Аврал одуулах суртгаалын зэрэг

1) Алинаа шүтэн аврал одуулахын шалтгаан

Ер нь олон шалтгаан байдаг ч энэ үест дээр номносон мэт энэ насанд удаан суулгүй түргэн үхэх буюу. Үхсэний хойно хаана төрөх гэдэг өөрийн эрхгүй бөгөөд гагцхүү бусад үйлийн эрхээр явдаг бөлгөө.

"Бодичиряаватара"-д:

Түнэр харанхуй шөнө үүлэн завсраас
Түргэн зуур цахилгаан гялбахуй адил
Тэрчлэн Бурханы хүчээр л хааяа нэгтээ
Тив ертөнцөд буяны сэтгэл заримдаг төрьюү

Тэр мэт буяны чадал үргэлжид өчүүхэн
Тэнцэшгүй хилэнц хүч ихтэй, бас барагдашгүй

хэмээн айлдсан мэт буяны үйлийн чадал өчүүхэн, нүглийн үйл машид хүчтэй тул муу заяанд унахын ёсыг санаснаар айж цочирдохын сэтгэл төрж авралыг эрж хайх ухаан төрнө.

Их багш Дигнага (Чоглан) бээр:

Оёор хязгааргүй орчлонгийн
Далайд үргэлж баттай оршихдоо

Барагдашгүй их шунал зэрэг
Усны мангаст биеэ идүүлэх учир
Хэнээс эдүгээ аврал эрэх вэ хэмээн айлдсан мэт.

Товчилбоос, өөрөө муу заяа тэргүүтнээс айх ба түүнээс аврах чадал чухаг дээдэд буй хэмээн сэтгэл итгэмжлэх хоёр ухаан (түүний шалтгаан) болой.

Тэр хоёрыг үг төдий одуулваас, авралыг одуулах явдал ч мөн тэр адил болно. Харин тэр хоёр ухаан хүчтэй хатуу, баттай байх аваас аврал итгэл ч туушстай лавтай болох тул хоёр шалтгаанд шамдаж үйлдээрэй. [37]

2) Шүтэж авралыг одуулах орноо хоёр:

а) Орноо танин мэдэх
б) Тэд авралд зохистойн учир шалтгаан

а) Орноо танин мэдэх

"Зуун тавин шүлэгт магтаал"-д:

Алин нэгэн хамаг гэмээ
Ашид үгүй болгож чадсан ба
Алив хамаг эрдмийн
Агуу орон болж ялсан түүнээ

Хэрвээ ухаан нэгэн байваас л
Зөвхөн түүнээ авралыг одуулах ба
Түүнийг магтах, түүнийг хүндлэх
Түүний үзүүлснээ орших нь зохистой хэмээсэн мэт

Аврал ба аврал бусыг ялгах ухаан нэгэн байваас хуурмаггүй аврал болсон Ялж төгөлдөр нөгчихсөн бурханаа аврал одуулах зохистой болой. Чингэвээс бас ном болон хувраг ч чухаг дээд мөн болмой.

Мөн *"Авралын далан шүлэгт"*-гаас:

Бурхан ном хувраг нь
Тонилохыг хүсэгчдийн аврал хэмээсэн мэт болой.

б) Авралд зохистойн учир шалтгаан

(1) Өөрөө машид усхал номхон мөн чанарт аймшиггүйн хутгийг олсон болой. Хэрвээ түүнийг олж чадаагүй болвоос мөлхөө мөлхөөгөө шүтэх мэт бусдыг хамаг аюулаас аварч чадахгүй болой.

(2) Хэзээ ямагт шавийг номхотгох боловсруулах арганаа мэргэн болой. Тийм бус бөгөөс аврал одуулавч хэрэг тусыг бүтээж чадахгүй болой.

(3) Их нигүүлсэнгүй сэтгэл төгөлдөр болой. Тийм бус бөгөөс аврал одуулавч эс аврах болой.

(4) Эд өлгийн элдэв тахилд үл баясах ба харин бүтээлийн тахилд баясах хэрэгтэй. Тиймгүй бол урьд тус болсныг л тооцох учир бүгдийг аварч эс чадна.

Товчилбоос өөрөө аюул бүгдээс гэтэлсэн, бусдыг аюулаас аврахын арганаа мэргэжсэн, ойр холд ялгалгүй бүгдийг энэрэн нигүүлсэх, тусалсан туслаагүй бүгдийн тусыг бүтээгч нэгэн авралд зохистой болно.

Тэр нь зөвхөн Бурхан бөгөөд Вишнү тэнгэр тэргүүтэн биш ээ. Тиймээс зөвхөн тэр л аврал болно. Түүгээр жишээд түүний үзүүлсэн ном болоод түүний сонсоод сонсогч хувраг нар ч авралд зохистой буюу. Ийнхүү *"Хураангүй"*-гаас айлдсан эдгээрийг танин барьж нэгэн үзүүрт ухаанаар эзэмшиж чадваас аврахгүй гэхийн газаргүй тул зүрхний мухраас магадлан бариарай.

Өөрийгөө аврах хоёр шалтгаан байдгаас гадаад үндэс буюу гишүүн нь бурханы талаас бээр бүрэн төгс бүрдсэн байна. Харин дотоод үндэс гишүүн болсон ухаанаа даатгах буюу (сэтгэл итгэх) авралд барих явдал эс төрвөөс зовлонтой болно.

Учир нь хуурмаггүй үнэн, их нигүүлсэнгүй сэтгэлээс төрсөн нөхөр бөгөөд тэрээр залхууг үл эрхшээгч ханьцашгүй авралын сайн орон болж миний итгэл мөнийг таньж мэдээд түүнээ авралыг одуулах хэрэгтэй.

"Магтваас зохист сайшаал магтаал" -аас:

Итгэл үгүй та нар намайг
Нөхөр болсу хэмээн дуурсах учир
Их нигүүлсэхүй сэтгэлээр
Даяар олон амьтныг тэвэрч өмгөөлөх

Их нигүүлсэхүйг эрхшээгч бурхан
Энэрэл төгөлдөр нигүүлсэн зохиомой
Эгнэгт залхууг огоорон энэрлийг туурвигч
Энгүй тантай адил өөр хэн байна

Хотол түмэн амьтны итгэл билээ Та
Хосгүй олон ардын сайн өмөг билээ Та
Авралаа болгож таныг эс барьсан тул
Ард төрөлхтөн доошлох буюу

Алин үнэнхээр барьсан болвоос
Эгэл дорд боловч нөхөрлөн чадах
Нөхөр болох ном эрдмүүдийг
Танаас бусад заримууд үл онох

Гадаад нөхцөл шалтгаан бүхнийг
Гайхамшигтай бүтээж чадсан Та
Дотоод нөхцөл шалтгааныг дутаасан тул
Нялхас ардууд зовлонг шүтэх хэмээн айлджээ.

3) Хэрхэн авралыг одуулахын ёс:

"Хураангуй"-гаас айлдсан дөрвөн зүйл:

а) Эрдмийг мэдэх
б) Ялгамжааг мэдэх
в) Ам авах
г) Бусдад үл өгүүлэн аврал одуулах хэмээх дөрвөн зүйлээр айлджээ.

а) Эрдмийг мэдэж аврал одуулахуйд авралын эрдмийг санах хэрэгтэй тул түүнээ гурав:

1. Бурханы эрдэм
2. Номын эрдэм
3. Хуврагын эрдэм болой.

1. Бурханы эрдэм
(а) Лагшингийн эрдэм
(б) Зарлигийн эрдэм

(в) Тааллын эрдэм
(г) Үйлсийн эрдэм

(а) Лагшингийн эрдэм

Бурханы сайхан бэлэг найргийг сэтгэлдээ санаж үйлдэнэ. Тэр талаар *"Бэлэг найргийн магтаал"*-д:

Бэлэг найргаар хээлсэн таны лагшин
Үзвээс үзэсгэлэнт нүдний рашаан бөгөөд
Намрын үүлгүй тэнгэрт
Од эрхисын чуулган түгсэн мэт

Алтан өнгө төгс гийсэн Чадагч (Ялгуусан) Та
Номын баринтагаа үзсгэлэнтэйеэ асаажээ
Алтан уулын оройд
Завсрын үүлэн тунарсан адил

Итгэлт та гоёл чимэг эс зүүсэн ч
Нигуурын мандал тань юунаас ч тунгалаг
Үүлгүй гэгээн сарны мандал
Өөдлөн мандавч түүнтэй адил бус

Таны нигуурын линхуа болоод
Наранд амаа нээгч линхуа хоёрыг
Зөгий үзээд алин линхуа бол хэмээх
Эргэлзэхийн сэтгэлд автах буюу

Алтан өнгөт таны нигуурт
Хас цагаан шүдэн ярайх нь
Алтан уулын цаанаас намрын
Хиргүй тунгалаг сарны гэрэл гийх адил

Тахиваас зохист таны баруун мутар
Хүрдэн бэлэг юүгээр үзэсгэлэнтэй хээлсэн буюу
Зовлонгоор энэлсэн хүмүүн бүхнийг
Мутраараа аврахын тэмдэг зохиосон бөлгөө

Чадагч та залрахын цагт
Хоёр бойв юугаар тансаг сайхан линхуаг

Энэ газар дэлхийг хээлэн чимэх нь
Линхуан цэцэрлэгээс юутай үзэсгэлэнтэй вэ хэмээсэн мэтээр санаж үйлдэх болой.

(б) Зарлигийн эрдэм

Ертөнцийн оронд орших амьтан бүгдээр нэгэн зэрэг харилцан адилгүй асуулт тавин тус тусдаа асуухад, ганцхан агшинд ухаандаа болгоон нэгэн эгшгээр бүх асуултыг хариулж чадна. Амьтан тэд ч өөр өөрийн хэл дээр ухаарах зэрэг машид сонин гайхамшигт ёсыг санах мөн.

"Үнэнч өгүүлэгчийн бүлэг" -д:

Энэ мэт хамаг амьтан асуулт талбиж
Олон бүгдээр нэгэн зэрэг айлтган шаардахад
Сэтгэлийн ганцхан агшинаа таалалдаа болгоож
Ганцхан зарлиг эгшигээр тус тусын хариултыг өгөх

Тиймээс Сартваахь тэрээр ертөнцөд
Эсүрва тэнгэрийн эгшиг дууг цуурайтуулан зохиовой
Тийнхүү тэнгэр хүмүүний зовлонг үлдэн хөөгч
Номын хүрдийг сайтар эргүүлэн зохиовой хэмээсэн ба

Мөн *"Зуун тавин шүлэгт"*-ээс:

Таны нигуурыг үзвээс үзэсгэлэнтэй,
Түүнээ сонсвоос сонсголонтой
Эгшиг зарлиг эдгээр нь
Сарнаас рашаан цацран буух мэт

Таны зарлиг шунал хүслийн тоосыг
Машид амарлиулагч хурын үүлэн адил
Уур хилэнгийн могой цухуйхад
Огторгуйн гарьд адил

Дахин дахин үл мэдэх мунхагийн
Хөлхөлгөөг арилгагч шүхэр адил
Омгийн уулыг илт дарагч
Очир лугаа адил мөн

Утгыг болгоохдоо хуурмаггүй бөгөөд
Гэмийг үл эрхшээсэн тул даган зохилдох
Сайтар найруулсан тул ухаарахад хялбар
Таны зарлиг сайн эгшиг төгөлдөр

Заримдаа таны зарлигийг дөнгөж
Сонссон төдийгөөр сэтгэл булаагдах
Улмаар сэтгэлдээ бодон тунгаасаар
Шунал хүсэл мунхаг юугаа арилгах

Ядарсан бүгдийг амраах бөгөөд
Сэрэмжгүй бусдыг ч авран зохиох
Жаргалтай бусдад уйдах дохиог сануулан
Таны эгшиг зарлиг хотолтой зохилдох

Хамаг мэргэдийн баясгалан төрүүлэх
Хэр тааруу бусдын ухааныг нэмэх
Эгэл доорд бусдын эндүүргийг лавтай дарснаар
Энэ зарлиг амьтан бүхнээ эм болох
хэмээн айлдсан мэт санаж үйлдээрэй.

(в) Тааллын эрдэмд хоёр:

а/ Болгооллын эрдэм
б/ Энэрэх нигүүлсэхийн эрдэм

а/ Болгооллын эрдэм

Үнэмлэхүй ба янагуухуй мэдэгдэхүүн бүхнийг гарын алган доторхи жүрүра-г үзэх мэт ямар ч саадгүйгээр болгоож чадна. Тиймээс бурханы таалал буюу оюун ухаан мэдэгдэхүүн бүхэнд түгжээ. Харин түүнээс бусдад мэдэгдэхүүн нь ихдээд мэдэх ухаан багадсан тул үл түгсэн ажээ.

Ийн хэмээн *"Магтваас зохист сайн магтаал"*-д:

Зөвхөн таны билгэ билгүүн л
Хамаг мэдэгдэхүүнээ түгсэн билээ
Танаас бусад бүгдэд
Зөвхөн мэдэгдэхүүн нь үлэмж илүү буюу хэмээсэн ба

Ялгуусан минь ээ, Хамаг цагт орших ном юмс
Хаана хэзээ гарсан мэдэгдэхүүн бүхэн
Алганы толионд агуулсан жүрү мэт
Ашид таны тааллын орон билээ

Хөдлөх болоод үл хөдлөх юмс үзэгдэл
Нэг болоод элдэв олон тусгаар зүйлсийг
Огторгуйд гүйх хий салхи мэт
Огт торохгүй таны таалал болгоох хэмээсэн мэт санаж үйлдээрэй.

б/ Энэрэх нигүүлсэхүйн эрдэм

Амьтан гэдэг өөрийн эрхгүй нисваанис буюу муу сэтгэлдээ хүлэгдсэнтэй адил бурхан гэдэг өөрийн эрхгүй их нигүүлсэхүй сэтгэлдээ хүлэгдсэн байдаг ажгуу. Тиймээс л амьтны зовлонг болгоож их нигүүлсэнгүй сэтгэл завсаргүй төрдөг билээ.

"Зуун тавин шүлэгт"-д:

Эдгээр амьтан бүгдээр
Нисваанисаар хүлэгдсэн нь ялгалгүй
Та болбоос нисваанист амьтан бүхнийг
Тонилгохын тулд өнө үргэлжид их нигүүлсэхүйгээр хүлэгджээ

Эхлээд танд мөргөж үйлдэх буюу
Эсвээс таныг алин хорвоогийн
Зовлонг болгоолгож өнөд удаан
Энэ мэтээр "хүлж байгаа" их нигүүлсэхүйд тань мөргөх үү хэмээжээ.

"Үнэнч өгүүлэгчийн бүлэг"-ээс:

Түнэр их харанхуй мунхагаар үргэлж мөнхөд
Сэтгэл нь түйтгэрлэгдсэн хамаг амьтан
Орчлонгийн гянданд хоригдсоныг болгоож
Эрхэм арш түүний их нигүүлсэхүй төрөх хэмээсэн ба,

Хүсэл, шуналын хүчинд автсан амьтан
Шунал ихтэй тул юмс үзэгдэлд үргэлжид тачаах бөгөөд

Шунал тачаалын далайд унасан амьтныг болгоон
Ялгуусадын их нигүүлсэхүй мэндлэх

Өвчин зовлон гаслан гунигаар
Өнө энэлсэн нисваанист хамаг амьтныг
Асран өрөвдөж хамаг зовлонг арилгахаар
Арван хүчийг эрхшээснээ их нигүүлсэнгүй аяндаа төрөх

Чадагчийн их нигүүлсэхүй мөнхөд ажрах бөгөөд
Тэр үл орших гэж хэзээ ч үгүй буюу
Хамаг амьтны сэтгэлд орших учир
Тиймээс бурхан гэм үл эрхшээсэн болой
хэмээсэн мэт санаж үйлдээрэй.

(г) Үйлсийн эрдэм:

Лагшин, зарлиг, тааллын үйлс нь аяндаа бүтэх ба тасрахгүй үргэлжлэх хоёр чанартай тул амьтан бүгдэд тусалж чадах авай. Шавийн талаас хөтлөгдөж чадах аваас бурханы талаас тэрхүү шавийг сайн хотол чуулган лугаа үл учруулах ба унал доройтлоос татахгүй гэхийн газаргүй тул зохист нөхцөл бүхнийг магадтай бүтээх нь чухал билээ.

"Зуун тавин шүлэгт"- ээс:

Эндүү муу сэтгэлээ ялахыг номнох Та бээр
Элдэвлэгч шимнусын башир залийг буцаах
Эргэх хорвоогийн барагдашгүй араншинг өгүүлэх ба
Эсэн мэндийн зүг замыг заан үзүүлэгч билээ

Ач тусыг эрхэмлэгч их нигүүлсэлт Та бээр
Амьтан бүхний алин юу хүссэнийг
Алгасран эс бүтээв гэдэг
Алимад хаана байх билээ хэмээжээ.

"Магтваас зохист сайн магтаал"-д:

Алин амьтан хотлыг Та бээр
Үл дээшитгэн доройтуулсан тэр хаана байна
Алин ертөнцийн хотол чуулган тэр лугаа
Үл учруулсан хаана байна хэмээсэн мэтээр санаж үйлдээрэй.

Эдгээр нь бурханыг даган дурдах ёсны товч хураангуй бөгөөд олон талаас санан дурдаж чадваас сүсэг ч мөн төдий олон төрнө. Дахин дахин санаваас хүчтэй баттай бас өнө удаан тогтоно. Нөгөө хоёр чухаг дээдийн эрдэм дээр ч энэ адил болой.

Тийн дадуулж чадал суугаад ирвэл эрхэм зарлиг, тааллын тайлбар зэргээс гурван авралын тус эрдмийн талаар нилээд дэлгэрэнгүй заасан тэдгээрийг ч увдис болгон ухаарч мэдэх болно.

Бясалгахын үест ажиглах бясалгалыг атхаг хэмээн орхигч нар энэ мэтээр буян хураах болон нүгэл арилгах олон үүдийг хааж хориход хүрч болзошгүй. Тиймээс чөлөө учралт шүтээний шимийг хэмжээлшгүй ихээр авахад их саад тотгор болохыг ухаараарай.

Цаг үргэлжид эдгээрийг бодож бясалгаж сурна гэдэг сэтгэл ухааны дадлагаас шалтгаалах учиртай. Эхэндээ ухаан буухад хэцүү байвч хэсэг хугацааны дараа аяндаа буудаг болох вий.

Санан дурдаж буй энэ адилын бурханы хутгийг би өөрөө олно хэмээж бодь сэтгэл төрнө. Өдөр шөнө бүхэнд бурхантай уулзах болно. Үхэхийн цагт зовлон юу гаравч бурханыг даган дурдах сэтгэл доройтохгүй болно.

"Бясалгалын хаан судар"- аас:

Захисныг минь та дотроо тунгаана биз
Хэрхэн олон юмыг мэдэх гэсэн хүмүүс
Өөрт байгаа бодолдоо татагдваас
Явсаар тэр л зүйл рүү сэтгэл шулуудахад хүрдэг

Тэрчлэн ялгуусадын лагшин хөрөг болоод
Хэмжээлшгүй билгүүнийг бурхан хэмээн сана
Үргэлжид даган дурдахыг дадуулснаар
Түүнээ сэтгэл шулуудан магад чиглэх

Явах суух хэвтэх босохын цагт
Дээд төрөлхтний билэг оюуныг сайтар хүсэх
Ертөнцийг ялсан ханьцашгүй эзэн болно хэмээн
Бодь хутагт хүрэх ерөөлийг талби хэмээсэн ба,

Бие, хэл, сэтгэлээр машид сүжиглэ
Үргэлжид бурхадыг сайшаан өгүүл
Тэр мэт тэдгээр сэтгэлийн үндсээ дадуулваас
Өдөр шөнө бүхэнд Ертөнцийн итгэлтэй учрах

Хэзээ нэг өвдөж зовоод
Үхэхэд тулж шаналал амссан ч
Бурханыг санахаа үл доройтуулах аваас
Зовлонгийн амсуургад үл булаагдах хэмээн айлджээ.

Бодава гэгээнээс: "Дахин дахин санаваас сэтгэл дээрдэн үндэс ариусан одно. Адистид оршино. Түүнийг ухаарч аваад зүрхний мухраас авралыг одуулж, түүний суртгаалд юу чадахаар суралцах бүгдээр бурхны ном лугаа ялгалгүй нэгэн. Бид нар бурханы тааллыг мэргэ төлгийн хэмжээнд үзэж болохгүй .

Харин мэргэч төлөгч нэгэн бээр: "Энэ жил танд ямарваа саад зэтгэр байхгүй, би мэдэж байна" гэхэд сэтгэл амарч буцдаг. Нөгөө төлөгч бээр "Энэ жил саад зэтгэртэй байна. Энэ тэрнийг бүтээгтүн" гэхэд ихэд шамдан бүтээдэг. Бүтээж амжихгүй үедээ "Тийн хэлснийг бүтээсэнгүй би" хэмээн сэтгэл зовдог шүү дээ.

Гэтэл бид "Энэ хийгээд үүнийг тэвчих хэрэгтэй" хэмээсэн ба "Энэ болоод үүнийг бүтээгээрэй" хэмээсэн бурханы захиасанд ухаанаа чиглүүлсэн бил үү. Эс бүтээв хэмээн сэтгэл тевдсөн бил үү. Номонд л тийн номносон болой. Эдүгээ орон цагийн эрхээр түүнийг бүтээж яаж чадах вэ. Үүнийгээ бүтээж чадвал болно хэмээн бурханы зарлигийг хэнэггүй орхичихоод өөрийн дураар зөрүүдлэн гүйнэ.

Үг төдий байвал эндүүрэл гарахгүй, бас шинжлэхгүй байвал сайн гэж та баясдаг. Харин сэтгэлээ дотогш эргүүлэн нягтлан шинжлэхийг машид муушаах үзэгдэнэ.

Тиймээс бурханы эрдмийг дахин дахин санаж, зүрхний мухраас таньж мэдэхээр шамд. Тийн чадваас түүний айлдсан ном болоод номыг бүтээгч хувраг нарыг ч энэ адилаар танин мэднэ. Чингэх аваас авралыг одуулах ёсон бодитой болно. Эс чингэвээс бусад зам мөр байтугай авралыг одуулах ёс ч сэтгэлд баттай ирэхгүй билээ.

2. Номын эрдэм

Бурханаа бишрэх сэтгэл төрснөөс үүдэн бурхан хэмжээлшгүй их эрдэмтэй болсон нь эш болоод онолын ном, хорихуй ба мөрийн үнэн, гэмийг тэвчих эрдмийг бүтээх зэрэг эрдэм ухаанд сайтар суралцаж бясалган бүтээснээр ийн болжээ хэмээн дурдан санах мөн.

"Номын үнэн хураангуй"-д: "Алин Ялж төгс нөгчихсөн бурхад хязгааргүй их эрдэмтэй билээ. Тэдгээр нь номоос мэндэлсэн, номын үүрэг ачааг үүрсэн, номоор хувилсан, номын эзэн болсон, номоос үүдсэн, номын явдалт, номд зоригч, номыг бүтээгч буюу" хэмээн айлджээ.

3. Хуврагийн эрдэм

Хутагт бодгалис голлон багтана. Номын эрдмийг санаж тэдгээрийг ёсчлон бүтээсэн гэдэг үүднээс дурдан санана. *"Номын үнэн хураангуй"*-д: "Хувраг болвоос номыг өгүүлэгч, номын явдалт, номыг санагч, номын орон, номыг баригч, номыг дагагч, номыг тахигч, номын үйлийг үйлдэгч, номт явдлын орон, номоор явагч, хотол чуулсан номын явдалт, шударга мөн чанарт, шударга ариун, нигүүлсэнгүй номт, нигүүлсэнгүй төгөлдөр, үргэлжид аглагийн явдалт, үргэлжид номыг туурвигч, үргэлжид цагаан явдалт болой хэмээх тэргүүтэн болой" хэмээн айлджээ.

б) Ялгамжааг мэдэн авралыг одуулах:

"Хураангуй"-гаас айлдсан мэт чухаг дээд гурвын доторхи инагш чинагш ялгааг мэдэн аврал одуулах болой. Түүнээ зургаа :

1. Бэлэг чанараас гарсан ялгамжаа
2. Үйлсийн ялгамжаа
3. Сүсгийн ялгамжаа
4. Бүтээлийн ялгамжаа
5. Даган санахын ялгамжаа
6. Буян арвижихын ялгамжаа

1/ Бурхан чухаг дээд болвоос үнэхээр туулсан бодь хутгийн бэлэг чанарт мөн. Ном чухаг дээд нь түүнээс боловсорсон үр жимс бөгөөд хувраг чухаг дээд нь бусдын увдисыг үнэнхээр бүтээх бэлэг чанарт болой.

2/ Үйлсийн ялгамжаа нь эш зарлигийг сайтар хүртээх, нисваанис болон зовлонг тэвчихээр зорих, илт шамдан бүтээх зэрэг тус тусын үйлсүүд болой.

3/ Сүжгийн ялгаа нь өргөн хүндлэхүй еэ бишрэн хүндлэх, илт үйлдсэнээ бишрэн хүндлэх, ном зохилдонгуй ханьсан нөхөрлөхөд бишрэн хүндлэх тус тус болой.

4/ Бүтээлийн ялгамжаа нь тахих ба өргөн хүндлэх, егүзэрийн явдалд дадаж үйлдэх, ном ба нийтийн төгс эдлэл эд өлгийг тус тус бүтээж үйлдэх болой.

5/ Даган дурдах ялгамжаа нь "энэ мэт ялж төгөлдөр нөгчихсөн тэрээр" хэмээх тэргүүтнээр гурвуулангийн эрдмийг тус тус санах болой.

6/ Буян арвижихын гарсан ялгаа нь бодгаль ба номын эрхэнд үйлдсэн буян нь эрхэм дээдээр арвижина. Бурхан хувраг хоёр нь эхнийх болно. Улмаар нэг болон олон бодгальд шүтсэн буян ч арвижих мөн. Хувраг магадтай дөрөв байвал зохистой.

в) Ам авч аврал одуулах:

"Винайн их тайлбар"-аас айлдсан мэтээр "Бурхан болвоос авралыг заагч, ном болвоос нирваан буюу жинхэнэ аврал, хувраг болвоос авралыг бүтээгч жинхэнэ нөхөр" гэж үзэхийн үүднээс авралыг одуулна.

г) Бусдад үл өгүүлэн авралыг одуулах

Өөрийн болон бусдын (тэрсүүдийн) багш нар болоод ном сургаал, тэдгээрт суралцагч нарын дээд доодын ялгааг таньж мэдээд зөвхөн чухаг дээд гурвыг аврал барина. Энэ гуравтай үл зохилдох багш тэргүүтнийг аврал үл барих мөн. Тэдгээрийн хоорондын ялгаа гэхүл, Багшийн ялгаа нь Бурхан болвоос гэмээ барсан, эрдэм төгөлдөр ажгуу. Харин бусдын багш нар тиймгүй аж.

"Илүү ялгамжаат магтаал" -д:

Би бусад багшийг тэвчээд
Ялж төгөлдөр нөгчихсөн Танаа итгэмой
Яагаад ийн хэмээвээс
Та гэмээс гэтэлж эрдэм төгөлдөр болой хэмээсэн ба

Тэрсүүд бусдын ном сургаал
Ямар болохыг хэдэнтээ тунгаав
Тийн явсаар итгэлт Танаа л
Миний сэтгэл ийн сүсэглэв

Тэр мэт хамгийг болгоож чадаагүй
Тогтсон тааллын гэмээр сэтгэл гэмтсэн
Эргүү буруу үзэлтнүүд
Эндүүгүй багш таныг ч үзэхгүй хэмээжээ.

Номын ялгаа нь Ялгуусадын ном болвоос амгалантай мөрөөр одож амгалантай үрд хүргэх, зовлонгийн хүлээснээс гаргах, муу сэтгэлийг дарах, хуурмаггүй нирваанд хүрэх, үргэлжид буян бүтээх болоод нүгэл хилэнцийг арилгах болой. Тэрсүүдийн ном тэдгээрээс буцсан ажээ.

"Илүү ялгамжаат магтаал"-д

Алин юуны тухайд ч таны ном нь
Амгалангаар амгаланг олох буюу
Ийм л учраас "Өгүүлэгч арслан" таны
Эрхэм номд одсон минь энэ хэмээсэн ба

"Магтөөс зохист сайн магтаал"-д:

Алин орох буюу буцах эсэх
Алин асар гэтэлсэн эсвээс хотол нисваанисаас буюу
Тийм болохоор Баатар таны зарлиг болоод
Бусдын үгийн ялгааг мэдэх

Энэ болвоос гагцаар хоосон чанарт
Тэр болвоос зөвхөн хуурмаг ном тул
Таны зарлиг болоод тэрсүүдийн үгнээ
Түүнээс өөр ялгаа юу олдох вэ

Энэ л гагцаар буян бөгөөд
Тэр л гагцаар зэтгэрт мөн
Таны зарлиг болон тэрсүүдийн үгнээ
Түүнээс өөр ялгаа юу вэ

Тэрбээр дордуулж гутаах
Энэ бээр дээшлүүлж ариусгах буюу

Тийн болохоор Итгэлт таны зарлиг болоод
Тэрсүүдийн үгийн ялгамжаа болой хэмээн айлджээ.

Мөн үүгээр хуврагийн ялгамжааг ч мэдэж чадах болой.

4) Аврал одуулах суртгаалын зэрэг

а) "Хураангуй"- гаас гарсан суртгаал
б) "Увдис" -аас гарсан суртгаал

а) "Хураангуй"-аас гарсан суртгаал:

1. Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг
2. Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг

1. Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг

(а) Дээд төрөлхтнийг шүтэх. Дээр номносон мэт эрхэм сайн буяны садан болвоос хамаг эрдмийн орон гэж үзэж аврал шүтээнд барина. Бурхан дор аврал одуулах гэдэг мөрийг заагчаа аврал болгож барих ёсон буюу. Тэдгээрийг даган зохилдон бүтээл үйлдэх гэдэг мөрийг заагч багшийг бодитой шүтэх явдал билээ.

(б) Дээдийн номыг сонсох ба *(в) Сонссоноо сэтгэлдээ үйлдэх.* Дээд бурхан болоод бурханы шавь Сонсоод сонсогч нарын номносон судрын аймаг тэргүүтний номыг зохих ёсоор сонсож сэтгэлдээ бодож тунгаана. Муу сэтгэлээ буцаах зорилгыг сэтгэлдээ үйлдэнэ. Ном дор авралыг одуулснаар эш болоод онолын номыг илт оножбарих болно.Түүн лүгээ даган зохилдсон бүтээл үйлдэх гэдэг тэр мөн болой.

(г) Номыг даган зохилдож ном бүтээх. Гаслангаас нөгчихсөн номыг даган зохилдууж бүтээх явдал буюу.

Хувраг дор авралыг одуулах гэдэг тонилохуйд зорисон бодгалийг нөхөр болгон барина. Түүн лүгээ даган зохилдон бүтээл үйлдэх гэдэг тонилохуйн тухайд "Оршигч" нартай зохилдон суралцмуй.

2. Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг

(а) Эрхтэнээ үл догшруулах (зоргоор үл тавих). Юм бүхний зүг

эрхтэнээ зоргонд нь тавибаас сэтгэл түүнийг дагаж одно. Ингэж юмс үзэгдэлд сэтгэл зоргоор тэнэхээс сэрэмжилж тийм байдлаас сэтгэлээ татах хэрэгтэй.

(б) Суртгаалын суурийг үнэхээр авах. Бурханы айлдсан цааз суртгаалын суурийг юу чадахаар авах болой.

(в) Амьтаныг энэрэн хайрлах. Бурханы ном нь их нигүүлсэнгүйгээр ялгарна. Түүнээ авралыг одуулснаар амьтаныг энэрэн нигүүлсэх бөгөөд хорлохыг тэвчих болно.

(г) Цаг цагт чухал дээдийг тахихаар хичээх. Өдөр бүр чухаг дээдийг тахиж үйлдэх болой.

б) "Увдис"-аас гарсан суртгаалд хоёр:

1.Тус тусын зургаан суртгаал
2. Нийтийн зургаан сургаал

1. Тус тусын зургаан суртгаал

(а) Гурван хорихуйн суртгаал
(б) Гурван бүтээхүйн суртгаал

(а) Гурван хорихуйн суртгаал

"Ихэд нөгчигч судар"-аас:

Алин гурван эрдэнэ дор авралыг одуулагч
Алин хэн бээр буянаа үнэн шадарлагч буюу
Алин хэзээ ч бусад тэнгэр дор
Аврал одуулж үл болох бөлгөө

Дээдийн ном дор аврал одуулагч
Хорлох хөнөөхийн сэтгэлээс хагацсан мөн
Бурсан хувраг дор авралыг одуулагч ч
Буруу номтонтой үл нөхөрлөх мөн хэмээн айлдсан мэтээр

а/ Бусад тэнгэрт аврал эс одуулах
б/ Амьтаныг хорлох хөнөөхийг тэвчих
в/ Буруу номтонтой үл нөхөрлөх

а/ Ертөнцийн тэнгэр болох Рүдра (Лхадагву), Вишнү (Чавжүг) тэргүүтнийг ашидын авралд барихгүй учраас бирд болох газрын эзэн болон лусыг хэрхэхийг хэлээд яах вэ. Чухаг дээд гурав дор үл итгэдэг тэдгээрт ухаанаа даатгаж болохгүй.

Тухайн үесийн зарим нэг буян номын ажлыг бүтээхэд тэднийг нөхөр болгох төдий буюу. Үлгэрлэвээс амьжиргааны нөхөр болох өглөгийн эзнийг эрэх ба өвчин анагаахын тул оточ эмчийг горилох адил.

б/ Хүмүүн болоод адгуус тэргүүтнийг зодох, цохих, хүлэх, шоронд суулгах, дөрлөх, даахгүй ачааг үүрүүлэх зэргээр санаатай болон үйлдлээр амьтныг хорлох хөнөөхийг тэвчинэ.

в/ Чухаг дээд гурвыг аврал гэж үл итгэмжлэх басамжлан доромжлогч нартай зохилдон эвсэхгүй болой.

(б) Гурван бүтээхүйн суртгаал

а/ Бурханы лагшин дүрийг зурж урлан үйлдсэн, сайхан муухай ямар ч байсан тэдгээрийг муушаах буюу хазгай хэлтгий газар агуулах, барьцаанд тавих зэргээр үл бишрэх, басамжлах явдлыг тэвчиж бурхан адил өргөн хүндлэхийг орон гэж үзнэ.

"Садангийн захидал"-аас:

Хэрхэн бурханы лагшин дүрсийг
Модоор буюу юугаар хийсэн бай мэргэд тахих хэмээн айлджээ.

"Эшийн тийн ялгал"-аас айлдахдаа: "Мангасын хөвгүүн Сэржаа бээр суралцаж буй болон суралцаж төгссөн хуврагуудыг, Үхэр толгойт та нар ном, ном бус гэж юу болохыг мэдэхгүй байж гэх зэрэг арван найман янзаар муушааж хэлсний үрд хоорондоо ижилгүй арван найман толгойтой усны мангас болж төржээ. Тийнхүү Кашияаба (Одсүрэн) бурханы үеэс Шагжа Мүни буюу Бурхан багш хүртэл адгуусны төрөлд байсан" гэжээ.

"Винайн хэсэг эш"-ээс: "Кракучанда (Хорвоо жиг) бурхан нирваан дүр барьсны дараа Карумат (Төгс үзэсгэлэн) хаан нэгэн их суврага босгохоор шийджээ. Гэтэл нэгэн худалдаачин бээр, Том суврага босгоно

гэдэг юу л бол хэмээн хоёр гурван удаа басамжилж гэнэ. Харин хожим нь сайхан том суврага болсныг үзээд урд хэлсэндээ гэмшжээ. Нөгөө худалдаачин алтан хонх авч сувраганд өргөжээ. Үүнийхээ урд тэрээр муухай зүстэй давжаа биетэй ч харин сайхан яруу дуут болж төрсөн" хэмээн айлдсан буй.

Тиймээс лагшин дүр зэргийг тэр нь тийм ийм болой хэмээн үл өгүүлнэ. Бусад хүмүүс лагшин дүр тэргүүтний уг үндэс сайн болоод их хэргийг бүтээж байхад басамжлах дорд үзэх зэргээс буцаж хошуу дүрэх хэрэггүй.

Их егүзэр (Жанчүв Ринчэн) бээр Жовужэ гэгээнд Манзушир бурханы нэгэн шуумал дүр болгоолгохоор өргөжээ. "Энэ хэр зэрэг сайхан болж вэ. Би нэгэн дарханд буян бодож дөрвөн цэн алтаа өргөж бүтээлгэв" гэж айлтгажээ. Жовужэ гэгээнээс: "Манзушир бурханы лагшинаа юунд муу зүйл байх билээ. Урлалын хувьд дунд зэрэг юмуу даа" гээд толгой дээрээ тавьсан гэдэг. Урлаж бүтээсэн бүхэнд энэ мэтээр хүндэтгэлтэй хандахыг өгүүлжээ.

б/ Дөрвөн үгээс дээш алив номыг үл хүндэтгэх зэргийг тэвчинэ. Улмаар номыг барьцаанд тавих, наймаа арилжаа болгох, хазгай муруй газар агуулах, гуталтайгаа нийлүүлж үүрэх, алхаж гишгэх зэрэг үл хүндлэх алив бүгдийг тэвчиж ном чухаг дээд хэмээн бишрч дээдлэн үзнэ.

Гэвш Жан-а-ва бээр судар залж явааг хараад залбиран босоод зогсдог байжээ. Нас өндөр болж босож чадахаа больсон хойноо ч алгаа хавсран залбирсаар байсан гэдэг.

Нэгэн удаа Жову гэгээн өөрөөс нь ном сонсдоггүй нэгэн тарничтай Ари-д тааралджээ. Гэгээн тэр зуур нэгэн бичээч шүлсээрээ ном арчихыг харав. Тэрээр огт тэсэлгүйгээр: "Ээ халаг, Ингэж огт болохгүй, ингэж огт болохгүй" хэмээжээ. Түүнээс хойш нөгөө тарнич ихэд сүсэг орж ном үзсэн гэдэг.

Шарава гэгээн: "Юунд бид номоо тоглоом шоглоом болгож үйлдэнэ. Ном болоод ном өгүүлэгчийг үл хүндлэнэ, үл бишрэнэ гэдэг ухаан цалхайрахын үндэс болдог. Одоо ингэж мунхрахаа болин мэд. Мунхагийн шалтгааныг бүү хураа. Үүнээс цааш мунхарваас юу бүтээх билээ" хэмээн айлджээ.

в/ Хувраг буюу машид гарсан тойн зэргээс эхлээд тэмдэг төдий барьсныг хүртэл үл хорлон, үл басамжлах ба танай, манай хэмээн ялгаварлан дайсан мэт хэзээ ч үзэлгүй хувраг чухаг дээд хэмээн хүндэтгэн үзэх мөн.

"Үлэмж сэтгэлийг айлтгах судар" -аас:

Эрдмийг хүсэн аглагт орших
Бусад тэдгээрийн гэмийг бүү шинж
Би болвоос илүү би болвоос дээд хэмээх ба
Тэр болвоос тийн хэмээхийн сэтгэлийг бүү үүсгэ

Дээрэнгүй гэдэг хамаг сэрэмжгүйн язгуур
Буурай аяга тахимлагийг басамжилж бүү үйлд
Нэг галваар нирваанаас хойшлох буюу
Энэ болвоос энэ номын журам мөн хэмээн зарлиглав.

Алхах газарт алгын чинээ шар өнгийн нөхөөс даавуу тараахад ч алхаж гишгэлгүй, авч сэгсрээд өөд тавьдаг байсан Донбова болон Налжорва гэгээн нарын заншил ёсноос суралцах чухал болой. Би өөрөө хэдий чинээгээр чухаг дээдийг хүндлэх төдий чинээгээр бусад амьтан намайг бишрэн хүндлэх болмой.

"Бясалгалын хаан"-аас:

Юун адилын үйл үйлдвээс
Тэр адилын үрийг олох буюу хэмээн зарлиглажээ.

2. Нийтийн зургаан суртгаал:

(а) Чухаг дээд гурван ялгамжаа болон эрдмийг даган дурдан дахин дахин аврал одуулах:

Дээр номносон дагуу гадаад ба дотоодын ялгамжаа, гурван эрдэнийн инагш чинагшийн ялгамжаа болоод тэдгээрийн эрдмийг дахин дахин санах болой.

(б) Зарлигийн их ачийг дурдан санаж цаг үргэлжид тахихуй яа хичээж идээ ундааны дээжээр тахих:

"Бясалгалын хаан"-аас:

Бурханы буянаар идээг олсон боловч
Нялхас түүний ачийг хариулж үл чадах

хэмээсэн мэт амны идээг олсноор жишин надад сайн амгалан алин гарсан бүгд чухаг дээдийн ач гэж мэдээд ачийг хариулахын сэтгэлээр тахих мөн.

Үүнд: (1) тахиж үйлдэх ба (2) үйлдэхийн сэтгэл хоёр зүйл буй.

(1) Тахиж үйлдэх:

1/ *Лагшин тахих:* Бурханы дүрс лагшинг бодитой тахих болой.
2/ *Суврага тахих:* Бурхан болохын тулд суврага зэргийг тахих болой.
3/ *Илт тахих:* Дээрх хоёрыг өөрийн эрхтэн мэдрэхүйд илт болгон тахих болой.

4/ *Илт бус тахих:* Бурхан болоод түүний суврага илт бус байсан ч бурхан, суврага хамаг бүгдийн тухайд тахих болой. Бурхан гаслангаас нөчихсөн хойно түүний тухайд лагшин дүрс, нэгэн суврага тэргүүтнийг бүтээх нь ч илт бус тахил болой. Тэр хоёрын аль нэгийг тахисан ч болно. Тэдгээрийн нэгийг тахиснаар бүгдийг тахисантай агаар нэгэн болой. Иймээс илт болсон хоёрыг энд тахиж болно. Гурван цагийн хамаг бурхад болон арван зүгийн хязгааргүй олон сувраг тахису хэмээн тахиваас илт бусын тахил болно.

Эхнийх нь агуу их буянт болох, удаах нь түүнээс асар их буянт, гутгаар нь тэдгээрээс үлэмж их буянт болохыг айлджээ. Тиймээс бурхан болон түүний лагшин дүрс ганц нэг зэргийг тахих жам ялгалгүйг санан хамаг бүгдийг тахих санааг сэдвэл хэрэг ихтэй буюу.

5/ *Өөрөө бүтээгээд тахих:* Залхуу, алмай, сэрэмжгүй зэрэг бусдын эрхэнд оролгүй өөрийн гараар дархалж бүтээх мөн.

6/ *Бусдаар хийлгэх тахил:* Өөрт эд юм өчүүхэн бага байвч зовж шаналсан, буян муудсан, буян хийж чадахгүй эдгээр амьтнаар тахил үйлдүүлвээс амгалантай болюу хэмээх нигүүлсэхүй сэтгэлээр бусдыг тахил үйлдүүлэхээр оруулах мөн.

Улмаар шамдан өвөр бусад хоёулаа үйлдвээс өвөр бусад нийтийн

буян болно. Тэр гурван буяны үрийн их бага байх дээрхийн адил болой.

7/ *Олз болон өргөн хүндэлж тахих:* Баринтаг хувцас, амны идээ, сэрүүн өргөө, олбог дэвсгэр, иллэг, сэргээх эм, эд хэрэглэл, суудал, түрхлэг, хүж, цэцгэн эрхис, дуу хөгжим, элдэв зул гэрэл өргөх ба хүндлэн өгүүлэх, мөргөх, илт болох, алга хаврсах, элдвээр магтах, сайшаах, таван гишүүнээрээ мөргөх, нар зөв эргэх, чихний болон мөрний зүүлт зэрэг элдэв чимэг, наанадаж хонх өргөх, мөнгөн чимэг зүүх, хөшиг лавир татах зэргээр бурхад болоод бурхадын сүврага тэргүүтнийг тахих буюу.

8/ *Агуу их тахил:* Олз хүндлэл тэдгээрээр өнө удаан тахих, олон тоот, тансаг сайхан, илт ба илт бус эд зүйлс, өөрөө болон бусдаар үйлдсэн, зүрхний мухраас баясах, хүчтэй сүжигээр тахих тэрхүү буянаа тугуулагсан бурханы хутагт зориулах зэрэг долоо болой.

9/ *Хотол муу сэтгэлийн хиргүй тахил:* Үл тоомсорлох, сэрэмжгүй хандах болон залхууран бусдаар хийлгэх зэргийг огоорон өөрийн гараар урлаж бүтээх, биширч хүндлэх, сэтгэл үл алгасаран үйлдэх, хүсэл шунал үл холих, муу санаа бодол үл төрүүлэх, сүжигт хаад ноёд тэргүүтнээс олз ашиг олюу хэмээн горьдож бурханд үл хандах, зохилдох эдээр тахих зургаа болой.

Зохилдох эд гэдэг нь таарамжгүй бажүг зэрэг сүрчиг болон тосоор тослох, гүгүл үнэртүүлэх, "арга мэдог" зэрэг өргөст цэцэг болой. Ер хэрэглэж үл болох зүйлээс цээрлэх ёстой.

Эд өлгийн тахил тэдгээрийг өөрөө болон бусдаас бүтээж чадахгүй ч гэсэн бурханы тахил болохоор зүйлс ертөнцийн ямар орноо байгаа тэдгээрт баясах ба агуу ихээр төгс сүслэх сэтгэлээр түгээн үйлдэж даган баясваас алжаал багатай, агуу их тахилаар бодь хутгийн буяны чуулганыг төгс хураaж чадна. Улмаар сэтгэл амгалан болж баясгалант сэтгэлээр хичээн туурвих болно.

"Чухаг дээдийн үүлэн" болон *"Гурван тангараг байгуулах"* (Дамцэгсүм годва) зэрэг сударт айлдсанаар "Өөрөө эс барих цэцэг, үр жимс, ой мод, их эрдэнэ зэргээр ч тахиж үйлдэх болой"

10/ *Бүтээлийн тахил нь*: Наанадаж үнээ саах зуурт ч дөрвөн цаглашгүй, номын дөрвөн товчоо, гурван аврал, билиг барамид зэргийг даган дурдана. Гүн гүнзгий хоосон чанар зэрэг сүжиглэх, үл сэжиглэх,

тангараг санваар сахих, бодийн зүг болон билиг барамид, дөрвөн хураангуй зэргийг бясалгаж хичээх болой. Арван тахил эдгээр нь чухаг дээд гурвыг тахих төгс төгөлдөр тахил болой.

Чухаг дээд гурвын алин ялгалгүй эдгээр тахилаар багахан нэгэн тахисан ч хэмжээлшгүй их үр гарах зургаан сэтгэл буй. Үүнд :

1/ Үүнээс дээд эрдмийн орон үгүй хэмээн санах

2/ Үүнээс эрхэм ач тустай зүйл байхгүй хэмээн санах

3/ Хамаг амьтны дээд болой хэмээн санах

4/ Удамбар цэцэг адил маш ховор хэмээн санах

5/ Гурван мянган ертөнцөд зөвхөн ганц гарах тул зөвхөн гагц хэмээн санах

6/ Ертөнцөөс гэтэлсэн, эс гэтэлсэн хамаг хотол чуулганы суурь хэмээн санахын үүднээс тахих мөн. Эдгээрийг *"Бодийн газар"*-аас айлдсан дагуу бичив.

Цаг үргэлжид тэдгээрийг зохих ёсоор үйлдэнэ. Өлзийт сайн цаг, өлзий гийсэн өдрүүдэд өөрийн чадал бололцоогоор сайтар тахиваас зохистой.

Ер хоол унд байнга хэрэглэх шаардлагатай шүү дээ.Тэр цагтаа хоол ундныхаа дээжээр таслахгүй тахиж болно. Чингэж чадваас бага шиг алжааллаар агуу их буяныг хурааж болно. Ийм учраас уснаас эхлээд алин хэрэглэж эдлэх зүйлийнхээ дээжээр чин сэтгэлээсээ тахил өргөж болно.

Гэхдээ хөгцтэй тос ааруул болоод шарласан навч мэтийг бус, харин алин сайнаа өргөх хэрэгтэй билээ. Аяга тагш цай уухдаа ч дээжээ өргөж болно. Харин аяганд орсон тоосыг арилгахаар цацсан бол дээж болохгүй гэж Шарава айлдсан буй.

Үлгэрлэвээс шинэ атар газар тариа тариалахад үр хөрөнгө суулгалгүй зөвхөн хөрсийг хагалаад орхидоггүйтэй адил энэ хойдын хамаг сайн амар жаргалан төрөх эрхэм дээд тариалангийн газарт дөрвөн улирлын турш тасралтгүйгээр сайн амгалангийн үр хөрөнгийг тарьж байх учиртай.

Ингэж сүжгийн андисаар буяны тариалангийн шанг татсугай хэмээн судраас айлдсан ёсоор эс үйлдвээс машид үгээгүй болой.

"Магтваас зохист магтаал"-д :

Тантай адил арилсан орон
Гурван ертөнцөд хаана ч үгүй
Өглөг буяны орны эрхэм Та бөгөөд
Ариун суудлыг баригчийн дээд мөн

Хэмжээ хязгааргүй огторгуйн
Урт өргөний эн жишиг мэт
Танд тус болсон эсвээс ус (хорлол) болсон
Тэдний ач үрийг хэмжиж баршгүй хэмээн айлдсан мэт болой.

Буяны эрхэм орноо эглийн үзэгдэл өчүүхан ч үгүй. Ийм сайн авир бидэнд байхгүй тул цаг үргэлжид чухаг дээдийг тахих ёсноо хичээсүгэй.

Тийн үйлдвээс буяны үндэсийг мэндлүүлэх эрхэм орны хүчээр мөрийн зэргийг ухаарах оюуны чадал дээшлэн дээшлэн одох бөлгөө.

Сонсоод сонсоод үгийг мэдэхгүй, санаад санаад утгыг ухаарахгүй, бясалгаад бясалгаад сэтгэлд буухгүй оюун ухааны чадал машид хомсдсон цагт орны хүчийг түших нь увдис болой.

Тийн болохыг Балданхол бээр:

Яруу үгийг туурвих их хувьт
Танаа түшилдсэнээр миний өтөл ухаан
Зун цагийн ус мөрөн мэт
Зүйргүй ихээр арвижих болвой хэмээсэн мэт болой.

"Тахил өргөнө гэдэг зөвхөн эд өлөг дээр тогтох бус, өөрийн сүсэг дээр тогтоно" гэж айлдсан учир сүсэглэх сэтгэл байваас мандал, ус болоод бүр сэтгэлд баггашгүй тахил зэргийг өргөн тахиж болно. Эд өлөг байхгүй үед тэр адилаар үйлдэж болно.

Харин юмтай хирнээ гаргалгүйгээр: "Би буянгүй их гуйлгачин бөгөөд, тахилын бусад эд надад үгүй" хэмээн өгүүлэхийг Бодова гэгээн: "Хир буртагтай аяганд ганц нэг банбой өвс тавьчихаад зандан гавраар сүрчсэн хүжийн ус хэмээх нь харалган нэгэн бээр хараатай хүний толгойг эргүүлж үйлдэх гэсэнтэй" адил хэмээжээ.

Пүчүнва гэгээн: "Би анхандаа хурц үнэр анхилсан банбой өвс өргөдөг байв. Дараа нь дөрвөн сайн үнэртэнг найруулсан урт хүж өргөв. Эдүгээ агар, дүрүга тэргүүтэн тансаг үнэртнийг өргөж байна" хэмээжээ.

Өчүүхэн тахил гэж чамлаад эс өргөвөөс бүхэл насаараа тийн одох тул багаас эхлэн шамдаж хичээвээс дээшлэн дээшилж одох түүний гарын авлагад суралцах учиртай. Тэрээр нэгэн удаа хорин хоёр лан алтаар хүж найруулан өргөсөн гэдэг.

Эд баялгийг эрхшээсэн их бодисадва нар ч биеэ бумантаа хувилгаж бие тус бүртээ зуу мянган тоотой мутар бясалгаад, хамаг орон дэлхий бүхнээ залран олон тоотой галавт олон бурхадыг тахин үйлдэж байхад "эрдэм номоор дорой, юу ч мэдэхгүй шахам өчүүхэн над мэт бодь хутгийг үл горилно" гэж яриваас номоор хоосорсон дэмий чалчаа үг болох вий.

"Чухаг дээдийн үүлэн"-ээс: "Судрын аймгаас агуу ихээр тахил өргөх, эрхэмлэн хүндлэх ёсыг заасан дагуу сонсож зүрхний мухраас үлэмжийн дээд сэтгэлээр тэдгээрийг бурхан болоод бодисадва нарт зориулах буюу" хэмээн айлдсан мэт үйлдээрэй.

(в) Их нигүүлсэхүйг дурдан санаж бусад амьтныг энэ ёсноо байгуулах. Нигүүлсэхүй сэтгэлийн үүднээс бусад амьтныг ч аль чадлаар аврал одуулах ёсноо оруулах мөн.

(г) Аливаа үйлийг үйлдэх ба хэрэг юу нэгэн гарлаа ч чухаг дээд гурвыг тахиж залбирал талбин ертөнцийн бусад аргыг тэвчих

Ямарваа ажил үйл эрхлэх ба ямар нэг үйл хэрэгт зорихдоо чухаг дээд гуравт даатгана. Тэдгээр лүгээ зохих тахилаар чухаг дээдийг тахина. Харин тэдэнтэй үл зохилдох Бон (бөө удган) зэргийг хэзээд шүтэж болохгүй тул цаг үргэлжид чухаг дээдэд ухаанаа тушааж үйлдээрэй.

(д) Тус эрдмийг мэдээд өдөр шөнөд гурвантаа аврал одуулахад хоёр:

(1) "Хураангуй"-гаас номносон тус эрдэм
(2) "Үвдис"-аас номносон тус эрдэм

***(1) "Хураангуй"-гаас номносон тус эрдэм*:**

а/ Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг
б/ Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг

а/ Эхний дөрвөн зүйлт нэгэн аймаг

Агуу их буян олох талаар: "Үхэшгүй хэнгэрэгийн дуун тогтоол"-д:

Ялж төгссөн бурхад санаанд багташгүй
Дээдийн ном ч санаанд багташгүй
Хутагтан хуврагууд санаанд багташгүй
Санаанд багташгүйд сүсэглэгчдийн
Тийн боловсрох ач үр бүр ч санаанд багташгүй хэмээсэн ба *(1)*

"Хураангуй барамид"-аас

Аврал одуулсан буяныг дүрслэвээс
Энэ гурван ертөнцийн сав ч багадах
Их далайн усны хүү сангаар
Хэмжиж үл чадах хэмээсэн мэт болой.

Баясгаланийн дээд баясгаланг олох талаар: (2)

"Дурдахуйн цоморлиг"-оос:

Хэн хүн шөнө өдөрт
Бурханыг даган дурдах ба
Хэн хүн бурханаа аврал одуулваас
Тэдгээр бүхэн хүний төрлийг олох

хэмээн үлдсэн хоёр дээр ч жишиж болохыг айлджээ. Ийнхүү гурван авралын шүтээнтэй болсондоо би их олз оллоо шүү хэмээн ихэд баярлан бахархах хэрэгтэй. Бясалгал (3) болон тийн арилсныг (4) олно гэдэг бясалгал болоод билгийн суртгаалаар гэтлэх гэдэг болой.

б/ Удаах дөрвөн зүйлт нэгэн аймаг:

1. Их сахиус төгөлдөр болох талаар номносон болой.
2. Буруу зүйлд дурласан түйтгэр нимгэрч бүгд арилан огоот төгс болох: Муу багш, ном, нөхөр зэрэгт сүсэглэн авралд барьсны эрхээр хураасан муу үйл багасан арилана.
3. Эрхэм болох, дээд төрөлхтний тоонд багтана.

4. Бурхан адил ариун явдлаар явах, номд баясагч тэнгэр бурхадын сэтгэлд таалагдах, баяр баясгалантай болно гэдэг их төрөлхтөнд багтаж, бурхад дээдэс баясах болой. Бурхад хэрхэн баярлах хэмээвээс "Хэн нэгэн та нар бидэнд аврал төгөлдөр аврал одуулдаг учир үхэл егүүтгээд энд төрсүгэй. Авралыг олонтаа төгөлдөр одуулсан учир бидний нөхөр болж ирээрэй" хэмээн сэтгэл баясан тухайлан тухайлан өгүүлэх болой.

(2) "Увдис"-аас номносон найман тус эрдэм:

а/ *"Дотоод бурханы номтонд багтах"* гэдэг ер нь гадаад ба дотоод хэмээн томьёолох ёсон олон. Гэвч Жову болон Шантидэва нарын гэгээнтнүүд "аврал одуулснаар ялгана" гэж үзсэн учир аврал одуулах, эс одуулахаар ялгах буюу. Тиймээс бурханы номтонд багтахад юуны түрүүнд чухаг дээд гурвыг зүрхний мухраас багш тэргүүтэн болгож барих хэрэгтэй. Тиймгүй бөгөөс ямар ч буянтан байлаа бурхантанд үл багтах ажгуу.

б/ *"Санваар бүгд төрөх шүтээн болох"*: *"Авхидхармын тайлбар"*-т: "Авралыг одуулагч нар үнэхээр санваар авагчдын үүд болно" хэмээсэн ба "*Авралын далан шүлэг"*-т:

Буянаа шадарлагч гуравт авралт одуулагч
Тэрээр найман санваарын язгуур мөн

хэмээсэн нь аврал одуулснаар тонилохуйн санаа баттай төрөх түүнээс санваар төрнө гэж болгоожээ.

в/ *"Урьд хураасан үйлийн түйтгэр нимгэрэн барагдах"* гэдэг аврал одуулснаар хилэнц нүгэл арилах ёсыг номнох үест *"Суртгаалын хураангуй"*-гаас "Энд гахайны домгийг үлгэр болгох зүйтэй" хэмээсэн буй. Тийнхүү гахайн төрөл авах байсан тэнгэрийн хөвгүүн аврал одуулсны буянаар тэнд төрөөгүй гэх мэтээр аврал одуулснаар муу заяаны муу үндэс шалтгаан арилах болой.

Алин бурханаа аврал одуулагч
Тэдгээр бээр муу заяанд үл одох
Хүний биеийг орхиод тэд
Тэнгэрийн төрлийг олох хэмээн айлджээ.

Ном болоод хуврагад ч аврал одуулваас ийн буюу.Тийнхүү урьд хураасан хилэнц нүгэл нимгэрэх ба бүр барагдах мөн.

г/ *"Агуу их буян хураах"* талаар дээр номносон мэт.
д/ *"Муу заяанд ул унахыг"* дээрхээс мэдээрэй.
е/ *"Хүн болоод хүн бусын ад зүтгэрт үл дийлдэх"* талаар

"Судар"-аас:

Аюулаас айсан хүн бүгд
Их зонхи уул ус, ой цэцэрлэг
Хотол баясалт ба Тахилгат орон
Мод чулуунаа аврал одуулах

Тэр аврал эрхэм бус
Тэр аврал үл гэтэлгэх буюу
Хэзээд хэн нэгэн бээр бурхан,
Ном болоод Хуврагад аврал одуулваас

Зовлонгийн зовлон, хамаг гарахуй шалтгаан
Зовлонгоос үнэхээр гэтлэх бөгөөд
Хутагтын найман гишүүний амгалан болоод
Гаслангаас нөгчихүйн хутагт одох буюу

Хутагтын дөрвөн үнэнийг
Ухаанаар оножмэдэхэд
Аврал одуулах тэр эрхэм бөгөөд
Аврал одуулах тэр дээд мөн

Тэр л авралыг шүтэж гэмээ нь
Хамаг зовлонгоос гэтлэх мөн хэмээсэн мэт болой.

Энэ үест "Салхин цалам бүтээгч тэрсүүд" тэргүүтний домгийг үлгэрт аваарай.

ё/ *"Юу санасан бүгд бүтэх"* гэдэг ном буяны алив ажил бүтээхийн эхэнд чухаг дээдийг тахих ба авралыг одуулан, бүтээхийн соёрхолыг талбиваас амар хялбар бүтэх мөн.

ж/ *"Түргэн бурхан болох"* гэдэг нь *"Арслагийн айлтгал"*-аас: "Сүсэг төрснөөр чөлөөгүйгээс хагацах" хэмээсэн мэт ялгамжаат чөлөөт шүтээнийг олоод, аврал лугаа уулзан, ялгамжаат мөрд суралцах болсноор өнө удалгүй бурханы хутгийг олно. Энэ мэтээр тус эрдмийг санан хоног тутмын өдөр шөнөд гурав гурван удаа аврал одуулж үйлдээрэй.

(е) Чухаг дээд гурвыг наанадаж инээдэм наргианы тухайд эсвээс амь насны тухайд ч орхилгүй сахих гэдэг амь нас, бие махвод, эд хэрэглэл

бүгдээр лавтай барагддаг жамтай. Зөвхөн тэдний төлөө чухаг дээдийг огоорвоос төрөл дутамдаа зовлон дамжин эдлэх тул юу ч тохиолдлоо гэсэн авралаа орхихгүй хэмээн дахин дахин тангараглаж үйлд. Хаашаа ч явлаа гэсэн бурхан дор аврал одуулах ёсноо суралцах хэрэгтэй хэмээн дээдэс айлджээ. Эх сурвалж үзэгдэхгүй байна.

Тэдгээр зургаан суртгаалууд *"Мөрийн зулын тайлбар"*-т гарсан дагуу бөгөөд тус тусын суртгаалын анхны гурвыг судрын аймгаас номносон ба сүүлийн гурвыг *"Авралын зургаан гишүүн"*-ээс номножээ. Ийн хэмээн:

Лагшин дүрс, шүлэг үгсэн тасалбар ба
Шар нөхөөст баринтаг эгэлдэрснийг ч
Сүсгийн үүднээс багш хэмээн үзэх
Амнаас айлдсан бүгдийг

Хоч зүүлгүй толгойдоо барь
Ариун ба ариун бус бодгаль гэж ялгалгүй
Дээд хэмээн үзэх мөн хэмээжээ.

"Нотлон буулгах хураангуй"-гаас номносон тэдгээрийн талаар Гамаба гэгээний зарлигт өгүүлэхдээ: "Ниүсүрва эдгээр суртгаалыг айлдаагүй. Бид хоёр хамтдаа Гонбава багшаас сонссон" хэмээжээ. Тэдгээр суртгаал нь Гонбава багшаас Лүмбава-д дамжсан мөрийн зэрэг гарчээ.

Тэдгээр суртгаалтай харшлан доройтуулах буюу орхих шалтгааны талаар дараах тайлбарыг өгч иржээ. Зарим нэгэн бээр тус тусын суртгаалын эхний гурав болон үргэлжид аврал одуулах, алины тухайд ч үл орхих, чухаг дээдийг тахих лугаа зургаан суртгаалтай харшилваас орхисонд тооцно. Заримууд тус тусын суртгаалын сүүлчийн гурав лугаа харшлах буюу ийнхүү есөн зүйл болсноор орхисонд тооцно. Үлдсэн хэсгийг доройтуулахын шалтгаан гэж үзнэ.

Гэвч амь насны тухайд үл орхих лугаа харшилваас авралыг бодитой орхисон гэж тооцогдоно. Тэрчлэн чухаг дээд гурвыг орхиогүй ч тэдгээр лүгээ үл зохилдох багш тэргүүтнийг хослуулан бариваас бусдад үл өгүүлэх лугаа харшлах ба авралд сэтгэлээ оюунаа даатгаж чадаагүйд тооцогдоно. Тийм байдалд хүрээгүй бол суртгаалтай харшлах төдий гэх бөгөөд орхих шалтгаан бус хэмээн үзнэ.

Ийнхүү аврал одуулах явдал бурханы ном сургаалд орохын их үүд мөн бөлгөө. Үг төдийд бус үнэн зүрх сэтгэлээс аврал одуулахаас гайхамшигт хүч чадал гавьяарах (хамаарах) билээ.

Ингэж чадваас гадаад дотоодын зэтгэрт үл дийлдэх зэрэг ялгамжаатай эрдэм чадал хялбар төрөх ба тэвчээр хатуужил дээш дээш аривжих болой.

Ийм учраас дээр өгүүлсэн мэт айж сэрэмжлэх хийгээд эрдмийг санахын үүднээс авралыг одуулж түүний суртгаалаас үл хэтрэн шамдваас тун их ач тустай бөлгөө.

Үхлийг дурдан санаснаар үхсэний хойно муу заянд төрөх вий гэж айх сэтгэл бий болно. Чухаг дээд гурав болвоос тэрхүү айдас аюулаас гэтэлгэх аврал билээ. Тиймээс түүнийг авралаа болгон барьж суртгаалаас хэтрэлгүй сахиваас зохистой.

Чингэвээс хэрхэн аврах талаар, *"Цоморлиг"*-оос:

Орчлонгийн эвэршээл зовлонг таслагч мөрийг
Би та нарт заасан бөлгөө
Тэрчлэн заларсан бурхад багш буюу
Та бүгдээр бүтээх хэрэгтэй шүү хэмээн айлдсан мэт

Бурхан болвоос авралыг заагч багш бөгөөд хувраг нь аврал бүтээх нөхөр болж ном чухаг дээд нь бодит аврал болох ажгуу. Тэдгээрийг олсон учраас аюулаас гэтэлж чадна.

Эрхэм ном чухаг дээд болвоос үйлийг анхдагчийн үеийн ганц нэг гэмийг тэвчсэн тэвчихүй болон ганц нэг эрдэм төдийг бүтээсэн онол хоёроос үлэмж илүү ялгагдах агуулга онцлогтой. Түүнээс биш өөрөө гэнэт гарч ирсэн бус аа.

Чингээд энэ үест нүгэл буяны үр дагаварыг ухааран мэргэжээд авч орхихыг ёсчлон бүтээх ном нэгийг үйлдэх шаардлагатай болно. Хоёр үйл болоод тэдгээрийн үрийг өнөд санавч авч орхихыг ёсчлон эс үйлдвээс муу заяаны шалтгаанаас буцаж эс чадна. Хэдий муу заяанаас айвч тэр аюулаас гарч чадахгүйд хүрнэ.

Тиймээс хожмын үр дагавар болох муу заяанаас аврагдах гэдэг урьдын үндэс шалтгааны үест сэтгэл нүгэл рүү орохыг засах явдал буюу. Энэ маань үйлийн үрд сэтгэл итгэмжлэх сүсэгт харгалзах учиртай.



ҮЙЛИЙН ҮРИЙГ САНАХ

6. Хамаг сайн амгалангийн язгуур–Сэтгэл итгэмжлэх сүсэг төрүүлэхэд гурав:

1) Үйлийн үрийг ерөнхий санах
2) Өвөрмөц ялган санах
3) Тийнхүү ухаараад орох буцахыг үйлдэх

1) Үйлийн үрийг ерөнхий санах

а) Ерөнхий бодитой санах ёс
б) Тус тус ялган санах

а) Ерөнхий бодитой санах ёс

1. Үйл магадтай ёсон
2. Үйл ихээр арвижих ёсон
3. Үйлдээгүй үйлтэй үл учрах
4. Үйлдсэн үйл үл шамшаагдах

1. Үйл магадтай ёсон:

Эгэл төрөлхтөн болоод хутагтан хэнд ч ялгалгүй, бүр наанадаж тамын амьтнаа сэрүүхэн салхи сэвэлзэх төдийгөөр мэдрэгдэх амгалангаас дээшхи сэтгэл таатай амгалан жаргал бүгдээр урьд хураасан буяны үйлээс төрдөг мөн. Нүглийн үйлээс жаргал төрөх учиргүй ажгуу. *[38]*

Бүр наанадаж Дайснаа дарсан Архад нарын сэтгэлд төрөх таатай бус мэдрэмж төрүүлэх энэлэн шаналангаас дээшхи зовлон бүгд урьд хураасан нүглийн үйлээс төрдөг байна. Буяны үйлээс зовлон төрөх учиргүй ажгуу.

"Их эрдэнийн эрхи"-ээс:

Нүглээс хамаг зовлон
Тэрчлэн хамаг муу заяа болой
Буянаас хамаг сайн заяа болоод
Төрөл тутамд амгалан жаргалан
хэмээн айлджээ.

Тиймийн тулд жаргал болоод зовлон гэдэг учир шалтгаангүйгээр гарах бус, бас Жэ Зову, Ванчиг (вишнү) тэргүүтэн (ертөнцийг бүтээгч тэнгэрс гэгдэх) үл зохилдох шалтгаанаас гарсан бус аа. Нийтийн нүгэл буяны үйлээс нийтийн зовлон жаргал үүднэ.

Зовлон жаргалын элдэв ялгаатай байдал нь ч мөн л хоёр үйлийн элдэв ялгаанаас өчүүхэн төдий ч холилдолгүй тус тусдаа төрнө. Үйлийн үр магадтай буюу хуурмаггүй төрөх энэхүү жамыг таньж мэдэх явдал бурханы шашинтан бүгдийн үнэмлэхүй үзэл хэмээгдэн цагаан зүгийн ном бүгдийн суурь хэмээн сайшаагджээ.

2. Үйл ихээр арвижих нь: [39]

Буяны үйлийг өчүүхэн төдий үйлдэхэд л үрд нь амгалан жаргалан машид их гарна. Мөн нүглийн үйлийг өчүүхэн төдий үйлдэхэд л үрд нь зовлон машид их гарна. Тиймээс дотоод шалтгааны арвижихтай адилаар гадаад шалтгааныг нэмэгдэнэ гэж адилтган тооцож болохгүй.

Ийн хэмээн *"Цоморлиг"*-оос:

Өчүүхэн хилэнцийг үйлдсэн ч
Ертөнцийн чанадад их аюул болоод
Их гутамшигийг тарих буюу
Дотор харвасан хор адил болой

Өчүүхэн буяныг үйлдсэн ч
Ертөнцийн чанадад их амгаланг татах
Их үйл хэргийг ч бүтээх бөгөөд
Үр тариа хотол чуулан боловсрох адил хэмээжээ.

Өчүүхэн үйлээс их хэмжээний үр гарах талаар урьд гарсан домог тууҗид өгүүлснээс магадлах хэрэгтэй. *"Эшийн суурь"*-аас: "Хар зогдорт Гаваа хийгээд түүний таягаар хөнөөгдсөн мэлхий болон таван зуун галуу, загас, яст мэлхий , мөн таван зуун бирд, таван зуун тариачин, үхэр зэргийн домог, бас *"Цэцэн тэнэгийн судар"*-т номносон Алтан тэнгэр, алтан хулгана, үхэр хариулагчийн үлгэрт өгүүлсэн дагуу болой. Мөн *"Лун"*, *"Занлун"*, *"Лай Жава"* тэргүүтнээс магадалж үйлдээрэй.

Бас ёс суртахуун (шагшаавад), зан үйл, амжиргаа болон үзэл онол дөрвөөс сүүлчийн нь доройтуулаагүй хэрнээ эхний гурвыг нь төгс ариун

эс үйлдэн зарим нэгийг нь доройтуулагч нар "лусын төрөлд төржээ" хэмээн айлджээ.

"Жамц бээр айлтгасан судар"- аас: " Ялж төгөлдөр нөгчихсөн! Эрт цагийн эхний галавт миний бие их далайд амьдран суудаг байлаа. Нэгэн цагт Кракучанда бурхан (Хорвоо Жиг) ертөнцөд залрахын үест их далай дотор лус, лусын хөвгүүд, лусын охид маш цөөхөн байлаа. Би ч гэсэн цөөхөн нөхөртэй байв.

Ялж төгөлдөр нөгчихсөн! Эдүгээ их далай тоолж баршгүй олон лус, лусын хөвгүүд, лусын охидоор дүүрэн болжээ. Үүний учир юу вэ, Шалтгаан юу вэ гэжээ. Ялж төгөлдөр нөгчихсөн бээр зарлиг болруун: "Лусын эзэн, Алин тэдгээр сайтар айлдсан Винайн ёсоор хувраг тойн болоод ёс суртахуунаа төгс гүйцэд эс сахисан бөгөөд зан үйлээ доройтуулж, амьжиргаагаа доройтуулж, санваараа доройтуулж төгс төгөлдөр эс бүтээжээ. Харин тэд үзэл онолдоо шударга үнэнч байсан тул тамд төрөлгүй үхэл егүүтгэн лусын оронд төржээ" хэмээн айлджээ.

Тэрчлэн Кракучанда бурхан номоо номнох үед ерэн найман жива тоот, Канакамүни (Сэртүв) бурхан номоо номнох үед жаран дөрвөн жива тоот, Кашяапа (Одсүрэн) бурхан номоо номнох үед наян жива тоот бөгөөд Бабүрний (бидний) Бурхан багш номоо номнох үед ерэн есэн жива тоотой гэргийтэн болоод хуваргууд зан, үйл, амьжиргаа, ёс суртахуунаа доройтуулсны харгайгаар лусад төрсөн ба төрөхөөр болжээ. Бидний бурхан багш гаслангаас нөгчихсний хойно ч "Дөрвөн нөхөр" бээр нүгэл хилэнц хийж санваараа доройтуулваас лусад төрөхийг айлджээ.

Хэдийгээр тэд нарын ажил үйлс зүй бус байсан ч ном дор итгэх сэтгэлээ доройтуулаагүйн буянаар лусаас үхэл егүүтгэн тэнгэр болоод хүмүүн заяанд төрцгөөсөн гэдэг. Сайн цагийн бурхад залрах үед тэдний номоор их хөлгөнийхэн төдийгүй бусад хамаг амьтан бүгдээр гаслангаас гэтлэнэ гэж номножээ.

Иймээс л хар цагаан үйлийн үр хэдий өчүүхэн байсан ч сүүдэр мэт дагаж их жаргал зовлонгийн үндэс болохыг баттай таньж "өөдсийн чинээ ч бай буяныг бүтээх" ба "өргөсийн чинээ ч бай хилэнц нүгэлийг тэвчихээр" шамдаж үйлдээрэй.

"Цоморлиг"-оос:

Огторгуйд халигч шувууд лугаа
Огоот сүүдэр нь хамт одох адил
Сайн муу алин үйлдсэн үйл
Сайхь тэдгээр амьтныг даган одох

Аян замын хүнсээ өчүүхэн төдий базаагчидаа
Алс замд гарахад зовлон учрах буй за
Ашид сайн үйлийг эс бүтээгч
Амьтан тэдгээр муу заянд одох

Аян замын хүнсээ ихэд базаагчид
Алс замд амгалантай одох мэт
Ашид сайн үйлийг үйлдэгч
Амьтан тэдгээр сайн заянд одох хэмээсэн ба

Өчүүхэн багахан нүгэл байлаа ч
Эс хорлох хэмээн басамжилж бүү үйлд
Усны дуслыг хураасаар байж
Ужим сав аажимдаа дүүрэх мөн

Өчүүхэн чинээ хилэнц үйлдсэн юм чинь
Үргэлжлэн хойшдоо ирэхгүй хэмээн бүү санагтун
Усны дусал дусан дуссаар
Ужим савыг дүүргэх адилаар

Өчүүхэн бага багаар нүгэл хураагдсаар
Өчүүхэн нялхсыг эзлэх
Өчүүхэн буяныг үйлдсэн ч
Үргэлжлэн хойшид гарахгүй хэмээн бүү санагтун

Усны дусал дусан дуссаар
Ужим хумхыг дүүргэх адилаар
Өчүүхэн бага багаар буян хураасаар
Өнөд батжин машид дүүрэх мөн хэмээжээ.

"Төрлийн цадиг"-аас:

Буян нүглийн үйлд дадаж сурсаар
Хүмүүн бүхэн түүндээ ижил дасал болох

Тэр мэтээ арилгахаар эс хянах учир
Бусад төрөлдөө ч зүүд адил эдлэх

Өглөг ёс суртахуун зэрэгт сайтар эс суралцваас
Өнгө царай, язгуур угсаа, гоо сайхны эрдэм болоод
Агуу их бяр чадалтай, эд агуурсаар баян хэдий ч
Алин хойд насандаа хэн ч амгаланг үл олох

Язгуур угсаа дорд боловч нүгэлд үл шунах
Ямарваа өглөг, ёс суртахууны эрдэм төгөлдөр аваас
Яалтгүй зун цагийн ус бууж далайг дүүргэх мэт
Яахнаа ч хойд насанд амгалан дэлгэрэх буюу

Буян нүглийн үйлээс л ертөнцийн чанадын
Булт жаргал, зовлон гарна гэдгийг лавтай ухааран
Буянд сайтар шамдан бусармаг нүглийг огоорогтун
Бусад сүжиггүй ардууд хэрхэн хүссэнээр явсугай хэмээжээ.

3. Үйлдээгүй үйлтэй үл учрах: [40]

Жаргал зовлон амсахын үндэс болсон үйлийг хураагаагүй бол тэдгээр үйлийн үрд гарах жаргал зовлонг ерөөс амсахгүй байх учиртай. Бурханы хураасан тоолшгүй их буяны үрийг эдлэгч нар ч гэсэн тэрхүү буяны үндэс бүхнийг хураагаагүй ч нэг хэсгийг хураасан байх шаардлагатай.

4. Үйлдсэн үйл үл шамшаагдах: [41]

Буян нүглийн үйлийг үйлдсэнээр сэтгэлд таатай, таагүй үр дагаварууд үүсч бий болдог. *"Үлэмж ялгамжаат магтаал"*-аас:

Бярманууд буян нүгэл гэдгийг
Авах өгөхийн адил шилжих хэмээн өгүүлэх
Бурхан та бээр үйлдсэн бөгөөс үл шамшаагдах ба
Эс үйлдсэн лүгээ эс учрах хэмээн айлджээ хэмээсэн буй.

"Бясалгалын хаан"-аас:

Тийнхүү үйлдсэн л бол амсахгүй гэж үгүй
Бусдын үйлдсэнийг эдлэх гэж үгүй хэмээжээ.

"Винайн эш"-ээс:

Үйл гэдэг зуун галавт ч
Үл барагдан хуран цуглах буюу
Цаг болохоор амьтан бүхнээ
Үр дагавар боловсрох ямагт хэмээн айлджээ.

б) Тус тус ялган санахуйд хоёр:

1. Арван үйлийн мөрийг голчлон үзүүлэх
2. Үйл болон үрийг нотлон буулгах

1. Арван үйлийн мөрийг голчлон үзүүлэх Тийнхүү жаргал зовлонгийн шалтгаан үр тус тус болохыг ойлгож үйл ихээр арвижих, үйлдээгүй үйлтэй үл учрах, үйлдсэн үйл үл шамшаагдах зэргийг танин мэдсэнээр үйлийн үрийн ёс гэж юу болохыг эхлэн ухаарна.

Чингээд авч орхих ёсон юун хэмээвээс ер нь сайн муу явдалд орох гурван үүднээс хамаардаг. Гурван үүдний хамаг нүгэл буян үйлийн арван мөрд үл багтана. Гэсэн хэдий ч бурхан бээр нүгэл буяны үйлийн ерөнхий буюу гол гол зүйл болон амлашгүй нүглийн их язгууруудыг товчоолон хураангуйлж "Арван хар үйлийн мөр" хэмээжээ. Мөн тэдгээрийг тэвчсэн чухал гол аньсуудыг арван зүйлд хураан "Арван цагаан үйлийн мөр" хэмээн зарлиглажээ.

"Авхидхармакоша"-гаас:

Түүнээс ерөнхийлөн хураавaас
Нүгэл буян алин нэгэн болох
Үйлийн арван мөр болохыг зарлиглажээ хэмээсэн ба

"Эшийн тийн ялгал"-аас:

Хэлээ сахих, сэтгэлээ сайтар хянах
Биеэр нүгэл хилэнцийг үл үйлдэх ба
Гурван үйлийн мөр эдгээрийг машид ариусгаваас
Аршийн айлдсан мөрийг олох буюу хэмээн айлджээ.

Бурхан бээр: "Арван хар үйлийн мөр, түүний үр дагаварыг танин мэдсэнээр тэдгээрийг үүдэх "хотол өдөөлгийг" (анхдагч сэдэл санаа) хүртэл

хааж хорино. Улмаар гурван үүдийг тэдгээртэй хэзээ ч ижилсүүлэхгүй байлгах арван цагаан буяны мөрийг туурвина. Энэ болвоос гурван хөлгөн болон хамаг төрөлхтний хоёр тусыг бүтээх амин чухал суурь мөн" хэмээн олон талаас олон дахин сайшаасан ажгуу.

"Жамцо бээр айлтгасан судар"-аас: "Буяны ном хэмээх тэдгээр нь тэнгэр болоод хүмүүн төрөлхтний хотол чуулган сайн сайхны язгуурын шүтээн болой. Сонсоод сонсогч ба Өөрөө ялгуусадын бодь язгуурын шүтээн болой. Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийн язгуурын шүтээн болой. Язгуурын шүтээн чухам алин хэмээвээс, энэ мэт арван буяны үйлүүд буюу хэмээсэн ба "Лусын эзэн! Үлгэрлэвээс хамаг хот балгад, хот мандал, орон газар, гүрэн улс, хааны орд харш болоод хамаг өвс ургамал, ой мод, навч цэцэг, эмийн ургамал болон хамаг үйлийн түйл хязгаар, хамаг хөрөнгө чуулган, хамаг жимс тариа тарих тариалах, андисаар андислах, хамаг махвод бүгдээр газарт шүтэх бөлгөө. Тэдгээрийн суурь нь газар болой.

Лусын эзэн! Тэр адил арван буяны үйлийн мөр эдгээр нь тэнгэр хийгээд хүмүүнд төрөх, суралцагч, суралцан төгсөгч буянтны үрийг олох, өөрөө ялгуусадын бодь хутаг, бодисадвын хамаг явдал болон бурханы ном бүгдийн орон мөн болой" хэмээн айлджээ.

Тийн учрыг *"Арван газрын судар"*-аас арван хар нүглийг тэвчих шагшаавадыг сайшаасан утгыг *"Мадхямиккаватара"*-гаас ч:

Эгэл төрөлхтөн ба Зарлигаас төрөгсөд
Өөрөө бодь хутгийн мөн чанарыг мэдэгчид болон
Бодисадва нарын магад тонилохуй болон
Өндөр язгуурын үндэс-шагшаавад бусад үгүй хэмээн хураангуйлж айлджээ

Тэр мэт ганц нэг ёс журам байвч мөрдөж биелүүлэхийн санаа гаргаж сахиагүй хэрнээ би чинь "Их хөлгөний хүн" хэмээн өгүүлвээс машид муушаагдах буюу. *"Киштигарбагийн судар"*-аас: "Эдгээр арван буяны мөрөөр бурхан болох учиртай. Хэзээ амьд байх хүртлээ арван буяны мөрөөс нэгийг ч эс сахисан хэрнээ "Би их хөлгөнийх бөгөөд ханьцашгүй туулсан бодь хутгийг эрэлцмүй" хэмээн өгүүлэх тэр бодгаль ёсыг машид цалхайруулагч, ихэд худал яригч, бурхан ялж төгөлдөр нөгчихсөн бүгдийн мэлмийн өмнө ертөнцийг хууран үйлдэгч, тасархай өгүүлэгч мөн буюу.

Тийн мунхарсаар үхэл ирэхэд "буруу зүгт унах болой" хэмээн зарлиглажээ. Буруу зүгт унах гэдэг бүгдээр муу заяаны нэрийн тоонд багтахыг ухаараарай.

2. Үйл болон үрийг дагаварыг нотлон буулгахад гурав:

(а) Нүглийн үйл болон үр дагавар
(б) Буяны үйл болон үр дагавар
(в) Үйлийн бусад ялгалыг үзүүлэх болой

(а) Нүглийн үйл болон үр дагавар:

(1) Бодит нүглийн үйлийн мөрүүд
(2) Хүнд хөнгөний ялгаа
(3) Тэдгээрийн үр дагаварыг үзүүлэх

(1) Бодит нүглийн үйлийн мөрүүд:

1. Амь таслах : Амь таслах гэж юу вэ. Үүний талаар *"Хураангуй"*-гаас суурь, хуран мэдэхүй, санаа, нисваанис, төгсгөл гэсэн таван зүйлээр айлдсан байдаг. Гэхдээ дунд гурвыг санаанд багтааж үйлдлийг нэмбээс *Суурь, Санаа, Үйлдэл, Төгсгөл* гэсэн дөрөв зүйлд хураан номлохуй яа ухаарахад хялбар бөгөөд утгатай үл харшлах болой.

а) Амь таслахын суурь: Амь нас төгөлдөр амьтан байна. Харин алуурчин өөрөө амиа хорлох нөхцөлд бэлтгэлтэй нүгэл болох ч төгсгөл нь тодорхой бус байдаг. Үүнийг болгоон *"Егүзэрийн явдлын газар"*-гаас: "Гадны амьтан" буюу "бусад" гэж тодорхойлсон буй.

б) Санааны хувьд хуран мэдэхүй, нисваанис, хотол өдөөлгө гурав буй. "Хуран мэдэхүй" түүнээ :

і Суурь амьтныг амьтан гэж хуран мэдэхүй
іі Түүнийг амьтан бус гэж хуран мэдэхүй
ііі Амьтан бусыг амьтан бус гэж хуран мэдэхүй
іv Амьтан бусыг амьтан гэж хуран мэдэхүй

Эдгээрээс эхний болон гутгаар нь эндүүрэггүй байх, хоёрдугаар

болон дөтгөөр нь эндүүрэг болно. Зарим тохиолдолд эдний "хотол өдөөлгө" буюу үүдэх шалтгаан нь өөр өөр байдаг. Үлгэрлэвээс, зөвхөн Дэвадаттаа (Лхайжин)-г ална хэмээн бэлтгэлээ базаасан хэрнээ эндүүрээд Важна даттаа (Чоджин)-г алах нөхцөлд бодит сууртай нүгэл болохгүй. Тиймээс хуран мэдэхүй магадтай эндүүрэггүй байх хэрэгтэй.

Үйлдэх үест ялгаагүй, ер нь алах сонирхол байсан бол хуран мэдэхүй эндүүрэггүй байх шаардлагагүй. Энэ ёсыг үлдсэн есөн үйлүүдэд алин зохихоор тааруулж мэдээрэй.

"Нисваанис"-ын хувьд гурван хорын аль нэгэн болой. "Хотол өдөөлгө" нь алах хүсэл болой.

в) Үйлдэл. Үүнд үйлдэгч болон үйлдэх хэлбэр байдал гэсэн хоёр зүйл буй. Үйлдэгч нь өөрөө үйлдэх буюу бусдаар үйлдүүлсэн ч байсан ялгаагүй адил. Үйлдэхийн байдалд мэс, хор арвис тарнийн үүднээс үйлдэх тэргүүтэн аль нэгнээр болой.

г) Төгсгөл. Энэхүү үйлдлийг гүйцэтгэснээр нөгөө амьтан энэ цагт буюу өөр цагт үхсэн байх ёстой.

"Авхидхарма"-гаас:

Өмнө эсвээс хамт үхвээс бодит бус
Өөр төрөл авах учраас болой
хэмээн айлдсан нь энд ч мөн адил болой.

2. Хулгай хийх (өгөөгүйг авах): а) Бусдын төгс эзэмшиж байгаа эд хэрэглэлүүд хулгайн үйлдлийн суурь болдог.

б) Санаанд гурван зүйл байхаас хуран мэдэхүй болон нисваанисууд дээрхтэй адил.

Хотол өдөөлгийн хувьд зөвшөөрөөгүй байхад бусдаас салгаж авах сонирхол болой.

в) Үйлдлийн хувьд үйлдэгч эзэн урьдын адил. Үйлдлийн байдал хэлбэр нь хүчээр булаах ба далдуур хулгайлж авах зэрэг болой. Мөн зээлэх, гүйх, мэхлэх, залилах зэрэг бусад аргаар хулгайлна. Өөрийн болон бусдын тухайд буюу эсвээс бусдыг хорлохын тухайд үйлдсэн ч адил хулгайд тооцогдоно.

г) Төгсгөлийн талаар “Хураангуй”-аас: “ Өөр газарт шилжүүлэх болой” хэмээсэн буй. Энэ утгыг олон янзаар тайлсан ч эд хэрэглэлийг бусад газарт шилжүүлэхийг утгаар хэлсэн нь жишээ төдий юм. Тариалан гэх мэт зүйлийг газар нутгаас шилжүүлж болохгүй учир эцэстээ орхиход хүрэх нь ээ.

Тиймээс гол нь “олоод авлаа шүү” гэдэг бодол төрснөөр дээд цэгтээ хүрнэ. Булаачихлаа юм уу хулгайлчихлаа гэх бодол төрснөөр ч гүйцэж болно. Үлгэрлэвээс өөрөө мэдэхгүй хэдий ч захиалгаар бусдыг хөнөөлгөсөн ч байсан нөгөө хүн үхэнгүүт аллага захиалагч өөрөө бодитой суурийн нүгэл хураадагтай адил буюу.

3. Буруу явдал: а) Суурь. Түүний суурьд явалдах зохисгүй, гишүүн бус, орон бус болоод цаг бус дөрөв болой.

Явалдах зохисгүй эмэгтэй, эрэгтэй болон манингууд багтана. Тэдгээрээс эмэгтэйн талаар *“Хураангуй”*-аас: “Эх тэргүүтэн болон эхийн анхаарал халамжинд байгаа зэрэг хэмээн судраас заасан этгээдүүд явалдах орон бус хэмээсэн болой” хэмээжэ.

Тэр утгыг *Ловон даян бээр:*

Явалдан үйлдэх бус хэмээх нь
Бусдын барьсан ба номын дуазат (тэмдэгт)
Язгуураас сахисан, хаан бээр сахисан
Бусдын авсан татвар эм

Хамаатан садан, ах дүүс буюу
Тэдгээр явалдах орон бус аа хэмээн айлдсан мэт болой.

“Бусдын барьсан” гэдэг бусдын эхнэр болой. *”Номын дуазат”* гэдэг эмэгтэй хувраг болой. *”Язгуураас (гэр бүлээр) сахисан”* гэдэг хадамд гараагүй эмэгтэй болон өөрийн эцэг тэргүүтэн хамаатан садан, хадам эх эцэг, бараа бологч нар сахисан эс бөгөөс өөрөө өөрийгөө сахисан болой.

“Хаан болоод тушаалаар сахих” гэдэг түүнийг хорьсон цааз журам болой. Татвар төлж авсан бусдын татвар эмтэй явалдвал буруу явдалд тооцогдоно гэж айлджээ. Харин өөрөө үнэ төлсөн бол буруу явдал болохгүй гэжээ. Жовужи гэгээн ч мөн энэ адил айлдсан буй.

Удаах утга буюу *"явалдах зохисгүй эрэгтэй"* гэдэг нь өвөр бусад хоёр эр болой. *"Гишүүн бус"* гэдэг умайн үүднээс бусад гишүүн болой.

Ашвагоша багш (Ловон Даян) бээр:

Гишүүн бус алин хэмээвээс
Ам, хошного, шилбэ,
Гуя ташаа, гараар оролдох хэмээжээ.

Мөн Жовужи бээр: "Гишүүн бус нь ам болоод хошного, охин хөвгүүн зэрэг нялх балчир хүүхдийн дэргэд, урд хойд сүв, өөрийн гар болой" хэмээсэнтэй таарах буюу.

"Орон бус"-ын хувьд Багш тэргүүтний дэргэд, суврага шүтээн болон олон хүний нүдэн дээр ил задгай явалдах, тэр үйлдэлд хорлолтой хазгай муруй, хайрга чулуутай газар зэрэг болно. *Ашвагоша багш бээр:*

Орон бус гэж тооцогдох түүнээ
Дээдийн ном, суварга шүтээн тэргүүтэн
Мөн бодисадвын орших орон газар болон
Оронгийн эзэн, багш дээдэс,

Эх эцгийн дэргэд болвоос орон бус учир
Тэдгээр орноо үл үйлдэх болой хэмээжээ.

Жову гэгээн ч тэр адилаар айлдсан байна. *"Цаг бус"* гэдэг нь сарын тэмдэг буусан үе, төрөх сар гүйцсэн хөл хүндтэй эмэгтэй, нялх хүүхдээ хөхүүлэх үе, нэг хоногийн сахил сахиж буй үе, хурьцаж үл болох өвчтөй зовлонтой үе болон хэмжээнээс хэтрүүлэх болой. Хэмжээ нь тав хүртэл болой. *Ашвагоша багш бээр:*

Цаг бус хэмээх түүнээ
Сарын тэмдэг буусан ба жирэмсэн
Нялх хүүхэдтэй, үл хүсэх,
Өвчин зовлонтой, сэтгэл таагүй үе болон

"Найман гишүүнт нэг хоногийг сахигч" зэргүүд цаг бусын орон мөн хэмээжээ. Жову гэгээн мөн энэ адилд үзсэн ба ялгаа нь өдрийн цагийг ч цаг бус хэмээжээ.

"Гишүүн бус" зэрэг гурвыг өөрийн эхнэр дээр ч үйлдвээс ялгалгүй буруу явдал болно гэж үзэх тул бусдыг хэлэх хэрэг юун.

б) Санааны хувьд гурван зүйл буй. Хуран мэдэхүй талаар *"Хураангуй"*-гаас: "Түүнийг тэр шүү хэмээн" хуран мэдэхдээ эндүүрэггүй байх хэрэгтэйг айлдсан буй.

"Винай"-гаас: "Ариун бусын унал алдаанд чухалд эндүүрэх, эс эндүүрэх хуран мэдэхүй ялгаагүй" хэмээжээ. *"Авхидхармын тайлбар"*-т: "Өөрийнх мөн хэмээх хуран мэдлээр бусдын эхнэрийн дэргэд одвоос үйлийн мөр болохгүй. Бусдын эхнэрийг бусдын хэмээх хуран мэдэж одвоос урвах, эс урвах хоёр ёс буй" гэж номножээ.

Нисваанис нь гурван хорын аль нэгэн болно. Хотол өдөөлгө нь ариун бусын явдлаар явалдахын хүсэл болой. в) Үйлдлийн талаар *"Хураангуй"*-гаас: "Бусдыг буруу явдалд оруулахад ч оруулагч өөрөө буруу явдлын нүглийг хураана" хэмээн айлджээ.

"Авхидхармагийн тайлбар"-аас: "Тэр адилаар бодит суурийн үйлийн мөр болохгүй гэж айлдсан ч, түүний өмнөхийг бодит суурьд багтахгүй гэм гэж болгоосон юм болов уу шинжээрэй. г) Төгсгөлийн хувьд хоёр эрхтэн хоёулаа нийлэлдэх болой.

4. Худал өгүүлэх: а) Худал өгүүлэхийн суурь: Үзэх, сонсох, өвөрмөц ялгах, тийн мэдэх дөрөв ба тэдгээрээс буцааж өгүүлэх дөрвөн буй. Ухаарах орон гэдэг бусад хүн утгыг ухаарах явдал.

б) Санаанд гурван зүйл: Хуран мэдэхүйд үзсэнээ үзээгүй гэж урвуулах, үзээгүйгээ үзсэн гэж хуран мэдэхүйг урвуулах зэрэг болой.

Гурван нисваанис буй. Бүхэн өдөөлгө нь бодол санааг урвуулан өгүүлэх хүсэл сонирхол буюу.

в) Үйлдлийн хувьд ярих хэлэх, эсвээс юу ч үл өгүүлэн зөнд зөвшөөрөх маяг гаргах, биеэ хөдөлгөх зэргийн дохио зангаагаар илэрхийлж болно. Өөрийн болон бусдын тусын тулд юу ч өгүүлсэн бай адилхан болой. Энэ үест худал ярих, хов зөөх, ширүүн үг хэлэх гурвууланг захиалж бусдаар үйлдүүлсэн байсан ч яг тэр адилын гурван үйл хураахыг айлджээ.

"Авхидхармагийн тайлбар"-аас "Хэлний дөрвийг захиалж үйлдүүлсэн ч үйлийн мөрд тооцно" гэж айлджээ. *"Винай"*-гаас "Тэдгээрийн эцэст унал гарахад өөрөө өгүүлсэн байх" ёстойг айлдсан байна.

г) Төгсгөлийн хувьд нөгөө этгээд ухаарч ойлгосон байх явдал бөлгөө. "Эс ойлговоос чалчаа үг төдийд одно" гэж *"Авхидхармагийн тайлбар"*-аас айлджээ. Энэ нь хов ярих болон ширүүн үгэнд ч адил болой.

5. Хов ярих: а) Хов хэлэхийн суурь нь эвтэй, эвгүй хүн амьтан болой. б) Санаанд гурван зүйлээс хуран мэдэхүй болон нисваанисууд дээрхийн адил болой. Хотол өдөөлгийн хувьд эв найртай амьтныг салгах болон эвгүй амьтныг эвлүүлэхгүй хэвээр байлгах хүсэл сонирхол болой. в) Үйлдэхдээ худал үнэн ямар нэг юм ярих, сайхан муухайгаар хэн нэгийг хэлэх ба өвөр бусад хэн нэгний тусын тулд өгүүлэх буюу г) Төгсгөлийн талаар *"Хураангуй"*-гаас айлдахдаа "Салгаж үйлдсэнээ тийн мэдэх болой" хэмээсэн бөгөөд салгах үг хэлснээ ухаарах явдал ажээ.

6. Ширүүн үг хэлэх: а) Түүний суурьд хөнөөх сэтгэлийг лавтай төрүүлэх амьтан болой. б) Санааны хувьд хуран мэдэхүй болон нисваанисууд дээрхийн адил болно. Хотол өдөөлгө нь ширүүн үг хэлэх хүсэл сонирхол болой. в) Үйлдэхдээ ямар нэг худал үнэн таагүй зүйл ярих, язгуур угсаа, бие махвод, ёс суртахуун, явдал мөр зэрэгт тохиолдсон алдаа эндэлээр өөнтөглөн эвгүй муугаар хэлэх болой.

г) Төгсгөлийн талаар *"Хураангуй"*-гаас айлдахдаа: "Төгсгөл нь түүнээ ширүүн үг өгүүлсэн болой" хэмээжээ. Эл утгыг "Ширүүн үг сонссон этгээд ойлгосон байх хэрэгтэй" гэж *"Авидхармын тайлбар"*-т өгүүлжээ.

7. Чалчаа үг ярих: а) Чалчаа үгийн суурьд хэрэггүй, утгагүй орон багтана. б) Санаанд гурваас: Хуран мэдэхүйн хувьд *"түүнээ тэр хэмээх хуран мэдэхүй"* төдийгөөс цааш айлдаагүй болно.

Энэ үест *"хэлэх гэсэн тэр утгаа тэр хэмээн мэдээд"* өгүүлэх боловч энэ нь заавал ухаарах (утгатай) орон байх шаардлагагүй. Нисваанис дээр дурдсан гурвын алин нэг байна. Хотол өдөөлгө нь утга учиргүй, дэмий хоосон ярих хүсэл сонирхол. в) Үйлдэхдээ чалчаа үг яриаг өгүүлэх болой. г) Дэмий үг яриагаа дуусгахаар төгсгөл ирнэ. Тэрээр доорх долоон зүйлээр төгс илэрхийлэгдэнэ. Үүнд :

1/ Хэрүүл хийх, хориг уудлах, маргах, яс хаях зэргээр өгүүлэх;

2/ Мөн тэрсүүдийн шастар буюу бярманы тарнид баясах, сэтгэлээр эш ном авах, амны уншлага хийх зэрэг;

3/ Ядарсан дуугаар гаслах, хашгирах;

4/ Инээж тохуурхах, зугаа цэнгэл хийх, хөөрч сагсууран өгүүлэх;

5/ Хаад түшмэд хийгээд улс гүрэн, хулгайч дээрэмчний тухай домог хүүрнэх зэргээр хур үймцээний үг ярих;

6/ Согтуу галзуу мэтээр ярих;

7/ Буруугаар амьдрах хэн нэгнийг ярих болой.

Хоорондоо холбоогүй, номт бус, утгат бусыг өгүүлэх гэдэгт урд хойдын барилдлагагүй, хотол нисваанис муу сэтгэлийг заасан болон инээдэм наргиан, дуу хуур, бүжиг жүжиг үзэхийн үесийн яриа зэрэг багтана. Эхний гурван чалчаа үгэнд хэлний гэм гарах, гарахгүй хэмээдэг хоёр ёс бий ч энд урьд өгүүлсэнтэй тааруулан номнов.

8. Хомхой сэтгэл: а) Хомхой сэтгэлийн суурь нь бусдын эзэмшсэн эд эдлэл хөрөнгө баялаг болой. б) Санаанд гурваас: Хуран мэдэхүй нь "тэр зүйлээ тэр мөн" хэмээн мэдэх болой. Нисваанис нь гурвын алин нэг болой. Хотол өдөөлгө нь өөрийн болгох хүсэл эгээрэл буюу. в) Үйлдэл нь санасан хэргээ гүйцээхээр хичээх явдал. г) Төгсгөлд хүрэхдээ "Тэдгээр минийх боллоо хэмээн мэдэх" буюу "эд баялаг тэргүүтэн минийх болтугай" хэмээх болой. Тийнхүү хомхой сэтгэл төгс гүйцэхэд таван зүйл бүрэлдэх ёстой. Үүнд:

1/ Өөрийн төгс эдлэлдээ улэмж шунах сэтгэл төгөлдөр байх;

2/ Төгс эдлэл хөрөнгө хураах сувьдаг сэтгэл төгөлдөр байх;

3/ Бусдын эд баялгийг сайхныг мэдэрч шүлсээ гоожуулах сэтгэл төгөлдөр байх;

4/ Бусдын аливаа бүхэн минийх болтугай хэмээх атаархах жөтөөрхөх сэтгэл төгөлдөр байх;

5/ Хомхой сэтгэлээс болж ичиж зовохоо больж ямар гэм буруу гарахыг үл ухаарах мунхагийн сүрд дарагдсан сэтгэл төгөлдөр эдгээр болой. Энэ таван сэтгэлийн аль нэг эс бүрдвээс хомхой сэтгэлийн бэлэг чанар бүрдэхгүй.

Эдгээр таван сэтгэл арван нүгэл бүгдэд буй гэж *"Егүзэрийн явдлын газар"*-т айлджээ.

Төгөлдөр бус хомхой сэтгэл болоход:

а) “Аяа, Гэрийн эзэн, ноён бүгд миний боол болж хүссэнээр минь болвоос юун сайн” хэмээх; б) “Түүний хөвгүүд, эхнэр болон идээ зоог, эд баялаг зэрэгт мөн ийнхүү санах”; в) “Аяа, Намайг хүсэл шунал багатай, аглаг холд одож хичээнгүйг туурвих, олныг сонсох, өглөгийн ахуй ёст зэргийг бусад мэдвээс юун сайн” хэмээх ба; г) “Намайг хаан, сартваахь, дөрвөн нөхөр бээр өргөн хүндлэх ба хоол хувцсыг олвоос юун сайн” хэмээх ба; д) “Аяа, би хойд насандаа тэнгэрт төрөөд хүслийн таван идээгээр цэнгэн Дагву ба Вишнү тэнгэрийн орноос “Бусдын хувилгаан шидийг эрхшээгч” (Шанпрүл ванжид) тэнгэрт төрөх болтугай хэмээх хүслийг төрүүлэх” ба; е) “Эцэг, эх, хөвгүүн, эхнэр, боол тэргүүтэн болон ариун явдалтны эзэмшсэн төгс эдлэлд шунах” зэргээр шүлхийтэн шунах сэтгэлүүд болой.

9. Хорлох сэтгэл: а) Хорлох сэтгэлийн суурь, б) хуран мэдэхүй, нисваанис гурав нь ширүүн үгийнхтэй адил. Хотол өдөөлгө нь зодох цохих зэргийг хүсэх бөгөөд алах, хүлэх, бусдын төгс эдлэл баялаг аяндаа доройтвоос юун сайн хэмээх тэргүүтэн болой

в) Үйлдлийн хувьд тэр санаагаа ажил болгон гүйцээх явдал болой. г) Зодох нүдэх зэргээр лавтай гүйцэтгэх нь төгсгөл болой. Түүнээ таван зүйл бүрдвээс төгсөх ба эс бүрдвээс эс төгсөх болно. Үүнд:

1/ Хорлохын шалтаг болгосон тухайн зүйлийг үнэн шалтагт барин уурлах

2/ Хорлол гарахад үл тэсэх тэвчээргүй сэтгэл

3/ Дахин дахин ёс бусаар хилэгнэх сэтгэл төрүүлэх шалтгийг сэтгэлдээ хадгалах өс хонзонгийн сэтгэл

4/ Зодох болоод алах болвоос юу сайн хэмээх шунахайрах сэтгэл

5/ Хорлох сэтгэл төрөхөд ичгүүргүй бөгөөд ямар гэм гарахыг үл мэдэх сэтгэлээр дарагдсан сэтгэл тав болой.

“Хорлох сэтгэл төдий” гэж “Энэ намайг хорлох байх” гэх буюу “хорлож байсан” хэмээгээд түүнийг хорлохын тухайд юу нэгийг санах тэр бүгдээр хорлох сэтгэлд тооцогдоно. Түүнчлэн бусдын садан төрөл, төгс эдлэл, буян тэргүүтэн энэ насанд доройтог хэмээн ерөөх ба хойд насандаа муу заяанд одоосой хэмээн ерөөх нь ч хорлох сэтгэлд багтана.

10. Буруу үзэл: а) Буруу үзлийн суурь нь "буй хэмээх барих" болой. б) Санаанд гурваас. Хуран мэдэхүй нь басамжлах (дорд үзэх) утгыг үнэн хэмээн хуран мэдэх болой.

Нисваанис нь гурвын аль нэг болой. Хотол өдөөлгө нь басамжлах хүсэл сонирхол болой. в) Түүнээ дөрвөн зүйл бөгөөд үндэс шалтгаан, үр дагавар, үйлдэл болон буй зүйлийг басамжлах мөн.

i Үндэс шалтгааныг басамжлах гэдэг сайн (буян), муу (нүгэл) явдал зэрэг байхгүй хэмээн үгүйсгэн үзэх ;

ii Үр дагаварыг басамжлах гэдэг тэр хоёрын тийн боловсрол (үр) байхгүй хэмээх болой.

iii Үйлдсэнийг басамжлахад гурваас:

а/ Хөрөнгө тавих ба барихыг басамжлах нь эх эцэг байхгүй хэмээх;

б/ Ирж очихын үйлдлийг басамжлах нь хойд, урд төрөл байхгүй хэмээх;

в/ Төрөх үйлдлийг басамжлах нь хувилгаан төрөл байхгүй гэх болой.

iv Дайснаа дарсан (архад) зэргийг үгүйсгэх зэрэг нь буй зүйлийг үгүйсгэн басамжлах болой. г) Басамжласнаа мэдсэнээр буруу үзэл эцэстээ буюу дээд цэгтээ хүрнэ. Энд таван сэтгэл төгс байх ёстой.

1/ Мэдэгдэхүүний ахуй ёсыг үл мэдэх мунхагийн сэтгэл;

2/ Нүгэл хилэнцэд баясах хүчирхийлэх сэтгэл;

3/ Ёс бусын номыг ухааран үргэлж буруудд зүглэх сэтгэл;

4/ Өглөг өгөх, тахил өргөх галын тахилга зэрэг сайн явдал байхгүй зэргээр басамжлан машид доройтуулагч сэтгэл;

5/ Тэрхүү буруу үзлийн эрхээр ичиж зовохоо больж ямар гэм гарахыг ч үл мэдэх зэргээр сүрт дарагдсан сэтгэл болой. Эдгээр таван сэтгэлтэй төгөлдөр болой. Эдгээр тав эс бүрдвээс эс төгсөх болно.

Мөн эдгээрээс өөр буруу үзлүүд бий. Гэхдээ зөвхөн үүнийг буруу үзэл гэсэн нь энэхүү үзлээр буяны ном бүхнийг тасалж нүгэл бүгдийг дураараа үйлдэх буруу үзэл бүгдийн гол нөхцөл болдог учраас ийн энд өгүүлсэн билээ.

Тэдгээр арван хар нүглийн хувьд амь таслах, ширүүн үг хэлэх, хорлох сэтгэл гурвуул гурван хороор туурвигдах бөгөөд уур хилэн тэдгээрийг гүйцээж дээд цэгт нь хүргэнэ. Хулгай, буруу явдал, хомхой сэтгэл гурвуул

нөгөөх гурван хороор туурвигдах бөгөөд зөвхөн шунал хүсэл тэднийг дээд цэгт нь хүргэдэг байна. Худал хэлэх, хов ярих, чалчаа үг гурав дээр туурвих болон гүйцээж төгсгөх хоёуланд гурван хорын хувь оролцоно. Буруу үзлийн хувьд гурван хороор туурвигдан зөвхөн мунхагаар гүйцэж төгсдөг байна.

Тэдгээрээс санаа нь үйл болохоос үйлийн мөр болохгүй. Бие сэтгэлийн долоо нь үйл ч болно. Мөн санаа оршихийн суурь мөн учраас үйлийн мөр ч болдог. Хомхой сэтгэл тэргүүтэн сэтгэлийн гурав нь үйлийн мөр мөн болов ч үйл болдоггүй.

(2) Хүнд хөнгөнийг үзүүлэхүйд хоёр:

а) Үйлийн арван мөрийн хүнд хөнгөний ялгаа
б) Дашрамд хүнд үйлийн суурийг хураангуйлан үзүүлэх

а) Үйлийн арван мөрийн хүнд хөнгөний ялгаа: Энд үйлийг хүнд болгодог таван хүчин зүйл буй. Амь таслах үйл дээр үлгэрлэвээс:

i Санааны үүднээс хүнд болох: Гурван хороор хүчтэй хатуу үйлдэх буюу.

ii Үйлдэл ажлын хувьд хүнд болох: Амьтны амь тасалж байсан, тасалж байгаа, таслах болсон зэрэгтээ маш их баяр баясгалангийн сэтгэлтэй өөрөө үйлдэх болно.

Мөн бусад этгээдийг магтаж сайшаан тийм нүгэл хийлгэх,тийн нүгэл хийхийг хараад сэтгэл хөөрөх, өнө удаан санан санан үйлдэх, үргэлжид тэр ажлыг хүндлэх зэрэг болно. Нэг удаа үйлдэхдээ олноор цааш харуулах, ихэд тарчлааж зовоож гаргах, айлгаж сүр үзүүлж ёс бусаар хөнөөх, тамирдуулж ядраах, өлсөөж цангаах, хэлмэгдэгч амьтан цөхрөнг бартал орь дуу тавих, өршөөл энэрэл хүсэн гаслан уйлуулах зэргээр алах нүглүүд багтана.

iii Ерөндөг байхгүйгээс хүнд болоход ганц өдөр ч суртгаал авахгүй явах ба сарын хугас болон шинийн найман, арван дөрвөн, арван таван зэрэг өдрүүдэд нэг хоногийн сахил сахих, үе үе өглөг өгөх, буян хураах, ном сонсох, эргэл мөргөл хийх, бясалгалд суух, залбирах сүслэх сэтгэл үл үйлдэх зэрэг болой.

Мөн цаг цагт нүглээсээ айдаг ичгүүртэй, сонжуууртай бас ихэд гэмших зан чанар олоогүйгээс болон ертөнцийн шунал хүслээс хагацах мөрийн номыг оножухаараагүйгээс болой.

iv Буруугаар илт шунаснаас хүнд болох: Элдэв тахилга үйлдэгч нарын үзэлд автан буян хүсэхнээ аллага үйлдэх ба мал адгуус болвоос ертөнцийн эздийн эдлэгдэхүүн учраас алахад нүгэл болохгүй гэх мэтээр үздэг буруу үзэл баримтлалыг даган хөнөөх болой.

v Сууриас шалтгаалж хүнд болох: Том биетэй амьтан адгуус, хүн, хүний үр хөврөл, эх эцэг, ах дүүс, багш, өвөг дээдэс, номд суралцагч нар, Бодисадва, Дайснаа дарагчид, Өөрөө ялгуусад тэргүүтнийг алах болон Бурханыг егүүтгэж болохгүйг мэдсээр хэрнээ муу санаагаар цус шунх гаргах зэргээс хүнд болно.

Эдгээр таван шалтгаанаас уршигдаагүй нөхцөлд хөнгөн амь таслах нүгэлд тооцогдоно. Үлдсэн есөн нүглийн хувьд сууриас бусад дээр амь таслах нүглээр жишээлж хүнд хөнгөний ялгааг мэдээрэй.

Сууриас шалтгаалж хүнд болох, хулгайн үйлд олон юм авах, сайныг шилж авах, хүний итгэлээр тоглож мэхэлж авах, булааж авах, доорд ядуус, гуйлгачин, хувраг тойд зэргээс булаах, дээдэс болон суралцагч, дайснаа дарагчид, өөрөө ялгуусад, буянд шадарлагч нар болон суврага шүтээний эд зүйлийг булааж авах нүглүүд багтана.

Сууриас шалтгаалж хүнд болох буруу явдлын нүгэлд явалдах ёсгүй эх болоод түүний хамаатан төрлүүд, хүний хайртай эхнэр, гэлэнма, гэцүлма буюу эмэгтэй санваартан лугаа хэвтэх; гишүүн бусыг ам руу хийх; цаг бусын буюу нэг хоногийн санваар сахих үе, хөл хүндтэй сар гүйцсэн үе, өвчтэй үе зэрэг; орон бус буюу суврага шүтээний дэргэд, хуврагийн хүрээ хийдийн дотор хэвтэх явдлууд болно.

Сууриас шалтгаалж хүнд болох худал хэлэх үйлнээ бусдыг хуурч мэхлэхийн тулд олон зүйлийг худал өгүүлэх, эх эцгээс авахуулаад бурхан хүртэл сайн нөхөр, садан төрөл бүгдэд худал ярих болоод амь таслах тэргүүтэн гурвыг хүндрүүлэн үйлдсэн мэт ярих болой. Хувраг тойдыг эв эеийг салгахаар худал ярих явдал тэдгээрийн дотроос хамгийн хүнд болно.

Сууриас шалтгаалж хүнд болох хов зөөх үйлд аль эртнээс төрөл садан, буяны садан багш, эцэг эх хүүхэд болон хувраг нарын хоорондын

эв түнжинг эвдэх зэрэг орно. Биеэр үйлдэх гурван нүглийг хүндрүүлж үйлдэгч нь хов хэлэх болой.

Сууриас шалтгаалж хүнд болох ширүүн үгийн хувьд эх эцэг тэргүүтэн болон багш адил нэгнээ хатуурхан өгүүлэх, үнэн бус хуурмаг дүр эсгэн ширүүн үг хэлэх, загнах, зэмлэх, хараах зүхэх зэрэг болой.

Сууриас шалтгаалж хүнд болох чалчаа үг нь худал хэлэх тэргүүтэн гурвын хүндрэхтэй адил. Хэрэлдэх, хоригийг уудлах, зодолдох, таарамжгүй байдал зэргээс сэдэвлэн дэмий чалчах болон дур хүслийн сэтгэлээр тэрсүүдийн ном шастарыг унших, эх эцэг, төрөл садан, буяны садан тэргүүтнийг элэглэх, доог тохуу хийх, ёс бусаар хэлэх, хочлох зэрэг болой.

Сууриас шалтгаалж хүнд болох хомхой сэтгэлийн хувьд хувраг болон сүврага шүтээний тахилын эдэд шунах, эрдэмтэй гэж хөөрцөглөн хаад ноёд, ариун явдалтан, мэргэд дээдэс нараас илүү хишиг, өргөл хүндлэл хүлээхийг хүсэж шүлэнгэтэх болой.

Сууриас шалтгаалж хүнд болох хорлох сэтгэл нь эх эцэг, төрөл садан, багш болоод гэм зэмгүй хүмүүс, гуйлгачин, ядарсан зовсон нэгэн, өр нимгэн сэтгэлтэн нар болон гэм хийснээ үнэн голоос гэмшин наминчлагч зэрэгт хорсох сэтгэл гаргах болой.

Сууриас шалтгаалж хүнд болох буруу үзлийн хувьд суурь буюу юм бүхнийг дорд үзэн басамжлах явдал бусад бүх буруу үзлээс хамгийн хүнд болно.

Ертөнцөд Дайснаа дарсан (бурхан), үнэнд хүрсэн, үнэнд оршсон зэргүүд байхгүй хэмээн үзэх үзэл мөн багтана. Тэднээс буцсан бол хөнгөнд тооцогдоно.

"Газрын бодит суурь"-аас зургаан зүйлээр хүнд болох ёсыг үзүүлжээ. Үүнд:

1. Илт хуран үйлдэх гэдэг гурван хор хүчтэй байх буюу эсвээс тэр гурав огт байхгүй нөхцөлд үйл өдөөгдөх;

2. Дадаж сурснаар гэдэг нүгэл буяны хоёр үйлийг өнө эртнээс шүтэн дадуулж олон дахин үйлдсэн байна.

3. Мөн чанарын хувьд бие, хэлний долоогийн хувьд хойноосоо урагшлах тутам хүнд болдог бөгөөд сэтгэлийн гурав нь урдаасаа хойшоо хүнд болдог байна.

4. Суурийн хувьд бурхан, ном , хувраг, багш адил нэгнээ тус болон хор хүргэх болой.

5. Үл зохилдохын зүгт туушгай гэдэг нь хэзээ амьд байх хүртэл гагцхүү нүглийг үйлдэж ганц ч буян үл үйлдэх болой.

6. Үл зохилдох зүгийг арилгах нь нүглийн үйлийг тэвчин шунал хүлээс ангижран буяны үйлийг туурвих болой.

"Садангийн захидал"-аас:

Мөнх үйлдэх, илт шунах, ерөндөг үл шүтэх болон
Эрдмийн эрхэм болсон суурь зэргээс үүдсэн үйл зэрэг
Буян нүглийн таван их зүйл бөгөөд
Тэдгээрийг тэвчин буяны явдалд хичээсүгэй хэмээн айлджээ.

Үүнд чухаг дээд тэргүүтнийг "эрдэм төгөлдөр суурь" болон "эх эцэг тэргүүтэн ачтаны суурь" гэж хоёр хуваагаад тав болой.

б) Дашрамд хүчтэй үйлийн үүдийг хураангуйлан үзүүлэхэд дөрөв:

(1) Орны үүднээс их хүчтэй болох үйл нь:

Чухаг дээд гурав болон багш, багштай адил нэгэн, эх эцэг тэргүүтнээ хэдийгээр хатуу хүчтэй санаагаар бус ч өчүүхэн төдий тус хүргэх, эсвээс хор болсон бөгөөс маш их буян эсвээс нүгэл хураадаг байна.

Энэ тухай *"Санан дурдахуйг агуулах судар"*-аас айлдахдаа:

"Бурхан, ном, хувраг тойдоос хэдий өчүүхэн бага юм авсан ч нүгэл улам их болмой. Хэдийгээр тэдгээрээс хулгайлсан зүйлээ түр хугацааны дараа эргүүлээд өгсөн ч бурхан болоод номд холбогдсон нүгэл арилдаг. Харин хуврагаас хулгай хийсний үрийг амсах эдлэх хүртэл арилахгүй. Хүнд орон учираас. Хэрвээ хүнс тэжээлийн зүйл авсан бол их тамд унах ба тийн бус бөгөөс түүний доторхи аюус тамын нөхөр болох их харанхуй тэргүүтэнд төрөх болой" хэмээн айлджээ.

Ялангуяа "Ёс цалхай нэгэн бээр хуврагийн эд зүйлээс навч, цэцэг, үр төдийхнийг хэрэглэсэн ч их тамд унана. Өнө удаан тэнд сууж хааяа нэг гэтлэх хэдий ч говь цөл газар гар хөлгүй, яс арьс болсон зэрлэг адгуус болж төрөх буюу хөл гаргүй, сохор өлсгөлөн бирд болж төрж олон жилээр элдэв зовлон эдлэх зэрэг их гэмтэй болох" талаар *"Нарны зүрхэн судар"*-аас айлджээ. Мөн хувраг болон гэлэн нарт зориулсан цэцэг төдий зэргийг өөрөө эдлэх юм уу эсвээс гэргийтэнд өгөх, гэргийтэн хэрэглэж огт болохгүй гэж айлджээ. Чингэвээс маш их хүнд нүгэл болох аж.

Тэрхүү судраас:

Хурц иртэй илд мэсээр
Өөрийн гар хөлөө хэрчүүлэх амархан
Хувраг дор өргөсөн эд зүйлсийг
Гэргийтэн дор бүү өгсүгэй

Гал цог дүрэлзсэн
Ширмэн бөмбөлөг идэх амархан
Хувраг тойдоос бусад хэн бээр
Түүнийг эдэлж бүү үйлд

Сүмбэр уулын дайтай их галыг
Барьж аваад идэх амархан
Гэргийтэн харин хуврагийн
Төгс эдлэлийг бүү эдэлсүгэй

Хамаг байдгаа гаргаад
Шор модонд өлгөгдөх амархан
Гэргийтэн харин хуврагийн
Төгс эдлэлийг бүү эдэлсүгэй

Нүүрс гал дүрэлзсэн
Тэр байшинд орох амархан
Гэргийтэн харин хуврагийн орон гэрт
Шөнө хонож бүү үйлд хэмээжээ.

Мөн хуврагуудын дотроос бодисадва хуврагууд буян нүглийн их хүчтэй орон болдог.

"Сүжгийн хүчийг төрүүлэгч мутрын тамга судар"-аас: "Зарим нэгэн уурлаад арван зүгийн хамаг амьтныг хар гэрт (шорон) суулгаснаас, бодисадва хүнд уурлан араараа зүглэх төдийгөөр илүү их мунхаг болох энэ адилыг үзсэнгүй" хэмээснээс үзэхэд хичнээн их хэмжээлшгүй нүгэлт болохыг хэлнэ. Мөн Замбу тивийн хамаг амьтны байгаа эд зүйлийг булаасантай хэн нэгэн бодисадваг муу хэлсэн нүгэл урьд адил буюу.

Мөн Ганга мөрний элсний тоотой сацуу суврага шүтээнийг эвдлэн шатааснаас, их хөлгөнөө сүжигтэй бодисадва нэгнээ хорлох санаа гаргах, уурлан муучлан хэлвээс урьдын адил илүү нүгэлт болохыг айлджээ.

Тэрчлэн *"Магадлах эс магадлахуйд орох мутрын тамга судар"*-аас: "Арван зүгийн амьтны нүдийг ухчихаад хожим асрангуй сэтгэл төрснөөр дахин нүд оруулах ба түрүү нь хар гэрт суулгасан амьтан бүхнийг суллан тавиад Хүрдэн эргүүлэгч хаан болон Эсүрва тэнгэрийн амгалан заяанд байгуулснаас, их хөлгөнөө сүсэглэх бодисадваг бишрэн харах, тийн харахыг хүсэх, түүнийг сайшаан өгүүлэх буян тус тус цаглашгүй болохыг айлджээ.

"Машид амарлингуйг тийн магадлагч судар"-аас ч: "Замбу тивийн хамаг амьтны амийг таслах буюу байгаа бүгдийг булаасан нүглээс наанадаж бодисадва нэгний атга гурил амьтанд өгөх гэсэн буянд саад хийсэн нүгэл хилэнц нь үлэмж хэмжээлшгүй их болно" хэмээжээ. Тиймээс энэ оронд маш их анхааралтай хандах ёстой.

(2) Суурь шүтээний үүднээс их хүчтэй болдог үйлүүд:

Цул төмөр хэдий жижиг байсан ч усны ёроолд живдэг. Харин түүгээр хичнээн том сав суулга хийгээд усанд тавихад усан дээр хөвдөг билээ. Тэнэг болон ухаантны үйлдсэн нүглийн хүнд хөнгөн үүнтэй адилхан хэмээн айлджээ.

Эл учрыг *"Их нөгчигч судар"*-аас: "Мунхагууд хир буртагтай зууралдан салж чадахгүй байгаа ялаа адил өчүүхэн төдий гэм нүглээс ч гарч чаддаггүй ажгуу. Гэмших сэтгэлгүй болохоор буян хийж чадахгүй. Урьдын хураасан буян байсан ч гэмээ нууж хаацайлан нүгэл хилэнцээр дарна. Эдүгээ амсах байсан тийн боловсрох шалтгаан нөхцөл өөрчлөгдөн маш хүнд там болж хувирна. Балга усанд атга давс хийхэд ууж болдоггүйтэй адил буюу.

Бусдаас зоос зээлчихээд өгч чадахгүй бол нүүрийг нь ч харж чадахгүйд хүрдэг өр зээлийн зовлонг амсахтай адил болой. Тэрчлэн таван замаар тийн боловсролын үрүүд там болж боловсордог. Мунхаг тэнэгтээ, буяны үндэс өчүүхэндээ, хүнд нүгэлдээ гэмших санаа зовохгүй байх, эхнээсээ буян үйлдээгүй зэрэг болмой" хэмээжээ. Тиймээс урьд хийсэндээ гэмших, хойшдоо боомтлох, нүгэл буруугаа нуудаггүй, ерөндөг болсон буяныг үйлдэгч мэргэд тэднээ нүгэл хөнгөрч болохыг айлджээ.

Чингэлгүй мэдсээр хирнээ үл тоомсорлон мэргэн хэмээн хөөрцөглөгч нарт хүнд байх болно. *"Их эрдэнийн цогцос"*-оос ч: "Гурван мянган

ертөнцийн амьтан бүгдээр их хөлгөнөө оршин хүрдэн эргүүлэгч хаан төр төгөлдөр барих цагт тус тус далай шиг том зулын цөгцөнд Сүмбэр уулын чинээ гол орооож зул хийгээд бурханы суврага шүтээнийг тахисан буян нь гэрээс гарсан хувраг бодисадва бээр үрийн тосоор зулын гол орооож суврагаанд өргөсөн буяны зуугийн нэг хувьд ч үл хүрнэ" гэж айлджээ.

Энэ үед санаа болсон бодь сэтгэл хийгээд орон болсон суврага шүтээний хувьд ялгаагүй, харин эд юмны талаас асар их ялгаатай хэдий ч шүтээний хүчээрээ ялгагдах их онцлогтой байна.

Үүгээр жишээд санваартай байх санвааргүй байхын ялгаа болон санваартай байхдаа нэг, хоёр, гурван санваар төгөлдөр шүтээнтэй бодгаль бээр зам мөрийг бясалгах зэрэгт ч гэсэн өмнөхөөс хойдхи нь илүү газрын ахицтай байх нь тодорхой харагдана. Мөн гэрийн эзэд өглөг буян үйлдэхийн цагт нэг хоногийн сахил сахих үестээ өгөх, эсвээс сахил сахиагүй үедээ өглөг өгөх хоёрын буяны хүчний их багын ялгаа маш их байх нь тодорхой.

"Ёс суртахууны цалхайрлыг эслэн таслагч судар"-аас: "Зуун нас насалтлаа үргэлж тасралтгүй нүгэл хийсэн арван хар төгөлдөр хүний хураасан нүглээс, ганцхан өдөр ёс цалхай нэгэн гэлэн бээр арш багшийн дуазыг нөмрөн сүсгээр өргөсөн идээг хэрэглэсэн нүгэл нь үлэмж илүү болно" хэмээн айлдсан нь шүтээний талаас нүгэл хэр хүчтэй болохыг айлджээ. *"Эшийн тийн ялгал"-аас:*

Гал цог дүрэлзэх бөөрөнхий төмрөө
Гайгүй сайн зоогловол болох биз ээ
Ёс цалхай бас сайтар эс сахисан хэрнээ
Орон балгадын олны хоолыг зооглох юун

хэмээн ёс цалхай болон цааз сул хоёуланд айлджээ.

Донба гэгээн бээр "Номд шүтсэн нүглийн дэргэд арван хар нүгэл бүдүүхэн нэгэн шүү" хэмээсэн нь үүнийг үнэн үзэгдэнэ.

(3) Бодит үүднээс их хүчтэй болох үйлүүд:

Амьтанд өглөг өгөх дотроос номын өглөг өгөх болон бурханы тахил дотроос бүтээлийн тахил өргөл нь эд өлөгийн өглөг, тахилаас үлэмж илүү бөлгөө. Түүгээр жишин бусдыг мэдээрэй.

(4) Сэтгэлийн уурнээс их хүчтэй болох үйлүүд:

"Их эрдэнийн цогцос"-оос айлдахдаа: "Гурван мянган ертөнцийн хамаг амьтан тус тусдаа Сүмбэр уулын чинээ бурханы суврага бүтээж зуун сая галвын турш сүслэн шүтэж, хамаг байгаа бүгдээ өргөн тахисан тэр буянаас, бодь сэтгэлээр хамгийг болгоогчийн сэтгэл лугаа хагацалгүйгээр нэг ширхэг цэцэг өргөсөн буян үлэмж илүү болно" гэж айлджээ.

Тэрчлэн дээд доод зорилго алинд тухайлсан болон өвөр бусдын тус чухам алинд зорисон зэрэг санаа зорилгын ялгаа, түүний хүч чадлын чанга сул, мөн цаг хугацааны хувьд урт богино зэргийн уурнээс мэдээрэй. Буруу явдлын тал дээр ч муу сэтгэлийн хүч чадал ихтэй байх, өнө удаан үргэлжилсэн бол хүч ихтэй байдаг. Тэдгээрийн дотроос ч уур хилэн маш их хүчтэй нэгэн буюу. *"Бодичаряаватара"*-гаас:

Мянган галавт хураасан
Өглөг өгөх, бурхан тахисан тэргүүтэн
Сайн буян юу байгаа тэр бүхнийг
Ганцхан уураар дарж үйлдэх хэмээжээ

Мөн номын нөхөд болоод бодисадвад уурлаваас бүр түүнээс илүү хүнд нүгэл болдог.

"Бясалгалын хаан судар"-аас:

Нэг нь нөгөөдөө хорлох сэтгэл гаргаваас
Тэрээр шагшаавад сонссон ч үл авргадах
Бясалгал ч үл аврах, хийд орон ч үл аврах
Өглөг ч үл аврах, бурхан тахиад ч тусгүй хэмээсэн ба

"Бодичаряаватара"-гаас ч:

Хэн нэгэн тэр адилын өглөгийн эзэн бодисадвад
Хэрвээ муу санаа гарган үйлдвээс тэрээр
Муу сэтгэл гаргасан тоотой галавт
Тамд сууна гэж бурхан айлджээ хэмээжээ.

(3) Тэдгээрийн нүглийн үр дагаврыг үзүүлэх:

а/ Тийн боловсролын (ач) үр
б/ Шалтгаан зохилдох үр
в/ Эзэт үр буюу эрхэт үр

а/ Тийн боловсролын үр:

Үйлийн арван мөр тус бүрд суурь болох гурван хорын их, дунд, бага зэргээс хамааран гурав гурван үр гарна. Үүнд: Амь таслах тэргүүтэн их арван үйлийн үрээр тамд; дунд зэргийн арван үйлийн үрээр бирдэд; бага зэргийн арван үйлийн үрээр адгуусанд төрдөг гэж *"Газрын бодит суурь"*-т айлджээ. *"Арван газрын судар"*-аас бага, дунд хоёрын үрийг сольж айлдсан буй. [42]

б/ Шалтгаан зохилдох үр:

Муу заяанаас хүмүүн заянд төрөвч тус тус нас богинотой байх; эд юмаар ядмаг байх; эхнэр үл сахих; доромжлол олон амсах; садан төрлөөс салах; сэтгэлд таагүй үг сонсох; бусдууд үгийг үл сонсох; тачаал, урин, мунхаг их байх болой. *"Үнэнчийн бүлэг"* болон *"Арван газрын судар"* зэргээс тэдгээр тус бүрт хоёр хоёр үр гарна гэжээ.

Хэдийгээр хүн болж төрсөн ч нас богинотой, өвчин зовлон ихтэй, эд зүйлээр хомсхон, бусдууд эд юмсыг нийтээр эдлэх, хэрцгий бүдүүлэг албаттай, сэтгэл итгэх аргагүй эхнэр хань нөхөртэй, доромжлол ихтэй, бусдад хууртагдах, найз нөхөд үл хүрээлэх, муу муухайг дуулах, хэрүүлийн үг сурах, хэлж ярьж боломгүй муухай үг ярианд дуртай самбаатай болох, хүсэл шунал ихтэй, ханахаа болих, хэрэггүй юманд дурлах, хэрэгтэйг огоорох, бусдыг хорлох буюу бусдаар хорлуулах, буруу үзэл бодолтой болон башир муу зальтай болох хэмээн айлджээ. [43]

Багш дээдэс бээр, хүн болсон ч гэсэн амь таслах тэргүүтнээ баясдаг чинь шалтгаан зохилдох үр буюу урьд хийж байсан үндэс лүгээ зохилдсон үр мөн гэж болгоожээ.

в/ Эзэт буюу эрхэт үр:

Амь таслах үйлийн үрд гадаад сав ертөнцийн идээ ундаа, эм тан, үр тариа тэргүүтний шим чадал доройтон, болц боловсролт, үржил шим, хүч хомсдож, шингэхэд бэрхтэй болж, өвчин үүсгэх тул их зонхи амьтан насаа гүйцээлгүй үхэхэд хүрдэг байна.

Хулгай хийсний үрд үр тариа өчүүхэн бага, сайн тариа ургахгүй, ургац гарахгүй, ган гачиг ихтэй, хур ихээр буух, үр тариа хатаж үгүй болох буюу.

Буруу явдлын үрд баас шээс, балчиг шавар, намаг орших, өмхий муухай үнэр ханхлах, тохь тухгүй, таагүй орчин зэрэг буюу.

Худал ярихын үрд газар тариалан болон аялал жуулчлалын үйл эцэстээ хүрэхгүй, эвлэн найрамдахгүй, ихэнхдээ хуурах мэхлэх, аймшиг аюул болох шалтгаан нөхцөл олон байх.

Ховын үрд газар нутаг энхэл донхол ихтэй, хад чулуутай, өндөр намтай, зорчиход бэрхтэй, аюул гамшиг тохиолдох шалтгаан нөхцөл бүрдсэн байна.

Ширүүн үгийн үрд хожуул тайрдас, өргөст модтой, том хад чулуу, хурц шовх хайрга, том том үхэр чулуу, бул чулуунууд дүүрэн байх ч хатаж ширгэсэн хүрхрээ, далай, нуур, цөөрөм орших буюу давстай шорвог ус, говь цөл, ээрэм эзгүй тал болон хилэнц нүгэлтний газар, аймшиг аюулын олон нөхцөл бүрдсэн буюу.

Чалчаа үгийн үрд үр жимст найлзуур модноо үр үл тогтох, цаг бусаар үр тогтох, цагтаа үл боловсрох, боловсрох болоогүй хэрнээ боловсорч үзэгдэх, үндэс батгүй болох, удаан үл орших, үзэсгэлэнт сайхан ой цэцэрлэг цэцэгт хүрээлэн, нуур цөөрөм цөөрөх, аймшигийн шалтгаан бүрдэх буюу.

Хомхой сэтгэлийн үрд хотол чуулган сайн сайхан бүхэн жил, сар, өдөр хоногоор доройтон хомсдож нэмэгдэхээ болих буюу.

Хорлох сэтгэлийн үрд элдвийн өвчин тахал, халдварт өвчин, гамшиг зовлон, гадаадын цэргийн дайн тулаан, хямрал тэмцэл ихдэх, арслан, бар зэрэг араатан, хорт могой, хилэнцэт хорхой, галт хорхой шавьж олшрох, хорт ягчис, хулгайч дээрэмчин олшрох зэрэг буюу.

Буруу үзлийн үрд сав ертөнцийн эрхэм дээд түүх гарвал балрах ба үнэхээр ариун бус, ёс бус зүйлүүд ариун дээд зөв зүйл гэж тооцогдох ба авралын орон, аврагч үгүйсгэгдэхэд хүрнэ. [44]

(б) Буяны үйлийн үрийг санахад хоёр:

(1) Буяны үйлүүд
(2) Тэдгээрийн үр дагавар

(1) Буяны үйлүүд:

"Амь таслах, хулгай хийх, буруу явдал гурвын гэмийг мэдсэн нэгэн

бээр төгс буянт сэтгэлийн үүднээс тэдгээрийг үнэхээр хорих үйл ажлыг туурвих буюу эцэс хүртэл хорьж боож чадсан үйлүүд биеэр үйлдсэн үйл болно. Улмаар хэлний дөрөв, сэтгэлийн гурав дээр энэ мэтээр найруулах ба ялгаа нь хэлний үйл, сэтгэлийн үйл хэмээх болой" гэж *"Газрын бодит суурь"*-аас айлджээ.

Тиймээс суурь, санаа, үйлдэл болон төгсгөл зэрэгтэй найруулан амь таслахыг тэвчсэн үйлийн мөр лүгээ жишсүгэй. Суурь нь бусад амьтан болой. Санаа нь гэм бурууг ойлгоод тэвчих хүсэл эгээрэл буюу. Үйлдэл нь алах хөнөөх явдлыг баттай боож чадсан үйл ажил болой. Төгсгөл нь үнэхээр түүнийг үйлдэхээ хорьж чадсан биеийн үйл болой. Энэхүү ёсоор бусдыг мэдээрэй.

(2) Тэдгээрийн үр дагавар:

Гурван зүйлийн үр гарна. Бага, дунд, их буяны үйлийн тийн боловсролын үрд хүмүүн, хүсэлт тэнгэр, дээд хоёр орны тэнгэрт тус тус төрдөг байна. Шалтгаан зохилдох болон ээт үрийн хувьд нүглийн үрээс буцааж болгоогоорой.

"Арван газар"-аас: "Эдгээр арван буяныг үйлдэж зовлонгоос айж (их) нигүүлсэх сэтгэлгүй төрөөгүй хэдий ч бусдын үгийг дагаж бясалгаваас Сонсоод сонсогчийн үрийг олно. Мөн (их) нигүүлсэх сэтгэлгүй, бусдыг шүтэхгүйгээр өөрөө бурхан болно гэж зориод шүтэн барилдахуйг ухан судлаваас өөрөө ялгуусадын үрийг олдог.

Агуу их чанарт их нигүүлсэхүй сэтгэл, мэргэн арга ухаан, их ерөөл болон хамаг амьтныг хэзээ ч үл орхих бурханы гүн дэлгэр билгэ билгүүнийг зорин судалж Бодисадвын газар хийгээд хамаг чанад хүрэхүйг олдог болой. Тэдгээр хамаг юмс бүгдийг тийн сайтар болгоосноор бурханы ном бүгдийг олно" хэмээн айлджээ. Тийнхүү арван зүйлт хоёр үйлийн аймгийн үр сэлтийн талаар бусад номоос тодорхой зүйл үзэгдээгүй тул энэ бүгдийг *"Газрын бодит суурь"* болон *"Нотлон буулгахуйн хураангуй"* хэмээх шастаруудын таалал дагуу номновой.

(в) Үйлийн бусад ялгалыг үзүүлэх: [45]

(1) Хүргэх (илгээх) үйл ба гүйцээх үйл

(2) Амсах ёстой үйл ба ёсгүй үйл

(1) Хүргэх үйл ба гүйцээх үйл

Сайн заяанд хүргэдэг үйл нь буян байдаг. Муу заяанд хүргэдэг үйл нүгэл болно. Харин гүйцээх төгсгөх үйлийн хувьд тогтмол байх албагүй. Сайн заяанд төрсөн хэдий ч гар, хөл, эрхтэн дутуу байх, зүс царай муутай байх, нас богинотой, өвчин зовлон ихтэй, ядуу зүдүү байх явдал нь нүглээр үүдэгдсэн мөн. Адгуус болон бирдэд төрсөн хэдий ч эд баялаг хотол чуулсан байх нь буяны үрээс болой.

Чингэхээр хүргэгч буяны үйлээр хүргэгдсэн байхад гүйцээх үйл нь буянаар төгсөх, нүглээр төгсөх хоёр зүйл байна.

Хүргэгч нүглээр хүргэгдсэн ч гүйцээх үйл нь буянаар төгсөх, бас нүглээр төгсөх ч бий учраас дөрвөн талтай. *"Хотол хураангуй"*-гаас: "Буян нүгэл нь сайн муу заяанд хүргэх ба огоот гүйцээж төгсгөх үйл гэж мэдээрэй. Хүргэх үйл гэдэг хаана төрөх тийн боловсролын үрийг гаргаж өгдөг. Огоот төгс гүйцээх үйлээр алин авсан төрөл дээр зовлон жаргал эдлэх болой" хэмээжээ.

"Авхидхарма"-аас:

Нэг бээр нэг төрөлд хүргэх буюу
Гүйцээгч бээр элдэв олон буюу

хэмээн нэг үйлээр нэг л төрөлд хүргэх болохоос олонд хүргэхгүй. Гүйцээн үйлдэгч үйлд элдэв олон байвч тэр олон нэг ч төрөлд хүргэхгүй гэж номножээ.

"Хотолын хураангуй"- гаас: "Нэг үйлээр нэг төрөлд хүргэдэг үйл ч бий. Нэг үйлээр элдэв олон төрөлд хүргэдэг үйл ч бий. Элдэв олон үйлээр нэг төрөлд хүргэдэг үйл ч бий. Элдэв олон үйлээр элдэв олон төрөлд хүргэдэг үйл ч бий" гэжээ.

"Тайлбар"-аас: "Ганцхан агшингийн үйлээр нэг төрлийн тийн боловролын үрийн хөрөнгө сэргээдэх ч бий. Тэр үйлээр олон төрлийн тийн боловсролын хөрөнгө сэргэх ч бий. Үйлийн олон агшинд ганцхан түүний хөрөнгө дахин дахин сэргэх ч бий. Элдэв олон инагш чинагш шүтэлцэн нэг төрлөөс нөгөө төрөлд дамжих хөрөнгийг дахин дахин сэргээдэг" гэж номножээ. [46]

(2) Амсах ёстой ба ёсгүй үйл:

"Газрын бодит суурь"-аас "Амсах албатай үйл гэдэг санаатай үйлдэж хураасан алин болой. Амсах албагүй үйл нь санаатай үйлдсэн ч хураагаагүй үйл алин болой" хэмээжээ. Үйлдэх хураах хоёрын ялгааны талаар тэрхүү шастараас: "Үйлдсэн үйл юун хэмээвээс сэтгэх буюу санаж байсан ч бие болоод хэлээр өдөөгдсөн алин болой" хэмээжээ.

"Хураасан үйл гэдэг арван үйлээс бусад болой. Энэ мэт буюу. Зүүдэнд үйлдэх, мэдэхгүй үйлдэх, санаатай бус үйлдэх, хүчээр үл үйлдэх, үргэлж эс үйлдэх, эндүүрч үйлдэх, мартаж үйлдэх, хүсээгүй үйлдэх, мөн чанарын хувьд дундаж үйлүүд, гэмшиж арилсан үйл, ерөндөгөөр арилсан үйл болон арван үйлээс бусад алин үйлүүд болой. Эс хураах үйл нь тийн үзүүлсэн арван үйл болой" хэмээсэн мэт.

"Нотлон буулгасан хураангуй"-д ч дөрвөн зүйлээр номножээ.

а) Амь таслах үйлийг үйлдсэн ч эс хураах үйлнээ эс мэргэшин үйлдсэн, зүүдэнд үйлдсэн, зориудаар үйлдээгүй, хүсээгүй байтал бусдын эрхээр үйлдсэн, ганцхан удаа үйлдсэн, түүндээ гэмшсэн, гэм буруугаа үнэхээр ухаарсан сэтгэлд эзлэгдэн улмаар тэвчих тангараг тавин машид нимгэлэх, ач үр боловсрохоос өмнө шуналаас хагацсан ертөнцийн мөрийн эрдмээр хөрөнгийн чадлыг бууруулах, ертөнцөөс нөгчихсөн тэвчлийн мөрийн эрдмээр хөрөнгийг баттай дарсан зэрэг болой.

б) Хураасан ч үйлдээгүй үйл гэдэгт амьтан алахын тулд аль эртнээс судлан ажиглах хэрнээ хараахан амийг таслаагүй байгаа үйл багтана.

в) Үйлдээд хураах гэдэг дээрх хоёр зүйлээс бусад тохиолдлын амь таслах үйлүүд болой.

г) Үл үйлдэн үл хураах үйл нь дээрх гурваас бусад болой. Хулгай хийхээс чалчаа үг хүртэл тэр дагуу тааруулан мэдээрэй.

Сэтгэлийн гуравт хоёрдугаар зүйл гарахгүй бөгөөд эхний зүйлийн хувьд ч зориудаар үл үйлдэх, бусдын эрхээр орно гэдэг гарахгүй.

Амсах ёстой үйл дээр үрээ амсах цагийн үүднээс гурван зүйл буй,

Үүнд :

а) Энэ насанд амсах үйл нь тэрхүү үйлийн үр энэ насанд боловсрох болой. Түүнээ найман зүйл буюу. "Бие, төгс эдлэл болон ертөнцийн үзэл бодолд хүсэл ихтэй учраас энэ насанд зовлон амсах болдог. Харин тэдгээрт шунах хүсэл сэтгэлгүй болвоос буян болно. Цаашлаад амьтныг хорлох сэтгэл ихтэй байх эсвээс энэрэн нигүүлсэж туслах сэтгэл ихтэй байх, мөн чухаг дээд гурав болон багш тэргүүтнээ нэрмэх, зовоох сэтгэл ихтэй байх, эсвээс тэднээ сүсэглэх биширэхийн санаа сэтгэл их байх, ач тус болдог эх эцэг багш тэргүүтнээ өс санах, ач тусыг үл хариулах зэрэг нүглийн үрийг энэ насанд амсана. Харин эргэн тусалж ачийг хариулахын санаа бодол ихтэй байх буяны үрийг энэ насанд амсана" гэж *"Газрын бодит суурь"* -т айлджээ.

б)Төрөөд амсах үйл нь хоёрдугаар төрөл дээр үрийг амсах үйл билээ.

в) Бусад олон төрөл дээр амсах үйл нь гурван төрлөөс цааш амсах үйл болой. Үндсэнд байгаа буян нүглийн олон үйл боловсрохдоо аль хүнд үйл нь эхлэн боловсорно. Хүнд хөнгөн нь адил байвал үхэх цагт аль ил гарч ирсэн тэр нь боловсордог. Тэд зэрэг гарч ирвэл аль их дадсан нь болой. Чингээд адилхан байвал эхлээд үйлдсэн бодогдсон нь эхэлж боловсорно. *"Авхидхармын тайлбар"*-аас:

Үйлээр ертөнцөд төрөхөд алин хүнд
Алин ойрхон, алин дадаж сурсан
Алин урьд үйлдэж байсан тэдгээрээс
Түрүү түрүүч нь боловсрох хэмээн айлдсан мэтээр болой.

2) Өвөрмөц ялган санах:

Арван хар нүглийг тэвчсэнээр нэгэн сайн шүтээнийг олж болно. Гэвч Хамгийг болгоогчийн хутаг бүтээх бэлэг чанар төгс бүрдсэн (шүтээн) нэгийг бүтээвээс бусадтай адилтгашгүй зам мөрийн ахицаа гарах тул тийм шүтээнийг бүтээх хэрэгтэй.

Үүнд гурван зүйл:

а) Тийн боловсролын үрийн эрдэм
б) Тийн боловсролын үр дагавар
в) Тийн боловсролын үрийн үндэс

а) Тийн боловсролын урийн эрдэм

Үүнд найман зүйл буй.

1. Нас хотол чуулсан нь урьдын үйлийн хаялгаар урт наслахаар заяагдсан тэр ёсоор урт насалж амьдрах болой.

2. Сайхан өнгө дүртэй төрж зүс царай сайтай, эрхтэн бүрэн, харваас нүдэнд дулаахан, өндөр нам тааруу гоо үзэсгэлэнтэй болвоос өнгө дүрс хотол чуулсан болно.

3. Ертөнцийнхэн хүндлэн бишрэх алдар суу дуурссан өндөр язгуурт төрвөөс язгуур угсаа хотол чуулсан болно.

4. Эд баялаг ихтэй, элгэн садангаар өнөр өтгөн, олон хань нөхөдтэй болвоос эрх баялаг хотол чуулсан болой.

5. Бие, хэлээр бусдыг хуурч мэхэлдэггүй, баттай итгэл найдвар болдог, аливаа хэргийн шалгуур гэрч болдог учраас бусад хүмүүс үгэнд итгэдэг зэрэг нь зөв үгт болой.

6. Өглөг өгөхдөө дуртай, хичээнгүй тэргүүтэн эрдэм төгөлдөр тул нэр алдар ихтэй, түүнээс төрсөн их буяны чуулганы тахилын орон болсноор нэр алдартай болно.

7. Эр хүйс төгөлдөр учраас эр хүмүүний заяат болой.

8. Урьдын үйлийн буянаар элдэв зовлон багатай, өвчин үгүй, энэ насны учраас үүдсэн санаачлага үйлс ихтэй болвоос хүч чадал төгөлдөр буюу. Тийнхүү сайн төрөх нь эхнийх болой. Бие нь удаах болой. Төрөл нь гутгаар буюу. Төгс эдлэл болон нөхөр нь дөтгөөр болой. Тавдугаар нь ертөнцийн шударга шалгуур болой. Зургаа нь түүний нэр алдар болой. Долоо нь хамаг эрдмийн сав буюу. Найм нь үйл ажилдаа хүч чадал төгөлдөр болой.

б) Тийн боловсролын урийн үр дагавар.

Үүнд найман зүйл буй.

1. Өвөр бусдын тусыг туурвин өнө удаан их буян хурааж үйлдэх болой.

2. Шавь нар харсан төдийд баясан цуглах бөгөөд түүний үгийг сонсож, бүтээхээр эрмэлзэх болой.

3. Захиа даалгаварыг ёсчлон бүтээх болой.

4. Өглөг өгөх зэргээр амьтныг хураан боловсруулах болой.

5. Яруу өгүүлэх, тус хүргэх, ухаанд тааруулах зэргээр амьтныг татан боловсруулах болой.

6. Үйл ажил бүхэнд хань болж, тус хүргэж, ачийг хариулан тушаасныг түргэнээ санах болой.

7. Хамаг эрдмийн сав болох, хичээнгүй туурвил үйлсийн сав болох, саруул уужим ухаанаар мэдэгдэхүүн бүхнийг сайтар онох сав болно. Мөн нөхөртөө түшигтэй, хамаг амьтантай хамт байх, ярих хөөрөлдөх, баясах цэнгэх, аглагт суухад үл буцаах, хорлол үл болох болой.

8. Өвөр бусдын тус алинд ч үл уйдах бөгөөд харин эрмэлзлэл хүсэл ихтэй, тус тус онохын хүчийг олж, зөн мэдэл түргэн болох болой.

в) Тийн боловсролын үрийн үндэснээ найман зүйл буй.

1. Амьтныг үл хорлох бөгөөд үл хорлох сэтгэлийг шүтэх болой.
Мөн түүнээс:

Алагдах газраа одогсдыг сайтар чөлөөлөх,
Амь биеэр туслах хийгээд
Амьтныг аюулаас аврах зэргээр
Ашид урт наслах буюу

Өвчтөн хүнийг өргөж асрах
Эм тан, эмч оточоор туслах
Саваа мод, шороо чулуу зэргээр
Амьтныг эс хөнөөвөөс өвчингүй буюу хэмээжээ.

2. Зул тэргүүтэн гэрэл гэгээ болон шинэ хувцас баринтаг өгөх болой.
Мөн дээрхээс:

Уур уцаарыг огоорох бөгөөд
Чимэг зүүлтийг өгвөөс сайхан царайт болох
Атаа хорсолгүй явсны үрд
Ачит сайн хувьт болохыг номнов хэмээжээ.

3. Омог бардам зангаа даран багш дээдэс тэргүүтнээ мөргөн залбирах ба боол зарцын явдлаар бусдыг хүндэтгэх болой.

4. Идээ хувцас тэргүүтнийг гуйхад өгөх ба гуйгаагүй байсан ч туслах, эд тавараар ядмаг зовлонтон болоод эрдмийн орноо өгөх буюу.

5. Хэлний дөрвөн нүглийг тэвчиж сурах болой.

6. Хойшдоо их эрдэм сурах ерөөл өөрөө тавих, чухаг дээд гурав болоод эх, эцэг, сонсогч, өөрөө ялгуусад, оронгийн эзэд, багш дээдэс тэргүүтнийг тахиж үйлдэх болой.

7. Эрийн эрдэмд баясах, эмэгтэй төрөлд үл баясан зовлонтойг ухаарах, бүсгүй төрөлд дурлахаа болих, эр эрхтэнг таслагч нарыг гэтэлгэх (болиулах) болой.

8. Бусдаар шаардуулалгүй өөрөө бүтээх бөгөөд өөрийгөө сахин чадагч нартай нөхөрлөх, идээ ундаа тэргүүтнээр дайлах болой. Эдгээр найман үндсүүд дээр гурван нөхцөлийг төгөлдөр бүрдүүлвээс ач үр нь гайхамшигтай сайхан боловсрох болно. Эдгээр гурван нөхцөл нь:

а) Сэтгэлийг ариусгах талаас өөрт харгалзах хоёр зүйл буй. Үндэс болох бүтээсэн буянаа ханьцашгүй бурханы хутагт зориулахаас бус тийн боловсролын үрийг үл горилох болой. Зүрхний мухраас үндэс нөхцөл бүхнийг баттай сайнаар бүтээх болой. Бусдад харгалзах хоёр буй. Дээд, дунд, бага зиндааны нэгэн номын нөхдөө үзэхдээ атаархах, тэнсэлдэх, басамжлах зэргийг огоорох ёстой. Даган баясах бөгөөд тэдэн шиг хараахан чадал олоогүй ч өдөр бүр олон дахин давтаж суралцах ёстой.

б) Үйл ажлаа ариусгах тал дээр өөрөөс харгалзах зүйл буй. Удаан хугацаанд, тасралтгүй, хүчтэй зоригтой үйлдэх буюу. Бусдаас хамаарах зүйлийн хувьд үнэхээр авч хийж чадаагүйг хийхээр оруулах, хийсэн бүтээсэн зүйлдээ урамтай байлгахын тулд магтаж сайшаах, тасралтгүй, орхилгүй хийж бүтээх болой.

в) Арилсан оронт гэдэг нь энэхүү сэтгэл, үйл хоёроос олон сайхан үр дагавар төрөх учраас орны хувьд ижил болой. Эдгээрийг *"Бодийн газар"*-т үзүүлсэн дагуу *"Тайлбар"*-аас нэмэлт хийж өгүүлвэй.

3) Тийнхүү ухаарч орох буцахыг үйлдэх ёсноо:

а) Ерөнхий үзүүлэх

б) Тусгайлан дөрвөн хүчээр арилгах ёсон

а) Ерөнхий үзүүлэх:

"Бодичарияаватара"-гаас:

Нүглээс зовлон төрөх буюу
Түүнээс л яаж гэтэлнэ хэмээн
Би бээр өдөр шөнө үргэлжид
Зөвхөн үүнийг санаваас зохистой

Алин сайн буяны орон бүхний
Үндэс нь сүсэг мөнийг Чадагч айлджээ
Түүний үндсийн үндэс болвоос
Үйлийн үрийг үргэлж бясалгах явдал болой

хэмээсэн мэт хар, цагаан үйлийн үрийг ухааран таниад зогсохгүй дахин дахин бясалгах хэрэгтэй. Энэ орон маш далд мэдэгдэхүүн учир оножойлгоход бэрхтэй болой.

Энэ талаар *"Бясалгалын хаан судар"*-аас:

Од гариг эрхис, сар нар газарт унаж
Ой мод, хот балгад газар дэлхий эвдрэн сүйрч
Сансар огторгуй өөрчлөгдлөө ч
Хэзээ ч Та худал үг үл айлдах хэмээсэн мэт

Сайвээр ажрагсан- Бурханы зарлигт сэтгэл итгэмжлэн суралцах хэрэгтэй. Үүнээ итгэл үнэмшил эс олвоос Ялгуусад баясах ямарваа номд магадлал үл олно. Заримууд үйлийн үрийг огт ухаараагүй, мэдээгүй бас үл тоомсорлох хэрнээ хоосон чанарыг ухаарчихлаа гэж ярих нь хоосон чанарыг огт ухаараагүйн шинж шүү. Хоосон чанарыг ухаарна гэдэг шүтэн барилдахуйн утганаа буулгаж мэдэх явдал бөгөөд үйлийн үрийг онож мэдэхийн нөхөр болдог ажгуу.

Дээрх судраас:

Хамаг ном юмс илбэ, усны хөөс, зэрэглээ,
Гэлбэлгээ (цахилгаан), усны саран адил буюу
Үхсэний хойно ертөнцийн чанад одох амьтан
Шумнасаас төрөхөө мэдэхгүй хэдий ч

Үйлээс үүдсэнээ үгүйсгэж болохгүй
Хар, цагаан үйлийн эрхээр үр боловсрох буюу
Ийн ухаарваас сайн үүд нээгдэх бөгөөд
Нарийн нь мэдэхэд бэрхтэй учир бурханы тааллын орон болой хэмээжээ.

Иймээс шүтэн барилдахуй болон үйл хоёр болвоос үйлийн үрийн зүй тогтол мөн гэдгийг ухаарч аваад өдөр шөнө бүхнээ гурван үүднээс шинжиж чадсанаар муу заяаг хааж чадна. Харин эхнээсээ үйлийн үрийн ухааныг эс мэдэх эсвээс бага зэрэг ухаарах хэдий ч үл тоомсорлон хандваас зөвхөн муу заяаны үүдийг нээх болно шүү.

"Жамцо айлтгасан судар" –аас: "Лусын эзэн! Бодисадва нар нэг л номоор муу заянд очих буруу уналыг хаадаг билээ. Тэр нэг ном алин хэмээвээс энэ мэт буюу "Би гэдэг юусан билээ, өдөр шөнийг хэрхэн өнгөрөөнө вэ гэж санан буян ном болох зүйлийг тунгаадаг явдал буюу" хэмээн айлджээ.

Тийнхүү сэтгэлээ шинжигч дээдэс мэргэд бээр: "Үйлийн үрийг санах энэ үед ном сэтгэл хоёроо огт ижилсүүлж чадахгүй байна. Ийм чадал ухаан хомс болохоор бид яаж тонилох билээ. Үйлийн үрийн ухааныг сэтгэлдээ нийлүүлж чадаж уу, үгүй юу гэдгээ тунгааж бод. Бид өөрийн сэтгэлээ номтой ижилсүүлж үү, үгүй юү гэдгийг шинжихдээ үнэн сэтгэлээс үйлийн үрийг ухаарч мэргэжснээр нь дүгнэх буюу" хэмээжээ.

"Цоморлиг"-оос:

Хэн нэгэн нялхас өөрийнхөө нялх гэдгийг
Хэдий ухаарсан бол тэрээр энд мэргэн болой хэмээжээ.

Сэтгэл номтой нийлж үү гэтэл хүүрийг үүрэгч мэт ар араараа зөрөлдөж одсон бол номч, мэргэн, гэгээнтэн хэзээ ч болохгүй бөгөөд харин нялхсын адаг болох биз ээ.

"Цоморлиг"-оос:

Хэн нэг нялхас өөрийгөө мэргэн хэмээн сэтгэвээс
Хэзээд тэрээр нялхас хэмээн өгүүлэгдэх буюу.

Иймээс эхлээд номын утгыг өөрийнхөө дотор бодон тунгаах хэрэгтэй шүү. Бодава гэгээн бээр ч бурханы цадигийн энэ хэсгийг эш авч сэтгэлдээ тунгаах хэрэгтэй гэж таалжээ.

Судраас:

Огторгуй газар хоёр хоорондоо хол зайтай
Оёоргүй далайн хоёр эрэг хоорондоо хол зайтай
Өрнө дорнын хоёр уул хоорондоо хол зайтай
Эгэл дордын болон дээдийн ном хоёр хоорондоо хол зайтай

хэмээн эгэл бид болон ном хоёр тэдгээр үлгэр адил хоорондоо асар их хол зайтай болохыг өгүүлжээ. Энэхүү ганцхан шүлэг номыг Бодисадва Даваа (Чандра) бээр Сайн номт бярман Субасидаад мянган алтан зоос өргөж хүртсэн ном гэдэг. Додлүнба гэгээн бээр: "Хэрсүү ухаанаар шинжиж сурвал утасны дамар уруу газар өнхрөх адилаар холын ном сэтгэлд буух бий" хэмээжээ.

Тэр мэтийг санаж гэмт явдлаас буцах талаар
"Үнэнчийн бүлэг"-ээс:

Хаан та, амьтны амийг хороож бүү үйлд
Хамаг амьтан аминдаа хайртай байдаг шүү
Харин тиймээс хэн хүн урт наслахыг хүсвээс
Хамаг сэтгэлээс амь таслах санааг ч бүү бод

хэмээсэн мэтээр арван хар болон басхүү дээр номносон амлашгүй нүгэл талаар санах сэдэхийн төдий ч бодол төрүүлэлгүй боох сэтгэлийг бүгдээр шүтэх, дадуулж сурах, олон дахин үйлдэх шаардлагатай болой.

Тийнхүү гэмт явдлаас буцаж эс чадваас хүсээгүй байсан ч амсах хэрэгтэй болох бөгөөд хаашаа ч мултрахын аргагүй болно.

Тиймийн учир түр нэг жаргалтай мэт боловч үр боловсроод ирэхийн цагт нүдээр дүүрэн нулимс мэлтэгнэн хичнээн дургүй байсан ч эдлэх л болох үйлийг үйлдэхгүй л байваас зохистой. Харин боловсрохын цагт амгалан жаргал эдлүүлдэг тийм л үйлийг үйлдэх хэрэгтэй билээ.

"Цоморлиг"-оос:

Та бээр зовлонгоос айх бөгөөтөл
Та өөртөө зовлон тарихаас зовохгүй
Ил ч бай далд ч бай ялгалгүй
Хилэнцийн үйлийг бүү үйлд

Хэрвээ нүглийн үйлийг үйлдсэн буюу
Үйлдүүлэхээр оруулчихсан л бол та
Оргож босоод зугатаавч
Зовлонгоос гэтэлнэ гэж үгүй

Хаана ч байлаа үйлээр үл дийлдэх
Газар орон үгүй болой
Гэгээн завсарт ч үгүй, далай усанд ч байхгүй
Уул модны завсарт ч орших бус болой

Ухаан багатай нялхсууд
Өөрөө өөртөө дайсагнах
Алин урд нь гал болох
Аюулт нүглийн үйлийг туурвих

Юуг ч үйлдсэн энэлэн шаналан болох
Нүүр дүүрэн нулимс төрүүлэх
Тус тусын зовлонг боловсруулах
Тэдгээр үйлийг үл үйлдвээс сайн

Юуг ч үйлдсэн үл энэлэх, үл шаналах
Сэтгэл баясах басхүү амгалантай
Үрийг тус тус боловсруулах
Тэдгээр үйлийг бүтээвээс сайн

Өөрөө амгаланг хүсэх хэрнээ
Өөдгүй хилэнцийг үйлдвээс
Өнөөх нүгэл сайтар боловсроод
Үхэтхийн уйлах тамыг эдлэх буюу

Хилэнц нүгэл үйлдсэн тэр даруй шууд
Хутга мэсээр огтлуулж харагдахгүй ч гэсэн
Амьтан бүхний хилэнцийн үйл
Алсдаа боловсорч ил болох

Алин хэзээ тэдгээр тийн боловсорч
Аймшигт халуун зэргийг тус тус эдлэхээр
Амьтан хилэнцийн үйлээс болжээ гэж
Алс хойно ухаарах буюу

Төмрөөс төрсөн төмрийн зэв
Төмөр өөрийг нь идэхтэй адил
Өөрийн ухаангүй хийсэн
Өөрийнхөө үйлээр тамд одох буюу хэмээн айлджээ.

Хамлүнва бээр Пүчүнваад ийн өгүүлрүүн: "Буяны садан бээр зөвхөн үйлийн үрийг ухаарах л тун чухал шүү гэсэн" гээд "Одоо ч номнох, сонсох, бясалгах гэдэг ямар ч үнэ цэнэгүй болж дээ. Зөвхөн түүнийг л бодож байхад тийм хэцүү юм уу" гэхэд Пүчүнва бээр "Тийм, тийм" гэж айлдсан байдаг.

Долба гэгээн бээр: "Их шавь нар аа, Их сүр үзүүлэхийн хэрэг юун Үйлийн үр гэдэг тун нарийн шүү" хэмээсэн ба Пүчүнва гэгээн бээр "Өтөл өвгөн би "Үлгэрийн далай л шагайж сууна" хэмээн айлддаг байжээ.

Мөн Шарава гэгээн бээр: "Ямар ч зовлон муу зүйл гарлаа гэсэн аль нэг муу тал юм уу болон өөр шинэ шалтаг хайж тохоохыг бодолгүй "энэ үйлийг хийсэн учраас энд төрлөө, ийм боллоо гэж бодохыг бурхан багш айлдсан бөлгөө" хэмээн айлдсан буй.

б) Тусгайлан дөрвөн хүчээр арилгах ёсон [47]

Тийнхүү гэм бурууг халдаахгүйн төлөө шамдах хэдий ч анхаарал сэрэмжгүй болон олон нисваанисын эрхээр гэм алдаа гарахад үл тоомсорлон орхиж болохгүй. Бурханы айлдсан жич заслын арганаа хичээх хэрэгтэй. Тэрхүү уналыг жич засахдаа гурван санваар тус тусаас айлдсан ёсоор үйлдэж болно. Хилэнцийг дөрвөн хүчний үүднээс засаж арилгана.

"Дөрвөн номыг үзүүлсэн судар"-аас: "Жамба аа, Бодисадва, Их бодисадва нар дөрвөн хүч төгөлдөр болвоос үйлдсэн болон хураасан нүгэл хилэнцийг хүлэн дарж чадна. Ямар дөрвөн зүйл хэмээвээс, энэ мэтээр тийн сөхөөн гаргагч хотол явдал, өрөндөгийн хотол явдал, гэмээс буцахуй, шүтээний хүч болой" хэмээжээ. Үйлдээд хураачихсан үйлийг амсах нь магадтай тул түүнийг сүрээр дарж чадваас амсах албагүйг хэлээд яах вэ.

/1/ Түүнээ анхдугаар хүч: Тэргүүлшгүй цагаас нүгэл үйлдсээр ирсэндээ олонтаа гэмших явдал бөлгөө. Ийм бодол төрүүлэхдээ тийн боловсрол тэргүүтэн гурван үрийн үүдэх ёсыг бясалгах хэрэгтэй. Гарын авлага болгож *"Алтан гэрэл судрын наминчлахуй"* болон *"Гучин таван бурханы үүднээс наминчлахуй"* хоёроор үйлдэж болно.

/2/ Хоёрдугаар хүчнээ зургаан зүйл:

а) Гүн судрын аймгийг шүтэх. Чанад хүрэхүй (Барамид) тэргүүтэн судрын үгийг авах, барих, унших тэргүүтэн мөн.

б) Хоосон чанарт сүслэх. Би үгүй болон тунгалаг гэрлийн мөн чанарыг ухах, анхнаасаа арилсан чанарт зэрэгт сэтгэл итгэмжлэх болой.

в) Урин тоолох. "Зуун үсэгт" (егжа) тэргүүтэн ялгамжаатай тогтоол тарни тэргүүтнийг зан үйлийн ёсоор урин тоолох болой.

"Бүнсэн бээр айлтгасан судар"-аас:

Хаврын ойд үсэрсэн галын цог
Харахын зуургүй хамаг ойг түймэрдэх мэт
Шагшаавадын салхиар урин тоолохуйн галыг ноцоож
Их хичээнгүйн гал дөлөөр хилэнцийг шатаах

Цаст уулнаа нарны гэрэл тусахуй яа
Цас мөс тэсэлгүй энэлэн хайлдаг шиг
Шагшаавадын наран гэрлийн урин тоолохуй бээр
Шаналж энэлэн хилэнцийн цас мөс барагдах буюу

Түнэр харанхуйн дотор зул барин асаахад
Тас харанхуй бүгдийг арилган цэлмээх адил
Олон мянган жил хураасан хилэнцийн харанхуйг
Урин тоолохуйн зулаар түргэнээ арилган үйлдэх хэмээн айлджээ.

Чингэхдээ нүгэл арилсан шинж гартал тоолж үйлдээрэй. Зүүдэнд муу идээгээр огих, тараг сүү уух, түүгээр огиулах, нар сар үзэгдэх, огторгуйгаар зорчих, гал бадрах, том үхэр болон хар хүн тэргүүтнийг дийлэх, гэлэн, гэлэнмаа, хувраг тэргүүтэн үзэгдэх, сүү гарах, мод, заан, сүргийн манлай, уул, арслант ширээ, сайхан байшин өөд авирах, ном сонсох зэргийг зүүдлэнэ гэж *"Шаардагчийн тогтоол"*-оос айлджээ.

г/ Лагшин дүрийг шүтэх. Бурханд сүсэглэн лагшин дүрийг бүтээх болой.

д/ Тахил өргөх. Бурхан болоод түүний суврага тэргүүтнийг элдэв зүйлээр тахих болой.

е/ Нэр алдар шүтэх. Бурхан болон их бодисадва нарын нэр алдрыг сонсож дуудах болой. Эдгээр нь *"Суртгаалын хураангуй"* -гаас айлдснаар бөгөөд бас бусад олон буй.

/3/ Гуравдугаар хүч:

Арван хар нүглийг үнэхээр боох явдал болой. Ингэснээр амь таслах тэргүүтний үүднээс гурван үүдний үйл, нисваанис, номын түйтгэр болж үйлдсэн ба үйлдүүлсэн, даган баяссан зэрэг урьд үйлдсэн бүгдийг дарна хэмээн *"Наран зүрхэн"*-ээс айлджээ. Сэтгэлийн мухраас боох санаагүй наминчлах төдий болчихно гэж болгоон хойшдоо ч боох буюу хэмээн *"Винайн агуу их тайлбар"*-аас номножээ.

Тиймээс хойшид ч үл үйлдэх хэмээх боомтлох сэтгэл маш чухал бөгөөд тийм бодол төрөхөд анхдугаар хүчнээс хамаарна.

/4/ Авралыг одуулах хийгээд бодь сэтгэлийг бясалгах тэргүүтэн болой.

Ер нь анхлан суралцагч нарт зориулж хэрхэн нүгэл хилэнцээ арилгах олон аргыг бурхан айлдсан буй. Гэхдээ дөрвөн хүч бүрэн бүрдсэн цагт төгс төгөлдөр ерөндөг болдог ажгуу.

Нүгэл арилах ёсон. Муу заяаны асар их зовлонг эдлэх байсан үйлийн үндсүүд багавтар зовлон эдлэх үндэс болж хувирах буюу муу заянд төрөх хэдий ч түүний зовлонг үл амсах ба эсвэл энэ насан дээр толгойн өвчин зэргээр арилах зэрэг болой. Мөн удаан хугацаанд эдлэх байсан үйлийн хугацаа нь богиносох юм уу ерөөс амсахгүй өнгөрөх ч байна. Гэхдээ эдгээр нь гэмээ арилгагч хүний хүчин чадлын их, багаас, ерөндөгийн дөрвөн хүч төгс төгөлдөр болсон, эс болсноос, тэдгээр баттай, батгүй болсноос, хэр удаан богино хугацаанд зэргээс хамаардаг учраас заавал бүгдээр арилна гэж үзэх албагүй шүү.

Судрын аймгууд болон Винайгаас: "Зуун галав болсон ч, Үйл барагдахгүй" гэж айлдсан байдаг нь ерөндөг дөрвөн хүчийг төгс бүрдүүлээгүй нөхцөлд тийн болохыг болгоожээ. Харин дээр үзүүлсэн

адилаар ерөндөг дөрвөн хүчнээ суралцваас амсах ёстой байсан үйл ч арилах учиртайг номножээ.

"Найман мянгатын их тайлбар"-аас: " Энэ мэтээр ерөндөгийн зүгтэй нөхөрлөх тусам хомсдох багасах жамтай тул хүчин чадал төгөлдөр ерөндөгөөр тэр бүгд огоот барагдах буюу. Үлгэрлэвээс хиртсэн алттай адил. Дээдийн номын түйтгэр тэр бүгдээр ч дээр номносон адилаар арилах жамтай учраас хөөргөн сэтгэлийн уналын хамаг орон бүгдийг арилгах болно.

Гэхдээ "Зуун галав болсон ч үйл..." хэмээснийг ерөндөгийн зүгийг бясалгаагүй нөхцөлд гэсэн утгаар ухаарах хэрэгтэй. Эс чингэвээс олон эш судар, учир шалтгаан лугаа харшилдана. "Магадтай амсах" гэсэн нь энэхүү утгаар айлджээ.

"Эс амсах" хэмээсэн нь басхүү ерөндөгийн зүгийг бясалгаагүй нөхцөлд ч хаая гарах үр дагаваруудыг багтааж мэдээрэй" хэмээжээ. Тэр мэтээр наминчлах боомтлох зэргээр тийн боловсролын үр гарах чадлыг доройтуулсан нөхцөлд бусад шалтгаан лугаа учирсан ч тийн боловсрох үр төрөхгүй. Тэрчлэн буруу үзэл төрөх болоод уураар буян дарагдах тэргүүтэнд ч адил болохыг айлджээ.

"Учир шалтгааны цог"-оос: "Нэгэн цагт буян байсан ч буруу үзэл, хорлох сэтгэлээс болж доройтох юм уу, нүгэл боловч муушаах, боомтлох, наминчлах зэргийн ерөндөгөөр хүч нь сулрах зэрэг тохиолдол нөхцөл тохироо бүрдэх шаардлагатай.

Гэхдээ буян, нүглийн хөрөнгө чадал барагдсан үед хаанаас ямар үр гарах билээ. Харин цаг хугацаа өөрчлөгдсөн ч нөхцөл бүрдээгүй үед яав ч язгуураас арилна гэж үгүй буюу. "Дээдийн номыг баригч тэрээр амсах ёстой нүглээ энэ насан дээр амсах болой" хэмээжээ.

"Муу заяанд хүргэх үйлүүд нь энэ насанд толгой өвдөх төдийгээр" хэмээн Судраас айлдсан буй. "Хэрвээ толгой өвдөх төдий зовлон байгаа бол язгуураас арилсан гэж хэрхэн үзэх вэ хэмээвээс, нүглийн үйлийн хамгийн төгс үр болсон тамын зовлонг амсаж эдлэх байснаа харин тэр зовлонгоос хумсын төдий ч амсахааргүй болж чадаж байгаа энэ чинь язгуураас арилсан биш гэж үү. Энэ насанд толгой өвдөх төдийгөөр дахиад огт үр гарахгүй байдалд хүрснийг юу гэж үзнэм" хэмээжээ.

Нисваанисын хөрөнгийг дарах ерөндөгийг хараахан олоогүй ч харшлах шалтгаанаар сулруулах нөхцөл бүрдсэнээр үр дагаварыг

гаргахгүй явдал гадаад дотоодын олон үзэгдэл юмс дээр тохиолдоно. Мөн түүнтэй адил их буян хураахаар хичээх үед ч буяныг дарах шалтгаан болсон уур хилэн зэргээс эс сэрэмжлэвээс дээрхийн адил болно. Тиймээс сэрэмжлэн нүглийн жич засалд хичээж шамдах хэрэгтэй.

"Маш хүнд нүгэл байсан ч арилгахаар байнга шамдаж чадсан бол тийн боловсролын үрээс бусад нөхцөлд" хэмээсэн нь ямар утгатай айлдал вэ гэвээс, Харалган төрөх зэргийн тийн боловсролын үр нэгэнт боловсорсон цагт одоогийн ярьж байгаа ерөндөгөөр арилгахад бэрхтэй. Тийн боловсролын үр боловсроогүй буюу үндэс шалтгааны үед буцаахад хялбар болохыг болгоон тийнхүү номносон учраас буруугүй болно.

"Учир шалтгааны цог"-оос: "Хэрвээ үнэхээр нүгэлээ арилгаж болдог юм бол юунд үйлийн тийн боловсролын үрээс бусад нөхцөлд хэмээсэн юм бэ гэвээс харалган, өрөөсөн нүдтэй, тахир, доголон, хэлгий, дүлий зэргийн ахуй байдлыг бий болгох үндэс болон тийм үр дагаварыг эдлэгч этгээдийг болгоон тийн айлджээ. Тийм учраас нэгэнт ач үр боловсорчихсан үеийн мөн чанарт оршсон үйлийг төгс арилгах чадал байхгүй. Харин үндэс шалтгааны үе буюу анх сэтгэлд илт хураагдах үед ялгавартай өөр бодол санаа олж авснаар төгс арилгаж болно.

Сорпрэн (Ангулимала), Мажида (Ажтасатру), Суга (Свака), Нянанмэд (Ашока) зэрэг эцгийгээ хөнөөгсдийг жишээнд үзүүлсэн болой. Чингэвэл юунд Мажида болон эхийгээ хөнөөгсдөд буяны бодол санаа бусад нэгэн төрсөн байтал яагаад үйлээ баралгүй тамд төрөө вэ хэмээвээс, Тэдэнд өөрсдийн хийсэн үйлийн үрдээ итгэх сэтгэл төрүүлэхийн тулд аюус там тэргүүтнийг үзүүлсэн хэрэг ээ. Үйлийн үлдэгдлээ арилгаагүй байсан биш ээ. Торго нэхэх бул чулуу нэг дээш гарч, нэг доош бууж ээлжлэх мэт тэнд нэг төрөөд буцаад гарсан болой. Тэд тамын галын цог дөлийг ч мэдрээгүй гэдэг. Ийм болохоор нүглийг язгуураас хөөж арилгаж болдог. Бас үйлийн үр үргэлжилсээр байгааг илтгэх буюу" хэмээжээ.

Зарим нэг бодгаль хүмүүсийн ялгамжаа байдгаас болж заавал тийн байх ёсгүй аж. Хаан Баву бээр Бодисадва Мэдог Дазэйг егүүтгэсэндээ гэмшиж суврага бүтээж агуу их тахил өргөж өдөрт гурвантаа нүглээ наминчлан ерэн таван сая жил ёс журмыг үнэнчээр сахисан боловч үхээд тамд төрсөн гэдэг.

Чингээд хорин жива галвын турш нүдээ тэс цохиулах зэргийн зовлонг хэмжээлшгүй ихээр эдэлсэн" хэмээн *"Бясалгалын хаан судар"*-аас айлджээ. Хэдий тийн боловч наминчлахгүй байж болохгүй шүү. Эс наминчлаваас түүнээс ч илүү их, өнө удаан зовлон эдлэх хэрэгтэй болох билээ. Ер наминчилах боомтлох зэргээр бүгдийг арилган ариусгаж болох хэдий ч анхнаасаа алдаа эндэлгүй ариун байлгах ба наминчлаад арилгах хоёрын хооронд их ялгаа бий.

"Бодисадвын газар"-аас: "Язгуурын унал гарахад бодисадвын санваар авч дахин засаж болох хэдий ч энэ насан дээр анхдугаар газрын эрдэм олох нь хойшлоно" гэж айлджээ. *"Тийн утсыг хураагч судар"*-аас: "Ялж төгөлдөр нөгчихсөн өө! Хэрвээ заримууд муу нөхрийн эрхээр номыг тэвчих үйл энэ адилыг үйлдсэн бол хэрхэх вэ. Ялж төгөлдөр нөгчихсөн өө! Тэр цагт тэрээр яаж гэтлэх вэ хэмээн айлтгав. Ялж төгөлдөр нөгчихсөн бээр Залуу Манзушир (Зөөлөн эгшигт) дор ийн хэмээн зарлиг болвой. Манзушир ээ, Долоон жилийн турш өдөр бүр гурвантаа гэм буруугаа хүлээж наминчласны дараа арилах болно.

Түүнээс цааш хамгийн багаар бодоход арван галвын дараа тэсвэрийн эрдмийг олох болой" хэмээн нүгэл арилсан хэдий ч тэсвэрийн эрдэм олоход хичнээн түргэндээ гэхэд арван галав хэрэгтэй" гэж айлджээ.

Хамаг нүглээ барна гэдэг сэтгэлд зохисгүй муу үр дагавар гарах байсныг арилгаж байгаа хэрэг. Мөрийн эрдэм онол төрөх явдал машид холдох учраас анхнаасаа халдаахгүйн төлөө шамдаж үйлдээрэй.

Тийм учраас хутагтан нараас "Амь насны төлөө ч байлаа өчүүхэн төдий нүгэлд мэдсээр байж бүү оропун" хэмээн айлдсан буй. Хэрвээ наминчлаад арилгах болон анхнаасаа ариун сахих хоёрын хооронд ялгаа байхгүй байсан бол ингэж айлтгахын хэрэг юун билээ. Ертөнцөд ч ийм байдал үзэгдэнэ. Хөл гараа гэмтээж бэртээхэд жич засаж болох хэдий ч анхнаасаа гэмтээхгүй байхтай адилгүй билээ.

Ингээд хичээх талаар "Цоморлиг"-оос:

Нүгэл үйлдэхээс буяныг үл үйлдэгч
Номтой эсэргэлдэн ном бусыг эдлэгч хүмүүн,
Нүглийн үйлт амьтан үхлийн аюулд нэрвэгдэх бөгөөд
Муу хөлөг онгоц их далайд живэх адил

Буяныг туурвин нүглийг үл үйлдэх
Дээдсийн номын ёсоор явагч нар
Хэзээд үхлийн аюулаас үл айх бөгөөд
Сайн хөлөг онгоц далайн чанадад хүрдэгтэй адил

хэмээн айлдсан мэт түрүүчийг үл үйлдэн сүүлчийг номносон дагуу үйлдээрэй. Мөн зөв зүйтэй үг өгүүлэвч сэрэмжгүй хандваас хэрэг бага гарна. Ном багатайгаас мэдэхгүй байвч алин мэдсэн зүйл дээрээ ч авч орхихыг бүтээвээс их хэрэг бүтнэ.

"Цоморлиг"-оос:

Хэдий зөв зүйтэй олныг өгүүлэвч
Сэрэмжгүй аваас хүмүүс дээрх адил үйлдэж чадахгүй
Үлгэрлэвээс малчин хүн бусдын малыг тоолох адил
Тэд буянтны хувийг үл олох буюу

Хэдий зөв зохистой бага зүйл ярих ч
Номын ёсоор номыг үйлдэх хийгээд
Шунал урин мунхагаа тэвчигч тэдгээр
Буянтны хувийг олсон болой

Аяга тахимлагууд сэрэмжтэй явахад баярлах ба
Сэрэмжгүй явахаас айхын учир
Өөрийгөө муу заяанаас татагч агаад
Шавраас бусдыг татагч их заан адил

Аяга тахимлагууд явахад баярлах ба
Сэрэмжгүй явахад айхын учир
Салхинд хийсэх модны навч адил
Саар нүгэл бүхнийг сэгсэрч орхих хэмээжээ.

Мөн *"Садангийн захидал"*-аас:

Хэрвээ өндөр язгуур, бурхан хутгийг хүсвээс
Үнэн үзлийг судлан дадуулж зохиогтун
Хэн нэгэн буруу үзлийг хэдий сайн сурсан ч бай
Хэмжээлшгүй буруу үр дагавар боловсрох буюу

хэмээсэн мэтээр шүтэн барилдаж гарсан хоёр үйлийн үрийг ёсчлон заасан

энэхүү үзэл нь хамаг хөлгөн болон төрөлхтөн бүгдийн хэргийг бүтээх заавал байх үндэс билээ. Дээр номносноо суурилан *"Дурдахуйг шадар агуулахуй"*, *"Цэцэн тэнэгийн судар"*, *"Зуун үйл"*, *"Зуун домог"*, *"Винайн эшийн дамжлага яриа"* зэрэг болон бусад эрхэм зарлигуудаас үзэж бат зөв магадлалыг баттай сайнаар олж авч гол утгыг бариарай.

Б. Тэрхүү бага төрөлхтний санаа бодол төрөх хэмжээ

Урьд нь энэ ертөнцийг завсаргүй чухалчлах санаа бодолтой байлаа. Хойд насаа чухалчлах үгийг даган ухаарах төдий болсноор тэр бодол чинь өөрчлөгдөж хойд насаа голдуу чухалчлах болж ирэх вий. Энэ насаа дашрамд бодно. Гэвч цааш баттай болгох шаардлагатай тул тийм бодол төрсөн хэдий ч шамдаж суралцаарай

В.Тэдгээрийн талаарх буруу сэжгийг буцаах

Эрхэм зарлигаас хорвоогийн хотол чуулган бүхнээс сэтгэлээ буцаах хэрэгтэй гэж айлдсанаа эндүүрсэн нэгэн бээр "Бие, төгс эдлэл тэргүүтэн хотол чуулсан өндөр язгуур нь хорвоо учраас түүнийг чухалчлах нь зохисгүй болой" хэмээнэ. Чухалчлах зүйлд чинь орон үесийн болон алс хэтийн чухалчлах зүйл гэж хоёр буй. Тэдгээрээс хорвоогийн бие тэргүүтэн хотол чуулганыг тонилохуйг хүсэгч хэн ч орон үест чухалчлах ёстой шүү.

Тэрхүү бие шүтээнийг дамжин байж алсдаа тонилохуйн хутгаа олдог жамтай. Бие, төгс эдлэл, нөхөр сэлтийн хотол чуулганы өндөр язгуур тэр бүгдээр хорвоод (зовлонд) хураагдах бус аа. Бие тэргүүтэн хотол чуулж төгс боловсроод ирэхээр дүрст лагшин болж бусад нь түүний оронгийн хүч чадал, түүний нөхөр сэлт болдог билээ.

Тэдгээрийг болгоож "Судрын аймгийн чимэг"- ээс

Төгс эдлэл болон бие хотол чуулган,
Нөхөр хотол чуулганы өндөр язгуур

хэмээн эхний дөрвөн барамидаар өндөр язгуурыг олохыг айлдсан байна. Мөн олон номоос тэдгээрээр бурханы дүрст лагшин бүтдэгийг айлджээ. Тиймээс хамгийг болгоогчийн хутгийг бүтээгч нар ёс суртахуун, өглөг, тэсвэр тэргүүтэн эрдмийг маш олонтоо эрхэм сайнаар өнө үргэлжид бүтээх хэрэгтэй тул тэдгээрийн үндэс болсон өндөр язгуурыг эрхэм сайнаар

чухалчилдаг бөлгөө. Эцэстээ нирваан хутгийг бүтээх талаар

"Бодичаряаватара"-гаас:

Хүмүүний онгоцыг шүтэн явсаар
Зовлонгийн их далайгаас гэтлэх буюу

хэмээн айлдсан мэтээр хүмүүний шүтээнээс эхлэх сайн заяаг шүтэн дамжсаар зовлонгийн далайгаас гэтлэн хамгийг болгоогчийн хутагт хүрэх хэрэгтэй билээ. Чингэхдээ олон төрөл дамжих шаардлагатай. Тэрхүү бие шүтээнийг бүтээх дээд үндэс ёс суртахуун болвоос мөрийн язгуур болой.

Сайн заяаны бие хэдий ч бэлэг чанар огоот төгс бус болоод эрдэм ганц нэг байснаар мөрийг бүтээж болох боловч газрын ахицаа гарахгүй тул огоот төгс болгох хэрэгтэй. Тийм болохоор "буяны ёстон" тэргүүтэн суртгаалын суурь огоот төгс бус тэргүүтнийг сахихаар зогсохгүй "аяга тахимлаг" тэргүүтэн огоот төгс суртгаалын суурь тэргүүтнийг сахихаар шамдах хэрэгтэй.

Заримууд сахил сахиснаар сайн заяанд хүрэхэд нэг өдрийн сахилаар олчих тул бэрх хэцүү бас хэрэг багатай аяга тахимлагийн сахилаар юу хийх гэж хэлнэ. Мөн заримууд тус тус гэтлэх санваарын хэрэг нь дайснаа дарсны үрийг олохын төлөө болохоор аяга тахимлагийн санваарыг хорин нас хүртэл өгдөггүй буюу.

Уваш сахилтны шүтээн дээр ч дайснаа дарсны үрийг олж болно гэж эл шүтээнийг сайшаасан тул бэрх хэцүү хэрэг багатай аяга тахимлагаар юу хийх хэмээнэ. Ийн өгүүлэгч нар болвоос дээдийн номын аньсыг ухааргүй хүний дэмий чалчаа үг гэж мэдээрэй. Бага санваар дээр суурь хийж дээшхи их санвааруудыг хүртэж суртгаалын суурийг огоот төгс сахиж бүтээгээрэй.

Бага төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн зэрэгт ухаанаа судлахуйг номновой.



(II) ДУНД ТӨРӨЛХТӨН ЛҮГЭЭ НИЙТИЙН МӨР

Эрхэм ариун дээд богд их нигүүлсэхүй төгөлдөр та бүхнээ бишрэн мөргөмү. Тийнхүү үхэхийг дурдан санаж улмаар муу заянд унах жамыг бодсоноор энэ ертөнцөөс ухаанаа буцаан хойд насаа чухалчлах санаа төрж ирнэ. Чингээд нийтийн авралыг одуулах ёс болон хар цагаан үйлийн үрийг ухаарахын үүднээс нүглийг тэвчиж буяныг бүтээн шамдсанаар сайн заяаны хутгийг олж болно. Гэсэн хэдий ч энэ үест энэ төдийгээр хязгаарлаж болохгүй.

Бага төрөлхтний нийтийн ухааныг төрүүлээд дараагаар нь дунд төрөлхтний нийтийн ухаан болох зовлонт хорвоод шунах сэтгэлээ буцааж түүнээ шүтэн тонилохуйн ухааныг бясалгана. Тийм ухаанд хүрч байж эрхэм бодь сэтгэл төрөх буюу. Тиймээс их төрөлхтнөө хөтлөх дунд төрөлхтний мөрийг судлах хэрэг гарч ирнэ. Энэ мэтээр тэнгэр хүмүүний хутгийг олж болох ч хуран үйлдэх зовлонгоос үл хэтрэх ба түүнийг үнэхээр бүтсэн жаргал гэж баригч буруу үзлээр тийн болохоос бус үнэн жаргал байхгүй билээ. Харин буцаад муу заяандаа унадаг учраас эцэстээ таагүй нэгэн буюу. Үлгэрлэвээс даруй хадан халил руу унах гэж яваа нэгэн бээр ирмэг дээр түр амсхийх лүгээ адил болохыг *"Бодичарияаватара"*-д:

Амгалант заянд дахин дахин төрж
Амгалан жаргалыг олонтаа эдлэх хэдий ч
Өнгөрч үхсний дараа муу заяаны зовлон
Өнө удаан барагдашгүй болсноо унах хэмээжээ.

"Шавийн захидал"-д ч:

Алин хэн орчлонгийн хүрднээ мөнхөд эргэлдэн
Ашид дотор оршин амсхийж яваагаа жаргал гэж сэтгэх
Тийнхүү өөрийн эрхгүй магадтай зэрэгчлэн олон дахин
Тэнцсэн тэнцээгүй төрөл бүхнээ тэнэн явах хэмээн айлджээ.

Иймээс сайн муу заяанаас ялгалгүй адилхан уйдах ёстой.

"Дөрвөн зуут"-д:

Мэргэд нарт өдөр сайн заяа байлаа ч
Там адилын аюултай санагдах
Хаана хэзээ боловч тэднээ
Хорвоогоос айхгүй суух нь ховор хэмээсэн ба

"Их эрдмийн хураангуй"-д: "Шунасан сэтгэлтэнгүүд хорвоод үргэлж эргэлдэх" хэмээжээ.

"Шавийн захидал"-аас ч:

Хэзээ ямагт амгалантай гэдэг бодол амьтан бүхнээ төрснөөр
Тэр мэт тэр төдийгөөр мунхагийн харанхуй улам зузаарах
Хэзээ ямагт зовлонтой гэдэг ухаан амьтан бүхнээ төрснөөр
Тэр мэт тэр төдийгөөр мунхагийн харанхуй улам нимгэрэх

Хэзээ ямагт жаргалтай хэмээн улам их бясалгах тусам
Тэр адилаар шуналын гал улам бадрах
Хэзээ ямагт зовлонтой хэмээн улам их бясалгах тусам
Тэр адилаар шуналын гал машид сүүмийх болмой

хэмээн тэргүүлшгүй цагаас хорвоогийн хотол чуулган бүхнийг амгалантай хэмээн сэтгэж жаргалтай хэмээн хөөрцөглөж дадсан бодлынхоо эрөндөг болгож зовлонтой, бас жаргалгүй хэмээн тунгааж бясалгаваас тэдгээр буруу бодол буцна.

Эс бясалгаваас мунхаг болон, шунал арвижин зовлонгийн хүрднээ эргэлдэх хэмээн айлдсан тул хорвоогийн гэм эргүүг бясалгах ухаан маш чухал бөлгөө.

Дунд төрөлхтний нийтийн мөрийн зэрэгт оюунаа судлахад дөрвөн зүйл:

А. Сэтгэлийг бодитой судлах
Б. Судлах бодол төрөх хэмжээ
В. Алжаас буруу бодлыг буцаах
Г. Нирваан (тонилохуй) хүрэх мөрийн мөн чанарыг үзүүлэх болой.

Эдгээрээс:

А. Сэтгэлийг бодитой судлахад хоёр

1. Нирвааныг чухалчлах ухааныг танин барих
2. Түүнийг төрүүлэх арга замын үүднээс санах болой.

1. Нирвааныг чухалчлах ухааныг танин барих

Тонилохуй хутаг (нирваан) бол хүлээснээс гэтэлсэн эрдэм бөлгөө. Үйл, нисваанис хоёр орчлонд хүлэгч буюу. Тэр хоёрын эрхээр Хүсэлт ертөнц тэргүүтэн гурван ертөнцөд төрнө. Мөн амьтны язгуураар бол тэнгэр тэргүүтэн тав буюу зургаан төрөлд төрнө. Төрөх орны үүднээс умайд төрөх зэрэг дөрвөн зүйлээр төрөл авдаг билээ.

Тийнхүү төрөл авч яваа маань хүлэгдэж буй хэрэг болой. Үүнээс гарах нь тонилохуй болой. Тийм хутагийг олох хүсэл эгээрлийг тонилохуйг буюу нирвааныг чухалчлагч ухаан хэмээнэ. Үйл нисваанисаас үүдсэн бүхэн төрөх ба дараа нь түрдэж үгүй болж байгаагаар нь тонилолоо гэж хэлж байгаа бус. Чингэвээс төрөх юмс хоёрдахь агшиндаа түрдэх учраас ерөндгийг бясалгах зэрэг шалтгаан нөхцлөөс харгалзалгүй ямар ч хичээл шамдалгүйгээр бүгдээрээ тонилох гэм гарахад хүрнэ. Иймээс ерөндөг шүтэхгүй бол цааш цаашдаа дахин дахин төрөл авахад хүрнэ. Харин ерөндөг шүтсэний хүчээр төрөл авахаас буцдаг болой.

2. Түүнийг төрүүлэх арга зам.

Үлгэрлэвээс цангахын зовлон амсахгүй гэсэн хүсэл төрүүлэхэд цангах энэлгээг огт үл хүсэх байдал гарч ирэх эсэхээс хамаардаг. Үүнтэй адил чухал авсан цогцосын зовлонг амарлиулах нирвааныг олох хүслийг төрүүлэхэд ч уг цогцосынхоо зовлонгийн мөн чанарт гэм бурууг таньж мэдэхээс хамаарна. Иймээс орчлонгийн гэм бурууг бясалган түүнээс гарах ухаан эс төрөх хүртэл тэрхүү зовлонг амарлиулах нирваан хутгийг олох хүсэл үл төрнө. *"Дөрвөн зуут"*-д:

Алин түүнээ уйсах бодол эс төрвөөс
Амарлиулах бишрэл хаанаас ирэх вэ
Өөрийн гэрт байгаа шиг шунах аваас
Эндээс гарч явахад бэрхтэй буюу хэмээжээ.

Тиймээс нирвааныг чухалчлах арга замд:

а. Зовлон хийгээд Бүхэн гарахуйн (Зовлонгийн үндэс) үүднээс санах болон [48]

б. Арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санах хоёр [49]

а. Зовлон хийгээд Бүхэн гарахуйн үүднээс санах

1) "Зовлонгийн үнэн" буюу орчлонгийн гэм эргүүг санах
2) "Бүхэн гарахуйн үнэн" буюу орчлонд эргэлдэхийн зэргийг санах

1) Зовлонгийн үнэн буюу орчлонгийн гэм эргүүг санах

а) Зовлонгийн үнэнийг дөрвөн үнэний эхэнд айлдсан хэргийг үзүүлэх
б) Зовлонг бодитой бясалгах болой.

а) Зовлонгийн үнэнийг дөрвөн үнэний эхэнд айлдсан хэргийг үзүүлэх:

Бүхэн гарахуй үнэн бол үндэс шалтгаан юм. Зовлонгийн үнэн бол түүнээс үүдсэн үр болой. Тиймээс бүхэн гарахуй нь эхэлж гараад хойноос зовлон гарах учиртай. Гэтэл юунд Бурхан бээр тэрхүү утгатай үл нийлүүлэн "Аяга тахимлаг нар аа, Энэхүү зовлон хутагтын үнэн болой. Энэхүү бүхэн гарахуй хутагтын үнэн болой" хэмээн айлдав хэмээвээс. Бурхан ийн учир шалтгааны эрэмбэ зэргээс буцаан айлдсан нь анхааран бясалгахын ач тустай учраас гэм байхгүй ээ. Учир нь эхлээд шавь нарт орчлонгоос магад тонилох санаа эндүүрэггүй нэг төрөхгүй бол үндэс шалтгаан юуг таслаж тонилохуйн мөрд хэрхэн орох билээ. Тийм л учраас шавь нар эхнээсээ мунхагийн харанхуйд хөлхөгдөн зовлонт орчлонгийн хотол чуулганыг жаргалтай мэтээр барих чанх буруу үзэлд хуургагдах ажгуу.

"Дөрвөн зуут"-д:

Энэхүү зовлонгийн далайд
Эцэс хязгаар хэзээ ч үгүй
Энэ л газар нялхас живэх хэрнээ
Эвэршээж юунд үл айх хэмээн айлдсан мэт

Иймээс "Энэ орчлон үнэнхүү жаргалтай бус зовлонтой болой" хэмээн зовлонгийн олон байдлыг айлдаж уйтгар төрүүлэхийн тухайд "зовлонгийн үнэнийг" анх түрүүн айлджээ. Цаашлаад зовлонгийн далайд унаснаа мэдээд ирэхээр түүнээс тонилсу гэх бодол төрнө. Тийм бодол бий

болсноор зовлонгоо хариулах хэрэгтэй гэх бодол төрнө. Чингэхдээ уг шалтгааныг буцаахгүй бол бүтэхгүй гэдгийг мэдэж авна. Улмаар уг шалтгаан юун хэмээж бүхэн гарахуйн үнэнийг мэдэх шаардлага гарч ирдэг. Иймээс түүний дараагаар "бүхэн гарахуйн үнэнийг" айлджээ.

Чингээд орчлонгийн зовлон гэдэг цувиралт үйлээс үүдэх, үйл өөрөө нисваанисаас үүдэх, нисваанисын үндэс "би-д барих" үзлээс үүдэх зэрэг бүхэн гарахуйн үнэнийг таньж мэднэ. Ийн мэдээд "би-д барих" үзлийг буцаах хэрэгтэй гэдгийг ухаж "хорихуйн үнэнийг" илт олохоор сэтгэлээр тангараглахад хүрдэг учраас "хорихуйн үнэнийг" үүний дараа айлдсан бөлгөө.

"Зовлонгийн үнэнийг үзүүлснээр тонилохуйг хүсэх санаа төрөх учир зовлонгийн үнэний дараа хорихуйн үнэнийг заах хэрэгтэй бус уу" хэмээвээс, ийн номноход гэм байхгүй. Тэр цагт зовлон амарлиулах нирваан хутгийг олно гэх нирвааныг хүсэх сэтгэл байх хэдий ч зовлонгийн үндсээ таньж мэдээгүй, тэрхүү үндсээ буцааж чадна гэж ухаагүй зэргийн улмаас хорихуйн хутгийг илт болгосугай хэмээн нирвааныг зорилгоо болгож тавиагүй байдаг.

Тийнхүү нирваан хутгийг илт болгосугай хэмээх зорилго тавиад ирэхээр түүнд хүрэх зам мөр юу болохыг үзүүлсэн "мөрийн үнээ" орох учраас сүүлд нь "мөрийн үнэнийг" айлдсан болой.

"*Дээд дамжлага*"-д:

Өвчнөө мэдэж, өвчний угаа тэвчих,
Эрүүл энхийг хүсэж, эмч эмийг шүтэх адилаар
Зовлон ба үндэс шалтгаан, түүнийг хорихуй, түүнд хүрэх зам мөрийг
Мэдэж, тэвчиж, зорьж бас бүтээж үйлдсүгэй хэмээн айлджээ.

Ийнхүү дөрвөн үнэний талаар их, бага хөлгөн бүхэнд олонтоо айлдсан байна. Бурхан бээр, зовлонд учрах хийгээд түүнээс буцах увдис сэлтийг үүнд товчоолон айлдсан учраас тонилохуйн хутгийг бүтээхэд тун чухал болой. Анхааран бясалгахын хувьд хорьж боох зүйл ихтэй ч энэхүү зэргээр шавийг хөтлөх хэрэгтэй. Зовлон үнэн болохыг мэдээд орчлонгоос лавтай шуналаа буцааж эс чадваас, нирвааныг олох хүсэл чинь үг төдий болж хоцроно. Тиймээс юу үйлдсэн бүгдээр нисваанис болж одно. Бүхэн гарахуйг санахын үүднээс орчлонгийн үндэс болсон үйл нисваанисыг сайтар эс мэдвээс "байгаа харалгүй сумаа тавих" хэмээхийн адилаар

мөрийн аньс утга алдран ертөнцөөс гэтлэх мөр бусыг мөр хэмээн барьж ямар ч ашиггүй алжааж баахан зовоход хүрнэ. Тэвчих ёстой зовлон, түүний шалтгаан хоёроо эс ухаарваас тэдгээрийг амарлиулагч нирваан хутгаа ч таньж мэдэхгүйд хүрэх тул нирваныг хүсэх сэтгэл нь хий мөрөөдөл болж барагдана.

Найман зовлонг санах

б) Зовлонг бодитой бясалгахад хоёр:

1. Хорвоогийн зовлонг ерөнхий санах
2. Тус тусын зовлонг санах

1. Хорвоогийн зовлонг ерөнхий санах

(а) Найман зовлонг санах
(б) Зургаан зовлонг санах
(в) Гурван зовлонг санах

(а) Найман зовлонг санах:

"Садангийн захидал"-д:

Магад шунаснаар хоосрох ба үхэх,
Өвдөх, өтлөх зэрэг олон зовлонгууд зэрэг
Гарахын орон-Орчлон хэмээн уйсан зохиох бөгөөд

хэмээн айлдснаар бясалгах болой. Ийнхүү орчлонгоос уйдах сэтгэл төрнө гэдэг түүнийг хамаг зовлонгийн үүр уурхай гэж ухаарах явдал буюу. Зовлонгийн хувьд энд үзүүлж буй шунаснаар хоосрох зэрэг дөрөв болоод зэрэг гэдэг үгээр товчилсон дөрвөн зовлон нийлээд найм болой.

Эдгээр найман зовлонгийн талаар Бурхан бээр судрын олон аймгийн зовлонг бодитой заан үзүүлэх хэсэгтээ олонтаа айлджээ. Дунд лугаа нийтийн мөрийн бодол санааг бясалгах үес бүхэнд ч бага лугаа нийтийн мөрийн үест номносон бүгдийг энд ч мөн анхааран авах хэрэгтэй.

Оюуны чадал хүрвэл нийт бусын судлах орны үест хэрхэн номносон дагуу судлаарай. Хэрвээ оюуны чадал бага аваас эш татсан хэсгийг орхиод

тухай тухай үесийн утгын мөн чанарыг бясалгаарай. Энэ бүгд шинжлэх бясалгал хэдий ч бясалгах ёстой зүйлээсээ бусад ямарваа нэгэн буян, нүгэл, эш үл үзүүлсэн зэрэгт сэтгэлээ алдалгүй бодсон бодлоосоо сэтгэлээ салгалгүй үйлдэх хэрэгтэй. Нойрсон харанхуйлах, живэх зэргийн эрхэнд оролгүй саруул ухаан гэгээн сэтгэлээр тууштай бясалгах хэрэгтэй.

"Бодичарияаватара"-д:

Урин тоолох болон хатуужил тэвчээр зэргийг
Өнө удаан хугацаанд бясалган туурвивч
Бусдад сэтгэл алгасран үйлдвээс
Тэр л язгуураас утгагүй хэмээн айлджээ

хэмээн сэтгэл бусад руу алгасарч үйлдсэн буян бүхний үр өчүүхэн бага гарахыг айлджээ. *"Их хөлгөнөө сүсэг бясалгах судар"*-т ч: "Язгуурын хөвгүүн ээ! Ийнхүү бодисадва нарын их хөлгөнөө сүслэх ба их хөлгөн төрөх энэхүү зүйл алин бэ хэмээвээс, тэр бүгд тийн эс алгасрах сэтгэл утга болоод номыг үнэхээр бодох сэтгэлээс гарахыг мэдээрэй" хэмээн айлджээ.

Тэрхүү "эс алгасрах сэтгэл" бол буяны бодлоос сэтгэлээ үл алгасруулах явдал болой. "Утга болон ном" гэдэг нь үг утгыг сайтар тунгаан тус тус оногч ухаанаар оножшинжлэх болой. Иймээс эрдэм номын бүтээл бүхэнд энэ хоёр хэрэгтэй болохыг үзүүлжээ. Иймучраас гурван хөлгөний эрдэм бүгдийг бүтээхийн тулд сэтгэлээ буяны бодлоос өөр зүйлд үл алгасруулан нэгэн үзүүрт бодолд төвлөрүүлэх бодит "амарлингуй сэтгэл" болон түүн лүгээ зохилдох нэгэн хийгээд, буяны бодлоо тус тус шинжлэн янагуух болон үнэмлэхүй зэргээр ялган ухаарагч бодит "үлэмж үзэгч ухаан" болон түүн лүгээ зохилдох нэгэн гэсэн хоёр сэтгэл шаардлагатайг ийн айлджээ.

Тийн болохыг *"Хутагт тааллын тайлбар"*-т: "Майдар аа! Сонсоод сонсогч нар, бодисадва нар, Түүнчлэн заларсан бурхад нарын ертөнц болон ертөнцөөс нөгчихсөн буян ном бүгд ч амарлингуй сэтгэл болон үлэмж үзэгч ухааны үр гэж ойлгоорой" хэмээн айлджээ.

Чингэхдээ бодит болон даган зохилдох гэж хоёр ялгаж үзэхгүй бол гурван хөлгөний эрдэм бүгд бодит амарлингуй болон үлэмж хоёрын үр болох ч бас албагүй болой. Найман зовлон дараах болой.

1. Төрөхийн зовлон. Түүнээ таван зүйл буй.

(а) Төрөхдөө өвдөж зовж төрдөг учраас зовлонтой буюу. Үргэлжийн зовлонт тамын амьтад, бирдүүд, умайнаас төрөгсөд болон өндөгнөөс төрөгсөд зэрэг эдгээр дөрвөн зүйлд төрөл авахад маш их хүчтэй нажид зовлонг амсдаг болой.

(б) Төрөхдөө муу авьяастай барилдах учраас зовлонт болой. Гурван ертөнцийн хуран үйлдсэн бүхэн нисваанисын зүгт багтах муу авьяас төгөлдөр учраас үл эрхшээгдэх, үл номхрох болой. Гурван ертөнцийн амьтан бүрэлдэн буй болсон ч муу сэтгэлийн зүгт хамаарах муу авьяас лугаа барилдсан байна. Товчхон өгүүлвээс муу сэтгэлийн төрөх, орших, арвижихын хөрөнгөтэй барилдсан байдаг учраас буян тогтоох, бүтээхийн үйлнээ чадалгүй, хүслээр эрхшээх чадалгүй ажээ.

(в) Төрөх гэдэг зовлонгийн орон учраас зовлонт болой. Гурван оронд төрөл авснаас болж өтлөх, өвдөх, үхэх тэргүүтний зовлон маш ихээр дэлгэрэх болой.

(г) Төрөх гэдэг муу сэтгэлийн орон болдог учраас зовлонт болно. Орчлонд төрөнгүүт шунах, уригнах, мунхрахын орон лугаа учран түүнээс уршигдан гурван хорт сэтгэл үүднэ. Улмаар бие, сэтгэл үл амран зовох бөгөөд амгалан үл гарна. Элдэв муу сэтгэлийн гайгаар бие сэтгэлийн зовлон эдэлнэ.

(д) Хүсээгүй атал хагацахын жамт учраас төрөх гэдэг зовлон буюу. Төрсөн бүгдээр эцэстээ үхлээс үл гэтлэх болой. Түүнийг эс хүсэвч зовлон ямагтыг амсуулмой тэр бээр. Төрөхийн цагт төгс төгөлдөр энэлэл зовлон, муу зан авиртай төрнө. Төрсөн заяа нь өвдөх, өтлөх болон олон нисваанис, бүр явсаар үхэлээр баригдана. Ийнхүү зовж гаслах жамыг санаж аваарай.

Ялангуяа эхийн хэвлийд оршихын үест хэрхэн зовлон амсах талаар: *"Шавийн захидал"*-д айлдахдаа:

Машид тэсэхүй еэ бэрх өмхий үнэрт хананд шахагдан
Машид түнэр харанхуй сүүдэр бүрхсэн там адилын дотор
Хэвлийд оршигч (үр хөврөл) хамаг биеэ атийлган хумьж
Хамаг зовлонг эдлэх болой хэмээсэн мэт болой.

Эдгээрийн утгыг *"Хэвлийд оршихуй судар"*-т: "Хэвлийд оршигч бээр элдэв зүйлийн бузар буртгаар огоот бялхах түм буман язгуурын нян хорхой орших, өмхий муухай үнэр ханхалсан хоёр үүдэт, элдэв олон ясны нүх

сүв, баас, шээс, тархи, тархины эд, өтгөн шүлс, чөмөг зэргээр дүүрсэн балчиг шавартай орон зайд ходоодны доохон талд нарийн гэдэсний дээхэн талд амаа нурууны үе рүү хандуулж ходоод гэдсэнд нуруугаа харуулан оршино.

Сар сард буух сарын тэмдгээр тэжээгдэнэ. Эхийн дээд доод хоёр шүдээр зажилж залгисан идээ хоолны зүйл түүний гол тэжээл болдог. Тэрхүү хоол тэжээл нь залгисны дараа доод талаас амны хөндийн хир буртагт шүлс салхиагаар чийглэгдэж дээд талаас тархинаас буух зузаан шүлс салиагаар дэвтээгдэнэ. Иймэрхүү байдлаар боловсорсон идээ бээрийн зүйл доошилж хүйсний нүхээр орж үр хөврөлийг тэжээж өсгөдөг бөлгөө.

Цаашлаад үр хөврөл улцганан улцганах, мэлмэлзэн мэлмэлзэх, суналзан сунах, дүгрэглэн дугуйрах зэрэг биежих үе шатуудыг дамжин гар хөл зэрэг эрхтэн бүрэн төгс бий болох явц үргэлжилнэ. Ихэсийн саванд нүүр, гар, хөл бүгд багтана. Түнэр харанхуй нөмөрсөн нүхэнд өмхий муухай үнэр ханхлуулсан нус цэр, баас шээс дээш доош эргэлдэнэ. Нүүрс адил төөнөх нарийн гэдэсний дулаан илчэнд элдвийн эхүүн, гашуун, ширүүн, давстай, халуун, хурц гэх мэт амттай идээ хоолны үлдэгдлүүд бузар шингэнтэй холилдон боловсорно. Улмаар гал бадарсан балчиг намаг болон өөрчлөгдөнө. Ийм нөхцөлд амь нас ч баттай бус аа.

Эхийн биеийн доторх галын илчинд энэлэх, маш ихээр энэлэх, бүрэн гүйцэд энэлэх буюу. Мөн халах, маш ихээр халах, бүрэн гүйцэд халах буюу. Бас түлэгдэх, маш ихээр түлэгдэх, бүрэн гүйцэд түлэгдэх зэргээр зовох болой. Эдгээр зовлонг ихээр, хүчтэйгээр, хатуугаар, барагдашгүй муугаар амсаж эдлэдэг байна. Хэдий хүртэл эх хүн хөдлөх, маш ихээр хөдлөх, бүрэн төгс хөдлөх тэр төдийгөөр нөгөө үр хөврөл таван хүлээсээр хүлэгдэж галт гуунд суух адилын гай зовлонг ихээр, хүчтэйгээр, хатуугаар, барагдашгүй муугаар амсах болой" хэмээн айлджээ.

Мөн "Эх хүн идээ хоолоо хэтрүүлэх дутаах, хэтэрхий хатуу зөөлөн, хүйтэн халуун болон их давстай, хэтэрхий гашуун нясуун, чихэрлэг, амтлаг, халуун, шорвог исгэлэн идээ ундааг хэрэглэх, хүслийн явдлаар явах, хэтэрхий их явах давхих, гүйх, харайх, усанд сэлэх, галын дэргэд суух, цомцойж суух зэрэг нь үр хөврөлд хортой болохыг айлджээ. Тэрчлэн нарийн гэдэс, олгой ходоодоо шахах, бүс бүслэхэд хүртэл дотор байгаа үр хөврөлд таван хүлээсээр баглачихсан юм шиг эсвэл сэрээ шороор хатгуулах адил болдог" хэмээжээ.

Ингээд хэвлийгээс төрөх буюу гадагш нярайлахын цагт ямар зовлонтой учрах талаар *"Шавийн захидал"*-д:

Тэрээр уур нүдүүрт тос болтол шахагдах дэл будаа
Шахуурганд орж хавчуулагдах адилаар зэрэгчлэн төрж гарна
Гэвч тэр даруйдаа амиа алдах ч бий
Маш их зовлон зүдгүүр эдлэн байж төрөх буй за

Бузар буртаг дотор хөлбөрөн торнисон өнөө бие
Умайд байхдаа тэсэшгүй муухай өмхий бөөлжистэй хутгалдан
Хатгуулга хорлолд баригдан боловсорсон яр шарх задрах мэт
Хоолой тээглэж огиулах зэргээр зовж урьдын санаснаа мартаж төрөх

хэмээжээ. Эдгээр утгын талаар *"Хэвлийд оршихуй судар"*-т: "Чингээд бие эрхтэн бүгд бүрэн боловсроод гүйцэхээр ялзарсан шээсний оронд сууж байснаа босож, тэсэхийн аргагүй муухай үнэр ханхлах түнэр харанхуй, үзэхийн аргагүй аймшгийн орон, баас шээс наалдсан өмхий үнэрт, үргэлж цус шар ус садрах яр шархан хаалган дээр урьдын үйлээс боловсрон гарсан хийний хүчээр хөл нь дээшээ толгой нь түрүүгээ харж байрлана.

Хоёр гараа хумьж, хоёр ясны хүрднээ шахуулан тарчлах, ихээр тарчлах, хамаг байдгаар тарчилж, зовлон нажидыг ихээр, хүчтэйгээр, хатуугаар, барагдашгүй ихээр эдлэх буюу. Улмаар биеийн бүх эрхтнүүд шинэ шархны халуун адил хөхөртөл өвдөж хавдан бүх биеэр халуу шатна. Умайн өмхий үнэрт бузар буртаг биеийг бүрхэнэ. Ундаасаж цангаж хоолой, ам, зүрх хатна. Амьсгаа давчдах тэсэхийн аргагүй зовох тэр орноо шалтгаан нөхцөл бүрдэхийн эрхээр урьдын үйл боловсрон төрөх хийгээр өргөгдөн зовж зовж сая нэг төрдөг ажээ.

Төрсөн даруйд яр шархыг ширүүн зүлгүүрээр үрэх адилын зовиур болон өлгий давуу бас гараа хүргэх төдийд хутгаар огтлох адилын зовлон шаналлыг ихээр, хүчтэйгээр, хатуугаар, тэсэшгүй сэтгэл зохисгүй байдлаар амсах болой" хэмээн айлджээ.

Арьсаа хуулуулсан үхрийн махыг элдэв хорхой шавьж идэж зулгаах адилын зовлон, хулгана яранд баригдсан биеийг төмрөөр саваадах адилын зовлонг хүчтэй хатуу мэдэрч эдэлдэг байна. Мөн төрсөн даруй өвөр дээрээ авахад хүртэл халуун хүйтнийг амсах мэдрэх зэргийн зовлонг

ихээр, хүчтэйгээр, хатуугаар, тэсэшгүй сэтгэлд зохисгүй ёсоор эдлэх жамтайг айлджээ.

Найман зовлонгийн дотроос эхнийх болоод эцсийн хоёрыг тун сайн хичээж бясалгах хэрэгтэй тул дээр номносон мэтээр тус тус онох билгүүнээр дахин дахин шинжлэн бясалгаж үйлдээрэй.

2. Өтлөхийн зовлон. Түүнийг санахуйд таван зүйл:

1/ Гоо сайхан дүр төрх огоот доройтмой. Нуруу нум мэт бөгтийж толгойн үс өвсний хяруу мэт цайрах, дух магнай хөрөөний ир мэт үрчлээтэн хээтэх зэргээр сүр жавхлан гундаж гоо бус болно.

2/ Хүч чадал огоот доройтмой. Суухдаа үүдний чагтаг тасрах адил суух, босохдоо модны үндсийг татах адил. Өгүүлэхдээ бөгтхөн, явахдаа бүдчих зэргээр болой.

3/ Эрхтэн доройтмой. Нүдээр өнгө дүрс зэргийг тодорхой ялгахаа болино. Ихэд умартах болсноор санах ой чадал хомсдоно.

4/ Төгс эдлэх тамир огоот доройтмой. Идээ ундааны зүйлс шингэхдээ бэрхтэй болдог. Бас бус хүссэн зүйлээ санаснаар үйлдэж, төгс эдэлж чадахаа болино.

5/ Нас бие огоот доройтмой. Насныхаа их зонхийг барсан тул маш түргэн үхэлд зүглэх ажгуу. Эдгээр бүгдийг дахин дахин санаж үйлдээрэй.

"Ихэд цэнгэлт судар" -т:

Өтөлж өвгөрсөөр насны хэмжээ барагдах тул
Аянганд ниргүүлсэн том мод адил болох
Өтлөхийн эргүүлэгт идүүлсээр ялзарсан байшин мэт болох
Өтлөхүйг ялан чадагч байгаа бол түргэн өгүүлэгтүн

Эмэгтэйгээс төрсөн бүгд өтөлж өвгөрөн хатах
Улаан шуурганд хийсэх чөдөр өвст Сала ой мод адил
Хичээнгүй хүч чадалт өтлөхийн зовлонд ээлэгдэх
Үлгэрлэвээс, намагт шигдсэн эр хүн адил

Өтлөөд ирэхээр гоо сайхан дүрс гоо бус болох
Өтлөөд ирэхээр цог жавхлан булаагдах, хүч чадал ч булаагдах
Өтлөөд ирэхээр амгалан булаагдаж доромжлуулах болох
Өтлөөд ирэхээр үхэхэд хүрэх, тунсаг сайхан минь ч булаагдах хэмээн айлдсан болой.

Жан-а-ва гэгээн бээр: "Үхэх зовлон бол аймшигтай. Гэвч асар богино байдаг. Харин өтлөхүй бол хамгийн аймшигтай нэгэн" хэмээжээ. Гамбава гэгээн бээр: "Өтлөх гэдэг аажим аажмаар явсаар чангарагч нэгэн мэдэхэд дийлэхийн аргагүйд хүргэдэг" хэмээсэн буй.

3. Өвдөх зовлон. Түүнийг санахад таван зүйл:

(1) Биеийн мөн чанар өөрчлөгдөнө. Биеийн мах, арьс, шим тэжээл хатах зэрэг болой.

(2) Сэтгэл таагүй зовлонтой болох нь нэмэгдэж үргэлж тийм байдалд оршино. Биеийн усан махвод зэргүүд тэнцвэргүй болж их бага хэмжээгээр хямарч улмаар зовиур шаналгаа үүднэ. Түүнээс шалтгаалж сэтгэл амар тайвангүй байдлаар өдөр шөнийг өнгөрөөх хэрэгтэй болдог.

(3) Сэтгэлд таатай зүйлээ төгс эдлэх, хүсэхээ болино. Сэтгэлд таатай зүйлээ эдлэвээс өвчин сэдрэнэ гэж үзээд өөрийн хүслээр эдлэх эрхгүй болдог. Явдал мөр болон алин хүссэн зүйлүүд ч мөн ийн болой.

(4) Сэтгэлд зохисгүй огт хүсдэггүй зүйлээ эдлэх хэрэгтэй болно. Эм тан, идээ унд зэрэг дургүй зүйлээ албаар эдлэх хэрэглэхэд хүрдэг. Тэрчлэн галаар төөнүүлэх, мэсээр цоолуулах зэрэг хатуу эм заслыг ч шүтэх хэрэгтэй болой.

(5) Амь биенээсээ хагацахад ч хүрдэг. Өвчин эдгэрэхгүй гэдгээ мэдээд зовж шаналахад хүрдэг зэргийг нягтлан санаж аваарай.

"Ихэд цэнгэлт судар"-т:

Хүмүүнд хөнөөгдөн зовох гөрөөс адил
Хэмжээлшгүй их өвчин тусаж амьтан шаналах
Өтлөх, өвдөхөд эзлэгдсэн амьтныг үзээд
Үтэр түргэн зовлонгоос гаргах минь болтугай

Үлгэрлэвээс, өвлийн эцэст их цас шуурга хуйларч
Үндэс мөчир бүрэн эмийн ойн шимийг дарах тэр адил
Энэ л өвчин зовлон амьтны амийг булаах агаад
Эрхтэн, дүр төрх, хүч чадлыг доройтуулж үйлдэх

Эрдэнэсээ ухсаар эцэстээ эрдэнэсээ барах адил
Өвчин гэдэг үргэлжид амьтныг доош хийж доройтуулах
Ойворгүй хөнөөж олон зовлонг үүдэж босгох
Огторгуйгаас нар ургах мэт огоот тарчилган зовоох

4. Үхэх зовлон. Түүнийг санахад таван зүйл:

(1) Гоо сайхан хотол чуулсан төгс эдлэлээсээ хагацах
(2) Гоо сайхан хотол чуулсан элгэн саднаасаа хагацах
(3) Гоо сайхан хотол чуулсан нөхдөөсөө хагацах
(4) Гоо сайхан хотол чуулсан бие цогцосоосоо хагацах
(5) Үхэхийн цагт сэтгэл амгалангүй болж хүчтэй хатуу зовлонг амсах бөлгөө.

Тиймээс сэтгэлд уйсал төртөл тэдгээр жамыг дахин дахин санаарай. Түрүүчийн дөрвөн хотол чуулган зовлон болдог учир нь тэднээс хагацахаа мэдэхээр зовж шаналдагаас болой.

"Их цэнгэлт судар"-аас:

Үхэх, өөр төрөлд шилжих, үхлээр егүүтгэгдэн одоход,
Энхрий хайртай сайн хүнээсээ үргэлжид хагацах та,
Эргэж үл ирэх хийгээд үл учрах, уулзах ч бус аа
Эрхгүй модноос гөвөгдсөн навч адил, бас усны үргэлжлэл мэт

Үхэл бээр эрхтэй бүхнийг эрхгүй болгох
Үхлээр булаагдана гэдэг усанд түрэгдэх мод адил
Хүмүүн бид хосоороо бус, хань нөхөргүй ганцаар одох,
Үйлийн үр төгс учраас өөрийн эрх байхгүй

Далайн матар бээр далайн олон амьтныг (жунба),
Гарьд бээр лус, арслан, их заан зэргийг
Гал бээр өвс ногоо, ой мод ан амьтныг эрхшээх адил
Үхэл бол олон амьтны амийг авдаг буюу хэмээн айлдсан болой.

5. Садан бустай учрах зовлон. Түүнийг санахад таван зүйл:

(1) Дайсан адилтай учрах тэдийгээр зовж сэтгэл амгалангүй болох
(2) Түүний цаазаар таслагдах болууЖин гэж айж зовох
(3) Үг дуугарах аргагүй, муу үгнээс айх
(4) Энэлж шаналсар үхэхэд хүрэх
(5) Номтой харшилсан тул үхсэний дараа муу заяанд одно гэж сэжээд айх буюу. Тэдгээрийг санах болой.

6. Садангаас салах зовлон. Түүнийг санахад таван зүйл:

(1) Ихэд энхрий хайртай садан төрлөөсөө хагацан салж сэтгэлийн гашуун зовлон эдлэх

(2) Амаар гаслан гингэнэн уйлах

(3) Биеэр гаслан зовох

(4) Тухайн хүнийхээ сайн сайхныг дурсаж, хүсэж мөрөөдөн гаслах

(5) Тэрээр үйл хэргээ төгс гүйцээгээгүй зэргийг санах болой.

7. Хүссэнээр болдоггүй зовлон

Түүнээ таван зүйл бөгөөд садангаас хагацах зовлонтой адил болой. Хүссэнээр болдогүй гэдэгт хавар үр таривч намар ургац гарахгүй байх, арилжаа наймаа хийвч ашиг үл олох зэрэг бөгөөд аливаа хүссэн горилсон зүйлдээ шамдавч бүтэхгүй болсноос сэтгэл гансрах зовлонгууд багтана.

8. Товчловоос "чухал авсан таван цогцос өөрөө зовлон" хэмээсэн утгыг санахад таван зүйл:

(1) Илт бүтсэн зовлонгийн сав

(2) Илт бүтсэнээ шүтэх зовлонгийн сав

(3) Зовлонгийн зовлонгийн сав

(4) Урвах зовлонгийн сав

(5) Хурмал зовлонгийн мөн чанарт буюу эдгээрийг санах болой.

Эдгээрээс нэгд, "чухал авсан цогцост" болж төрсөн болохоор дараагийн төрөл тутамд зовлонтой учирна. Хоёрт, нэгэнт цогцост бүтсэн учраас түүнээ шүтэж өвдөх, өтлөх зэрэг зовлонгийн суурь болно. Гуравт ба дөрөвт, дээрх хоёр зовлон, муу авьяастай барилдсан тул энэ хоёр зовлон үүдэхэд хүрнэ. Тавд, чухал авсан цогцос бүрэлдэх төдийд л хурмал зовлонгийн мөн чанарт болж төрдөг.

Мөн урьдын үйл, нисваанис бусдын эрхээр хурсан бүгд хурмал зовлонд тооцогдоно. Эдгээрийн талаар гурван зовлонгийн үест тодорхой номнох болно.

Чухал авсан цогцосын мөн чанарт хорвоогоос уйсах сэтгэл лавтай төрөөгүй нөхцөлд тонилохуй хутгийг чухалд үзэх ухаан баттай төрөхгүй. Улмаар хорвоод төөрч зовсон амьтныг энэрэн хайрлах их нигүүлсэхүй

сэтгэл ч төрөх аргагүй болдог. Иймээс их, бага хөлгөн алинд ч орсон эдгээрийг санах явдал маш их чухал бөлгөө.

Эдгээр санаа бодол төрөхөд хиргүй эрхэм зарлиг болон үнэн зөв тааллын тайлбар зэргийг даган барьж зөв ойлголт олж авна. Цаашид удаан хугацаанд түүнийг тус тус оногч ажих бясалгалаар шинжиж, оюун ухааны хүчтэй хувирал өөрчлөлтөд хүрдэг ёстой. Ялж төгөлдөр нөгчихсөн бээр зовлонгийн үнэн болсон ертөнцийн жам ёсыг мэдүүлэхээр эдгээр найман зовлонг заан үзүүлсэн бөгөөд тэдгээрийн утгыг хутагт Асанга бээр хэрхэн сайтар нотлон буулгасан ёсоор номновой.

Бодова гэгээн бээр: "Нэгэнт зургаан зүйлийн оронд төрснөөс хойш өвдөх, үхэх тэргүүтний зовлонг эдлэнэ. Өвдөх шалтгаан нэгэн буй учраас өвдөх буюу. Үхэх шалтгаан нэгэн буй учраас үхэх буюу. Тэдгээр зохилдохгүй шалтгаанаас буюу эсвээс гэнэт гарч ирэх бус аа. Ерөөс ертөнцийн бэлэг чанар, мөн чанар тийн буюу. Ертөнцөд орших үед түүнээс нөгчиж үл чадах. Бид түүнээс уйдаж сэтгэл гансарч зовлонгоос салах хэрэгтэй. Тиймээс түүний уг үндсийг тэвчих хэрэгтэй" хэмээн айлдсан дагуу дээр өгүүлсэн төрөх, өтлөх, өвдөх, үхэх зэргийн зовлонг үүдэх үндэс шалтгааныг мөн санах болой.

(б) Зургаан зовлонг санах

"Садангийн захидлын тайлбар"-т долоо гэсний сүүлийнх тус тусын гэм бурууг номносон тул энд зургааг санах болой. Үүнд:

(1) Сэтгэлд батгүйн гэм:

Орчлонд эргэлдэхийн цагт эцэг, эх тэргүүтэн элгэн садангууд маань урьдын төрөлд дайсан болж явсан ба дайснууд маань ч садан болж явжээ. Тэр мэтээр эцэг нь хүү болж, хүү нь эцэг болж, эх нь эхнэр болж, эхнэр нь эх болох зэргээр удаа дараалан солигдож явсан тул сэтгэл итгэхийн газар ерөөс үгүй билээ.

"Садангийн захидал"-д:

Эцэг нь хүү болж, эх нь эхнэр болж
Дайсан нь садан төрөл болох зэргээр
Өөрчлөгдөж урваж ирсэн жамтай учраас
Орчлон бүхнээ итгэх зүйл хаана ч үгүй буюу хэмээжээ.

Энэ насны хувьд ч дайсан садан хэмээгч нааш цааж урван одох талаар *"Бунсангийн айлтгасан судар"*-т:

Заримдаа дайсан гэвч садан болох
Садан гэвч дайсан ч болох
Тэр мэт заримууд танихгүй хүн болох
Танихгүй тэр хүн дайсан ч болох

Тийнхүү элгэн садан эргэх урвах ёсыг таниад
Ухаантан мэргэд бээр хэзээд тачааж үл үйлдэх
Саднаа баясагч сэтгэлийн сэжгээ буцааж
Амгалант буяны сэтгэлийг агуулж үйлд

хэмээн айлдсан мэтээр бясалгаад дайсан садан гэж ялгаж үзэхээ орхивоос тачаах, уригнах муу сэтгэл хаагдахад хүрнэ. Ийнхүү ертөнцийн юмс үзэгдэлд сэтгэл найдахын газар хаана ч байхгүйг мэдээд сэтгэл уйсах хэрэгтэй буюу.

(2) Ханахаа үл мэдэх гэм:

Нижгээд дөрвөн далайгаас үлэмж илүү
Сүү уусан хэдий ч эдүгээ тус тусын
Төрөл авсан ертөнц түүнээс
Илүү ихээр ундааг эрэлцэх

хэмээн нижгээд нижгээд амьтны сүүг уучихаад эдүгээ бас тонилохуйн мөрд үл суралцваас хэдий чинээ ихээр уух болохоо санана. Энэ бол зөвхөн жишээ төдий буюу. Орчлонд амсаагүй жаргал зовлон гэж нэг ч үгүй билээ. Үүнийг санаж сэтгэл уйсах хэрэгтэй. Хэдийгээр амгалан жаргаланг эдэлж сэтгэлээ жаргуулна гээд орчлонгийн амгалан жаргаланг хичнээн эдэлсэн ч амарч жаргасан юмгүй харин улам л шунал нэмэгдэж иржээ.

Чингээд зогсохгүй орчлонд өнө удаан тэнүүчилсэн хэдий ч нөгөө жаргалынхаа ганц хувийг ч үл олжээ. Харин тэсэхүйеэ маш бэрхтэй зовлонг цаг үргэлжид амсаж байнам.

"Садангийн захидал"-д:

Хэрхэн хулгана яраар энэлэхүй еэ
Загатнахгүйн тухайд л галд ээвч
Амарлихгүй улам өвдөх адилаар
Хүсэл шунал улам нэмэгдэхийг болгоов хэмээжээ.

"Чанад хүрэхүйн хураангуй"-гаас:

Хүсэл жаргал тэдгээрийг олоод
Нэгэн өдөр төдий шүтээд
Олныг хураасандаа эс ханаваас
Түүнээс их өвчин хаана байх хэмээсэн ба

"Шавийн захидал"-д:

Олонтаа төрөөгүй төрөл гэж алин бэ
Урьд нь амсаагүй жаргал гэж алин бэ
Үзэсгэлэнт цагаан дэвүүр адилын эдлээгүй үзэсгэлэн гэж алин бэ
Тэдгээр алин боловч хүсэл л улам арвижих

Урьд эдлээгүй зовлон гэж үгүй л
Ямар ч амьтанд ханах сэтгэл хэзээ ч үгүй
Хэвлийдээ унтаж үзээгүй амьтан гэж үгүй л
Тийн атал юунд орчлонгоос шуналаа үл буцаана вэ

хэмээн айлдсаныг санах буюу. Мөн *"Гасланг арилгахуй"*-д айлдсан мэтээр санаваас машид уйсал төрөх буюу.

Дахин дахин тамд төрж
Буцалсан хайлмаг зэс ууж явснаа
Далайн усаар хэмжиж үзлээ ч
Түүний хэмжээг жишиж үл болох

Гахай нохойн төрөлд явснаа
Бузар буртгаар хооллож явснаа тоолоход
Уулсын хаан Сүмбэр уулын өндрөөс
Үлэмж илүү гарах билээ

Элгэн садангаас хагацаж салж
Эл орчлонд уйлж гасалж явсан
Нүдний нулимсан дуслаа багтаах гэвэл
Далайн сав ч багадах мөн

Инагш чинагш байлдаж
Толгойгоо таслуулж явсан
Тэр бүхнээ өндөрлөж овоолвоос
Эсрэва тэнгэрийн ертөнцөөс хэтрэх буй за

Хорхой болж машид өлсөж явахдаа
Идэш болгосон чийгтэй шороо тэдгээрийг
Их сүүн далайн дотор юүлвээс
Бүрэн дүүрээд халих буюу хэмээн айлджээ.

Мөн *"Гол модыг байгуулах"*-д:

Та бээр, хүсэхийн учиргүй шимээ барсан
Урьд төрлийн хязгаарыг эргэцүүлж санаад
Өнөөдрөөс бодь хутгийг эгээрэх ёс журам болон
Цааз тангарагийг сахих ёсоор хүслээ дар

Та бээр, хүсэхийн учиргүй шимээ барж одсон
Урьд насны амь биеийн хязгаарыг эргэцүүлэн санахад
Ганга мөрний элсний чинээ ч баярлах зүйл олохгүй хэмээсэн
Энэ адилын зарлиг нэгийг бурханаас сонсоогүй гэж үү

хэмээн айлдсан мэтээр орчлонгийн амгалан сайныг олсон ч хуурмаг, тусгүй, хэмжээлшгүй их зовлонт болохыг урьд тоо томшгүй олон төрөлд төрсөн ч шамшаагдан барагдсан зэргээр санагтун. Эдүгээ эс шамдваас урьдын адил болох ёсыг санаж уйсах сэтгэлийг төрүүлэх хэрэгтэй.

Жан-а-ва гэгээн бээр: " Эрхэм дээд багш минь ээ, Би тэргүүлшгүй цагаас хичнээн олон төрөл авч вэ. Эдүгээ болтол их хөлгөний номтой учраагүй тул хичээж шамдах хэрэгтэй байна" хэмээжээ.

Сан-пү-ва гэгээн: "Энэ орчлонд дээшилж нэг, доошилж нэг явах боловч энэ бодлоос буцахгүй байх хэрэгтэй" хэмээн айлдсан мэтээр баттай ухаан төрөх хүртэл бясалгах ба уг ухаан төрсөн хэдий ч үргэлж бясалгах хэрэгтэй.

(3) Дахин дахин биеэ орхих гэм:

Тус тусын мөн чанар болсон ясан цогцсыг овоолвоос
Сүмбэр уултай тэнцэх буюу түүнээс үлэмж хэтрэх

хэмээсэн мэтээр амьтан болж яваад үлдээсэн тус тусын биений ясыг овоолвоос Сүмбэр уулаас ч их болох ажээ.

(4) Дахин дахин төрөл авах гэм нь:

Эх болж явсан хэмжээ хязгаарыг арцны модны үртэй адил хэмжээний Үрээр жишин тоолоход газрын шороо хүрэлцэхгүй хэмээжээ.

Энэ бол урьд эх явсан нэг амьтны тоо биш юм. Энэ талаар *"Тайлбар судар"*-аас эш аван: "Гэлэн нар аа! Үлгэрлэвээс хэн нэгэн бээр газрын шорооноос арцны үр төдий нэгийг барин, "Энэ миний ээж юм. Энэ нь миний ээжийн ээж, тэр түүний ээж хэмээн тоолсоор байтал газрын шороо, түүний хөрөнгө шавар хүртэл бүгд түрүүлээд барагдах буюу.

Харин хүн бүгдийн эхийн дамжлага үүнээс өөр болой" хэмээн өөрийн ээжээс эхлээд ээжийн ээж гэхчлэн ээжийн дамжлагыг зэрэгчлэн үзүүлэхийн тухайд гол номоос "Эх болж явсны тулах хязгаар" хэмээн айлджээ.

Түүнээ уйсахын үндэс болгож *"Дөрвөн зуут"*-д:

Алин хэзээд ганц ширхэг үрийн
Анхны эхлэл үзэгдэхгүй тул
Тийнхүү нэгээсээ улам дэлгэрэх
Тэр жамыг үзээд түүнээс юунд үл аюуна вэ хэмээсэн ба

"Түүний тайлбар"-т ч:"Үүгээр жишиж үлж баршгүй үргэлжлэлтэй, туулахад маш бэрх бартаа саадтай орчлонгийн их аглаг цөлөөс үргэлжид уйсах буюу түүн лүгээ адилтган дүрсэлж бясалгаваас зохист болой" хэмээсэн мэтээр ухаараарай.

(5) Дахин дахин дээр доор болох гэм:

Ертөнцөд тахигдваас зохист Хурмаст тэнгэр болж төрөвч
Үйлийн эрхээр жич дахин газарт унах
Хүрдэн эргүүлэгч их хаан болж төрөвч
Орчлонд дахин боол зарц болж ч төрөх

Өндөр язгуурт охид эмсийн хөх, бэлхүүсийг
Таалан таашаал жаргалыг өнө удаан амсавч
Төд удалгүй тамд очиж эслэн таслах оньст хүрдний
Ирийг мэдрэн тэсэшгүй зовлонг эдлэх болюу

Хөвөн зөөлөн тансаг сайхныг хөлөөрөө мэдрэн
Хөхүй Сүмбэр уулын оройд өнөд удаан ажравч
Жич бас галт нурам, хүүрийн балчигт шигдэж
Жишишгүй зовлонд учрах вий гэж бодоосой

Өндөр язгуурт эмс охидтой хөөцөлдөн баясаж
Үзэсгэлэнт сайхан ой цэцэглэгт тоглон наадавч
Жич дахин мэсэн навчит ой цэцэглэгт хүргэгдэн
Гар, хөл, чих, хамраа отглуулах ч болзоогүй

Аальгүй дурааараа цэнгэгч тэнгэрийн охидын
Алтан линхуа адил гоо үзэсгэлэнтэй ханилавч
Ахин дахин тамын хөлгүй мөрөн далайн
Аймшигт их давстай халуун усанд орохоо сана

Хүсэл жаргалаар элбэг дэлбэг тэнгэрийн орноо
Шуналаас хагацсан ариун их амгаланг олох хэдий ч
Бас л дахин аюус тамын түлш болоод
Барагдашгүй зовлонг шүтэх ч бий

Нар саран болж төрөөд өөрийн биений
Өнгө гэрлээр ертөнц бүхнийг гэрэлтүүлэвч
Жич бас түнэр харанхуй тамд очоод
Өөрийн гараа хөдлөхөө ч үл үзэх хэмээн айлджээ.

Хүлэх зэргийн гурван "оньст хүрд" гэдгээр "Хураан дарах", "Хар шугамт", "Халуун" гэсэн гурван тамыг өгүүлжээ. "Өндөр язгуурт эмс охидтой хөөцөлдөн баясах" гэдэг нь тэнгэрийн охидыг шүтэх болой. "Хүсэл жаргалаар элбэг дэлбэг тэнгэрийн орон" нь "Гучин гурван тэнгэрийн орноос дээшхи хүсэлт тэнгэрүүд" болой. "Наран сарны гэрэл" гэдэг нь шүтээн, шүтэгдэхүүн гэж ялгалгүй ертөнцөд алдаршсанаар өгүүлсэн ба ялгаваас тэр хоёрын хэмжээлшгүй хот мандлын гэрэл болой. Эдгээр зүйлээр дээд төрлөөс доорд төрөлд одох ёс бүгдийг санаж орчлонгоос уйдах буюу. Орчлонгийн хотол чуулган, сайн сайхан бүхэн эцэстээ доройтлоор төгсдөг ажээ. Тийн болохыг *"Винайн эш"*-ид:

Хураасан бүгдийн эцэст барагдах
Өндөр бүгдийн эцэст доош унах
Учирсан бүгдийн эцэст салах
Амьдын эцэст үхэх мөн хэмээжээ.

(6) Хань нөхөргүй одох гэм. Энэ талаар:

Тэр мэтийг санан гэмших ёсыг эрэлцэж
Гурван буяны зулыг машид гэрэлтүүлэн таалагтун
Наран саран ч үл гийгүүлэх
Хэмжээгүй харанхуйд ганцаараа одохоо санаарай.

"Гэмших ёсыг эрэлцэх" гэдэг нь дээр өгүүлсэн мэт үхэх ёсыг болгоон буяны гэгээг таалан соёрх гэсэн утга мөн. "Гурван буян" гэдэг нь гурван үүдний буян буюу өглөгөөс үүдэх тэргүүтэн гурван суурь болой. "Хэмжээлшгүй харанхуй" гэдэг нь мунхагийн харанхуй болой.

Нөхөргүй ганцаар одох ёсны талаар *"Бодичарияаватара"*-д:

Энэ бие ганцаар төрсөн ч
Хамт төрсөн мах яс бүгд
Эвдрэн тус тус салах болохоор
Элгэн садан бусдыг хэлээд яах вэ

Төрөхдөө ганцаараа төрөх бөгөөд
Үхэхдээ ч ганцаараа үхдэг билээ
Зовлонгийн хувийг бусдууд үл авах учираас
Зовоогч садангаар юу хийх билээ гэж айлдсан буюу.

Эдгээр зургаан зовлон гуравт хурах буюу.
(а) Сэтгэлд баттай зүйл орчлонд үгүй,

(б) Түүний амгалан жаргалыг хичнээн эдлэвч ханахын эцэсгүй бөгөөд

(в) Тэргүүлшгүй цагаас оршсон эдгээр бөлгөө.

(а) Дөрвөн зүйл буй. Олсон бие батгүй болох нь дахин дахин биеэ орхих болой. Тус, хорлол үйлдэхэд батгүй нь лавтай бус болой. Олсон хотол чуулган батгүй гэдэг дээр, доор болон урвах мөн. Нөхөр батгүй болох нь хань нөхөргүйгээр одох мөн.

Тэрхүү гурвыг дахин дахин төрөл авах, төрөл дамжих хязгааргүй зэрэгт багтаан хураангуйлан санаарай.

(в) Гурван зовлонг бясалгах

(а) Урвахын зовлон

Үлгэрлэвээс мундас яр болон машид халуун яр шархнаа сэрүүн ус хүргэхэд түр нэг амсхийх адил санагддаг шиг орчлонгийн амгалант амсуурга (мэдрэмж) энэ адилууд хэзээд эргэн зовлон болдог учир урвахын зовлонт бөлгөө. Зөвхөн тэр амсуурга төдийгүй түүнтэй хамт байгаа сэтгэл болон сэтгэлээс гарсан бүгдээр, мөн бодож санаж байгаа цувиралт орон бүгдээр урвах зовлонт болой.

(б) Зовлонгийн зовлон

Халуунаар энэлгэх шархан дээр давс, ус зэрэг урвуулагч хүрэлцэхүүнийг учруулваас улам их энэлэн шаналал гардагтай адил гэж зовлонт амсуургыг ухаарах хэрэгтэй.

Нэгэнт төрөл авснаас хойш бие сэтгэлээр энэлж зовох учиртай аж. Тиймээс зовлонгийн зовлонт бөлгөө. Бөөрний хатгуулга адил болой. Тэгээд ч ганц амсуурга бус дээрхийн адил бүгдээр тийн бөлгөө.

(в) Түгээмэл хуран үйлдэхийн зовлон

Дээрх хоёр амсуурга мэдрэмж төрөөгүй байх үеийн халуун шарх болвоос дундын цувиралт амсуургатай адил болой. Тэд муу авир ёстой барилдсан тул хуран үйлдэхийн зовлонт болой. Ийнхүү ганц амсуурга бус дээрхийн адил бүгдээр бөлгөө. Эдгээр зовлонгууд урьдын үйл нисваанисын бусдын эрхээр бөгөөд дараагийн зовлон болон нисваанис төрөх хөрөнгө лүгээ даган барилдсан тул хотлоор түгэх буруу авир ёстой төгөлдөр буюу. Тийн амгалант амсуурга төрснөөр шунал тачаал нэмэгдэнэ. Зовлонт амсуурга төрвөөс уур урин арвижна. Амгалан зовлонгийн алин ч болдоггүй авир ёсноо багтах мөнх бусын биеийг мөнх хэмээн үзсэнээр мунхаг ихдэх буюу.

Чингэж шунаснаар хойно гарах учиртай зүйл эхэнд гарах зэргийн зовлон үүднэ. Уурласнаас болж энэ насандаа гаслан шаналал төрж хожмоо муу заяаны зовлон ирнэ. Мунхаг сэтгэл нь тэр хоёроос үүдэх хоёр зовлон хоёуланг орхихгүйн төлөө одох бөлгөө. Иймээс амгалант амсуургыг зовлон

гэж үзэж шуналаа няцаах мөн. Зовлонт амсуурга төрөхөд энэ цогцос зовлонгийн шалтгааны чуулган болдог. Тиймээс түүнийг хатгуулга мэт санан уураа дарах буюу. Дундын амсуурга гарахад мөнх бус бөгөөд барагдах, хаагдахын мөн чанарт гэж үзэж мунхагаа арилгах мөн. Гурван амсуургыг гурван хорын уг үндэс бүү болгоорой.

Тэдгээрийн тухай *"Егүзэрийн явдлын газар"* болон *"Нотлон буулгахуйн хураангуй"* зэрэгт номносон дагуу өгүүлвэй. Үлгэрлэвээс: "Их ачааг үүрэгч бээр хэдий чинээг үүрэх шаардлага байгаа төдий чинээгээр зовдогтой адил, чухал авсан цогцосын үүргийг хэдүй хүртэл барих шаардлага байгаа тэр хүртэл зовох буюу. Тэрхүү цогцост зовлон, нисваанисын муу авир баттай тогтсон байдаг тул хуран үйлдэх зовлонт бөлгөө Эдүгээ зовлонт амсуурга түр байхгүй мэт боловч гарсан даруйдаа элдэв үүднээс элдэв зовлон үүдэх билээ.

Тийнхүү хуран үйлдэх зовлон гэдэг зовлон бүхнээ түгэх буюу бусад хоёр зовлонгийн үндэс болдог учир түүнээс уйсах бодлыг олонтаа дадуулах хэрэгтэй.

Мөн хүсэл шуналыг нэмэгч өнөөдрийн жаргалтай гэх мэдрэмж маань ерөнхийдөө өвчний жич засал хийлгэснээр түр амсхийх санаа төрдөгтэй адил буюу. Түүнээс бус зовлонг арилгах зэрэг явдалд огт харгалзахгүйгээр жинхэнэ мөн чанараар бүтсэн амгалан жаргал гэж байхгүй билээ.

Үлгэрлэвээс, Хэтэрхий их явсаар байтал нэг мэдэхэд ядрах зовлон гарч ирдэг. Энэ үед сууснаар амгалантай сэтгэл төрдөг нь түрүүчийн их ядарсан зовлон зэрэгчлэн хорогдож улмаар ядаргаа тайлагдан сэтгэл амрах явц гарч ирж байгаатай холбоотой болохоос жинхэнэ мөн чанараар амгалантай учирсан бус. Учир нь цааш их удаан суугаад байвал мөн л урьдын адил ядарч зовоход хүрдэг шүү дээ.

Хэрвээ жинхэнэ мөн чанараар амгалангийн үндэс мөн юм бол, зовлонгийн үндсийг хичнээн дагах тусам зовлон улам арвижихтай адилаар, хэдий өнө удаан хугацаанд явах, суух, хэвтэх, идэх, уух, гэрэл сүүдрийг дагах зэргээр шүтсэн тэр төдийгөөр амгалан жаргал улам улам дээш арвижих учиртай билээ. Гэтэл удаан суух тутам зөвхөн зовлонг л үүсгэх нь үзэгдэнэ.

Тийн болохыг *"Хэвлийд оршихуй"*-д: "Баясгалант аа! Явах, суух, босох, хэвтэхийн явдал бүгд тус тусын зовлонтой нь мэдрэгдэнэ. Тэдгээр явдал

мөрийн мөн чанарыг бясалган шинжвээс, хэрвээ суулгүй, хэвтэлгүй, амралгүй өдрийн турш явсаар байвал тэр явалт чинь зөвхөн зовлон болж хатуу, ширүүн, тэсэшгүй, сэтгэлд тааламжгүй чанарууд болж мэдрэгдэнэ. Тийм явдлаас тааламжтай хур мэдэл гарахгүй болой" хэмээжээ.

Үлдсэн гурван явдал дээр ч энэ адил болохыг айлдсан бөгөөд "Баясал ирэвч явдал мөрийн зовлон хийгээд тэдгээрийн үргэлжлэлийг таслахын тухайд бий болсон өөр бусад шинэ зовлон болон түүнээс гарсан зүйлийг л тааламжтай мэтээр ухаарч байгаа хэрэг. Баясал гарсан ч зөвхөн зовлон ямагт гарах буюу. Хорьсон ч зовлон ямагтаа хорих буюу. Гарлаа ч гэсэн хуран үйлдэж гарах буюу. Хорихдоо ч хуран үйлдсэн ямагтыг хорих буюу" хэмээжээ.

"Дөрвөн зуут"-д:

Арвижин нэмэгдэх жаргал тэрээр
Хэрхэн буцахыг үзсэн болвоос
Тэр адилаар зовлон арвижин нэмэгдэх болохоос
Буцаж байхыг үзсэнгүй хэмээн айлджээ.

2. Тус тусын зовлонг санахад зургаан зүйл:

Гурван муу заяаны зовлонг дээр номносон болой. (1-3)

(4) Хүний зовлон:

Өлсөх цангах, халууцах даарах зэргээр сэтгэл зовж амьдрах, эрж хайх, алжаах зүдрэхийн зовлонт болой. Мөн төрөх, өтлөх, өвдөх, үхэх тэргүүтний долоон зүйлийн зовлон амсах зэргийг дээр номносон дагуу мэдээрэй.

*"Буяны яриа"-*д:

Хамаг муу заяаны зовлон,
Хүний заяанд тохиолдох үзэгдэнэ
Зовлонгийн хатгуулга там лугаа адил
Эрлэгийн эзний ертөнц үүнээ доорд ядуус

Адгуусын зовлонг ч амсах
Чадалтай нь чадалгүйгээ
Дарлаж хөнөөх зэрэг
Усны үргэлжлэл адил буюу

Заримууд ядуу зүдүүгээс болох
Бас зарим нь хана мэдэлгүйгээс болох
Нийтээр эрж бэдрэх ийн барагдашгүй зовлонт
Бүгдээр өслөн хорлогдох буй хэмээжээ.

"Дөрвөн зуут"-д:

Дээдэст сэтгэлийн зовлон
Доодост биеийн зовлон төрөх болой
Хоёр зовлонгоор энэ ертөнц
Өдөр нижгээд нижгээдээр дарагдах хэмээснээс мэдээрэй.

(5) Асурын зовлон: *"Садангийн захидал"*-д:

Асур нар угаас тэнгэрийн цог учралд
Уурлан сэтгэлийн их зовлон эдлэх
Тэд ухаантай ч хэсэн тэнэж түйтгэрлэгдсэн тул
Үнэнийг үзэж чадахгүй болой хэмээсэн мэт.

Тэнгэрсийн цог учрал, сайн сайханд үл тэсэж атаархахын сэтгэлээр шаналан түүнээсээ болж тэнгэр нартай байлдан биеэ тасдуулах, цавчуулах зэрэг олон зовлонг амсаж эдэлнэ. Хэдий тэд ухаантай ч хувь заяаны буюу тийн боловсролын түйтгэртэй төрсөн тул тэрхүү төрөл дээрээ үнэнийг (үнэмлэхүй) оножс мэддэггүй аж.

"Шадар санан дурдахуй судар"-т эднийг адгуус хэмээжээ. *"Егүзэрийн явдлын газар"*-т тэнгэрийн амьтан гэж номножээ.

(6) Тэнгэрийн зовлонг санахад хоёр зүйлээс:

а) Амармагийн тэнгэрийн зовлонг санахад дараах гурван зүйл:

1. *Үхэл егүүтгэх ба унахын зовлон*
2. *Айж мэгдэхийн зовлон*
3. *Таслагдах, цавчигдах, алуулах, хөөгдөх зовлон*

1. Үхэл егүүтгэх ба унахын зовлон

а. Үхэл егүүтгэх нь:

Тэд өндөр язгуурт төрж машид их жаргалтай ч
Үхэл егүүтгэх зовлон нь түүнээс ч илүү зовлонтой
Тэр мэтийг санаад мэргэд нар
Барагдах өндөр язгуурын тухайд шунаж бүү үйлд хэмээсэн мэтээр.

Урьд нь тэнгэрийн төгс сайхан амгалан жаргалыг эдлэн тансаг дээдээр амьдарч яваад үхэхийн цагт үхлийн таван ёрыг үзэж түүнээс болоод маш ихээр шаналж зовдог ажгуу. Үхлийн таван ёрын тухай дээрх номонд:

Биеийн өнгө гундаж гуа бус болох
Суудалдаа дургүйцэх, цэцгэн эрхис гандах
Баринтаг хувцсанд нь хир тогтох
Биенээс урьд байгаагүй хөлс гарах хэмээсэн

Өндөр язгууртны үхлийг сануулагч таван ёр
Тэнгэрийн орноо ажрагч тэнгэрст тусах бөгөөд
Үхэх гэж буй газрын хүмүүст үхэх гэж байгааг
Сануулан мэдрүүлэгч үхлийн ёр лугаа адил хэмээжээ.

б. Доорд газар унах зовлон:

Тэнгэрийн орноос шилжих агшинд
Хэрвээ буяны үлдэц байхгүй бол
Түүнээс өөрийн эрхгүй адгуус, бирд,
Тамын орон алинд ч талийн одох хэмээжээ.

2. Айж мэгдэх зовлон:

Буян заяа үлэмж ихтэй тэнгэр нарт маш их сонин гайхамшигт хүслийн эрдмүүд төрдөг аж. Буян багатай тэнгэрийн хөвгүүд тэдгээрийг үзээд айн мэгдэж түүнээсээ болоод сэтгэл нь тавгүйтэж маш их зовж шаналдаг буюу.

3. Таслагдах, цавчигдах, алагдахын зовлон:

Тэнгэрүүд Асур нартай байлдан бие эрхтэн, гар хөлөө таслуулах, биеэ цавчуулах, бүр алагдахын зовлонг амсаж эдэлнэ. Толгойгоо таслуулж

байж л үхэх бөгөөд харин биеийн бусад хэсэг таслагдан цавчигдавч дахин ургаж амьдардаг байна. *Хөөгдөх гэдэг* их бяр чадалтай тэнгэрүүд байлдах үед тэнгэрийн их хөвгүүд бялд өчүүхэн тэнгэрүүдээ өөрийн нутгаас хөөж явуулдаг байна.

Мөн *"Буяны яриа"*-д:

Хүслийг эдлэгч тэнгэр алин түүнээ
Амгалант сэтгэл үгүй буюу
Хүсэл тачаалын өвчинд баригдан
Дотор галаар түлэгдэх буюу

Алин сэтгэл алгасарсан бүхэнд
Амар амгалан хаанаас байх
Үл алгасарах сэтгэлийн ганц агшинг ч
Үнэхээр эрхшээж чадаагүй тул

Алгасрал хямралын мөн чанарт болж
Амарлингуйг хэзээ ч үл олох билээ
Хий салхиар бадран түгсэн гал
Мод лугаа авалцах адил хэмээгээд

Өвчин илааршаад удаагүй байхад өвчтөн
Өөрт зохихгүй идээг идсэнтэй адил хэмээн айлджээ.

6. Дүрст ба Дүрсгүй тэнгэрийн зовлонг санах

Дүрст ба Дүрсгүй тэнгэрийн дээд орноо ийм зовлон байхгүй хэдий ч нисваанис болоод түйтгэр төгөлдөр учраас үхэл егүүтгэх бөгөөд болон өөрийн эрхээр орших бус аа. Тиймээс тэд муу авьяасаар зовдог болой.

"Буяны яриа"-нд:

Дүрст болоод Дүрсгүй тэнгэр алин тэд
Зовлонгийн зовлонгоос тонилсон буюу
Самади бясалгалын энх амгаланд цэнгэн
Сац хэдэн галавт ч үл хөдлөн суух

Гэвч маш магадтай тонилж чадаагүй тул
Түүнээс жич дахин унах ч буй

Муу заяаны зовлонгийн давалгаанаас
Тонилсон мэт боловч

Хөх огторгуйд халих шувуу адил
Хичнээн шамдаад өнө үл орших
Хүүхэд нялхсын бяраар сум тавих мэт
Хэзээд нэг унахын хязгаар буюу

Удаан бадамлах гэрэлт зулууд
Агшин тутамд жаргах адилаар
Хуран үйлдэх, огоот урвах хэмээх
Зовлон зэргээр лавтай хөнөөгдөх хэмээн айлджээ.

Тийнхүү тав буюу зургаан зүйл амьтан тэдгээрийн нийтийн болоод тус тусын зовлон зүдгүүрийг санахын үүднээс орчлонгоос сэтгэл гансран уйдаж чадах бөлгөө. Чингээд тэрхүү зовлонгийн үндэс шалтгаан юу бол хэмээх үндэс шалтгааныг шинжлэх бодол урган гарна.

Зовлонгийн шалтгааныг санах

2) "Бүхэн гарахуйн үнэн" буюу хорвоод эргэлдэх ёсыг санах

а) Хэрхэн нисваанис (муу сэтгэл) төрөх ёс

б) Хэрхэн түүгээр үйл хураах ёс

в) Хэрхэн үхэх ба төрөл авах ёс

а) Хэрхэн нисваанис төрөх ёс

Үйл нисваанис хоёр болвоос хорвоог (эргэх зовлон) бий болгох үндэс бөлгөө. Энэ хоёроос нисваанис нь гол үүрэг гүйцэтгэнэ. Хэрвээ нисваанис байхгүй бол урьд хураасан үйл хичнээн их байсан ч чийг, хөрс шороо байхгүй нөхцөлд зөвхөн хөрөнгөөр тариа ногоо ургадаггүйтэй адилаар үйлд хамт байх ёстой нөхцөл бүрдээгүй учраас зовлонгийн тариа ногоо ургахгүй учиртай. Харин нисваанис байхад хэдий урьд хураасан үйл байхгүй ч тэр даруйд шинээр хураан дараагийн бие цогцсоо авах буюу.

Тэр талаар *"Тийн тайлбар"*-т:

"Хамт байх нөхцөл болдог учраас
Орчлонд шунах нисваанисаас ангид,
Өөр бусад үйлээр хаягдана гэж үгүй хэмээсэн ба

Шунах нисваанис л буй аваас
Дахин дахин төрөх болой" хэмээжээ.

Иймээс нисваанисын ерөндөгийг шүтэх их чухал. Нисваанис сэтгэлд харгалздаг учраас таньж, мэдэж болно.

Түүнээ дөрвөн зүйл :

1. *Нисваанисыг танин барих*
2. *Хэрхэн төрөх зэрэг*
3. *Нисваанисын үндэс шалтгаан*
4. *Нисваанисын гэм эргүү*

1. Нисваанисыг танин барих [50]

Нисваанисын ерөнхий бэлэг чанар: "Хотлын хураангуй"-гаас: "Алин ном юу гарах вэ хэмээвээс, машид эс амарлих бэлэг чанарт буюу. Хэзээ тэр гарваас сэтгэлийн үндсийг машид эс амарлиулагч тэр л нисваанисын бэлэг чанар болой" хэмээсэн мэтээр хэзээ төрвөөс сэтгэлийн үндсийг машид эс амарлиулан үйлдэгч болой. Арван нисваанисын тус тусын бэлэг чанар дараах болой.

Хүсэл тачаал: Сэтгэлд тааламжтай, гоо сайхан гэгдэх гадаад дотоодын юмс үзэгдэлд барьцалдаж шунах сэтгэл буюу. Эл нисваанис өөрийн бодсон зүйлдээ шунах тачаах нь нэмэгдэх тусам түүнээс салж хагацахад бэрхтэй болдог. Үлгэрлэвээс бөс даавуунд шингэсэн тос салахдаа бэрх байдагтай адил буюу.

Уур хилэн: Амьтан хүн болон зовлон бэрхшээл, хутга мэс, өргөс хатгуур зэрэг зовлон бэрхшээлтэй орныг бодоод бүгдийг хөнөөх устгахын санаа сэдэл төрж, хатуу догшин сэтгэлээр тэдгээр орныг хорлох сэтгэл бөлгөө.

Омог (өөрийгөө ялагч): Эвдрэх үзэлд тулгуурлах бөгөөд гадаад дотоодын орныг дээд доод, сайн муу гэж ялгаварлаж сэтгэл хөөрч сагсайж, өөрийгөө өндөрт өргөх сэтгэл болой.

Мунхаг (үл мэдэх): Дөрвөн үнэн, үйл үр, чухаг дээдийн мөн чанар зэргийг үл ухаарах зэрэг үл мэдэх нисваанис болой.

Доноголзох: Үнэн тэргүүтэн гурван орон (дөвөн үнэн, үйл ба түүний үр г.м) зэргийг бодож буй юу, буй бус уу, мөн үү, биш үү хэмээх болой.

Эвдрэх чуулганы үзэл : Чухал авсан цогцосоо тухайлан "би" гэж үзэх ба "минийх" гэж үзэх буюу. Би-г "өөрөө" болоод "өөрийнх" хэмээн үзэгч ухааны нисваанис буюу. Энэ үгний "эвдрэх" гэдэг нь мөнх бусыг, "чуулган" гэдэг нь олон гэсэн утгатай тул тухайн үзлийн барих суурьд мөнх бус болон олон зүйлийн үзэгдлийг жишээлсэн төдий хэрэг. "Мөнхөд болон гагцаар оршигч бодгаль байхгүй" гэдгийг мэдүүлэхийн тулд эвдрэх чуулганы үзэл хэмээн нэрийджээ.

Туйлд баригч үзэл: Эвдрэх үзлийн орон болох "Би"-г тухайлан барьж, мөнхөд ганцаараа орших ба энэ төрлөөс хойш дахин төрөл авна гэж байхгүй үгүйсгэх тасархай үзлийн ухааны нисваанис болой.

Үзлээ дээдэд баригч: Эвдрэх үзэл, туйлд баригч үзэл, буруу үзэл гурвын аль нэгэн болж, тэднээс үүдэж гарсан үзэл онолын цогцосыг тухайлан бодож дээд хэмээн баригч ухааны нисваанис болой.

Ёс суртахуун, зан үйлийг дээдлэн баригч : Цалхай ёсыг тэвчигч ёс суртахуун, зан үйл, ёс заншил, бие хэлний явдлыг хянах сахил хийгээд алин шүтэн гарсан бие цогцос түүний хилэнцийг арилгах, нисваанисаас гэтлэх, орчлонгоос магад гаргагч хэмээн онцгойлон үзэх ухааны нисваанис болой.

Буруу үзэл : Урд хойд нас, үйлийн үр зэргийг байхгүй хэмээн басамжлан доорд үзэх, Виншү, Зову зэрэг ертөнцийн тэнгэрийг аливаа ертөнц амьтны уг үндэс, бүтээгч хэмээн барих ухааны нисваанис болой. Эдгээр арван нисваанисын талаар *"Хотлын хураангуй", "Егүзэрийн явдлын газар", "Таван цогцосын ялгал"* зэрэг шастаруудаас номносон дагуу өгүүлвэй.

2. Хэрхэн төрөх зэрэг

Эвдрэх үзэл болон мунхаг хоёрыг тус тус авч үзвэл, үлгэрлэвээс, харанхуй буусны улмаас ороож тавьсан олс дээсний ахуй байдал сайн танигдагдахгүй тохиолдол гардаг. Ийм үед тэрхүү ороосон дээсийг могой гэж сэжиглэх ухаан төрдөг билээ. Үүнтэй адилаар цогцосын тунгалаг ахуй байдлыг түйтгэрлэх мунхагийн харанхуйгаас уршигдаж цогцосоо "Би-д үзэх" эндүүрэл төрдөг буюу. Түүнээс бусад нисваанисууд төрдөг аж.

Дээрх хоёрыг нэг гэж авч үзэх ёсноо эвдрэх үзэл нисваанисын язгуур болдог. Тийнхүү эвдрэх үзлээр "би"-гээ бариваас, өвөр бусад (миний чиний) хэмээн тусгаарлан үзэж өөрийн зүгт тачаах шунах, бусдын зүгт уур хилэн үүсгэх, "би"-гээ онцгойлох омог дээрэнгүй ч төрөх буюу. Улмаар "би"-гээ мөнх болон тасархай үзлээр барих,"би"-дээ шунах, түүнээс үүдсэн муу явдлыг сайн гэж үзэх буруу бодол ч гарч ирнэ.

Үүний дээр "би-үгүй" үзлийг заагч Бурхан багш, түүний заасан үйлийн

үр, дөрвөн үнэн, чухаг дээд зэргийг байхгүй хэмээн буруу үзэхэд хүрнэ. Мөн тэдгээрийг байна уу, үгүй юу, мөн үү, биш үү хэмээн доноголзох явдал ч үүдэх буюу.

"Тийн тайлбар"-т:

Би-г буй гэснээс л бусдыг буй гэж үзэх мэдэх
Өвөр бусад гэсэн хувиас шунах ба уригнах буюу
Эдгээр бүхэнтэй эгнэгт барилдваас л
Элдэв хамаг гэм гарах болюу хэмээн айлджээ.

3. Нисваанисын төрөх үндэс шалтгаан. Нисваанис төрөх зургаан үндэс шалтгаан буй.

(1) Суурийн хувьд нисваанисын авьяас оршиж байна

(2) Бодлын орны хувьд нисваанис үүдэх таатай үзэгдэл орнууд үзэгдэх харагдах буюу.

(3) Хуран үймцээн буюу сайн нөхрийг бус саар муу нөхрийг даган суралцах болой.

(4) Номын талаас буруу номыг сонсох болой.

(5) Урьдаас муу сэтгэлтэй ижилсэх хүчинд сурамгай дадсан байна.

(6) Сэтгэлдээ тунгаадаг зүйлийн хувьд сайн юмыг муу ёр мэтээр хэтрүүлж үзэх, мөнх бус зүйлсийг мөнх хэмээн барих зэрэг ном бусыг анхаарч үйлдэх болой.

4 Нисваанисын гэм эргүү

Нэгэнт нисваанис төрсөн аваас л, сэтгэл бүхэлдээ муу сэтгэлд нэрвэгдэх, бодол санаа чанх буруугаар эргэх, муу авьяас батжих, тухайн язгуурын нисваанис үл тасрах, өвөр бусад хоёуланд хорлол гарах, энэ нас эцэс хойд хоёуланд амлашгүй хүнд нүгэл үйлдэх, зовж шаналах, сэтгэлд таагүйг амсах, төрөх тэргүүтэн зовлонгоор уршигдах, гаслангаас нөгчихүйгээс холдох, буян доройтох, төгс эдлэл буурах, нөхдийн дотор одоходоо сэтгэлээр унах, баяр баясалгүй болох, аймшигтай санагдах, зүг завсар бүхнээ яруу бус арвижих, багш, сахиус зэрэг дээдэс муушаах, гэмшилтэйгээр үхэх, үхсэн хойноо муу заяанд унаж өөрийн хэргээ бүтээж чадахгүйд хүрэх зэрэг элдэв муу үүдэх болюу.

"Судрын аймгийн чимэг"-т айлдахдаа ч:

Нисваанисууд намайг дарах, амьтныг хорлох, ёс журмыг баллах,
Доройтуулах, ололт амжилтыг буруулах, сахих, заахыг муушаах,
Хэрүүл тэмцэл, яруу бусыг үүдэх, бас эрх чөлөөгүй төрөлд төрүүлэх,
Олсон олох ёстой бүхнийг доройтуулж
Сэтгэлийн их зовлонг төрүүлэх хэмээсэн ба,

"Бодичарияаватара"-д:

Урин тачаал тэргүүтэн дайсан тэд
Гар хөл зэрэг эрхтэн байхгүй
Баатар цэцэн юу ч үгүй хэрнээ
Баттай намайг боолоо болгох

Миний сэтгэлд наалдан суусаар
Баясуулж хөөргөн намайг хорлох
Чингэвч үл уурлан тэсч сууна гэдэг
Ёс бусдад тэсэх муушаалын орон буюу

Хэрвээ тэнгэр хийгээд тэнгэр бус
Хамаг бүгдээр дайсан болж боссон байсан ч
Тэр бүгд аюус тамын их галын дотор
Хөтөлж оруулж чадахгүй

Нисваанисын хүчит дайсан энэ бээр
Юутай ч учирлаа Сүмбэр уулыг хүртэл
Үнс ч үлдээлгүй хийсгэх болохоор
Тэнд ганцхан агшинд л хаягдах би

Миний нисваанисын дайсан алин тэр
Эхлэл төгсгөлгүй, өнө удаан хугацаат буюу
Бусад дайсан бүгдээр тэр адилаар
Өнө удаан дийлэх бус болой

Зохилдох хүндлэлийг үзүүлж тахиваас
Бүгдээр тус болж амгалантай үйлдэх
Харин нисваанисыг шүтэж тахиваас л
Хожмоо зовлон хорлолыг үүдэх

хэмээн айлдсан гэм буруу зэргийг мэдэж үйлдээрэй.

Гомбава гэгээнээс, “Нисваанисыг тэвчихийн тулд түүний гэм буруу, бэлэг чанар, ерендег, терехийн үндэс шалтгаан зэргийг мэдэх хэрэгтэй. Гэмтэйг мэдээд муу зүйл гэж үз. Дайсан гэж барь. Гэм бурууг эс мэдвээс дайсан гэж ухаарахгүйд хүрнэ.

Иймээс *“Судрын аймаг”, ”Бодичарияаватара”* зэрэгт айлдсан ёсоор ухаарах хэрэгтэй” хэмээн айлджээ. Нисваанисын бэлэг чанарыг мэдэхийн тулд *“Авхидарма”*-г сонс. Наанадаж *“Таван цогцосын тийн ялгал”*-ыг сонсож язгуурын болон ойрын нисваанисаа таньж авна. Чингээд “шунах уригнах тэргүүтэн алин нэгэн сэтгэлд төрвөөс, За өнөө нөхөр чинь гараад ирлээ шүү” хэмээн танин бариад нисваанистайгаа тэмцэх мөн хэмээсэн мэтээр ухаарах хэрэгтэй.

б) Түүгээр үйл хураах ёс

1. Хураагдахуун үйлээ таних мэдэх
2. Түүнийг хэрхэн хураах ёс

1. Хураагдахуун үйлээ таних мэдэх

(а) Сэтгэлийн үйл
(б) Санааны (бие хэлний) үйл

(а) Сэтгэлийн үйл

“Хотлын хураангуй”-д: “Сэтгэлийн үйл гэж юу вэ хэмээвээс, Сэтгэлээр илт хураагдах сэтгэлийн үйл буюу. Буян, нүгэл, эшид эс үзүүлсэн (дундын) зэргийн сэтгэлээр үйлдсэн үйл болой” хэмээсэн мэт “Өөртэйгээ адил оронд (вишай) одох гол сэтгэлийн орныг өдөөж хөдөлгөж байдаг сэтгэлээс гарсан үйл болой.

(б) Санааны (бие хэлний) үйл. Тэрхүү хамаг сэтгэл санаагаар сэдэгдэх бие, хэлний үйл болой.

“Авхидхарма”-д:

Үйл гэдэг сэтгэл болоод түүгээр үйлдэгдэх буй
Сэтгэлийн гэдэг сэтгэлийн үйл болой
Түүгээр үйлдэгдсэн гэдэг бие, хэлний үйл хэмээн айлджээ [51]

Бие, хэлний үйлнээ мэдрэгч, эс мэдрэгч гэж хоёр хуваагаад "дүрс" болно хэмээн Өвөрмөц өгүүлэгч (Вайбхашика) нар үздэг. Үүнийг Ловон Егнин (Васубанду) үгүйсгээд "Бие, хэлний мэдрэгчтэй хамтрагч нь сэтгэл" гэж үзээд хоёр үйлийг "сэтгэлт" гэж номножээ. Ер нь үйлд буян, нүгэл, эшид үл үзүүлсэн гэсэн гурван зүйл байдаг ч энд эхний хоёр байна. [52]

Буяны үйлд цувиралттай, цувиралтгүй гэж хоёр буй. Энэ үесийн цувиралт буянууд хутагтын болон эгэл төрөлхтний сэтгэлд байж болохоос энд хойдхоор (эгэлийн сэтгэлд буй цувиралт буян) авч үзлээ. Нүглийн үйл гэдэг буян бусын үйл буюу. Буяны үйлд Амармагийн орноо багтах буяны үйл болой. Үл хөдлөх үйл гэдэг Дүрст болон Дүрсгүй орноо хураагдах цувиралт буяны үйл бөлгөө. [53]

Тэр талаар *"Авхидхарма"*-д:

Амармагийн орны буяны үйлүүд буянд багтах
Үл хөдлөх үйлүүд дээд орноос төрөх болой хэмээжээ.

Үл хөдлөх үйл юун хэмээвээс: "Амармагийн орны тэнгэрийн төрөлд боловсрох учиртай зарим үйлүүд адгуус, бирдийн төрөл дээр боловсордог. Үүнийг хөдлөх үйл гэж үздэг. Түүнтэй адил дээд оронд байхад өөр газарт боловсрох учиртай байсан үйлүүд тэр газраас өөр газарт үл боловсрох учраас үл хөдлөх үйл" хэмээжээ. [54]

"Авхидхарма"-д:

Алин орон тэдгээрт
Үйл боловсрох тул үл хөдлөх хэмээжээ.

2. Түүнийг хэрхэн хураах ёс:

Ер хутагтууд буяны үйлийг үйлдэж бас хураадаг. "Үргэлж орогч", "Жич ирэгч" хутагтууд [55] нүгэл хураах нь байх ч тэд сайн муу заянд хүргэгч үйлийг хураадаггүй буюу.
"Төв үзлийн үндэс"-ээс:

Орчлонгийн үндсийг хураан үйлдэх буй
Тиймээс хутагтууд хурааж үл үйлдэх
Тиймийн учир мунхагууд үйлдэх буюу
Хоосон чанарыг болгоох учир мэргэд тийн бус хэмээжээ.

Васубанду гэгээн (Ловон Егнин) бээр: "Үнэнийг үзсэнээр хаягдах бус" хэмээжээ. Хэдий хүртэл би бээр "бодгалийн би-д барих" буруу үзлийн эрхэнд автах тэр хүртэл, хаягдах үйлийг хураасаар л байна. "Би-үгүй" буюу хоосон чанарыг илт онох цагт үйл нисваанисын эрхээр орчлонд төрөл авах байвч хаягч үйлийг шинээр хураадаггүй.

Бяр тэнхээтэй хүн бяргүйгээ дийлэх адилаар "Үргэлжид орогч", "Жич орогч" нар "Би-д баригч" үзэлд автахгүй харин тэвчдэг болохыг *"Егүзэрийн явдлын газар"*-т айлдсан байна.

Тиймээс орчлонд хаягч болон хүргэгч, үйлийг хураагч нар их хөлгөний найрлагын мөрийн "их дээд номт" хэмээх дөтгөөр шатанд оршигчдоос доош орших эгэл төрөлхтөн бүгд багтах болой.

Тэр мэтээр нисваанист мунхаг болон эвдрэх үзлийн эрхэнд орсноор гурван үүдээр амь таслах зэрэг нүглийг илтэд үйлдэж, буян бусын үйлийг хураана.

"Амармагийн орны" буян болох өглөг өгөх, ёс журам сахих зэргийг үйлдвээс буяны үйлийг хураана.

Мөн "Диян" болон "Дүрсгүй" орноо харьяалах амарлингуй сэтгэл зэргийг бясалгалаас үл хөдлөх үйлийг тус тус хураах бөлгөө.

Чингэвээс орчлонгийн хотол чуулган бүгдийг гэмтэй гэж үзээд тонилохуйг эгээрэх хүслээр бүрэн эзлэгдэж ихээр хураасан буяны үйл болон тэрчлэн ажиглах ухаантай хамт орших сэтгэлээр хураасан зэрэг буяны үйлүүд орчлонгийн уг- бүхнийг гаргагч (нисваанис) болох уу, болохгүй юу хэмээвээс ер нь "Чуулгант" ба "Найрлагын мөрд орогч" [56] нар хаягч үйлийг өөрсдөө хураадаг.

Гэвч тэр адилын санаагаар өдөөгдсөн хоосон чанарыг ажиглагч ухаантай нэг зүгт орших буяны үйлүүд хойд төрөлд шунах сэтгэлийг хариулах ерөндөгийн зүгт багтаж болно. Зовлонгийн үндэс би-д баригч үзлийн оронтой харшлах учраас хаягч -"бүхэн гарахуйн үнэн" яг биш ч дахин хойд ертөнцийг үүдэх бодитой "бүхийг гаргагч" лугаа даган зохилдох учраас "бүхэн гарахуйн" бүлэгт багтах ажээ.

Тийм болохыг *"Нотлон буулгахуйн хураангуй"*-д: "Аливаа ертөнц бүхний "номыг гаргагч"-нисваанисыг сөхөөж түүнээ үл зүглэн, ертөнцөөс гэтэлсэн мөрийг төрүүлэгч тэдгээрийг юуны учир "бүхэн гарахуйн үнэн"-д багтааж үзнэ вэ.

Үнэндээ тэд эргэх зовлонт хорвоо руу зүглээгүй билээ. Гэхдээ тэд хорвоогийн бие, хэл, сэтгэлийг сайтар эдэлж, түүнтэй зохилдон байгаа учраас "бүхэн гарахуй"-д багтаж байна гэж мэдээрэй" хэмээжээ.

Хорвоогоос тонилох мөрийг заагч нараас орчлонгийн гэм эргүүг сайтар мэдээд, түүнээс сэтгэл ганcрах санаагаар өдөөгдсөн буяны үйлийг бүхнийг гаргагчтай даган зохилдоно хэмээн айлджээ. Иймээс энэхүү санааг болоод хоосон чанарын ухааныг төрүүлэхийн төлөө шамдах хэрэгтэй.

Орчлон зовлонтой шүү гэж олон дахин тунгааж бясалган байж түүний сайн сайханд шунах сэтгэлийг сөхөөх ерөндөгийг олоогүй, "би-үгүй"-н утгыг тус тус ажиглагч ухаанаар ёсчлон ажиглаж чадаагүй, хоёр бодь сэтгэлийг дадуулахаас хагацсан тийм буяны үйлүүд хаая нэг орны хүчнээ шүтэхээс бусад нөхцөлд "бүхэн гарахуйн" зүг өөрийн дураар одох тул орчлонгийн хүрднээ эргэлдэн байгаа буюу.

2. Түүнийг хэрхэн хураахад

(а) Амгалантай амсуургын [57] тухайд хураах
(б) Тэгш агуулах амсуургын тухайд хураах хоёр зүйл буй.

(а) Амгалантай амсуургын тухайд хураах

Дүрс, дуу тэргүүтэн хүслийн эрдмээс үүдэх амгалан болон б) Гадагш зүглэсэн амгалан зэрэгт шунахаас буцаж бясалгалаас төрсөн амгалант амсуургын тухайд үйл хураах болой.

а) Үүнээ үхэхээс наашхи энэ насны жаргалыг голлон буян бусын үйлийг хураах ба хойд насны амгаланд голчлон зорьж буяны үйлийг хураах гэсэн хоёр хэсэг буй.

б) Бясалгалаас төрсөн амгалангийн амсуургад голлон зорьж "гутгаар бясалгалын орноос доош анхдугаар орон" хүртэл төрөх үл хөдлөх үйлийг хураах болой.

(б) Тэгш агуулах амсуургын тухайд хураах

Хүслийн эрдмээс шунал буцан, амгалант амсуургаар сэтгэл залхаж тэгш агуулах амсуургын тухайд үйлийг хураан, "дөтгөөр бясалгалын

орноос орчлонгийн үзүүр хүртэл" төрөл авдаг үл хөдлөх үйлийг хураана" гэж Васуванду гэгээн үзжээ.

Энэхүү ухаанаар хамаг хорвоод шунахаа больж нирваанд зорин гурван үүдээр буяныг илт хураах болсноор орчлонгоос холдон холдож нирваан хутагт ойртон ойртох болой.

в) Үхэх ба төрөл авах ёсноо таван зүйл

1. *Үхэх шалтгаанууд*
2. *Үхэх үеийн сэтгэл*
3. *Хаанаас эхэлж илч хураагдах ёс*
4. *Үхлийн дараа зуурдын төрөл авах ёс*
5. *Түүний дараа орчлонд төрөл авах ёс*

1. Үхэх шалтгаанууд

Насаа гүйцээгээд үхэх: Урьдын үйлээр хаягдсан бүх насаа барж гүйцээд үхэх буюу цаг нь гүйцээд үхэх буюу.

Буянаа бараад үхэх: Эдлэл хэрэгсэлгүй болоод үхэх болой.

Сэрэмжгүйгээс үхэх: Судраас насаа гүйцээлгүй үхэх есөн шалтгаан байдаг талаар айлджээ. Үүнд идээ хоолны хэмжээг барилгүй идэх, таарамжгүйг идэх, түрүүчийн идсэнээ шингээлгүй идэх, ходоодонд байгаа шингээгүй зүйлийг эс гаргах, боловсорсныг хорих, эмийг тус тус эс шүтэх, сурсан сураагүйгээ үл мэдэх, цаг хугацааг буруу сонгох, ариун бусаар явах эдгээр ажгуу.

2. Үхэх үеийн сэтгэл. *Үүнд гурван зүйл буй.*

(а) Буяны сэтгэл төгөлдөр байж үхэх: Өөрөө санах буюу бусдаар сануулсан ч байсан болно. Бүдүүн хур мэдэлтэй (өөрийн ухаантай) байх хүртлээ сүслэх биширэх зэрэг буян номоо сэтгэлдээ бүгдийг бодож санаж байх болой.

Нүгэл буян үйлдсэн бодгаль амьтан үхэх үед өөрөө буюу бусдууд сануулсан ч бай ялгаагүй алин урьд олонтаа дадаж сурсан тэрхүү үйл их хүчтэй байдаг. Түүгээр дамжиж тухайн үеийн сэтгэл хөтлөгдөж харин бусдууд мартагдах болой.

Хоёуланд тэнцүү дадсан бол эхлээд алиныг санасан түүнээс сэтгэл

буцахгүй бөгөөд өөр тийшээ явахгүй. Буян хийж байсан бол үхэхийн цагт харанхуйгаас гэрэл гэгээ рүү явж байгаа юм шиг санагдаж, үзэсгэлэнт сайхан дүрс зүүдлэгдэн, сэтгэлд тааламжтай элдэв олон зүйл бодогдох бөгөөд амар тайван явах буюу.

Мөн үхэх болоход хүчтэй хатуу энэлэл шаналал мэдрэгдэхгүй. Сайн үйлийг үйлдэгч нарт маш бага нажид зовлон учирдаг байна.

(б) Нүглийн сэтгэлтэй үхэх: Өөрөө буюу бусдууд ч сануулж болно. Бүдүүн хур мэдэлтэй байх хүртлээ шунах тачаах зэргийн нүгэлт муу сэтгэлийг хадгалах бөгөөд үхэх шахуут хүчтэй хатуу зовлон нажидийг биеэр мэдэрч амсана. Нүгэл үйлдэгч үхэхийн цагт урьдын үйлдсэн нүгэлт үйлийн үрийн муу ёрыг амсана.

Мөн элдэв муу муухай юмс зүүдлэх ба гэрэл гэгээнээс харанхуй газарт одох адил санаанд буүна. Нүглийг ихээр үйлдэгч нарт муухай дүрс үзэгдэх, биеэр зовох шаналах, шар үсний нүх босож гар хөл салгалах, өтгөн шингэн алдах, хий хоосноос зуурах, нүдээ эргэлдүүлэх, амнаас нь хөөс цахруулах мэтийн үзэгдэл гардаг аж.

Харин дунд зэргээр нүгэл үйлдэгчдэд тэдгээрээс заримууд гарах ба заримууд үл гарна. Бүгд гарах албагүй ажээ. Мууг үйлдэгч нар маш хатуу зовлон нажид амсах буюу. Нажид зовлон гэдэг тэнгэр, там хоёроос бусад төрөл бүхэнд байдаг.

Үхэхийн цагт хамаг хур мэдэл, мэдрэхүй балартахын зуур аль эртнээс дадсан "би"-дээ тачаах сэтгэл төрдөг. Тийнхүү "би"-д тачаасаар "би чинь байхгүй" боллоо гээд биедээ баясдаг байна. Энэ санаа зуурдын төрөл авахын шалтгаан болдог.

Хэдийгээр "Үргэлжид оргч", "Жич ирэгч" нарт "би"-дээ тачаах явдал гардаг боловч билгээр шинжиж тэвчих учраас тэдэнд орших боломж олгодоггүй байна.

Үлгэрлэвээс, Их хүчтэй нь хүч доройгоо дэлсэх адил "Жич ирэгч" нарт би-д тачаах сэтгэл ургахгүй болой.

(в) Эшид эс үзүүлсэн (дундын) сэтгэлтэй үхэх. Нүгэл буяныг үйлдсэн байна, эсвээс үйлдээгүй ч байж болно Өөрөө болон бусад хэн ч тэр хоёрыг эс сануулна. Үхэх цагт төгөлдөр жаргалтай ч бус, зовлонтой ч бус байх болой.

Бүдүүн хур мэдэлтэй байх хүртлээ л буяны сэтгэлтэй байж үхэх буюу. Нарийн хур мэдэл гүйхийн цагт буяны сэтгэл хураагдаж дундын сэтгэл болж хувирсан байдаг. Тэр үед урьд дадсан буянаа санах чадалгүй болсон байх агаад бусдууд ч сануулаад дийлэхгүй. Нүгэл дээрч мөн энэ адил бөгөөд нарийн хур мэдэл гүйхийн цагт үхлийн сэтгэл бүхэн дундын байдалд шилждэг .

"Авхидхармын тайлбар" –т айлдахдаа "Буяны сэтгэл гэдэг тунгалаг гэгээлэг учраас тасарч буй үхлийн сэтгэлтэй адилгүй " хэмээжээ.

3. Хаанаас эхэлж илч хураагдах ёс

Нүгэл үйлдэгч нарын хувьд тийн мэдрэхүй (сүнс) нь биеийн дээд хэсгээс орхигдох (хураагдах) учраас биеийн дээд хэсэг хөрч эхэлдэг байна. Хураагдаж явсаар зүрхэнд хүрнэ. Буян үйлдэгч нарын хувьд доороос хураагдан хөрч эхэлдэг байна. Сүнс эл хоёулангийн зүрхнээс гарч одох буюу шилждэг болой. Дусал шимийн дотор анх оршсон сүнс тэр биений зүрх болж тогтдог ажгуу. Тиймээс эцэстээ аль ч зүгээс шилжсэн бай ялгалгүй анхныхаа байранд ирж хурдаг жамтай. Энэ мэтээр биеийн илч эхлээд доороос эсвэл дээрээс шилжиж зүрхэнд хураагдах буюу. Түүнээс бус доор, дээр эсвээс завсар хооронд хурна гэж байхгүйг ухаараарай.

4. Үхсэний дараа зуурдын төрөл бүтэх ёс:

Дээр тайлбарласан мэт тийн мэдрэхүй (сүнс) шилжих яг тэр цагт жинлүүрийн таваг дээш доош солбицох адилаар ямар ч завсаргүйгээр үхэл гүйцэж, зуурдын төрөл бүтдэг ажгуу. Чингэхэд биендээ шунах сэтгэл төрсөн, урьд дурлаж баясаж байсан төгс гүйцсэн, нүгэл буян зэрэг хоёр үйлийн үрт шүтэх зэргийн шалтгаан нөхцлүүд бүрдсэн байдаг.

Зуурд төрөл дээр нүд ам зэрэг эрхтэн бүхэн бүрэн гүйцэд, хаана төрөх тэр төрлийнхөө биеийн намба төрхтэй байдаг. Төрөл авах хүртлээ нүдний хараа нь тэнгэрийн нүд мэт юуг ч нэвт шувт харах, бие нь юунд ч торж тулахгүй рид хувилгаант байдаг аж. *"Авхидхарма"*-д:

Урьд цагийн төрлийн махан бодитой
Тэр нь үхэхийн өмнө буюу
Төрөх агшинаас цааш болой
Тэнгэрийн арилсан нүдээр зохилдуул харах

Үйлээр рид хувилгааны хүч төгс байх
Хамаг эрхтэн төгс болоод үл торох тулгарах
Үүнээс үл буцсан тэрээр үнэр идэштэн болой.

Бясалгалаар олдог тэнгэрийн арилсан нүдээр язгуур зохилдуу зуурдын төрөлтнөө харж чадна. Аль ч төрлийн зуурдын төрөл авсан нөхцөлд өөр төрлөөр солигдохгүй гэж айлдсан буй. Гэвч *"Хотлын хураангуй"* -д ингэж үзээгүй байдаг.

"Урьд цагийн төрөл" гэхэд дөрвөн төрөл байдаг.

(а)Үхээд төрөл авахын завсарт зуурдын төрөл

(б) төрөл авсан анхны агшинг төрөх төрөл

(в) түүний удаах агшингаас хамгийн сүүлчийн үхлийн агшингийн өмнөх хүртэл урьд төрөл

(г) үхлийн хамгийн сүүлчийн агшинг үхлийн төрөл гэж *"Авхидарма"*-д айлджээ. Одоо байгаа энэ төрөл дээр ирэх үхэх төрөлтэй харьцуулан "урьд" гэж өгүүлсэн хэрэг. Үүнийг эндүүрэн үүнээс урьд төрлийн бие дүр төрхтэй гэх буюу хойд төрлийнхөө бие дүртэй гэх зэргээр номносон үзэгдэнэ.

Ингэхдээ хоногийн дөрөвний гурав нь урьд төрөл, дөрөвний гурав нь хойд төрлийн биеийн байдалтай гэж үзэх нь ямар ч зөв эш баримтгүй зөвхөн хэтийдэл төдий болой. *"Егүзэрийн явдлын газар"*-т "тийн мэдрэхүй оршихгүй учраас урьдын бие гэж үзэж болохгүй" гэж айлдсан тул урьдын биеэ үзээд таагүй сэтгэл төрнө гэх нь ч бас хэтийдэл болой.

Нүгэл үйлдэгчийн зуурд нь хар дарцаг хийсэх буюу шөнийн харанхуйд яваа мэт санагдана. Буянтай зуурд нь цагаан бөс даавуу хийсэх буюу сарны гэрэл гийх шөнө мэтээр санагдана. Өөр өөрийн язгуур зохилдох зуурдын төрөлтөн болон төрөх орноо үзэж харна.

"Хэвлийд оршихуй"-д: "Тамын зуурдууд шатсан хожуултай адил, адгуусных утаа униар мэт, бирдийн зуурд ус мэт, амармагийн тэнгэр болон хүний зуурд алт мэт, дүрст орны зуурд цагаан байхыг айлдсан байдаг нь өнгөөр ялгасан аж. Дүрсгүй ертөнцөөс доод хоёр ертөнцөд төрөхөд зуурдын төрөл авдаг. Тэр хоёроос дүрсгүй ертөнцөд төрөхөөр хаана ч үхсэн бай тэндээс дүрсгүй орны цогцос бүтэх хүртэл зуурдын төрөл авахгүй. Гол номуудаас зуурдын төрөл авахгүй байх онцгой тохиолдол

үүнээс өөрийг номноогүй байна. Иймээс дээр (тэнгэр) доор (газар) хоёрын савслага завсарт зуурдын төрөл байхгүй гэж үзэх нь зохисгүй буюу.

Тэнгэрийн зуурд нь цэх дээшээгээ, хүний зуурд хажуугаараа явна. Муу үйл хийгчдийн зуурд нь толгойгоо доош харуулан нүдээ буулгаж одно" хэмээжээ. Гурван муу заяаных энэ адилаар ажээ.

"Авхидхармын тайлбар"-т айлдахдаа: "Хүмүүн, бирд, адгуус гурав өөрсдийн явдалтай адил явдлаар явна" гэжээ. Насны хэмжээний хувьд, төрөх нөхцөл бүрдээгүй бол түр долоо хоног тогтоно. Нөхцөл бүрдвээс заавал албагүй. Нөхцөл бүрдээгүй байсан ч биеэ солиод долоон долоо хоног л орших ёстой. Энэ хугацаанд заавал төрөл авах нөхцөл бүрдсэн байх учраас түүнээс цааш орших учиргүй. Гол номуудаас ч үүнээс удаан байна гэж номноогүй тул үүнээс удаан оршино гэж үзэх үндэсгүй. Тэнгэрийн зуурд зэргээр жишээлэхэд үхээд долоо хоногийн зуур тэнгэрийн зуурд юм уу, эсвээс хүн тэргүүтний зуурд болж явдаг байна. Бусад үйлийн эрхээр урвах учраас зуурдын хөрөнгө өөрчлөгдөж болдог байна. Бусад дээр ч мөн адил буюу.

5. Түүний дараа төрөл авах ёс

Умайд төрөх зуурд төрөлтөн тэрээр төрөх орондоо язгуур таарах амьтнаа үзэж харах ба тоглож наадмаар бодогдож улмаар төрөх орон руу одох хүсэлд эзлэгдэнэ. Эх эцгийн бөөм, цус (цагаан улаан) хоёрыг шууд харах болно. Тэр цагт эх эцэг хоёр хэвтэж үйлдээгүй байсан ч тийм буйг илбэ адилаар үзнэ. Түүнээ хүсэл шунал төрж ирнэ. Чингэхдээ эм болж төрөх болвоос эмээс салахын хүслэн төрж эрд тачааж хамт хэвтэхийн хүслэнд автана. Эр болж төрөх аваас эрээс хагацахын хүслэн төрж эмд тачааж хамт хэвтэхийн хүслэнд автдаг ажгуу.

"Егүзэрийн явдлын газар"-т: "Үнэндээ эх эцгээ харж байгаа бус, бөөм цус хоёрыг эндүүрч хэвтэж байна гэж хардаг" хэмээн номножээ. Тэр мэтийн хүсэл оргилоод ирэхээр хэдий чинээ дөтлөх төдий чинээ оргилж ирэх учир эмэгтэйн гар хөл зэрэг бусад юу ч харахгүй зөвхөн эр эмийн хоёр бэлгэ төдийг л харах буюу. Хэн нэгэнд уурлангуут зуурдын төрөл үхэл егүүтгэн төрөл авах нь тэр ээ.

Чингээд нөгөө эх эцэг хоёрт хүсэл оргилж хүчтэй дур хүсэл буухын сүүлчээр эхүүн дусал ялгарна. Түүний дараа нөгөө эцэг эх хоёулангаас

бөөм, цусны дусал лавтай яа бууж ирдэг. Тэр хоёр эхийн умайд холилдож тогтоно. Үлгэрлэвээс сүүг хөөрүүлж, хөргөж, загсаахад сүүний дээгүүр тогтсон өрөмтэй адил буюу.

Чингэхтэй хамт нөгөө зуурдын амьтан төрдөх (үгүй болох) болно. Тэр үгүй болохын хамт *"Хотолын суурь"*-ийн тийн мэдлийн хүчээр түүнээс үндэслэн бусад эрхтний нарийн бүдүүн махводууд, нөгөөх бөөм цусны нийлмэл хурмалаас бусад эд эс, эрхтэнгүүд төрж гарна. Тэр цагт (тэнд) тийн мэдэл орших болсноор төрөл авлаа гэж үзэх болой.

"Хотолын суурь"-ийг зөвшөөрдөггүй ёсноо дотоод сэтгэлийн тийн мэдэл оршсоноор төрөл авсан гэж үздэг. Ийн төрөл авахдаа буян багатай нэгэн доод төрөлд төрнө. Төрөл солигдох, умайд орохын үест уйлж цурхирах дуу гарах. Намаг шавартай харанхуй ой шугуйд одох адилын үзэгдэл ургана. Сайн үйл үйлдэгчид дээд төрөлд төрөх бөгөөд яруу уянгатай дууг сонсон, сайхан орон байшин, хэмжээлшгүй их орд харшийн зүг одох зэргээр үзэгдэнэ. Тэд бас хэвлийд гучин найман долоо хоногт гар хөл зэрэг бие эрхтэн бүгд төгс төгөлдөр болдог бөлгөө. Ингээд дөрөв хоноод төрдөг буюу.

"Хэвлийд оршихуй"-д: Тэндээ есөн сар жаахан илүү гараад төгс боловсрох болой. Найман сар болоод гүйцэх байвч төгс бус болой. Зургаа юм уу долоон сар бол огт гүйцээгүй бөгөөд эд эрхтэнгүүд дутуу байна" хэмээжээ. Эдгээрийн талаар дэлгэрэнгүйг *"Хэвлийд оршихуй"*-гаас мэдээрэй.

Хэрвээ төрөх орноо одох хүсэл төрөхгүй бол тийшээ очихгүй. Очихгүй болохоор тэнд төрөхгүй байж болдог. Тамд төрөх үйлийг үйлдэж бас хураачихсан байсан хэдий ч, ямар нэг цээргүйгээр хонь гаргах, гахай шувуу нядлах зэргийн үйлийг үйлдэгчид зуурдын төрөл дээрээ төрөх оронд нь хонь гаргах зэрэг ажил зүүд шиг үзэгдээд ирэхээр урьд сурсан ажилдаа баясал төрж улмаар тийшээ гүйдэг ажээ. Чингээд төрөх төрлийнхээ дүрсэнд уурлангуут зуурдын төрлөөс салж төрөл авах буюу.

Там түүнтэй адилаар бирд ч мөн ингэж төрөл авна. *"Егүзэрийн явдлын газар"*-т айлдахдаа: "Адгуус, бирд, хүмүүн, хүсэлт тэнгэр, дүрст ертөнцийн тэнгэрийн орон зэрэгт төрөх цагт өөрийн язгуур нэгт амьтныг тухайн орондоо баясгалантай яа харж үзэх ба түүнээс улбаалан тэдэн рүүгээ баясаж тэмүүлэн очно. Ингээд төрөх орондоо уурлах сэтгэл төрмөгц оршихуй гишүүн хаагдаж төрөх орондоо төрдөг" хэмээжээ. Санваргүй

үйлтэн болон гахайны наймаачин бусууд тамд төрөх зэргүүд үүнтэй адил буюу.

"Авхидхарма"-д: "Үнэр болон орноо илт шунах бусад" хэмээн чийг элчнээс төрөх бол элчинд дурлах, рид хувилгаанаар төрөх бол орныг хүсэх зэрэг бодол төрдөг аж. Мөн зуурдын төрөл дээр явахад халуун тамд төрөх бол дулаан элч хүсэх, хүйтэн тамд төрөх бол сэрүүн баймаар бодогдоно гэж *"Тайлбар"*-т номножээ. Өндөгнөөс төрөхөд ч умайгаас төрөхтэй адил гэж *"Авхидхармын тайлбар"*-т номносон буй. Үхэл егүүтгэх болон төрөл авах ёсны талаарх тусгай нөхцөл заагаагүй зүйлсийг *"Газрын бодит суурь"*-д айлдсан дагуу номнов.

Арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санах

б. Арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санахад дөрөв

(1) Гишүүдийн ялгал
(2) Гишүүдийн товч хураангуй
(3) Хэдэн төрөлд гүйцэх
(4) Тэдгээрийн утгын хураангуй

(1) Шүтэн барилдаж гарахуйд арван хоёр гишүүн буй. Үүнээс:

1) Мунхаг

"Авхидхарма"-д: "Мунхаг болвоос дайсан болон хуурмаг тэргүүтэнтэй адил" хэмээсэн мэт буюу. Энэ дайсан болно, тэр хуурмаг шүү гэж үзэхдээ зөвхөн тэр хоёрыг садан бус, үнэн бус гэж үгүйсгэх төдийхөн буюу эсвээс тэдгээрийг бусад зүйл хэмээх төдийхнөөр хязгаарлаж болохгүй. Харин садан болон үнэн хоёрын жинхэнэ харшлах утга болж байгаа талаас нь авч үздэг билээ. Мунхагийг авч үзэхдээ түүний ерөндөг болох ухааны эсрэг тал буюу эсвээс түүнээс өөр зүйл төдийхнөөр хязгаарлан үзэж болохгүй. Харин мунхаг бол оюун ухааны жинхэнэ харшлах зүг гэдэг талаас нь авч үзэх хэрэгтэй.

Их багш Дхармакирти бээр: "Энэ үесийн ерөндөг ухаан бол үнэмлэхүй үнэн болсон бодгалийн "би-үгүй" чанарыг оносон билиг мөн тул түүний харшлах нөхөр нь бодгалийн "би- баригч" эвдрэх үзэл болой" хэмээн тодорхойлжээ. Ах дүү Асанга нар айлдахдаа, үнэмлэхүй үнэний

утгыг чанх буруугаар барих болон үнэмлэхүй утганаа эндүүрэх хоёр зүйл мунхаг байдгаас сүүлчийнхээр болгоосон байна.

Товчилвоос буруу онох болон үл онох хоёр ухаанаас үл онох ухаан болой. Гэхдээ түүнийг буцаах гол ерөндөг би-үгүй буюу хоосон чанарыг оносон ухаан билиг гэдэг дээр (мэргэд багш нар) нэгэн таалалтай бөлгөө. Эндүүрэх мунхагт үйлийн үрд эндүүрэх, хоосон чанарын утганаа эндүүрэх гэж хоёр ялгаж үздэг. "Эхнийхээр муу заяанд одох үйлийг хураах, удаахаар сайн заяанд төрөх үйлийг хураана" гэж *"Хотолын хураангуй"*-д айлджээ.

2) Хуран үйлдэхүй (үйл)

Хуран үйлдэхүй бол үйл буюу. Түүнээ муу заяанд хүргэдэг нүглийн үйл болон сайн сайн заяанд хүргэдэг буяны үйл гэж хоёр буй. Буяны үйлд хоёр хүсэлт ертөнцийн амгалан сайн заяанд хүргэгч буяны үйл, дээд тэнгэрийн заяанд хүргэгч үл хөдлөх үйл гэж хоёр буй.

3) Тийн мэдрэхүй (мэдэл)

Судартай айлдахдаа: "Зургаан тийн мэдрэхүй буй" хэмээжээ. Гэвч энэ үест түүнийг *"Хотлын суурь"* байна гэж үзэгч нарын хувьд *"хотлын суурь"* гэж гол болгож үзэх ба хотлын суурийг үгүйсгэгч нараас "тийн мэдрэхүй" гэж эрхэмлэн үздэг байна. Нүгэл хилэнц үйлдвээс зовлонгийн зовлон үр болж гарна шүү гэдгийг үл ухаарснаас нүгэл хилэнцийн үйлийг бодитойгоор хураадаг. Тэрхүү үйл явсаар дотоод сэтгэлийн авьяас болж тийн мэдрэхүйд наалдаж хадгалагддаг байна. Тэр үеийн тийн мэдрэхүйг "үндэс шалтгааны үеийн тийн мэдрэхүй" гэдэг. Түүнээ шүтэн дараагийн муу заяанд төрөл авах үед гарч ирэх тийн мэдрэхүйг "үр дагаварын үеийн тийн мэдрэхүй" гэнэ.

Түүгээр зогсохгүй би-үгүйн хоосон чанарыг мэдэхгүйн эрхээр сайн заяаны амьтан ч үнэхээр зовох буюу. Түүнийг ухаараагүй учир жаргалтай мэт барьдаг аж. Ийнхүү буяны үйл болон үл хөдлөх үйлийг хураах үесийн тийн мэдрэхүй нь үндэс шалтгааны үеийн тийн мэдрэхүй болно. Түүнээ шүтэн хүсэлт ертөнц болон дээд сайн заяанд төрөл авах үеийн тийн мэдрэхүй нь үр дагаварын үеийн тийн мэдрэхүй болно.

4) Нэр болон дүрс

Амсуурга, хуран мэдрэхүй, үйл, тийн мэдрэхүй дөрөв буюу дүрс бус дөрвөн цогцосын нэр гэнэ. Дүрсгүй орноо төрөхөд дүрсний хөрөнгө төдий

нэгэн байх ч түүнээс бусад төрөлд орших улцагнах зэргийн дүр болох алин бүгдээр дүрсэнд багтах буюу.

5) Зургаан төрөн түгэхүй

"Газрын бодит суурь"-т: "Умайд төрөх үед анх тийн мэдрэхүй оршсон улцгар байсан цус шим, болон цэр зэргүүд улам төлжиж боловсорсоор нүд тэргүүтэн дөрвөн эрхтэн болж хөгжнө. Бие болон сэтгэлийн төрөн түгэхүйнүүд улцгар байх үеэс л бүрэлдэж байдаг. Рид хувилгаанаар төрөл авах үед эрхтэнгүүд нэгэн зэрэг бүтдэг учраас ийм үе шат байхгүй. Өндөгнөөс төрөх болон чийгнээс төрөх умайгаас төрөхтэй адилгүй өөр болой" хэмээжээ. Чингээд нэр, дүрс бүрэлдэхээр биеийн мөн чанарыг олдог. Зургаан төрөн түгэхүй бүрэлдсэнээр биеийн ялгамжаанууд бүрэлдэн бий болж эдлэгч эзэн тодордог байна. Дүрст зургаан төрөн түгэхүй дүрсгүй орноо бүрэлдэхгүй.

6) Мэдрэхүй (хүртэхүй)

Мэдэгдэхүүн (орон), эрхтэн, тийн мэдрэхүй гурав хурж нийлсний үндсэн дээр сэтгэлд таатай, таагүй болон эсвээс дундын орон болохыг ялгаж мэдэх сэтгэл буюу. "Зургаан төрөн түгэхүй шалтгаанаар" хэмээсэн нь орон болон тийн мэдрэхүйг ч мөн бэлгэдсэн буюу.

7) Амсуурга (сэрэхүй)

Мэдрэхүйгээр гурван орныг мэдэж ухаарсны дараа даган зохилдсон амгалантай сайхан, зовлон шаналалтай, эсвээс дунд оршсон гурван зүйлийн амсуурга (сэрэхүй) төрнө.

8) Шунах

Амгалантай амсуургаас үл хагацах ба зовлонтой амсуургаас хагацъюу хэмээн шунахайрах болой. "Амсуургын шалтгаанаар шунал төрнө" гэж айлдсан нь мунхагаас шалтгаалж мэдрэхүй төрөх, түүнээс шалтгаалж шунах сэтгэл үүдэхийг айлджээ. Хэрэв мунхаг төрөхгүй бол амсуурга байвч шунах сэтгэл төрөхгүй. Мэдрэхүй бол мэдэгдэхүүн орныг төгс эдлэгч болдог. Амсуурга бол төрөл буюу тийн боловсролыг төгс эдлэгч болдог. Иймээс энэ хоёр бүрэн гүйцэхээр бүрэн төгс эдлэгч болдог аж. Шунах сэтгэлд гурван ертөнцийн гурван шунал байна.

9) Авахуй

Дөрвөн зүйлийн орноо дурлаж шунах буюу. Дүрс тэргүүтэн хүслийн эрдэм, эвдрэх үзлээс бусад буруу үзлүүд, буруу үзэлтэй барилдсан муу ёс журам, муу зан заншлууд болой. Мөн эвдрэх үзэлд дурлаж шунан хүслийг тухайлан авах, үзэл онолыг тухайлан авах, ёс журмыг тухайлан авах, зан заншлыг тухайлан авах, "би-д" өгүүлэгчийг тухайлан авах зэрэг болой.

10) Оршихуй (үйл)

Урьдын хураасан үйл авьяас болж тийн мэдрэхүйд наалдаж хадгалагдана. Тэрхүү хадгалагдсан авьяас шунал, авахуй (нисваанис) зэргээр сэргэж өдөөгдөн дахин хойд төрлийг үүдэн гаргах хүч чадал оршсон байдал буюу үндэс шалтгааны үр дагавараар нэрлэсэн болой.

11) Төрөхүй

Төрөхүйн дөрвөн оронд анхлан тийн мэдрэхүй оршиж төрөл авч буй явдал болой.

12) Өтлөх ба үхэх

Өтлөх гэдэг цогцос боловсорч гүйцээд өөрчлөгдөж байгаа явц буюу. Үхэх гэдэг цогцосоо сольж орхих явдал бөлгөө.

(2) Гишүүдийн товч хураангуй

"Хотолын хураангуй"-д: "Хэрхэн гишүүдийг товчлон хураах вэ? хэмээвээс,

а) Хүргэх гишүүн (хаягч)
б) Хүргэгдсэн гишүүн (хаягдагч)
в) Илт бүтээгч гишүүн
г) Илт бүтээгдсэн гишүүн

а) Хүргэх гишүүн алин хэмээвээс, Мунхаг, үйлийн үр, тийн мэдэл гурав буюу.

б) Хүргэгдсэн гишүүн алин хэмээвээс, Нэр ба дүрс, зургаан төрөн түгэхүй, мэдрэхүй, амсуурга дөрөв болой.

в) Илт бүтээгч гишүүн алин хэмээвээс, Шунах, авахуй болон оршихуй гурав буюу.

г) Илт бүтээгдсэн гишүүн алин хэмээвээс, Төрөх болон өтлөх, үхэх болой" хэмээн айлдсан мэт буюу.

Чингэвээс "хүргэгч" болон "бүтээгдсэн гишүүн" хэмээх шалтгаан, үр дагаварын хоёр хэсэг аймгаар нэг амьтны төрөл авах шалтгаан үр дагаварыг нэг зэрэг зааж байна уу, эсвэл хоёр хэсэг зааж байна уу

Эхнийхээр болвол үрийн үед гарах тийн мэдрэхүйгээс эхлээд амсуурга хүртэл бүрэлдэж бий болсны дараа шунал тэргүүтэн нисваанис төрнө гэж номнох учраас таарахгүй. Удаахаар болвол дараах үед бий болох шалтгаан үр дагаваруудад мунхаг сэтгэл, үйлийн үр, үндэс шалтгааны үеийн тийн мэдрэхүй зэргүүд байхгүй байгаа учраас эхний үндэс шалтгааны аймагт шунах авахуй болон оршихуй зэрэг гишүүд үгүй болох уу гэвээс, Ийм гэм гарахгүй.

Аливаа хүргэх ёстой шалтгаанаар "хүргэгдсэн" тэрээр түүнийг бүтээгч шалтгаанаар "бүтээгдсэн" бөгөөд тийнхүү "хүргэгдэн бүтээгдсэн" түүн дээр төрөх, өтлөх, үхэх гишүүд агуулагдана. Тэгвэл юунд шалтгаан үрийн хоёр аймаг гэж номнов. "Хүргэгч" үйлийн үрд гарч байгаа зовлонгийн үнэн болон "бүтээгч" гишүүний үрд гарч байгаа зовлонгийн үнэн хоёрын бэлэг чанар тус тус гэдгийг үзүүлэхийн тулд буюу.

Эхнийх нь хүргэгдэх үедээ хөрөнгө байгаа учраас хараахан өөрийн мөн чанараар бүтээгүй байна. Харин ирээдүйд зовлон болж боловсордог. Удаах нь тэрхүү зовлон бүтэж биелэлээ олсон үе учраас энэ насны зовлонгууд болж бүтсэн буй. Түүнчлэн үр болсон төрөл авахад "хүргэх" үндэс шалтгаан болон түүгээр хүргэгдэн "бүтээгдэх" хоёр шалтгааныг танин барихын тулд хоёр учир шалтгааны хоёр аймаг болгон номножээ.

"Газрын бодит сууръ"-д: "Тийн мэдрэхүй тэргүүтнээс амсуурга хүртэлх гишүүд болон төрөх, өтлөх, үхэх зэрэг гишүүд нь ижилсэж нийлэх бэлэг чанартай байхад юунд хоёр янзаар үзүүлсэн бэ. Бодит зовлонгийн бэлэг чанарууд тус тус гэдгийг үзүүлэх, мөн хүргэгч болон илт бүтээгдэх гишүүдийн тийн ялгалыг үзүүлэхийн тулд болой" хэмээжээ. Гишүүд дотроос хэд нь зовлонгийн үнэн болж энэ насны зовлон болдог вэ. Хоёр нь буюу төрөх болон өтлөх үхэх болой. Хэд нь зовлонгийн үнэн болж хойд насны зовлон болдог вэ. Тийн мэдрэхүйгээс эхлээд амсуурга хүртэлх хөрөнгө зэргүүд болой" хэмээн айлджээ.

Тиймээс бүтээн үйлдэгч "шунах сэтгэл" болон түүгээр бүтээгдэх "амсуурга" хоёр нэг дор байх шүтэн барилдлага бус билээ. Тиймээс шуналаар үүдэгдэх амсуурга болвоос өөр нэгэн шүтэн барилдахуйн үрийн үесийнх болой.

"Хүргэгч" болон "хүргэгдэх" гэдгийг дөрвөн янзаар ухаарч болно. Юу хүргэгдэх вэ. Үрийн үеийн тийн мэдрэхүйгээс эхлэн амсуурга хүртэл хагастай таван гишүүн (дөрвөн бүтэн, нэг хагас) болой. Юугаар хүргэгдэх билээ. Мунхагт шүтсэн хуран үлдсэн үйл буюу. Хэрхэн хүргэгдэх вэ. Үндэс шалтгааны үеийн тийн мэдрэхүйд үйлийн авьяас наалдаж агуулагдах замаар буюу. Хүргэгдэх гэж юу вэ. Бүтээн үйлдэгч шунал тэргүүтэн нисваанис оршин байж өөрсдийн үр дагавараа гаргаж буй хэрэг.

"Бүтээгч" болон "бүтээгдэгч" гэдгийг гурван зүйлээр ухаарч болно. Юугаар бүтээгдэж байна вэ. Шунах нисваанисын шалтгаанаар авахуй зэрэг нисваанис төрөх болой. Юуг бүтээх вэ. Төрөх болоод өтлөх үхэх болой. Хэрхэн бүтэх вэ. Тийн мэдрэхүйд агуулагдсан үйлийн авьяас хүч орох байдлаар болой.

"Шүтэн барилдахуйн судар"-т: "Ганцхан төрөл дээр бүтэх гишүүд гэж ойлговол өтлөх үхэх тэдгээр гишүүдийг буруугаар ухах болно" хэмээн айлджээ. Тийнхүү үйлийн үрийг үл ухаарах мунхаг төрж, түүгээр хотол өдөөгдөн нүглийн үйлийг хураана. Муу үйлийн авьяас тэдгээр тийн мэдрэхүйд наалдаж хадгалагдана. Улмаар гурван муу заяаны үрийн үеийн тийн мэдрэхүйгээс эхлээд амсуурга хүртэл бүтэх болно. Тэдгээр гишүүд шунах, авахуй хоёр нисваанисаар дахин дахин тэжээгдэн төлжиж ирэхэд үйлийн авьяас улам хүч чадалтай болдог. Ингээд муу заяаны төрөх, өтлөх тэргүүтнийг бүтээнэ.

Мөн хоосон чанарын утганаа үл ухаарсан мунхагаар хотол өдөөгдөн Хүсэлт ертөнцөд багтах ёс суртахуун зэргийн буяны үйлийг хураана. Дээд ертөнцөд багтах сэтгэл амарлингуй зэргийг бясалгах зэрэг үл хөдлөх үйлийг хураадаг. Тэдгээр сайн авьяас тийн мэдрэхүйд наадаж агуулагдана. Улмаар Хүсэлт ертөнцийн сайн төрөл болон дээд тэнгэрийн төрлийн үрийн тийн мэдрэхүйгээс амсуурга хүртэлх гишүүд төрнө. Тэдгээр шунах, авахуй хоёр нисваанисаар дахин дахин тэжээгдэн төлжөөд үйлийн авьяас улам хүч чадал орсноор хойноо сайн заяанд төрөх тэргүүтэн бүтэх болой.

Мөн тэдгээр арван хоёр гишүүд нисваанис, үйл, зовлонгийн мөр гуравт хураагдана. *Хутагт Нагаржуна бээр:*

Нэгдүгээр, наймдугаар, есдүгээр нь нисваанис буюу
Хоёрдугаар, аравдугаар нь үйл буюу
Үлдсэн долоо нь зовлон мөн хэмээсэн мэт болой

"Салужанби судар"-т: "Арван хоёр гишүүнийг дөрвөн үндсэнд багтааж, "мунхагийн" тариачин "үйлийн" тарилангийн талбайд "тийн мэдрэхүйн" хөрөнгийг суулгаж, түүнийгээ "шунахын" усаар чийглэж усласаар умайд "нэр дүрсийн" ногоог төрүүлнэ" хэмээн айлджээ.

(3) Хэдэн төрөлд төгсөх

Хүргэгч үйл болон хүргэгдэх гишүүд хоорондоо тоолшгүй олон галваар завсарлагдаж болно. Гэвч дахин төрөл авахад бусад төрлөөр завсарлагдахгүй хоёрдугаар төрөл дээрээ бүтэх ч бас байна. Бүтээгч болон бүтээгдэх төрөл хоёрын хооронд завсар зай гардаггүй учраас түргэндээ хоёр төрөл дээр бүрэн төгсөх ёстой.

Үлгэрлэвээс, Энэ насандаа тэнгэрт төрөх үйлийг шинээр хураах тэр цагт мунхаг, үйл, урийн үеийн тийн мэдрэхүй буюу хагастай гурван гишүүн болон үхэхийг хүртэл шунах, авахуй, оршихуй гурав бүрэлдэнэ. Хойд төрөл дээр хүргэгдэх хагастай таван гишүүн болон бүтээгдэх хоёр гишүүн бүрэлдэх болно. Их удлаа гэхэд гурван төрлөөс цааш үргэлжлэхгүй. Бүтээгч, бүтээгдэх хоёр болон гурван хүргэгч гишүүдэд нэг нэг төрөл дээр байх хэрэгтэй. Хүргэгдэх гишүүд нь бүтээх гишүүддээ хураагдсан байдаг. Хүргэгч болон бүтээгч хоёрын хооронд олон төрлөөр завсарлагдаж болох хэдий ч бусад шүтэн барилдахуйн үест болохоос энэ шүтэн барилдахуйн үест бус болой. Тэдгээрийн зуурдын насыг тусгайлан тооцоогүй болно.

Тэр мэтээр урийн гишүүн тэдгээр бүтэхийн үест ч үйлийг хураагч болон үйлийг эдлэгч бодгалийн "би үгүй" ч дээр номносон мэт ном төдий шалтгаан гишүүнээс ном төдий урийн гишүүд тэдгээр төрнө. Орчлонгийн ёсыг үл мэдэж түүнээ мунхарснаар "би"-г буюу өөрийгээ барих үзэл төрнө. Өөрийгөө жаргалтай байлгахыг хүсэж улмаар гурван үүдээр буян нүглийг илт хураах болно. Чингэж дахин эргэж гурван нисваанисаар хоёр үйл

хурааж, түүнээс долоон зовлон төрөхөд хүрдэг. Долоон зовлонгоос нисваанис үүдэж түүнээс бас дахин түрүүчийн адил тойрох зэргээр орчлонгийн хүрд тасралтгүй эргэлдэх ажээ. *Нагаржуна багш бээр:*

Тэдгээр гурваас хоёр гарах буюу
Хоёроос долоо гарах,
Долоогоос гурав гарах зэргээр
Орчлонгийн хүрд дахин дахин эргэх хэмээжээ.

Ингэж хорвоод тэнэж эргэлдэх жамтайг санаваас уйтгар сайтар төрөх болно. Тоолшгүй олон галваас буян нүглийн үйлийг хураасан хүргэгч үйлийн тийн боловсрол боловсроогүй, ерөндөгөөр даараагүй байхад ч одоогийн шунал, авахуй зэрэг нисваанисаар тэжээгдэн тэтгэгдсний эрхээр сайн заяа болон муу заяанд тэнэж оддог байна. Дайснаа дарагчдийн үндсэнд урьд эгэл байх үедээ хураасан тоолшгүй олон хүргэгч үйл байх ч нисваанис байхгүй учраас орчлонгоос гэтлэх ёсыг магадтай туурвих буюу.

Чингээд нисваанисыг дайснаа гэж үзээд хорихоор хичээнгүй сэтгэл төрөх болой. Энэ талаар буяны садан Пүчүнва бээр: "Эдгээр шүтэн барилдаж гарсан арван хоёр гишүүнийг оюунаар судалж мөрийн зэрэг эдгээрт орох буцахын ухааныг өөртөө санаж бүтээх хэрэгтэй. Муу заяанд арван хоёр гишүүнээр орох буцахыг ухаарна гэдэг бага төрөлхтний аймаг буюу.

Дараа нь хоёр сайн заяанд арван хоёр гишүүнээр орох буцахыг ухаарна гэдэг дунд төрөлхтний аймаг болой. Тэр адилаар жишин эх болсон амьтан бүгд ч арван хоёр гишүүний эрхээр орчлонд тэнэж яваад асрах нигүүлсэхүйн сэтгэл төрж улмаар тэдний тусад бурханы хутаг олох сэтгэл төрж түүний зам мөрд суралцаж явах нь их төрөлхтний аймаг болно" гэж айлджээ.

(4) Тэдгээрийн утгын хураангуй:

Дээр номносон мэт бүхэн гарахуй-үйл нисваанисын эрхээр зовлонгийн бие цогцос бүтэх ёс болоод нэн ялангуяа арван хоёр гишүүний үүднээс орчлонгийн хүрднээ эргэх жамыг сайтар ухаарч ойлгоод түүнийг тунгааж бясалгах явдал нь хамаг гутамшиг доройтолын үндэс - балай мунхагийн барагдашгүй харанхуйг дарах, үндэс шалтгаангүй болоод үл зохилдох шалтгаанаас гадаад дотоодын хуран үйлдэх бүхэн гарна хэмээх

будангүй буруу үзлийг буцаах, Ялгуусадын зарлиг номын хүү санг эрхлэн үзэх эдийг арвижуулах, орчлонгийн мөн чанарыг ёсчлон ухаарч хүчтэй уйтгар төрснөөр тонилохуйн мөрд сэтгэл хөтлөгдөх, урьдаас тийн тунгааж бясалгаж чадсан бүхнээ хутагтын хутаг олохын авьяас сэргэж бадрах зэргийн эрхэм арга болой.

Тэр талаар *"Бунсангийн айлтгасан тантр"*-т: "Мунхагаас шүтэн барилдахуйн зам мөрүүд салбарлах буюу" хэмээсэн ба *"Салужанба судар"*-т: "Шүтэн барилдахуйг сайтар ухаарваас урьд хойдын хязгаар болон эдүгээд тухайлсан буруу үзлийг няцаана" хэмээн айлджээ. Хутагт Нагаржуна багш бээр:

Энэхүү шүтэн барилдаж гарахуй болвоос
Ялгуусдын эрхэм зарлигийн хүү сангийн эрхэм дээд буюу хэмээжээ.

"Винайн эш"-д: "Эрхэм хоёр шавь нар (Шарипутра ба Маудгаляаяана) таван зүйлийн амьтны орноор зорчин явдаг байжээ. Тэд тийн зорчиж яваад Замбу тивд заларч гэнэ. Зовлонгийн тухай дөрвөн нөхөртөө ярьж өгчээ. Заримууд буяны явдалд дургүй хамт оршигч болон ойр дотнын хүмүүсээ дагуулан нөгөө хоёр шавиас ном заалгахаар авчирдаг байж. Тэр хоёр тэдэнд ном заана. Ном зааснаар нөгөө хүмүүс буяны явдалд дуртай болж ялгамжаатай ухаарлыг ч олжээ. Бурхан багш болгоож Гунгаавaас асуусанд учрыг айлтгажээ.

Чингээд Бурхан багш бээр: "Бүгдээр эрхэм хоёр шавь шиг зөв ухаарч чадахгүй тул, Таван хэсэгтэй орчлонгийн хүрдийг урагшаа хойшоо эргэж буцах ёсоор арван хоёр шүтэн барилдахуйтай хамт эргэн тойронд зурж бүтээсүгэй" хэмээн зарлиг болжээ. Ийнхүү орчлонгийн хүрдний зураг хөрөг бий болжээ. Энэхүү зургийг Удраяана хаанд хүргүүлжээ. Үүнээс хойш Хаан бээр эргэх буцах жамыг үзүүлсэн арван хоёр шүтэн барилдахуйн тэрхүү зургийг өглөө босох болгондоо биеэ тэгшлэн завилж суугаад хоёр шүтэн барилдахуйн жамыг нүдээр харж сэтгэлээр санан санасаар хутагтын хутгийг олсон" хэмээн айлдсан буй.

Б. Тэрхүү санаа бодол төрөх хэмжээ

Тийнхүү зовлон, бүхэн гарахуй хоёр болон арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс орчлонгийн мөн чанарыг таньж мэдээд ирэхээр тэдгээрийг орхих буюу чухал амарлингуй хутгийг олохын хүсэл эгээрэл

төдийгөөс эхлээд магад гарахуйн санаа төдий зэрэг бодлууд төрөх болно. Гэвч энэ төдийгээр хязгаарлаж болохгүй билээ.

"Ухааны жаран шүлэгтийн тайлбар"-т: "Мөнх бусын гал бадарсан гурван ертөнцөд сууна гэдэг дүрэлзэн шатах гэрт суугаа адил буюу. Түүнээс магадтай гарахыг л хүсэх" хэмээсэн ба "Хэрхэн хоригдол хүн гяндангаас" хэмээн дээр өгүүлсэн мэт хэрхэн дүрэлзэн шатах гэрт суугаа хүнд болон гяндангд хоригдсон хоригдолд тэдгээр зовлонг үл хүсэх сэтгэл болон тэдгээрээс гэтлэхийн хүслэн хэдий чинээ төрөх тусам тэр адилын ухааны хэмжээ тогтоогдоно. Түүнээс дээш нэмж ахиулах хэрэгтэй"

Эл магад гарахуйн санааны талаар Шарава гэгээн айлдахдаа: "Исгэлэн ундаан дээр гурил хийгээд хутгачихаар зунгаарч исэж амсар дээгүүр гарч ирэхээс цааш хэтрэхгүй болчихвий. Орчлонгийн үндэс – бүхэн гарахуй буюу нисваанисыг үл хүсэх бодол ч энэ адилаас цааш төрөхгүй байна. Ийм болохоор зовлон, түүнийг үүдэгч нисваанисыг хорих нирвааныг чухалчлах мөн түүнтэй адил.

Тийм болохоор тонилохуйн мөрийг бүтээх хүсэл ч үг төдий болж одно. Орчлонд тэнэх бусад амьтны зовлонд үл тэсэх их нигүүлсэхүй сэтгэл ч төрөхгүйд хүрнэ. Ханьцашгүй бодь сэтгэл засваргүй төрүүлэх шаардагч сэтгэлийн хүч чадал ч үл төрөх учир их хөлгөн маань үг дагасан ухаарал төдий л болно шүү" хэмээжээ. Тиймээс энэхүү дунд төрөлхтний аймгийг увдисын туйлд барин судлах хэрэгтэй буюу.

В. Энэ талаарх буруу сэжгийг арилгах

Хэрвээ ингэж орчлонгоос сэтгэл машид гансрах, уйдах бодлыг бясалгаад байхаар Сонсоод сонсогч нар шиг орчлонд төрөхдөө дургүй болж улмаар нирвааны туйлд унахад хүрмээр санагдана. Иймээс уйтгар бясалгах чинь бага хөлгөнд л үзэсгэлэнтэй биз ээ. Бодисадва нар түүнийг бясалгах нь зохисгүй билээ.

"Санаанд багташгүй нууцын судар"-т айлдахдаа: "Бодисадва нар амьтныг төгс боловсруулах явдлыг чухалчлан бариад орчлонг тус эрдэмтэйд үзэх болохоор огоот их тонилогчид байхгүй болой" хэмээжээ. "Хэрвээ бодисадва нар орчлонгийн явдлын орноос айваас явдал мөр бишдэж унах буюу" хэмээсэн ба, "Бурхан аа, Сонсоод сонсогч нар

орчлонгийн явдал мөрөөс айдаг буюу. Бодисадва нар дахин дахин тоолшгүй олон орчлонг барьж үйлдэх болой" хэмээн айлдсан байна шүү дээ хэмээвээс. Энэ бол судрын утгыг огт буруугаар барьсан их эндүүрэл байна.

"Орчлонгоос уйсаж бүү үйлдээрэй" хэмээхийн утга болвоос үйл нисваанисын эрхээр орчлонд тэнэж төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн зовлон эдлэхээс сэтгэл гансарч бүү үйлд гэсэн утга бус аа. Амьтны тусын төлөө бодисадва нар орчлонгийн хязгаар хэдүй хүртэл бодисадвын явдалд суралцах хөө хуягийг өмсөөд, амьтны зовлон бүхэн хурж чуулан агшин бүхнээ өөрийн бие сэтгэлд бууж байсан ч, тэд нар сэтгэл уйсах, айж мэгдэх явдалгүйгээр агуу их явдал үйл хэргийг туурвихдаа хичээнгүйлэн шамдаж, орчлонгоос уйдахгүй байх учиртайг айлдсан ажээ.

Тийн учиртайг Чандракирти гэгээн бээр: "Хамаг амьтны үлэмж их зовлон орчлон хэдүй хүртэл агшин болгонд өөр өөр байдлаар бие сэтгэлийг хорлож зовоож байвч тэдгээрээс огт айлгүйгээр, амьтны зовлон нэгэн зэрэг гарч ирсэн ч орчлон хэдүй байх хүртэл дуртай яа хичээнгүйлэн үйлдэх агшин бүрдээ амьтан бүхэн болвоос хамгийг болгоогчийн эд болсон хэмжээлшгүй буяны чуулганыг төрүүлэх үндэс хэмээн ухаараад, дахин дахин орчлонд төрөл авах буюу" хэмээж түүнийг батлахын тухайд олон судраас эш татан айлдсан буй.

Орчлонг тустай гэж үзэх учир шалтгааны талаар тэрхүү *"Судар"*-т: "Бодисадва нар амьтны тусад хичээж байдаг. Түүнд хичээн шамдах тусам таалал сэтгэл амгалантай болдог" хэмээн айлдсан тул орчлонд үл уйдахын хэрэг нь орчлонд амьтны тус хийхдээ үл уйдаж харин баярлаж явах учиртай аж. Тиймээс үйл болоод нисваанисын эрхээр орчлонд тэнэхэд олон зовлонгоор нэрвэгдэн өөрийн тусаа ч бүтээж чадахгүйд хүрдэг тул бусдын тусыг хэлээд яах вэ. Энэ нь доройтол бүгдийн үүд мөн тул бага хөлгөнөөс машид их уйсаж хорьж үйлдэх хэрэгтэй буюу. Ерөөл болон их нигүүлсэхүй тэргүүтний эрхээр орчлонд төрөл авахдаа баясах хэрэгтэй. Энэ хоёр хоорондоо ялгаатай билээ.

Эдгээрийг ялгалгүйгээр түрүүчийн адил өгүүлвээс өгүүлэгч нэгнээ бодисадвын санваар байгаа бол нисваанисын гэм уналыг төрүүлнэ" гэж *"Бодийн газар"*-т айлджээ. Үг ихдэх вий гээд бичсэнгүй.

Тиймээс орчлонгийн гэм бүгдийг ухааран машид сэтгэл гансравч их нигүүлсэхүй сэтгэлээр татагдан орчлонг үл орхих явдал сонин гайхамшигтай билээ. Орчлонгийн хотол чуулганыг хэмжээлшгүй тансаг сайхан орд харш шиг үзэх шуналаас өчүүхэн төдий ч хороогоогүй хэрнээ бусдын тус хэмээн өгүүлж яривч бид орчлонг тэвчиж чадахгүй болохоор мэргэд хүндлэнэ гэж хаанаас байх вэ.

"Төв үзлийн зүрхэн"-ээс:

Гэмийг мэдэх тул орчлонд шунах бус
Нигүүлсэх тул нирваанд үл суух
Бусдын тусыг бүтээх тул тангараг ёстон
Орчлонд ч оршиж ажрах буюу хэмээжээ.

Мөн *"Бодийн газар"*-т, Хамаг амьтныг хайрлах их нигүүлсэхүй төрүүлэхийн үндэс болгохоор, түмэн зовлонг өнө удаан хугацаанд эдлэхийг мэдэж үл тэсэх байдлыг сэтгэлдээ бий болгохын тулд орчлонгоос уйдахын хэрэггүй гэж номносон гэвэл их харшлах болно шүү. Орчлонгоос сэтгэл сайтар уйдаж үйлдсэн ч амьтан тэр бүхнийг садан гэж үзэж тэдний тусад орчлонгийн далайд орох мөрийн зэрэг нь *"Бодисадвын егүзэрийн явдал дөрвөн зуут"*-ын таалал мөн билээ. Цогт Чандракирти гэгээн бээр ч түүний тайлбартаа тодорхой өгүүлжээ.

Ийн хэмээн: "Орчлонгийн гэм зовлонг номносноор сэтгэлээс айж гэтлэхийг хүсэгч нар их хөлгөнөө магадтай орохын тулд, Ялж төгөлдөр нөгчихсөн бээр: Аяга тахимлаг нар аа, Өнө удаан хугацааны турш орчлонд эргэлдэн эргэлдэж явсан учраас хоорондоо эцэг, эх, хүү, охин, ойр, холын садан болж яваагүй гэж хэлж болохгүй. Чингэж яваагүй амьтан нэгээхэн ч үгүй билээ" хэмээгээд "Бодисадва нар ч бурханы зарлигийг ухааран болгоож тэргүүлшгүй цагаас орчлонд дамжиж ирсэн эцэг эх тэргүүтэн ядарч зовсон аврал итгэлгүй болсон элгэн садан энэ амьтан бүхнийг их хөлгөний ёсны хөлөг онгоцоор гэтэлгэж үйлдэхдээ туйлбартай байх буюу" хэмээн айлджээ.

Энэ нь ханьцашгүй арвис тарнийн ёсноо ч мөн ийм байх хэрэгтэй аж. *"Явдлын хураангүй зул"*-д: "Энэхүү ёсоор машид цацралтгүй явдалд орж үйлдэх болой. Түүний зэрэг ийн болой. Юуны түрүүнд бүтээлчин бээр

тэргүүлшгүй хугацаат зовлонг санан байж нирвааны амгаланг хүсэх учир хуран үймцээн бүхнийг тэвчиж үйлдэнэ. Хамгийн наанадаж хаан төрийн эрх баялгийг олохыг хүслээ ч зовлонгийн хур мэдлийг бясалгах болно" хэмээн Арьяадэва хутагт айлджээ.



НИРВААНД ХҮРЭХ МӨРИЙН МӨН ЧАНАР

Г. Нирваанд хүрэх мөрийн мөн чанарыг нотлон буулгахуй [58]

Шри Загда Мэдри бээр:

Ёроолгүй зовлонгийн далай болох
Ертөнцийн гүнд живсэн хэдий ч
Үл уйдан, үл айн баясгалантай яа цэнгэх
Бидний зүрхэнд юу нэгэн байна вэ

Ядуурах, олоход бэрхшээл учрах, хамгаалах, эвдрэх
Олсон ч хагацаж салах, өвдөх өтлөхийн зэргийн
Зовлонгийн мөнхийн бадарсан гал дотор суугаа хэр
Жаргалтай мэт хөөрөмшин байх нь галзуутай адил

Мөн:

Аяа, Ертөнцийнхний нүд сохор гэж үү
Үргэлж бодитой үзсээр хэрнээ
Өдгөө хүртэл өчүүхэн төдий үл санах нь
Таны зүрх очир чулуу болж бүтсэн юм уу хэмээжээ.

Энэ мэтээр өөрөө өөртөө шаардлага тавин орчлонгийн гэм эргүүг бясалгамой.

"Долоон эхийн тууж"-д:

Орчлонд орших гэдэг усны доторх сарны дүрс адил хөдөлж үзэгдэх
Хүсэл гэдэг уурт могойн бие мушгиралдан цогнойх сүүдэр мэт харагдана
Эдгээр амьтан бүхэн зовлонгийн дүрэлзсэн гал дотор суугааг үзээд
Хаан бид нар магад уйдаж хүүрийн газар илт баясан зүглэх
хэмээсэн мэт сав шим ертөнцийн хийгээр хөдлөх усны саран мэт ганц агшинд үл тогтох үргэлж эвдрэх мөнх бус, хэрэг багатай гэм ихтэй хорт могойн бие сүүдэр мэт хүслийн эд, гурван зовлонгийн дүрэлзэх галд үргэлж энэлэх таван зүйл амьтныг хараад орчлонгийн шуналаа ёзоороос буцаасан "Хойд зүгийн нялхас"-ын ухаан нэгэн төрвөөс магад гарахуй-нирваанаа илт баясаж олохын ухаан төрөх болой. "Хойд зүгийн нялхас" гэдэг ийн буюу.

Хойд зүгт арвайн гурил ховор аж. Өчүүхэн төдий манжингаар хооллох нялх хөвгүүн өлсөж арвайн гурил идэхийг хүсчээ. Ээж нь арвай байхгүй хэдий ч хооллохын тулд шинэ манжин өгчээ. Гэвч түүнийг идэхгүй гэж гэнэ. Хатаасан нэгийг өгч гэнэ. Бас л идэхгүй гэж гэнэ. Дараа нь чанасан нэгийг өгөхөд бас л түлхжээ. Ингээд чанаж хөргөсөн нэгийг өгсөнд идэхгүй хэмээн дургүйцжээ. Бүр сүүлдээ ихэд ундууцан "Дандаа манжин, манжин" хэмээн хашгирсан гэдэг.

Үүнтэй адилаар орчлонгийн жаргал юуг ч үзсэн, сонссон, санасан бүгдээр эвдрэхийн шүтээн, тэр бүгдээр эвдрэхийн шалтгаан, тэр бүгдээр зовлон болох нь ялгалгүй шүү гэдгийг санаж түүнд шунах явдлаа зогсоох хэрэгтэй хэмээн айлдсан дагуу болой.

Тийнхүү тэргүүлшгүй цагаас орчлонд тэнэх ёсыг санан сэтгэл уйдан гансрах бөгөөд эдүгээ ч тэнэх жамтайг санаснаар айж цочих ухаан үг төдий бусаар төрөх болой. *"Садангийн захидал"*-д:

Орчлон тэр адил үзэгдэх тул тэнгэр хүмүүн хийгээд
Там бирд адгуусны орон бүхэнд
Сайн бусын төрөл төрж
Олон хорлолын сав болохыг болгоон зохиожээ

хэмээн айлдсан мэтээр элдэв олон зовлонгийн үндэс болсон орчлонд төрөхөөс буцах хэрэгтэй буюу. Энэ нь зовлон үүдэх шалтгаан нөхцөл болсон үйл болон нисваанис хоёрыг буцаах явдлаас хамаардаг билээ. Чухамдаа нисваанис байхгүй аваас хичнээн үйл байгаад ч тэр хоёр төрөхгүй буюу. Харин нисваанис байх аваас урьд нь үйл хураагаагүй байсан ч даруй даруйд хураах учраас нисваанисыг дарах хэрэгтэй. Түүнийг дарах явдал эндүүрэггүй, төгс төгөлдөр мөрийг бясалгахаас хамаардаг бөлгөө.

Үүнээ хоёр зүйл: 1. Ямар шүтээн дээр буцаах
2. Ямар мөрийг бясалгаж буцаах болой

1. Ямар шүтээн дээр буцаах

"Садангийн захидал"-д:

Буруу үзлийг баригч болон адгуус,
Бирд болон тамд төрөх,

Бурханы номгүй болон бөглүү газарт,
Тэрсүүд номтон болон хэлгий дүлий,

Урт наст тэнгэр зэргийн алин нэгнээ
Төрөл авах хэмээх чөлөөгүй найман гэм
Тэдгээр бүхнээс ангижирсан чөлөөт төрлийг олоод
Зовлонт төрлөө буцаахын төлөө шамдан зохио

хэмээсэн мэтээр чөлөө учралыг олсон энэ л цагт буцаах хэрэгтэй. Чөлөөгүй шүтээн дээр буцаахын боломж гардаггүй учрыг дээр номносон билээ. Налжорва чэнбу гэгээнээс: "Одоо л адгууснаас ялгагдах цаг мөн" хэмээжээ. Бодава гэгээн бээр ч: "Урьд тэр мэт тэнэж тэнэчихээд өөрөө эс буцаасан билээ. Өнөөдөр ч буцаасан зүйл алга учир буцаах шаардлагатай буюу. Буцаахын цаг нь өнөөдөр чөлөө учралыг олсон энэ цаг болой" хэмээн айлджээ. Тэдгээрийн дундаас гэрт байхад саад зэтгэр олонтой, элдэв гэмээс болж буруу алдаа гардаг. Машид гарсан буюу хувраг тойн болвоос түүнээс буцах болно. Тиймээс хорвоог буцаах эрхэм шүтээн нь хувраг тойн мөн тул мэргэд илт баясдаг ажгуу.

Гэргийтний гэм болон машид гарагчийн эрдмийг дахин дахин санах; Урьд машид гарагч нарын сэтгэл санааг баттай болгох, машид эс гарагч нарын сайн авьяасыг тогтоох, сэргээж гаргахын тулд энэ ёсыг өчүүхэн өгүүлсүгэй.

Гэргийтэн нар хөрөнгө баялагтай аваас түүнийгээ хамгаалах гэсээр зовж шаналана. Ядуу аваас эрж олохын зовлонд баригдаж яс арьсаа барагдтал гүйдэг. Ямар ч амгалангүй зүйлийг амгалантай мэтээр мунхарч үзсэнээс болж муу үйлийн үрд хүрдгийг мэдэж аваарай.

"Төрлийн цадиг"-т:

Гяндан адилын гэр дотор
Хэзээд жаргал буй гэж бүү сана
Баян ч бай, ядуу ч бай хэн бээр
Гэрт оршвоос зовлон ихтэй

Нэгэн бээр сахих гэж зовох
Нөгөө бээр олох гэж махаа идэх буюу
Баян, ядуу хэн ч бай ялгалгүй
Хэн ч жаргах гэж байхгүй

Тийм зүйлд баясаж мунхрах аваас
Нүглийн үйл боловсорсон тэр ямагт хэмээн айлджээ.

Тийн учраас элдэв эд зүйлийг хураах, ханаж цадахаа мэдэхгүй хөөцөлдөж гүйх явдал машид гарагсад буюу хувраг тойдын ажил үйлдвэр биш ээ. Үүнээс өөрөөр болвоос гэргийтнээс ялгагдахгүй болно шүү.

Мөн гэрт оршихуйд ном лугаа харших учраас буян ном бүтээхэд бэрхтэй байдаг.

Дээрх цадигт:

Гэрийн амьжиргааг бүтээхийн тулд
Худал ярихгүй байж болохгүйд хүрнэ
Гаднаас хорлол ирэхэд ч
Хариулахгүй байж болохгүйд хүрэх

Хэрвээ номын явдлаар гэвэл гэрийн амьжиргаа сүйрэх
Гэрт зүглэвээс ном буян ч яаж бүтэх билээ
Номын явдал машид амарлингүй мөн
Гэрийн хэрэг хатуу хүчээр бүтэх буюу

Тиймээс номтой харшлах гэм буйн учир
Өөртөө туслахыг хүссэн хэн бээр гэрт орших билээ хэмээн мөн,

Дээрэнгүй сэтгэл, уур омог, мунхагийн могойн үүр
Асар амарлингүй, баясгалан, амгаланг эвдэгч
Элдэв барагдашгүй олон зовлонгийн орон болсон
Ичээ гэртээ хэн орших билээ хэмээн айлджээ.

Энэ мэтээр гэрт оршихийн гэмийг дахин дахин санаж хувраг тойн болохын ерөөл тавиарай. Чингээд хэр тааруу номын хувцас, бадар аяга, буяны идээгээр ханан мэдэх, аглаг газраа өөрийн нисваанисаа арилгах, бусдын тулд эрдмийн орон болохоор ерөөл тавина.

"Долоон эхийн тууж"-д:

Үс сахлаа хусаж хяргаад
Хогжирч муудсан дээлийг нөмрөн
Аглагийн орныг хүсэн одох
Алин хэзээ тийн нэгэн болтугай

Буулга мод мэт харагдах
Шавар тагшаа гартаа барьж
Алба татваргүй айлаас айлд
Алин хэзээд гуйлгачин байдлаар явсугай

Олз хүндлэлд огт шунахгүй
Нисваанисын өргөст шавар намгаас
Татаж гаргах буюу хот балгадын
Өглөгийн орон хэзээд болтугай хэмээсэн мэтээр болой.

Өвс ногоогоор дэвсгэр суудлаа хийж хучлага нөмрөггүй хэвтэх, дээл хувцас хяруунд дарагдах, тааруу муу идээ ундаагаар ханан мэдэх, модны дэргэд зөөлөн өвс ногоогоор суудал засаж номын баясгалан амгалангаар амьдарч суухыг ерөөлийг тавина.

Энэ талаар :

Өвс ногооны дундаас сэрж
Хяруу цасанд дарагдсан дээл хувцастай
Хэр тааруу идээ унд зэргээр
Хэзээд биенээ үл шунах болтугай

Ой модонд амьдрах тоть шувуу адил
Ногоон өнгөт зөөлөн өвсийг нөмрөн
Үзсэн номын амгалангаар цэнгэн наадаж
Хэзээ би бээр хэвтэх бол оо хэмээсэн мэт болой.

“Гэрийн дээвэр дээр цас буусны дараа, өнгөрсөн шөнө *“Долоон эхийн тууж”*-д номнодогтой адил нэгэн болжээ гээд баярладаг байсан. Үүнтэй адилтгах өөр бусад бясалгахын хүсэл байхгүй билээ“ хэмээн Бодава гэгээн айлджээ. Эмт ой цэцэрлэг болон гол усны эрэгт суугаад усны долгионы төрөх түрдэхийг ажиглаж миний амь бие хоёр энэ адил шүү гэж санах, зовлонгийн үндэс болсон хамаг муу үзэл бүхнийг төрүүлэгч “би-д баригч” үзлийг тус тус оногч ухаанаар хорих, ертөнцийн жаргал цэнгэлд шунахаа болих, сав шим ертөнц бүгдээр илбэ адил гэх зэргийг дахин дахин санаж ерөөл тавих нь:

Усны эрэг, эмийн ой цэцэрлэгт оршихуй яа
Усны мяралзах долгисын төрөх түрдэх лүгээ

Амьдрах ертөнцийн ахуй ёсон адил хэмээн
Ахин дахин тунгааж бодох болтугай

Хамаг муу үзлийн эх үндэс болсон
Эвдрэх чуулганы үзлийг хөөх хийгээд
Ертөнцийн сайн сайханд шунахаа болих
Хэзээд надад төрөх болтугай

Зүүд, зэрэглээ, илбэ, үүл
Гандирсын балгад лугаа
Гүйх ба үл гүйх ертөнц бүхэн адил хэмээн
Хэзээд ухаарч онох болтугай хэмээн айлджээ.

Энэ бүгдийг хувраг тойны шүтээн дээр бүтээж үйлдэнэ гэж ерөөл тавиарай.

Чадгава гэгээн бээр: "Хатуужлын ой цэцэрлэгт аршийн явдлаар оршиж чадваас одоо л эцэг нь хүүгээ тэтгэж буйтай адил" хэмээжээ. Шарава гэгээнээс ч: "Гэргийтэн завгүй их ажилд барилдаж байхад та нар, машид гарагчид, сайхан хувцас өмсөөд залагдаж явна. "Машид гарах гэдэг жаргалтай юм даа" хэмээн бодогдоно. Энэ бол ирээдүйд машид гарахын авьяасыг төрүүлж буй хэрэг шүү" хэмээжээ.

"Дагшулжангийн айлтгасан судар"-т: "Хэзээ нэг би бээр, зовлонгийн орон болсон гэрээс машид гарч түүний явдлаар явах бол, хэзээ нэг би бээр хуврагийн үйл, сэргээх ариусгахын үйл, хорих салгахын үйл, мөргөх залбирахын үйлийг үйлдэх бол хэмээн энэ адилаар машид гарахуйн сэтгэлд баясаж үйлдээрэй" хэмээн гэрт оршигч бодисадва нар ерөөл тавихыг айлджээ.

Гэхдээ төгс төгөлдөр санваарт (гэлон) байхын төлөө ерөөл тавихыг зарлиглажээ.

"Судрын аймгийн чимэг"-т:

Машид гарсан шүтээний зүг бүхнээ
Хэмжээлшгүй эрдэм төгөлдөр байх ёстой
Тийнхүү тангарагаа сахихдаа
Гэргийтэн бодисадвагаас үлэмж байх хэрэгтэй хэмээн айлджээ.

Ийм учраас зовлонгоос гэтлэгч тонилохуйн хутаг буюу нирвааныг бүтээх шүтээн нь машид гарагч буюу хувраг тойн болохоор барахгүй билиг барамидын хөлгөн болон нууц тарнийн хөлгөний үүднээс бурханы хутгийг бүтээхэд ч машид гарагч хамгийн дээд шүтээн болохыг айлджээ. Машид гарахуйн санваар болвоос гурван санваарын дотроос тус тус гэтэлгэгч ямагт мөн болой. Иймээс номын үндэс болсон тус тус гэтлэхүйд бишрч үйлдээрэй.

2. Ямар мөрийг бясалгаж буцаах:

"Садангийн захидал"-аас:

Толгой, хувцсандаа гал дүрэлзвээс
Түүнийг унтрааж буцааж болох
Дахин зовлонд автахгүйн төлөө шамдах
Үүнээс илүү эрхэм тус хэрэг гэж байхгүй

Ариун ёс суртахуун, оюун ухаан, бясалгах сэтгэлээр
Амарлингүй, гаслангаас нөгчихсөн, хиргүй номхон хутаг
Үл үхэх, үл өтлөх, үл барагдахуйг олох буюу
Шороо ус хий нар сарнаас ангид нэгийг олж зохиовой

хэмээсэн мэт мөр буюу их эрдэнийн гурван суртгаалд суралцах хэрэгтэй.

Тэрхүү гурван суртгаалд суралцахад гурван зүйл:

а. Гурван суртгаалын тоо хэмжээ
б. Тэдгээрийн эрэмбэ дараа
в. Тэдгээрийн мөн чанар

а. Гурван суртгаалын тоо хэмжээ.

1) Сэтгэлийн номхотголд харгалзах тоо хэмжээ: Тийн алгасарсан сэтгэлийг алгасаралгүй болгон үйлдэхийг ёс суртахууны (шагшаавад) суртгаал гэнэ.

Сэтгэл тэгш агуулагдаагүй (төвлөрөөгүй) байдлыг тэгш агуулагдах болгон үйлдэхийг бясалгал буюу сэтгэлийн суртгаал хэмээнэ. Эс гэтэлсэн сэтгэлийг гэтэлгэж үйлдсэнээр билиг ухааны суртгаал болой. Эл гурван

сууртгаалаар егүзэр бүтээлчин нарын хамаг үйл үйлдвэр төгс боловсрох болой.

2) Үр дагаварт харгалзах тоо хэмжээ: Ёс суртахуун үл доройтуулваас түүний үрд хоёр сайн заяа бүтэх ба доройтуулваас үрд муу заяа үүдэх болой. Сэтгэлийн суртгаалын үрд хоёр дээд орны сайн төрөл болой. Билиг оюуны суртгаалын үрд тонилохуйн хутаг олох болой. Товчилвоос дээд төрөл болон нирваан хутаг хоёр тэдгээрийн бүтээгдэхүүн буюу. Эхнийхэд дээд доод ертөнцийн хоёр сайн төрөл багтах тул түүнийг бүтээгч нь ч гурав болой. Энэ хоёрын талаар *"Газрын бодит суурь"*-д айлдсан буй.

3) Тэвчигдэхүүнд харгалзах тоо хэмжээ: Дээдэс мэргэд бээр тэвчигдэхүүн нисваанист харгалзуулан гурав гээд нисваанисыг сөхөөх, ил гарсны толгойг дарах, хөрөнгө үндэснээс тэвчих гэсэн гурван суртгаал хэмээн болгоожээ.

б. Тэдгээрийн эрэмбэ дараа

"Газрын бодит суурь"-д *"Эсэрва айлтгасан судар"*-аас эш татан:

Үндэс язгуур машид баттай бөгөөд
Амарлингуй сэтгэлд баясах хийгээд
Хутагтын үзэл болон буруу үзэл лүгээ
Төгөлдөр болох эсвээс тэвчиж үйлдэх хэмээн үзүүлжээ.

Үүнд ёс суртахуун нь үндэс язгуур болж нөгөө хоёр түүнээс гардаг учиртай. Ёс суртахуунд шүтэн байж хоёрдугаар сэтгэл тэгш агуулагдах илт баясгалан төрөх буюу. Сэтгэл тэгш агуулагдаж байж үнэмлэхүй утгыг ёсчлон үзэх учраас хутагтын үзэл төгөлдөр болж буруу үзлээс ангижрах гутгаар төрөх болой.

в. Гурван суртгаалын мөн чанар [59]

"Эсэрва айлтгасан судар"-аас:

Зургаан гишүүн лүгээ төгөлдөр бөгөөд
Дөрвөн орны амгалан төгөлдөр буюу
Дөрвөн зүйлд дөрөв дөрвөн ялгамжаар
Үргэлжид арилсан бэлгэ билиг болой хэмээн зарлигласан мэт.

Үүнд ёс суртахууны суртгаалд зургаан гишүүн төгөлдөр буй. Төгс ёс суртахуунтай байх болон тус тус гэтэлгэгч санваар хоёроор нирваамыг магад гаргагч ёс суртахууныг үзүүлсэн байна. Зан үйл болон төгс явдлын орон хоёроор үл муушаагдах ёс суртахууныг үзүүлжээ. Бүдүүн нарийн амлашгүй нүглээс цээрлэх үзлээр үл доройтох ёс суртахууныг илэрхийлжээ. Суртгаалын суурийг үнэхээр авахад суралцах гэдгээр огт гэмгүй арилсан ёс суртахууныг харуулжээ.

Сэтгэлийн дөрвөн орон нь бясалгалын дөрвөн орон болой. Тэдгээрээр энэ насанд амгалантай тул амгалан төгөлдөр буюу сэтгэлийн суртгаалт болой. Дөрвөн зүйл гэдэг дөрвөн үнэн болой. Тэдгээрийн дөрөв дөрвөн ялгамжаа хэмээвээс, "зовлонгийн үнэн"-д мөнх бус, зовлонт, хоосон болон "би үгүй" чанарт болой. "Бүхэн гарахуйн үнэн"-д шалтгаан, хотол гарахуй, машид гарахуй, шалтаг нөхцөл буюу. "Хорихуйн үнэн"-д хорихуй, амарлихуй, гайхамшигт, магад гарахуй болой. "Мөрийн үнэн"-д мөр, язгуур, бүтээл, магад сөхөөгч болой. Эдгээр арван зургаан байдлыг онож ухаарсан арван зургаан билиг нь ухааны суртгаал болой.

Энэ үед дунд төрөлхтний мөрд өөрийгөө хөтөлж байгаа учраас гурван суртгаалаар хөтлөгдөх ёсыг дэлгэрэнгүй мэдэх шаардлагатай. Гэвч чингэлгүйгээр ухааны суртгаал буюу үлэмж үзэхүй болон сэтгэлийн суртгаал буюу амарлингуй сэтгэлийг төрүүлэх ёсны тухай их төрөлхтний мөрийн үест дэлгэрэнгүй номнох учраас энд үүнээс илүүг номносонгүй. Чингээд ёс суртахууны суртгаалд суралцах ёсноос хураангуйлан өгүүлсүгэй. Эхлээд ёс суртахууны тус эрдмийг дахин дахин санаж зүрхний мухраас хүчтэй баясах хэрэгтэй.

"Их нөгчихсөн судар"-аас:

Ёс суртахуун бол хамаг буяны номын шат буюу
Газар шороо мод ургамлын суурь болдогтой адил суурь буюу
Худалдаачны ноён худалдаачин бүхний өмнө одох адил
Буяны ном бүгдийн өмнө одох болой

Хан Хурмаст ялгуусан тэмдгийг өргөх адил
Хамаг ном бүхний ялгуусан тэмдэг болой
Хилэнцийн өвчин бүхнийг арилгагч эмийн мод буюу
Хорвоогийн мөрийг доройтуулах бэлтгэл нөөц

Нисваанисын дайсныг дарагч хөө хуяг буюу
Нисваанисын хорт могойг дарагч арвис тарни буюу
Нүглийн уснаас гэтэлгэгч гүүр болой хэмээжээ.

Хутагт Нагаржуна бээр:

Сав шим бүгдийн суурь газар шороо болдог шиг
Эрдэм бүгдийн суурь ёс суртахуун болой хэмээсэн ба

"Бүнсэн айлтгасан тантр"-аас:

Хэрхэн үр тариа бүгдээр газарт шүтэн
Хиргүй ариун ургах адилаар
Ёс суртахууныг шүтэн байж эрхэм дээдийн ном
Их нигүүлсэхүйн усаар чийглэгдэн лавтай мэндлэх

хэмээсэн зэргийг санаарай. Ам авчихаад эс сахиваас маш их гэм гарна.

"Аяга тахимлагийн машид энхрийлэх судар"-аас:

Заримуудын ёс суртахуун амгалантай буюу
Заримуудын ёс суртахуун зовлонтой буюу
Ёс суртахуун төгөлдөр аваас амгалантай буюу
Ёс суртахуун цалхай аваас зовлонтой буюу

хэмээн суртгаалд ам авагч тус эрдэм болон гэм буруугийн хоёр зүгт одож болохыг айлджээ. Тиймээс гэм буруу ч сайтар санаж суртгаалаа бишрэн дээдлэж үйлдээрэй.

Хэрхэн суралцах ёс. Унал гардаг дөрвөн үндэс буй. Тэдгээрээс сэрэмжгүй байхын ерөндөг болох авч орхих зүйлээ умарталгүй санах, байн байн гурван үүдээ тус тус ажиглах, сайн муу алинд зүглэж байна гэдгээ ухамсарлах, өөрт болон ном буянд хорлол болно гээд цээрлэх ичгүүртэй байх, бусад муушаах вий гээд цээрлэх ичгүүртэй байх, гэмт явдлын тийн боловсрох үр дагавараас айж эмээх зэрэгт суралцах болой.

Үл бишрэхийн ерөндөг болох бурхан багш болон түүний цааз зарлиг, нэгэн номын явдалт нөхдөө хүндлэн бишрэх болой.

Олон нисваанисын ерөндөг нь сэтгэлээ шинжиж аль их хувьтай байгаа нисваанисын ерөндөгийг шамдаж шүтэх болой. Тийн шамдалгүй энэ төдий харшлал гарсан ч гэм болохгүй гээд цааз журамд наазгай тоомжиргүй хандваас зөвхөн зовлон үүднэ.

"Эшийн тийн ялгал"-аас:

Хэн нэгэн бурханы нигүүлсэхүй номноо
Хөнгөн санаж өчүүхэн зөрчвөөс
Түүнээс болж тэрээр бусдын эрхэт зовлонг олох
Хулсан ойг хяргахад Амра жимсний төгөл мөхдөгтэй адил

Заримууд энэ үест Ялгуусны их зарлиг байсан ч
Зөрчвөөс дахин хэзээ ч цааз суртгаалыг үл олох
Чадагчийн зарлиг эшийг ёс бусаар хэтрүүлвээс
Адгуусан заяанд одох Элагийн (элапатра) лустай адил

хэмээн айлджээ. Тийм учраас гэм уналаар халдахгүйн төлөө шамдах хэрэгтэй бөгөөд хэрвээ халдваас үл тоомсорлон орхилгүйгээр унал хилэнцийн жич заслыг номносон дагуу үйлдэхээр шамдах зохистой.

"Эсрэва айлтгасан судар"-аас

Суртгаалыг шүтэн үйлдэж
Түүнээ чин зүрхнээс шамдах зохистой
Хожим тэвчисү хэмээн бүү үйлд
Амины тухайд ч зөрчиж бүү үйлд

Үргэлжид хичээн шамдаж үйлд
Сахих явдалд оршиж үйлд хэмээжээ.

"Үнэхээр төгөлдөр ёс суртахуун судар"-аас: "Аяга тахимлаг нар аминаас хагацан үхэхэд хялбар боловч ёс суртахуун доройтон эвдрэх гэдэг түүнтэй адил бус аа. Яагаад гэвэл аминаас хагацан үхнэ гэдэг энэ төрлийн нас барагдаж дуусч байгаа нь тэр билээ.

Харин ёс суртахуун доройтон эвдэрнэ гэдэг зуун буман жилээр язгуураас хагацан амгалан жаргалаа алдаж байгаа хэрэг. Асар их унал зовлонг амсаж эдлэх болой" хэмээсэн тул тангараг ам авсан бол зарлигийн дагуу амьтайгаа дүйцүүлэн сахих хэрэгтэй.

Түүнээс бус үсээ авахуулсан, эл шарын хувцсыг нөмөрсөн би гэх төдийгээр тус болохгүйг санаарай.

"Бясалгалын хаан судар"-аас:

Энэхүү бурханы номд орж тойн болчихоод
Нүглийн үйлийг машид үйлдэх
Эд тавааp тариалан ногооны ажилд шимтэн
Унаа хөсөг илжиг, үхэр, морин тэрэг зэрэгт шунах

Алив суртгаалд шамдахгүй болвоос
Юуны тулд үсээ хусуулсан юм бэ хэмээн айлджээ.

Хуран үйлдсэн орчлонгоос дутаахыг хүсэж нирвааны балгадад зорчихуй яа ёс суртахууны хөлөө хугалваас явж чадахгүйгээр барахгүй дахин орчлонд зовлонгоор нэрвэгдэх болохыг үлгэрлэн ийн өгүүлжээ.

"Бясалгахын хаан судар"-аас:

Олон дээрэмчинд баригдсан нэгэн хүмүүн
Амь гарахаар зугатааж гүйтэл
Хөл нь хөдөлж явж чадахгүй болчихвол
Дээрэмчдэд баригдан хөнөөгдөх адил

Ёс суртахуун доройтон мунхарсан хүмүүн бээр
Ертөнцөөс гэтлэхийг хүсэх хэдий ч
Ёс суртахуун доройтсон учир яаж дутаан чадах
Өтлөх өвдөх үхэхийн эзнээр лавтай дарагдах хэмээн айлджээ.

Тийнхүү дээрх судраас:

Гэргийтний хар хувцсыг өмсчихөөд
Би бээр алин суртгаалыг номновоос
Тэр цагт аяга тахимлаг тэдгээрт
Тэрхүү суртгаал үгүй болюу

хэмээн айлдсан мэт уваш ("буянд ойртогч" сахил) нарт айлдсан суртгаалын таван суурийг төгс сахина гэдэг аяга тахимлаг нарт ч байхгүй болсон энэ цагт суртгаалд хичээх явдал үлэмж сайн үртэй тул шамдах хэрэгтэй шүү.

Дээрх судраас:

Гөлт тоот ганга мөрний элсний тоотой сацуу гөлт галавт
Сүсэглэх сэтгэлээр идээ ундаа болон шүхэр
Нисгэлэн чимэг зул гэрлийн эрхисээр
Гөлт жива тоотой бурхадаа өргөж тахиснаас

Хэн бээр, дээдийн ном машид доройтох
Бурханы ном сургаал балрах цагт
Өдөр шөнөд ганц суртгаалыг ч болов сахисан
Энэ буян тэдгээрээс илүү ялгамжаатай хэмээн айлдсан буюу.

Мөн унал гарсан ч наминчилвал боллоо гэж үзээд хойшдоо үйлдэхгүй гэх буюу боомтлохын бодолгүй явах бий. Дараа засаж болно гэж хэлдэг чинь хор идсэнтэй адил шүү дээ.

"Арслангийн дуут Майдарын судар"-аас: "Майдар аа, Хожмын цагт хожмын таван зуун жилийн үест гэрт оршигч бодисадва нар болон зарим нэг машид гарагсад бээр нүглийн үйл, гэмийг наминчилваас бүгдээрээ барагдана гэцгээнэ. Хурж бүрдэх болон хурж бүрэлдсэн тэдгээр үйлийг ч наминчилав гээд, үлдэгдэл алдас уналаа бүгдээ хөөх боловч хойшдоо хорихгүй аваас эргэж гарч ирдэг билээ. Ийм учраас эдгээрийг үхлийн үйлтэн мөн хэмээн би өгүүлсэн буюу. Үхэл гэж юу вэ, Ийн буюу.

Үлгэрлэвээс хор идсэн хүнтэй адил үхэл хуран нийлж муу төрөлд аваачих явдал болой хэмэээв. Майдар аа! Хутагтын ном болох энэхүү ёсыг юунд хор гэж үзнэ вэ. Дагах ёстой суртгаалын сууриас хэтэрсэн учраас ийн буюу. Та нар битгий хор идэж үйлдээрэй" хэмээн айлджээ.

Ийнхүү ёсчлон сахигч, тус тус гэтлэгч санваар төгөлдөр байх явдал нууц тарнийн хөлгөнд ч адил хэрэгтэй.

"Бунсан бээр айлтгасан судар"-аас:

Ялгуусан миний айлдсан тус тус гэтэлгэгч
Ариун ёс суртахуун, номхотхууны сууртгаал бүхнээс
Гэрийн тарничин нар шинж тэмдэг, зан үйл заримыг огоорох
Үлдсэн бүгдийг анхааран бясалгаарай

хэмээсэн мэт гэргийтэн тарничин нар ч хуврагийн шинж тэмдгийн аймаг, зан үйлүүд, зарим дангаар байх хувь зэргээс бусад тохиолдолд Винайгаас номносон дагуу суралцах хэрэгтэйг зарлигласан учраас тарничин машид

гарсан байх ёстой. Тарнийн номыг бүтээх үндэс нь ч ёс суртахуун болой.

"Бунсан айлтгасан"-аас:

Тарнийн ёсны анхны үндэс ёс суртахуун
Түүнээ шүтэн хичээнгүй, тэсвэр болон
Бурханаа сүслэх, бодь сэтгэл төрөх буюу
Нууц тарни хийгээд үл залхуурах болой

Хэрхэн долоон эрдэнэ төгс хүмүүний хаан
Хамаг ардыг зоволгүй номхруулдагтай адил
Хэрвээ тарничин эл долоон гишүүн лүгээ
Төгөлдөр болвоос нүглээ дарж үйлдэх буюу

"Манзуширийн язгуурын дамжлагаас"-аас:

Ёсыг сахилгүй урин тоолох түүнээ
Дээдийн бүтээл гарахгүй
Дунд зэргийн бүтээл ч гарахгүй
Адгийн бүтээл ч гарахгүй буюу

Чадагч бээр, ёс цалхай аваас
Тарни бүтэхгүй хэмээн айлджээ
Нирвааны хот балгадын одох хэдий ч
Орон зүг алинд ч хүрэхгүй

Ийм муу нялх амьтнаа
Тарни бүтэх гэж хаанаас байх
Ёс алдсан энэхүү амьтанд
Амгалан заяа гэж хаанаас байх

Өндөр язгуурт ч үл төрөх бөгөөд
Амгалангийн дээдэд ч үл хүрэх тул
Бурханы айлдсан тарнийн ном
Бүтнэ гэж хэлж болох уу хэмээн айлджээ.

Хамлүнба гэгээнээс: "Ган гачиг тохиоход тариалан бүгд дээр буудаг. Түүнтэй адил бүгдээр ёс суртахуун дээр эргэлдэн буудаг учраас үүнд л шамдах хэрэгтэй. Ёс суртахуун цэвэр ариун байна гэдэг үйлийн үрийг санахгүйгээр оршихгүй. Тиймээс үйлийн үрийг санах явдал увдис буюу. Шарава гэгээнээс ч: Ер жаргал зовлон юу тохилдсон ч ном буянд шүтээрэй.

Түүний дотроос Винайгаас номносон дагуу шүтвээс айж сандрахын хэрэггүй санаа амар, үргэлж үл дийлдэх, баяр баясгалантай, алс хэтдээ жаргалтай байх болно.

Гэвш Донба гэгээнээс ч: "Ганц нэг өдөр винай шүтэхэд тарниар юу хийх, тарнийг шүтэхэд винайгаар юу хийх вэ хэмээв. Винай бол тарнийн нөхөр, тарни бол винайн нөхөр болно гэдэг миний багшийн зарлигийн дамжлага мөнөөс мөн" хэмээн айлджээ.

Жовужэ богд бээр айлдахдаа: "Бид Энэтхэгт байхдаа их асуудал гарах юм уу, гэнэтийн хэрэг тохиоход аймаг савыг баригч нарыг дуудаж ирүүлээд, гурван аймаг савнаас хорьж уу, үгүй юу эсвээс гурван аймаг савтай харшиж уу, үгүй юү гэдгийг хэлэлцэж ярилцаад тэр гурвын дээрээс шийдвэр гаргадаг байсан. Өнөөдөр "Брэкамалашилавала" энэ хийд дээр бол бодисадвын явдлаас хорьж уу, үгүй юү, түүнтэй харшилж уу, үгүй юү эдгээр хэлцэж байна. Хамаг хэргийг шийдэх үндэс Винайг баригчид орших болой" хэмээжээ.

Тийнхүү ёс суртахуун ариун байх талаар Ниү сүрва гэгээнээс: "Эдүгээ дотор байгаа нисваанистайгаа байлдах л хамгийн чухал бөлгөө. Нисваанистай эс тэмцвээс ариун ёс суртахуун үл ирмой. Иймээс нисваанисын толгойг дарах болон бүр ёзоороос нь үлдэн арилгах бясалгалын хийгээд билиг ухааны суртгаал ч үл төрөхөд хүрдэг.

Ийм байдалд хүрвэл орчлонд үргэлж тэнэх хэрэгтэй болно. Тиймээс дээр номносон мэт нисваанисыг танин барьж, тэдгээрийн гэм буруу болон тэднээс салваас ямар тус эрдэмтэй болох зэргийг тунгааж улмаар санан дурдах болон ухамсарлахын "шүдээр зуух" хэрэгтэй. Ямар ч нисваанисын толгой цухуйх тэр тоолонд жад тавих хэрэгтэй.

Алив нисваанис өөрийн сэтгэлд өчүүхэн төдий ургамагц дайсан гэж үзэж тэмцэх хэрэгтэй. Хэрвээ ингэлгүй эхлээд гарахад нь ая зөнгөөр тавьчихвал ёс бусын сэтгэлээр өдөөгдөн тэжээгдэж дийлдэхийн аргагүй нөхөр болно шүү" хэмээжээ.

Тийнхүү хичээгээд эс буцсан хэдий ч үргэлжлэлийг таслалгүй үйлдвээс буцаж харих буюу. Иймээс чулуун дээр сийлсэн зураг шиг бус, усан дээр зурсан зураг шиг болтол арилгах хэрэгтэй.

"Садангийн захидал"-аас:

Сэтгэлийг ус, шороо, чулуун дээр
Зураг зурсан мэт ухаараарай
Түүний дотор нисваанист анхных,
Дээд буюу номыг хүсэгчид сүүлчийнх буюу

хэмээсэн мэт номын зүгт түүнээс буцах болой.

"Бодичарияаватара"-гаас:

Үнээ л би шунаж үйлдэх бөгөөд
Өслөн барьж тэмцэн тулалдах буюу
Тэр адилын байдалт нисваанис хийгээд
Нисваанисаа дарахаас өөр юу хэрэгтэй

Намайг шатаах бас алж ч болох
Миний толгойг таслахад ч амархан
Харин хэзээд ч нисваанисын дайсанд
Хэрхэвч сөгдөж бүү үйлдээрэй хэмээн айлджээ.

Гэвш Пүчүнва гэгээн бээр, "Нисваанис сэмээрхэн гэтсээр намайг дарахад адаглаад дорооос нь чимхээд авах хэрэгтэй хэмээхийг Бодова сонсоод, чингэж чадвал ч даруй буцааж чадна шүү" гэж айлдсан байдаг.

Хөөж тууж явуулсан ч өөр нэгэн газар нутагт очоод тэндээ хүч тэнхээгээ сэлбэж аваад эргэн ирж тэмцэлддэг эгэлийн дайсан болон нисваанис хоёр хоорондоо адилгүй билээ.

Нисваанисыг нэгэнт сэтгэлийн үндэснээс хөөж гаргаж чадсан бол өөр бусад газар очих ч гэж байхгүй, дахин эргэж ирнэ гэж байхгүй. Чухамдаа бид нар нисваанисаа дарахаар хичээж шамдахгүй байгаа учраас л хорлогдож яваа билээ.

"Бодичарияаватара"-гаас:

Эгэлийн дайсныг орон газраас хөөхөд
Өөр бусад орон газарт орогнон хорогдох
Өөхшин тамир суугаад эргэж дайрах буюу
Өнөө нисваанисын дайсан үүнтэй адил бус аа

Билгийн нүдээр нисваанисын нисваанисыг тэвчих
Миний сэтгэлээс эгнэгт салж одсон болвоос
Хаа нэгтэйгээс намайг хорлохоор дахин ирэх үү
Ухаан муут би хичээхгүй явсаар уршигдах буюу хэмээн айлджээ.

Нүгрүмба гэгээнээс: "Нисваанис цухалзах төдийд ч залхууралгүй тэр даруйд ерөндөгөөр буцаа. Буцааж болохгүй байвал босож суугаад мандал, тахил бэлтгээд багш, ядам бурхадад соёрхол талби. Сайн бодоод хатуу тарни зэргийг уншваас хэвтэж одох вий" гэж айлдсан буй. Ланританба гэгээнээс ч: "Суудлаа сэлгэх юм уу хүзүү толгойгоо эргүүлэх төдийгөөр ч хэвтэж одох гээд та нарын нисваанистайгаа тэмцэх чинь харагдана" хэмээжээ.

Гонбава гэгээнээс: "Өдөр шөнө бүхэнд өөрийн сэтгэлээ манахаас өөр хэрэг юун хэмээн айлдсан дагуу үйлдээд байвал ахицаа гарна даа" хэмээжээ. Өдөрт уулзсан хүн бүхнээсээ Жовужэ гэгээн бээр: "Ингэхэд танд сайхан сэтгэл байна уу" гэж асуудаг байсан гэдэг.

Нисваанисыг тэвчих ёс. Язгуурын нисваанисуудаас салахад маш бэрхтэй. Хамаг олон нисваанисын суурь нь мунхаг билээ. Түүний ерөндөг болгож шүтэн барилдахуйг олонтаа бясалгах буюу орчлонд ирэх, буцах жамыг ухаарах чухал. Үүнийг тунгааж бясалгаж чадвал таван үзэл тэргүүтэн муу үзэл бүгд төрөхгүй болой.

Энэ хойд төрөл хоёуланд зовлонг үүдэж, хураасан буяны язгуур бүхнийг устгагч дайсан бол уур хилэн болой. *"Бодичарияаватара"*-гаас: "Уур хилэн адилын нүгэл байхгүй" хэмээн айлдсан мэт буюу. Тийм учраас түүнд хэзээ ч үүдэх бололцоо өгөхгүй байх тэсвэр тэвчээрт шамдах хэрэгтэй.

Тэр эс үүдвээс энэ насанд ч улэмж амгалантай
Хэн бээр хянамгайлан уураа дарсан аваас
Тэрээр энэ төрөл болон бусад төрөлд ч амгалантай
хэмээн *"Бодичарияаватара"* -гаас айлдсан дагуу болой.

Урьд хураасан нүгэл буяны хамаг үйлээс хорвоо бүтэхэд улам хүч нэмж, дээш дээш арвижуулж өгдөг нисваанис бол шунах тачаах сэтгэл буюу. Эл нисваанис Хүсэлт ертөнцийнхний хувьд мэдрэхүйн орноо төгс мэдрэх хүрэлцэх мэдрэмжээр нөхцөлдсөн сэрэхүйн амсуургаас үүдэж бий

болдог. Гадаад дотоодын гуа бус болон хүслийн таван эрдэмд шунахын гэм буруу зэргийг олонтаа бясалгаснаар түүнийг дарна.

Васубанду гэгээн бээр:

Буга, заан, эрвээхэй, загас болон
Зөгий зэрэг таван амьтан тавууланд дийлдэх
Хэрвээ ганц ганцаар дийлдэг юм бол
Тавуулаа үргэлжийн шүтээн түүнийг юунд үл дийлнэ вэ

хэмээсэн мэт болой. Мөн ойртох тусам салахад бэрхтэй болдог олз хүндлэл, нэр алдар, магтаал сайшаал, жаргал цэнгэл дөрөвт шунах тачаах буй. Тэдгээрийн эсрэг зүг болох сэтгэл үл баясах дөрвөн зүйлийн эрөндөгт шамдах ёстой. Түүний дээр ер нь орчлонгийн гэмийг бясалгах, ялангуяа мөнх бусын жамыг үнэхээр ухаарч чадвал буцаах болно.

Омог дээрэнгүй гэдэг энэ үест мөрийн эрдэм төрөхийн их тотгор болох, хожмоо бол боол зардас болохын үндэс учраас тэвчих ёстой билээ. Тэвчих ёсны талаар *"Садангийн захидал"*-аас:

Өвдөх өтлөх үхэхийн зовлонгоос хагацах гэдэг
Тэрчлэн үйлийг минийх хэмээн хүлээн авахаас үл хэтрэх
Тэр мэт дахин дахин санаж тунгаах
Тэрхүү эрөндөгийн үүднээс омог дээрэнгүй үл гарах хэмээсэн мэт

Тээнэгэлзэх (сэжиг) нисваанис үнэн хийгээд чухаг дээд гурав, үйлийн үр зэрэгт магад итгэмж олж чадвал төрөхгүй болой.

Нойр, балархуй, догшрох, залхуу, сэрэмжгүй, ичгүүргүй, сонжуургүй, умартах, мэдэгсээр бус (ухамсаргүй) хэмээгдэх ойрын нисваанисууд буяны зүгт нийлэхэд түргэн саад зэтгэр болдог учраас гэм бурууг нь мэдэж, эрөндөгөөр дарж даруй даруйд хүч чадлыг багасгаж сураарай. Тэдгээрийн гэмийн талаар

"Садангийн захидал"-аас:

Догшрох, гэмших, хорлох санаа, балрах,
Нойр, дурлах болон тээнэгэлзэх (сэжиглэх)
Эдгээр таван түйтгэр буяны эд баялагийг
Булаагч хулгайч гэдгийг мэдэж аваарай.

"Үлэмж сэтгэлийг шаардахуй судар"-аас:

Алин нойр болон бáлархуйд автваас
Хий шар бадган тэдгээр бүхэн
Хамаг түүний биенээ дэлгэр түгэх буюу
Түүний махвод бүхэн хямрахад хүрэх

Алин нойр болон бáлархуйд автваас
Амны идээний гэмээр ходоод гэдэс эвгүйтэх,
Бие хүндэрч өнгө зүс алдах зовиуртай болох
Түүний үг хэл нь ээдэрч бүвтнэх

Алин бáлархуй болон нойронд автваас
Тэрээр мунхран ном эрдэмд хичээхээ болих
Нялхас хамаг эрдмээс огоот зүг буруулах
Сайн сайхан доройтон тэнэг мунхаг болох
хэмээн олон янзын гэм буруу үүдэх тухай айлджээ.

"Шадар санан дурдахуй"-аас:

Элдэв нисваанисын нэгэн суурь нь
Эрхгүй залхуу яавчиг мөн бөгөөд
Хаана л залхуу орших тэр газраа
Хамаг ном үгүй бөлгөө хэмээсэн ба,

"Цоморлиг"-оос:

Анхаарал сэрэмжгүй явагч тэрээр
Ухаан самуурсан нялхас буюу
Худалдаачны ноён эд тавараа сахих адил
Ухаантнууд анхаарал сэрэмж төгөлдөр байх хэмээсэн ба,

"Төрлийн цадиг"-аас:

Тэнгэрийн хаан хэрнээ ичгүүр сонжуураа алдаж
Сэтгэл ном хоёроо харшуулж явснаас
Ноорхой дээл нөмрөн шавар сав бариад
Дайсныхаа гэрт ирж явна гэж харагдах сайхан хэмээсэн ба,

"Садангийн захидал"-аас:

Эрх баялагт бээр, бие тэргүүтэн санан дурдахуйг
Амгалан залрагсдын гагц зорчих мөр хэмээн заажээ
Түүнийг хянамгайлан илт сахин үйлдсүгэй
Санан дурдахуй доройтвол хамаг ном эвдрэх буюу хэмээсэн ба,

"Бодичарияиватара"-гаас:

Сүсэг бишрэлтэй, сонссон мэдсэн их байгаад
Хичээнгүй шамдал олонтой хэдий ч
Ухамсар үгүй бол гэм тогтож улмаар
Унал алдааны булингарт хутгалдах буюу хэмээн айлдсан буй.

Тийнхүү язгуурын болон ойрын нисваанисуудыг хорьж чадаагүй байгаа хэдий ч тэднийг дайснаа гэж үзэн тэдэнд зүглэхгүй, тэдэнтэй нийлэхгүй байх явдал эдүгээ зайлшгүй хэрэгтэй тул ерөндөгийн зүгийг барин нисваанисаа ялахын төлөө хичээн шамдаж, өөрийн ам авсан ёс суртахуунаа төгс ариун сахиж үйлдээрэй.

